



ХУУЛЬ САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2018 №2 (64) 16 дахь жилдээ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

Доктор (Ph.D), профессор

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ

Доктор (Ph.D), профессор

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

Доктор (Ph.D), профессор

Бадам БАТЗОРИГ

Доктор (Ph.D), дэд профессор

Баатар БОЛДБААТАР

Доктор (Ph.D), профессор

Насанжаргал ГАНБАДРАЛ

Доктор (Ph.D), дэд профессор

Жамсран ДОЛГОРСҮРЭН

Доктор (Sc.D), профессор

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

Монгол Улсын гавьяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Авирмэд ЛХАГВА

Монгол Улсын гавьяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Ганбат ЭРДЭНЭБАТ

Улсын Ерөнхий Прокурорын орлогч, төрийн
хууль цаазын шадар зөвлөх

Батзэвэг ЭНХБОЛД

Доктор (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА

Доктор (Ph.D), дэд профессор

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА

Доктор (Ph.D), дэд профессор

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Хүчитбаатар БАДНААЖОНОН



Гарчиг

Профессор С.Жанцан агсаны нэрэмжит “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг: тулгамдсан асуудал, урьдчилан сэргийлэх арга зам” эрдэм шинжилгээний хурлаас гаргасан зөвлөмж 4

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, харьцуулалт, урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал **А.Амгалан** 6

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх асуудлууд **Т.Халтар** 13

Өмчлөх эрхийн эсрэг гэмт явдлын суурь шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зам **Г.Оюунболд** 21

Нийслэлийн хотын хэмжээнд үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ **Ш.Мөнхбат** 26

Монгол Улс дахь олон шатлалт маркетингийн залилах гэмт хэргийн төрөл, чиг хандлага, анхаарах асуудал **Д.Чимэддамба** 33

Хилийн манаа биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үед гарч болзошгүй алдаа, зөрчлөөс сэргийлэх арга зам **Д.Зулбадрах** 44

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Мал хулгайлах гэмт хэргийн зүйчлэлийн зарим асуудал **Т.Мөнхдалай** 54

БНХАУ-ын хээл хахууль, авлигын гэмт хэргийн талаарх судалгаа **Ван Сарнай, Г.Урангоо** 59

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Залилах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгамдсан асуудал, прокуророос тавих хяналт **З.Сансарзолбоо** 66

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нотлох ажиллагаа, эдийн засгийн шинжилгээ хийхэд тулгамдсан асуудал **А.Пүрэвдорж** 73

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг өмгөөлөхөд тулгамдсан зарим асуудал **Х.Баатарбилэг** 83

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шинжлэн магадлахуйн дэмжлэг үзүүлэх нь **Т.Очирбат** 90

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтөд анхаарах асуудал **Б.Эрдэнэжаргал** 100



ХУУЛЬ
САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



УЛСЫН
ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН
ГАЗАР



МУИС-ИЙН
ХУУЛЬ ЗҮЙН
СУРГУУЛЬ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН



Суурийн
Жанцан Сан
Vantran
foundation



ХБНГУ-ЫН
ХАННС-
ЗАЙДЕЛИЙН
САН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР,
ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХУРАНДАА СУУРИЙН ЖАНЦАН АГСАНЫ НЭРЭМЖИТ
**“ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ”** ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛААС ГАРГАСАН

ЗӨВЛӨМЖ

Эрдэм шинжилгээний хуралд оролцогчдоос өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн зохицуулалт, арга зүй, урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, ажил хэрэг болгох нь зүйтэй хэмээн хүлээн зөвшөөрч, дараах зөвлөмж гаргав.

1. “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2018-2024/” баталж, хэрэгжүүлэх;

2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох зорилгоор гэмт хэргийн статистикийг түгээмэл үйлдэгддэг болон бусад гэмт хэрэг гэсэн ангилалаар гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж буй гадаадын зарим улсын туршлагыг нэвтрүүлэх;

3. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, Улсын Дээд Шүүхээс Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн зарим ойлголт, нэр томъёог тайлбарлах, Тухайлбал,

– Хулгайлах гэмт хэргийн үндсэн шинж /Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/-ийг хэлбэрийн шинжтэй хуульчлах;

– Дээрэмдэх гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/-ийн үндсэн шинжийг булаах гэмт хэрэг болгон хуульчлах;

– Хөрөнгө завших гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйл/-ийн объектив талын шинжид үрэгдүүлэх үйлдлийг нэмэх;

– Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 17.5 дугаар зүйл/-ийн халдлагын зүйлд санамсаргүй олдсон эд хөрөнгө гэж нэмэх;

– Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах гэмт хэргийн бүлгийн харъяаллыг зөв тогтоох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн бүлэгт хамааруулах /Эрүүгийн хуулийн 17.7 дугаар зүйл/-ийн диспозициас “...хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн шинжгүй” гэснийг хасах;

– Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэйгээр ашиглан шамшигдуулах гэмт хэргийг шинээр хуульчлах;

– Мал хулгайлах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл/-ийн хүндрүүлэх шинжид ноцтой хохирол учруулсан, бүлэглэн үйлдсэн, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн, машин механизм ашигласан гэж нэмэх;

4. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг Хууль зүй, дотоод хэргийн яамны харъяа Хууль Сахиулахын Их Сургуулийг түшиглэн байгуулах эрх зүйн үндсийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд тусгах;

5. Өмчлөх эрхийн эсрэг нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцоолох, иргэдийн аюулгүй байдлыг хангах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа” /Crime Victimization Survey/ гурван жил тутамд НҮБ-ын аргачлалын дагуу явуулж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд ашиглах;



6. Хохирлын санг байгуулж, түгээмэл үйлдэгддэг хүний амьд явах эрхийн эсрэг, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулах үндэсний тогтолцоог бүрдүүлэх;

7. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг мөрдөх, нотлох ажиллагаанд криминалистикийн орчин үеийн техник, хэрэгсэл ашиглах, мөрдөх арга зүйн аргачилсан зөвлөмж боловсруулж, мөрдүүлэх;

8. Шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх тухай сургаалийг Хууль Сахиулахын Их Сургуулийн “шинжээч” мэргэжлийн сургалтын хөтөлбөрт тусгах;

9. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, ялангуяа залилах /Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл/, хөрөнгө завших /Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйл/ гэмт хэргийн улмаас гадаад улсад байгаа мөнгө, эд хөрөнгийг эргүүлэн татах ажиллагаанд гадаадын хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх, туршлагыг нэвтрүүлэх;

10. Аж ахуйн үйл ажиллагааны тухай тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу “Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа”-г хориглож, тавих хяналтыг сайжруулах, энэ талаарх сурталчилгааг хязгаарлах, энэ чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

11. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх шууд чиг үүрэг бүхий цагдаагийн албан хаагчдын /мөрдөгч, эрүүгийн мөрдөгч/ тоог ажлын ачааллыг харгалзан нэмэгдүүлэх, албан хаагчдын нийгэм, хууль зүй, эдийн засгийн баталгааг хангах арга хэмжээ авах;

12. Иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоо /малчдын холбоо, хөршийн холбоо г.м/-г гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, цагдаагийн байгууллагаас мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, тодорхой ажлыг санхүүжүүлэх;

13. BIG DATA буюу мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоог бүрдүүлэх, гудамж талбай, олон нийтийн газрыг камерын хяналтад бүрэн авах, ингэхдээ CCTV олон улсын стандартад нийцүүлэх, хулгайлагдсан гар утсыг байршлаар нь илрүүлэх, ажиллагаагүй болгох программ хангамжийг нэвтрүүлэх, барьцаалан зээлдүүлэх газрууд, автомашины сэлбэг, эд анги худалдаж, захиалгаар нийлүүлдэг иргэн, аж ахуйн нэгжид тавих хяналтыг сайжруулах;

ХУРАЛД ОРОЛЦОГЧИД

2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр, Хуульчдын танхим



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, ХАРЬЦУУЛАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

А.Амгалан

Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх албаны дарга, цагдаагийн хурандаа


Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэрэг жил ирэх тусам өсөж, тэр дундаа бусдын эд зүйлийг хулгайлах, бусдын биед гэмтэл учруулах, залилан мэхлэх гэмт хэргүүд дийлэнх хувийг эзэлж байгаатай холбогдуулж тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гаралтыг бууруулах чиглэлээр дан ганц цагдаагийн байгууллага бус, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн тусламж дэмжлэгийг авах, хамтран ажиллах, хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх зорилгоор өнөөдрийн энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх алба нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг дагнан явуулах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсаны 68.0 хувь нь нийслэлд, 31.8 хувь нь орон нутагт үйлдэгдсэнээс “Бусдын эд зүйлийг хулгайлах” гэмт хэрэг 36,5 хувийг, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг 27.3 хувийг эзэлж, дээрх 2 гэмт хэрэг Монгол Улсад үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн 64,0 хувийг эзэлж байгаа нь өнөөдөр бид энэ төрлийн хэргүүдээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулах чиглэлд хаа хаанаа онцгой анхаарч, нэг санаа зорилгоор идэвхтэй, эрчимтэй хамтран ажиллах шаардлагатай болсныг харуулж байна.



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА



Нөгөө талаар хуучин Эрүүгийн хуулийн “Иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг” гэмт хэрэг, одоогийн хуулийн “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг нь гудамж талбай, олон нийтийн газар, гэр орон сууцанд байнгын үйлдэгдэж, ихэнх тохиолдолд хөнгөн гэмт хэрэг гэдгээр нийгэмд төдийлөн анхаардаггүй, төрийн болон холбогдох бусад байгууллагаас төдийлөн ач холбогдол өгдөггүй, энэ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан болон урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан эрдэмтэн багш, судлаачдын зөвлөмж, гарын авлага, сургалтын материал байдаггүй, өдөр тутам үйлдэгдэж, хүн бүр мэддэг болсон хэрэг боловч энэ гэмт хэрэг нь Монгол Улсад үйлдэгдэж буй нийт



гэмт хэргийн 30 орчим хувийг дангаараа эзэлж байгаа гэдгийг та бид өнөөдөр анхааралдаа авч, үүнд санаа зовж, үйл ажиллагаагаа чиглүүлж, хамтдаа тэмцэхгүй бол болохгүй болжээ гэдгийг хэлмээр байна.


Ингээд миний зүгээс сүүлийн жилүүдэд нийт гэмт хэргийн 27-30 хувийг эзэлж байгаа “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн гаралт, харьцуулалт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, дүгнэлтээ статистик тоо баримтад үндэслэн та бүхэнд товч мэдээлэл хийхийг хүссэн юмаа.

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг нь 2015 онд 29,1 хувиар, 2016 онд 30,3 хувиар, 2017 онд 6,8 хувиар тус тус өссөн ба үүнээс 61,1 хувь нь нийслэлд, 38,8 хувь нь орон нутагт үйлдэгдсэн байна.

Хэргийн гаралтаар авч үзвэл 89,6 хувь нь хөнгөн, 5,7 хувь нь хүндэвтэр, 4,5 хувь нь хүнд гэмт хэрэгт ангилагдаж, үүнээс бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг хамгийн ихээр буюу сүүлийн 3 жилд энэ бүлэгт заасан нийт гэмт хэргийн 84-89 хувийг эзэлж байна.



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА




Энэ төрлийн гэмт хэрэг нь гэм буруугийн шууд санаатай, идэвхитэй болон болгоомжгүй хэлбэрээр хүний биед шууд хохирол учруулдгаараа бусад гэмт хэргээс онцлог бөгөөд 2017 онд бусдын биед хүнд гэмтэл болгоомжгүй учруулах хэрэг 40,9 хувь, хүндэвтэр гэмтэл учруулах хэрэг 6,4 хувь, хөнгөн гэмтэл учруулах хэрэг 8,4 хувь өссөн, тарчлаах буюу гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг тодорхой хувиар буурсан байгаа нь гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа далд хэлбэрт нуугдмал байсан хүчирхийллийн гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, шалгах ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудаас анхаарч, идэвхтэй тэмцэж байгааг илрэл, үр дүн гэж үзэж байна.

Гэм буруугийн хэлбэрийн хувьд 87,7 хувь нь санаатай, 12,3 хувь нь болгоомжгүйгээр үйлдэгдсэн бөгөөд санаатай үйлдэгдсэн гэмт хэргийн 54,0 хувийг согтуугаар, 14,0 хувийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 5,4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА







Гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд 39,3 хувь нь гэр орон сууцанд, 26,9 хувь нь гудамж талбайд, 17,1 хувь нь олон нийтийн газарт үйлдэгдсэн бөгөөд олон нийтийн газарт үйлдэгдсэн нийт хэргийн 42,0 хувь нь баар цэнгээний газарт, 15,4 хувь нь амралтын газарт, 13,0 хувь нь зочид буудалд, 6,4 хувь нь ресторанд үйлдэгдэж, нийт гэмт хэрэг гарсан газрын 76,8 хувийг эзэлж байгаа нь мөн л архи дан согтуурснаас дээрх газруудад гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн гэж дүгнэхээр байна.



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА




ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА



Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа цаг хугацааны хувьд 22:00-06:00 цагийн хооронд 39,2 хувь, 14:00-19:00 цагийн хооронд 24,9 хувь, 19:00-22:00 цагийн хооронд 20,0 хувь, 06:00-14:00 цагийн хооронд 15,7 хувь үйлдэгдэж, хэргийн гаралт Даваагаас Ням гаригуудад жигд үйлдэгдэж байгаа нь ажил, амралт, баяр ёслолын өдрүүд гэлтгүй архидалт өдөр бүр жигд болж, нөгөө талаар ажилгүйдэлтэй холбоотой гэж үзэж байна.



Даваа	• 1302	14.7%
Мягмар	• 1226	13.9%
Лхагва	• 1229	13.9%
Пүрэв	• 1297	14.7%
Баасан	• 1259	14.2%
Бямба	• 1261	14.3%
Ням	• 1238	14.0%



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2017 онд 8890 иргэн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 316 буюу 1.8 хувиар өсч, хүнд гэмтэл авсны улмаас эмчлэгдэж байгаад нас барсан 22 хүн байна.

- ❖ 2015 онд нийт хохирсон хүний 40.1 хувь нь эмэгтэй, 4.4 хувь нь хүүхэд,
- ❖ 2016 онд нийт хохирсон хүний 38.6 хувь нь эмэгтэй, 3.7 хувь нь хүүхэд
- ❖ 2017 онд нийт хохирсон хүний 38.2 хувь нь эмэгтэй, 4.7 хувь нь хүүхэд тус тус хохирсон байгаа нь сүүлийн 3 жилд гэмт хэргийн улмаас нийт хохирсон хүний 42,9 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй шууд болон шууд бусаар холбоотой гэж дүгнэж байна.



Энэ төрлийн гэмт хэрэгт 2017 онд 7537 хүн холбогдон шалгагдсанаас 53,9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 54.0 хувь нь архи дан согтуурсан үедээ, 6,3 хувь нь бүлэглэж, 2,7 хувь нь насанд хүрээгүй хүүхэд холбогджээ.



ГЭМТ ХЭРГИЙН ХОЛБОГДОГЧ

2017 онд 7537 хүн холбогдон шалгагдсанаас 13.0 хувийг эмэгтэй хүн, 3.0 хувийг хүүхэд эзэлж байна. Нийт шалгагдсан хүмүүсийн тоо өмнөх оны мөн үеэс 14,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2017 онд сэжигтнээр шалгагдсан 7537 хүний:




Нийт шалгагдсан хүнийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 53,9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 21,6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 7,1 хувь нь ажилчин малчин гэх судалгаа гарч, нийт хүний 82,7 хувийг эзэлж байгаа нь дээрх хүмүүсийн боловсролын түвшин доогуур байгааг илтгэж байна.

Насны байдлаар нь авч үзвэл 30-39 насны хүн 31,4 хувийг, 40-49 насны хүн 17,0




ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА

2017 онд сэжигтнээр шалгагдсан 7537 хүний:



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА


СЭЖИГТНИЙ НИЙГМИЙН БАЙДАЛ, ЭЗЛЭХ ХУВЬ /2017 ОН/



ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ХОЛБОГДОГЧИЙН НАС:

Насны байдлаар нь харуулбал: 30-39 насны хүн 31.4 хувь, 18-29 насны хүн 16,4 хувь, 40-49 насны хүн 17.0 хувь, 50-59 насны хүн 5,7 хувь, насанд хүрээгүй хүүхэд 2,7 хувийг эзэлж байна.





хувийг, 18-29 насны хүн 16,4 хувийг эзэлж, нийт шалгагдсан хүний 64,8 хувийг эзэлж байгаа нь ид сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх 18-50 насны хүмүүс энэ гэмт хэргийн дийлэнхийг үйлдэж байгаа харамсалтай тоо гарч байна.

Хуучин Эрүүгийн хуулийн 138 дугаар зүйл “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчих гэмт хэрэг”-ийг одоогийн Эрүүгийн хуулиас хассан тул болгоомжгүйгээр бусдын биед гэмтэл учруулсан зүйл ангиар зүйлчлэн шалгаж байгаа. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байгаа нь барилга байгууламж, уул уурхайн салбарын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд зогсонги байгаатай холбоотой, 2017 онд 35 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 25 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна.

Дүгнэлт:

1. Сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс харахад Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” дангаараа 27-30 хувийг эзэлж, жил бүр тогтмол өссөн дүнтэй байна.

2. Гэмт хэргийн 40 орчим хувь нь гэр орон сууц ахуйн хүрээнд, 30 хувь нь гудамж талбайд үйлдэгдэж, нийт холбогдсон хүний 54 хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ уг гэмт хэргийг үйлдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гаралтыг бууруулах чиглэлээр дан ганц Цагдаагийн байгууллага бус яам, нийслэл, дүүрэг, хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, засаг захиргааны болон иргэний нийгмийн байгууллага, удирдлагууд, тэдгээрийн хамтарсан баг, Сууц өмчлөгчдийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд онцгой анхаарч цаашид үр дүнтэй хамтран ажиллах шаардлагатайг харуулж байна.

3. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэнх тохиолдолд санаанд оромгүй гэнэтийн үйл явдлаас, хоорондын харьцаанаас үүдэлтэй маргаанаас, эсхүл архидан согтуурснаас болж богинохон цаг хугацаанд хүний бие, эд эрхтэнд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол шууд учруулдаг нь бусад гэмт хэргээс онцлог бөгөөд үр дагавар нь ноцтой юм.

Тухайлбал: 2017 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны иргэн Д нь бусадтай хоолны давснаас болж маргалдан зодолдож биед

нь хүнд гэмтэл учруулсан.

Мөн Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах зочид буудлын өрөөнд иргэн Э нь хамт байсан хүнтэйгээ маргалдсаны улмаас гар утсаа шидэхэд хананд ойж хажууд сууж байсан хүний зүүн нүдийг онож хараагүй болгосон үйлдэлд “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүй учруулсан” гэмт хэрэг үүсгэн шалгаж байх жишээтэй.

4. Нийт гэмт хэргийн 27-30 хувийг эзэлж байгаа дээрх гэмт үйлдлийн гаралтад дүгнэлт хийж Цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг Хэрэг бүртгэх албанд хариуцуулсан нь гэмт хэргийг бууруулахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал:

- “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн багагүй хувьд нь хүүхэд, эмэгтэйчүүд хохирогч болох, мөн холбогдон шалгагдаж байгаад анхаарч ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, их дээд сургуулийн оюутан, хэвлэл мэдээллийн болон хүүхэд, эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудын оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг ойлгуулах чиглэлийн ажил, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу оновчтой зохион байгуулах;

- Их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт “Хууль, эрх зүйн хичээл”-ийн цаг сэдвийг заавал оруулах, сургуулийн нийгмийн ажилтан болон өсвөрийн цагдаа бүлгэмүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажилд татан оролцуулах;

- Иргэдэд үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор холбогдлыг хэвлэл, мэдээлэл, олон нийтийн нөлөөллийн арга хэрэгслийг ашиглан таниулах, хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг шинэлэг хэлбэрээр тодорхой давтамжтайгаар нэвтрүүлэх;

- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг удаа дараа үйлдэгддэг аж ахуйн нэгж, “баар” зоогийн газар, амралт, цэнгээний газруудын үйл



ажиллагаанд хууль зүйн дагуу хязгаарлалт тогтоох, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, гэмт хэрэг гарсан бүртгэгдсэн тохиолдол бүрт мэдэгдэл, шаардлага хүргүүлж, шалтгаан нөхцөлийг бүрэн арилгуулж үүрэг, хариуцлагын тогтолцоог сайжруулах;

- Согтууруулах ундааны зүйл худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагуудын хяналтын үйл ажиллагаа, эрх зүйн акт дээр тулгуурлан цагдаагийн байгууллагын алба хаагчдад сургалт зохион байгуулах, зөвшөөрөл, эрх зүйн акт нь өнөөгийн мөрдөж байгаа хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх, гэмт хэргийн гаралтад хэрхэн нөлөөлж байгаа зэргийг судлан шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэр гаргуулах;

-Улсын хэмжээнд нийт гэмт хэргийн илрүүлэлт 2018 оны эхний 2 сарын байдлаар 9.7 хувь, үүнээс “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн илрүүлэлт 20.6 хувь байгааг анхаарч цаашид эзэнгүй хэргийг илрүүлж, шуурхай шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагааг чанартай, үр дүнтэй явуулах, гэмт хэрэг үйлдэгддэг объектын дотор болон гадна гэрэлтүүлэг, стандартын шаардлага хангасан камержуулалт, тэдгээрийн оновчтой байршил үйл ажиллагааг сайжруулах, Шүүхийн шинжилгээний байгууллагаас хүний биед гэмтлийн зэрэг тогтоох дүгнэлтийг шуурхай гаргадаг байх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- Энэ төрлийн гэмт хэргийн дийлэнх хувь нь ахуйн хүрээнд, гэр орон сууцанд үйлдэгдэж байгаад дүгнэлт хийж сууц өмчлөгчдийн холбоо, баг хорооны Засаг дарга, хамтарсан баг, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нараас харьяа нутаг дэвсгэрийнхээ нөхцөл байдалд анхаарал хандуулж, хөршийн холбоо, орцны жижүүрүүдийн хариуцлагыг дээшлүүлэх, гэмт үйлдэл гарсан болон гарч болзошгүй тохиолдол бүрийг цагдаагийн байгууллагад мэдэгдэж хэвшүүлэх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох ажиллагааг эрчимжүүлэх

- Уул уурхай, барилгын салбар болон

бусад аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаандаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журмыг чанд мөрдөж, ажилчин-алба хаагчид, иргэд гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлэх тухайн ажил олгогч, гүйцэтгэгч байгууллагын удирдлагад мэдэгдэл, шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцох ажлыг үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.



ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ КИБЕР ГЭМТ ХЭРЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДЛУУД

Т.Халтар

ШУТИС-ийн зөвлөх профессор,
доктор, профессор

Хураангуй:

Монгол Улсын иргэд трояны довтолгоо, salami халдлага, и-мэйлийн бөмбөгдөлт, кибер залилан, DOS халдлага, мэдээллийн хулгай, системийг эвдлэх, хакердах гэх мэт олон төрлийн кибер гэмт хэргийн хохирогч болох нь жил бүр нэмэгдсээр байна. Байгууллага, иргэд мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт, техник, технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж буй ч сүүлийн арван жилд кибер гэмт хэргийн давтамж нэмэгдсээр байгааг бид харж байна. Интернет ашиглаж буй хэн бүхэн Кибер гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэхийн тулд урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ авах, үндэсний хэмжээнд кибер гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, шүүн таслах чадвар, мэдлэг, тогтолцоог бий болгох шаардлагатай болж байна. Энэхүү нийтлэлд кибер гэмт хэрэг, түүний дотор өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг, тэдгээрийн шинж чанар, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлд үндэсний чадвар, тогтолцоог бий болгох арга хэмжээг санал болгосон.

Түлхүүр үг: Кибер гэмт хэрэг, Компьютерийн гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг, халдлага, хакинг, кибер хулгай, залилан, кибер гэмт хэргээс сэргийлэх

Удиртгал

Кибер гэмт хэрэг гэж компьютерийн эсвэл кибер орон зайг (Интернэтийн сүлжээ) харилцаа холбооны хэрэгсэл болгон ашиглаж үйлдэгдсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг хэлдэг. Кибер гэмт хэрэг гэсэн албан ёсны тодорхойлолт байдаггүй боловч «Компьютерийн гэмт хэргийн судалгааны төв» –ийн тодорхойлсноор “Компьютерийг гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болгон ашиглаж, эсхүл компьютерийг гэмт хэргийн халдлагын зүйл болгож интернэт ашиглан эсхүл интернет орчинд үйлдсэн гэмт хэргүүдийг кибер гэмт хэрэг гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Бүх төрлийн кибер гэмт хэрэгт

Компьютер, түүний ард суугаа хохирогч хүнийг хоёуланг нь хамруулж үздэг; зөвхөн энэ хоёрын аль нь халдлагын зүйл болж байна гэдгээс хамаарч өөр өөр ангилалд хуваагддаг. Кибер гэмт хувь хүний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, төр, байгууллагын эсрэг, нийгмийн эсрэг гэсэн үндсэн дөрвөн төрөлд хуваагддаг ч үйлдэх арга нь хэдэн мянгад хүрч байна.

Энэхүү нийтлэлд Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийг голлон авч үзэж түүнийг үйлдэх аргууд, хор хөнөөл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зарим аргачлалыг авч үзсэн.

1. Кибер гэмт хэрэг

Дэлхийд хамгийн анх бүртгэгдсэн кибер гэмт хэрэг 1820 онд үйлдэгдсэн гэж үздэг. Францын нэхмэлийн үйлдвэрийн эзэн Жозеф Мари Жаккард нэхмэлийн суурь машин хийсэн нь ажилтнуудыг ажилгүй болгох эрсдлийг дагуулж байна гэж үзсэн зарим ажилтан уг төхөөрөмжийг ажиллагаагүй болгох гэмт хэрэг үйлдсэн нь анхны кибер гэмт хэрэг гэж тооцогддог.

Кибер гэмт хэргийн концепци нь уламжлалт гэмт хэргийн концепциос зарчмын ялгаа байхгүй. Аль аль нь үйлдэл, эс үйлдэхгүйгээр дамжин үйлдэгддэг, эрүүгийн юмуу кибер гэмт хэргийн хуулийн заалт, хэм хэмжээг зөрчсөн, төрийн санкциар тэнцвэрждэг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэх арга, орчин, нотлох баримт, мөрдөх хугацаа гэх мэт олон зүйлээр ялгаатай ойлголтууд. Мөн компьютерийн гэмт хэрэг, дижитал гэмт хэрэг гэсэн ойлголтуудаас багагүй ялгаатай. Тиймээс эдгээр ойлголтуудыг эхэлж тодорхойлох, ялгааг ойлгох зайлшгүй шаардлагатай.

Кибер гэмт хэрэг нь Интернет орчин, кибер ертөнц дахь хамгийн төвөгтэй асуудал болоод байна. Эртний Грекийн “Cyber” гэдэг үг удирдлага, засаглал гэсэн утгатай бөгөөд анх 1940 онд Норберт Винер удирдлагын ухааны тухай номоо “Cybernetics -Кибернетика” хэмээн нэрлэж гаргаснаар энэ үг дэлхий даяар хэрэглэгдэх эхлэл тавигдсан. Үүнээс үзвэл “Кибер” гэдэг нэр томьёо нь компьютерийн ухаан үүсэхээс аль эрт гарч ирсэн ба эрүүгийн эрх зүйн практикт тооцоолох төхөөрөмжөөр дамжин орж ирсэн.

Кибер гэмт хэрэг зөвхөн Интернетийн орчинд (кибер ертөнц) үйлдэгддэг. Тийм ч учраас зарим тохиолдолд кибер гэмт хэргийг интернет гэмт хэрэг гэж нэрлэдэг.



Харин компьютерийн гэмт хэрэг нь сүлжээнд холбогдсон эсэхээс үл хамааран компьютер, тооцоолох төхөөрөмжтэй хамааралтай, түүнийг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргүүд байдаг. Гэхдээ энэ хоёр ойлголтын хооронд маш нарийн зааг байдаг учир хольж хутгах нь элбэг. Монгол Улсын эрүүгийн хуучин болон шинэ хуулинд энэ ойлголтыг мэдэхгүйн улмаас буруу тодорхойлж оруулсан байдаг. Жишээлбэл, фишинг нь (интернетээр дамжуулан хүмүүсийн бүртгэлийн мэдээллийг хулгайлж дараа нь гэмт зорилгоор ашиглах) кибер гэмт хэрэг гэж тооцогддог бол хөршийнхөө компьютерт Интернетээр дамжуулан хортой код оруулах замаар бүртгэлийн мэдээллийг нь хулгайлах, эсхүл гэртээ байхгүй үед нь нэвтрэн орж компьютерээс нь эдгээр мэдээллийг хулгайлах нь компьютерийн гэмт хэрэг (Монгол Улсын эрүүгийн хуулиар “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”) гэж зүйлчлэгдэх ёстой.

Кибер гэмт хэрэг гэдэг ойлголттой төстэй цахим гэмт хэрэг, өндөр технологийн гэмт хэрэг, дижитал гэмт хэрэг гэсэн ойлголтууд дэлхий дээр хэрэглэгддэг ч хуульчлагдсан нэр томъёо нь “Кибер гэмт хэрэг”, “Компьютерийн гэмт хэрэг” гэж тогтсон, хүлээн зөвшөөрөгдсөн байна. Харин манай улсын хувьд ойлголтуудыг нарийн ялгаж салгаж үзээгүй улмаас “цахим гэмт хэрэг” хэмээх ойлголтын зөвхөн нэг төрөл болох “цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” хэмээх нэр томъёог ашигласан нь зөвхөн тооцоолох төхөөрөмжид агуулагдаж буй цахим хэлбэртэй мэдээлэл, өгөгдлийн эсрэг гэмт хэргүүд гэсэн явцуу хүрээнд хязгаарлагдсан байна. Энэ нь орчин үеийн кибер гэмт хэрэг, компьютерийн гэмт хэргүүдэд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг үгүй болгож, хэрэг завших, гэмт хэргийг чөлөөтэй үйлдэх боломжийг олгож байна.

Компьютерийн гэмт хэргийн жишээ: Дэлхийн ихэнх улсын компьютерийн гэмт хэргийн тухай хууль, эрүүгийн хуульд дараах хууль бус үйлдлүүдийг компьютерийн гэмт хэрэг хэмээн хуульчилсан байдаг:

- Компьютер, тооцоолох төхөөрөмж, систем, сүлжээнд хууль бусаар хандах;
- Програм, өгөгдөл, мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөх, гэмтээх, ашиглах, задлах, хуулах;
- Вирус, өт, троян гэх мэт хортой кодыг тооцоолох төхөөрөмжийн системд оруулах;
- Компьютерийг залилангийн гэмт хэрэг

үйлдэхдээ ашиглах;

- Бусад этгээд өөрийн тооцоолох төхөөрөмж, компьютертээ хандахад нь хөндлөнгөөс оролцох, саатуулах;
- Гэмт хэрэг үйлдэхийн тулд шифрлэлт ашиглах;
- Тооцоолох төхөөрөмжид хадгалагдаж буй өгөгдөл мэдээллийн эх сурвалж, зохиогч, огноо гэх мэт нарийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, устгах;
- Эмэйлийн эх сурвалж мэдээллийг хуурамчаар үйлдэх, өөрчлөх;
- Үйлчилгээ үзүүлэгчийн аль нэг цахим үйлчилгээг хулгайлах гэх мэт.

Дэлхийн улсуудын Эрүүгийн хууль, компьютерийн гэмт хэргийн тухай хуулиудад сүүлийн үед нэмэлт өөрчлөлтүүд орж кибер гэмт хэрэг хэмээх бүлэг нэмэх, Кибер гэмт хэргийн тухай хууль хэмээн өөрчлөн нэрлэх хандлага бий болсон. Эдгээрт зааж хуульчилснаас харахад дараах кибер гэмт хэргүүдийн жишээг дурдаж болохоор байна:

- Зохиогчийн эрх зөрчих;
 - Хүүхдийн порнограф;
 - Кибер скуаттинг буюу домэйн нэрийг булаан авах
 - Програм хангамжийн эрх зөрчих, булаан дээрэмдэх
 - Хакердах
 - Онлайн залилан
 - Онлайн хулгай
 - Цахим банкны гэмт хэргүүд, салями халдлага
 - Кибер авилга
 - Кибер сүрдүүлэг, доромжлол, гутаалт, мөшгөлт
 - Хувийн өгөгдөл хулгайлах
 - Картинг (картын өгөгдөл хулгайлах)
 - Фишинг (Смшинг, вишинг оруулаад)
 - Фарминг
 - Спам, соёлгүй реклам, зар
 - Мэдээллийн дайн
 - DoS буюу үйлчилгээ бусниулах халдлага
 - Трояны морь, логик бөмбөг
 - Э-скам буюу цахим залилан
 - Ботууд
 - Кибер махчин
 - Онлайн мансуурах бодисын худалдаа
 - Криптовалют олборлохтой холбоотой шинээр үүсэж буй гэмт хэргүүд гэх мэт хэдэн мянган төрөл байна.
- Энэ бүхнээс дүгнэхэд, технологийн хөгжлийн явцад бүх зүйл сүлжээний орчинд шилжиж байгаатай холбоотойгоор



компьютерийн гэмт хэрэг шинэ түвшинд гаран хувьсаж буйг кибер гэмт хэрэг гэдэг нэр томъёогоор илэрхийлэх болсон нь харагдаж байна. Энэ жам ёсоор дараагийн хувьсал нь дижитал гэмт хэргүүдийн хэлбэртэй болох таамаглал үүсэж байна.

Ашиглан шамшигдуулах, залилах, санхүүгийн залилан үйлдэх, хувийн өгөгдөл хулгайлах, мөшгөн дагах гэх мэт уламжлалт гэмт хэргүүд технологийн хөгжил, интернетийг ашиглан арга, хэлбэрээ хувиргах замаар компьютерийн гэмт хэрэг, улмаар кибер гэмт хэрэг болон хувирсаныг эндээс харж болно.

Кибер гэмт хэргийн дараах үндсэн шинжүүдийг тодорхойлон гаргаж болно:

- Кибер гэмт хэргийн зэмсэг нь технологи, кибер гэмт хэрэг нь технологийн ажиллагаа, кибер гэмт хэрэгтнүүд нь Интернет, компьютерийн зохих түвшний мэдлэгтэй технократууд байна.
- Кибер гэмт хэрэг маш хурдан үйлдэгддэг, ихээхэн үр дүнтэй.
- Кибер гэмт хэрэг газар зүйн хязгаарлалт, хил, зайнаас үл хамаарна.
- Кибер гэмт хэрэг кибер орон зайд зайнаас үйлдэгддэг.
- Кибер гэмт хэрэг нь төсөөлөхийн аргагүй хор хохирол учруулж болно.
- Кибер гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах маш хүндрэлтэй, нэгэн зэрэг хэд хэдэн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх боломжтой.
- Кибер гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, мөрдөн шалгахад тусгай мэдлэг, боловсрол, туршлага шаардагддаг.

Кибер гэмт хэргийн өсөлтийн шалтгаан:

Сүүлийн жилүүдэд кибер гэмт хэргүүд уламжлалт гэмт хэргээс тоо, хохирлын хувьд давж гарлаа хэмээн зарим улсад мэдээлж байна. Эрсдэл болон зардал бага, унац ихтэй тэр газарт түүнийг ашиглах гэсэн хүмүүс борооны дараах мөөг шиг олширдог. Яг энэ байдал кибер орон зай, Интернетийн орчинд үүсээд байна. Компьютер, мэдээллийн технологийн багахан ч гэсэн мэдлэг чадвартай, ашиг олохыг хүссэн, шударга бус хэн бүхэн энэ орон зайг ашиглан ашиг олохын төлөө улайран зүтгэх болсон. Түүнээс гадна энэ чиглэлийн эрх зүйн орчин сул, зарим улсад огт бүрэлдэн тогтоогүй, компьютер, тооцоолох төхөөрөмж, програм хангамжид эмзэг сул байдал, цоорхой их

байдаг, байгууллага, хүмүүс мэдээллийн аюулгүй байдлаа хангах, сүлжээ, интернетэд зөв, зохистой ажиллах чадвар, мэдлэг, туршлага муутай, кибер орчинд ул мөр бага үлддэг, нотлох баримт нь тогтвортой бус, бэхжүүлж авахад хүндрэлтэй, хууль хяналтын байгууллагуудын чадвар төлөвшөөгүй, чадварлаг мэргэжилтэн ховор зэргээс илрэх магадлал нь уламжлалт гэмт хэргүүдээс хэд дахин бага байдаг нь кибер гэмт хэрэгтнүүдийн дураараа аашлах боломжийг олгож байна.

Кибер гэмт хэргийн ангилал

Дэлхийн улсуудын Засгийн газар, хуулийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачдын ангилснаар кибер гэмт хэргүүд дөрвөн үндсэн төрөлд ангилагдаж байна:

1. Хувь хүмүүсийн эсрэг чиглэсэн;
2. Өмчийн эсрэг чиглэсэн;
3. Төр, байгууллагын эсрэг чиглэсэн.
4. Нийгмийн эсрэг чиглэсэн

Энэ нийтлэлийн үндсэн зорилго нь өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийг тодорхойлох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга замыг тодруулахад оршиж байгаа учир цаашид өмчийн (өмчлөх эрх) эсрэг кибер гэмт хэргийг илүү тодруулан авч үзнэ.

Хувь хүмүүсийн эсрэг чиглэсэн кибер гэмт хэргүүдийн гол онцлог нь гэмт хэргийн объект, халдлагын зүйл нь хувь хүн, түүний амьдрал, эрх, эрх чөлөө байдагт оршино. Энэ төрлийн кибер гэмт хэрэгтнүүд маш олон янзын арга, техник ашиглан хувь хүмүүст халддаг. Жишээлбэл, цахим шуудангаар залилах, захидал харилцааг дууриалгах, кибер сүрдүүлэг, доог, доромжлол, мөшгөлт, соёлгүй зар, фишинг буюу дэгээдэх (фишингийн улмаас хохирогч мөнгө хөрөнгөө алдаагүй үед, хэрэв алдсан бол өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг болон хувирна), хүүхдийн порно, шунахай зорилгогүй хакердалт, хортой код, кибер гүтгэлэг, IRC (Интернет дамжуулалтын чат), хүмүүс болон мансууруулах бодис онлайнаар худалдах, онлайнаар өгөгдөл, мэдээлэл, хувийн өгөгдлийг хулгайлах, систем, програм хангамжид нь өөрчлөлт оруулах, зүй бус мэдээлэл тараах, тооцоолох төхөөрөмж, компьютер, системийг нь хяналтандаа авах, зомби болгох гэх мэт маш олон хэлбэртэй.

Өмчийн эсрэг чиглэсэн кибер гэмт хэргүүдийн гол онцлог нь бүх төрлийн өмч, түүнийг өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн



байдагт оршино. Эдгээр гэмт хэргийг мөн эдийн засгийн эсрэг кибер гэмт хэргүүд хэмээн нэрлэх нь бий, Гэхдээ эдийн засгийн эсрэг кибер гэмт хэргүүд нь илүү өргөн хүрээтэй ойлголт болно. Энэ төрлийн хэргүүд хэдэн мянган төрөл, хэлбэртэй болсон бөгөөд нийт кибер гэмт хэргийн тал хувийг эзэлж байна. Жишээлбэл, хортой код, логик бөмбөг ашиглан бусдын тооцоолох төхөөрөмжийг эвдлэх, гэмтээх, ажиллагаанаас гаргах, устгах, оюуны өмч хулгайлах, хууль бусаар ашиглах, Кибер скуаттинг буюу домэйн нэрийг булаан авах, Програм хангамжийн эрх зөрчих, булаан ашиглах, цахим банкны салбарт үйлдэгддэг хэдэн арван төрлийн гэмт хэргүүд, онлайн залилан, шунахай зорилготой фишинг, смшинг, интернет хулгай, цахим өмчийн хулгай, интернетийн урсгалын хулгай, net-trespass, дамжуулагч вирус гэх мэт олон зуун төрлийн кибер гэмт хэргүүдийг үүнд хамааруулан үзэж болно. Хэдийгээр ийм олон янзын нэртэй, төрөл бүрийн салбарт үйлдэгддэг боловч ихэнх хэрэг нь онлайн залилан, хөрөнгө ашиглах, эд хөрөнгө авахаар заналхийлэх, далайлгах, төлөөс нэхэх хэлбэртэй байдаг.

Төр, байгууллагын эсрэг чиглэсэн кибер гэмт хэргүүд нь төрийн байгууллага, банк санхүүгийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, компаниуд болон бусад зохион байгуулалттай нэгдэл, аж ахуйн нэгжийн эсрэг чиглэсэн байдаг онцлогтой. Тухайлбал энэ төрлийн кибер гэмт хэргүүд нь хувь хүний эсрэг чиглэсэнээс бусад хакердалт, үйлчилгээ бусниулах довтолгоо, кибер дайн, тагналт, туршилт, кибер терроризм, хорлон сүйтгэх ажиллагаа, хортой кодууд, логик бөмбөг, салями халдлага, тагнуулын програм, цахим захидлын бөмбөгдөлт, байгууллагын систем, серверийн удирдлагыг гартаа авах, мэдээлэл, өгөгдөл хулгайлах, хууль бус програм тараах, харилцаа холбооны үйлчилгээ хулгайлах, кибер бусниулалт, авилга гэх мэт олон төрөлтэй бөгөөд жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Нийгмийн эсрэг чиглэсэн кибер гэмт хэргүүдийн гол онцлог нь нийгмийн сэтгэхүйг бусниулах, ёс зүйг унагах, гутаах, олон нийтийг төөрөгдүүлэх, хагаралдуулах гэх мэт олон янзын хортой сэдэлтэй байдаг. Энэ төрлийн гэмт хэргүүдийн зарим жишээг дурдвал онлайн порнограф, нийгмийн сүлжээн дахь бусниулалт, худал хуурмаг төөрөгдүүлсэн мэдээлэл тараах, сэтгэл

зүйн цифр дарамт, вебийн хакердалт, бохир мэдээллээр өвсөр үеийг хордуулах, зүй бус соёлын довтолгоон хийх, цифр контбанд, өгөгдлийг түр өөрчлөх (data diddling), интернет дахь хууль бус худалдаа, онлайн мөрийтэй тоглоом гэх мэт олон зуун төрөлтэй.

2. Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг

Өмнө дурдсанаар кибер гэмт хэргийг сүлжээгээр дамжин зайнаас үйлддэг учир өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийг компьютер, тооцоолох төхөөрөмж, мэдээллийн сүлжээ, түүний үүсгэсэн кибер орчныг ашиглан үйлддэг гэж хэлж болно. Мэдээж энэ төрлийн гэмт хэргийн төрлийн объект нь эдийн засгийн харилцаа байна.

Өмчлөх эрхийн эсрэг зарим төрлийн гэмт хэргийг кибер орчинд үйлдэх боломжгүй. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 “Хулгайлах” гэмт хэрэг, 17.2 “Дээрэмдэх” гэмт хэрэг, 17.5 “Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж”, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших”, 17.7 “Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах”, 17.9 “Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах”, 17.10 “Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих”, 17.12 “Мал хулгайлах” гэх зэрэг хэргүүдийг кибер орчинд үйлдэх боломжгүй. Харин Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан бусад хэргүүдийг кибер орчинд, зайнаас үйлдэх боломжтой учир эдгээр бүлэг хэргийн нийтлэг тодорхойлолт, шинж, бүрэлдэхүүнийг товчхон тодорхойлсон. Хэдэн зуун төрөл, нэртэй кибер гэмт хэргүүд үйлдэгддэг боловч ихэнх нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан хэргүүдийн үндсэн шинжүүдтэй нийцдэг учир нэр болгоноор нь салган тус тусад нь авч үзэх шаардлагагүй, боломжгүй болно.

Объект, халдлагын зүйл. Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүд зөвхөн мэдээллийн технологи, компьютерийн хүрээн дахь харилцаанд аюул учруулаад зогсохгүй нийгмийн бусад олон харилцаанд аюул учруулдаг. Кибер орчинд нэгэн зэрэг хэд хэдэн төрлийн гэмт хэргийг, өөрөөр хэлбэл нэг, хоёр объектод гэмт хэргийг нэгэн зэрэг үйлдэх боломжтой байдагтай энэ хамааралтай. Юуны өмнө эдийн засгийн болон өмчлөлийн харилцаанд хор хохирол учруулахаас гадна мэдээллийн технологи, компьютерийн салбарын харилцаанд хохирол учруулж байдаг.

Кибер орчинд үйлдэгдэж буй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн бүлгийн объект эдийн засгийн харилцаа байдаг бол



төрлийн объект нь хувь хүн, байгууллагын өмчлөх эрхийн харилцаа болох нь эндээс харагдаж байна. Гэмт хэргийн аргаас хамааран нэмэлт объект нь мэдээллийн технологи, тооцоолох төхөөрөмжийг хууль ёсоор, зөв зүйтэй, зохистой, аюулгүй ашиглах нийгмийн харилцаанууд болон нийгмийн аюулгүй байдал, дэг журам байж болно.

Эрүүгийн хуулийн дагуу авч үзвэл өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдэд онлайнгаар үйлдэгдэж буй залилах (17.3), хөрөнгө завших (17.4), бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх (17.6), Эд хөрөнгө устгах, гэмтээх (17.8), болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх (17.11) зэргийг хамааруулж болно. Банкны салбарт үйлдэгдэж буй төрөл бүрийн кибер гэмт хэргүүд, крипто валюттай холбоотойгоор шинээр гарч ирсэн кибер гэмт хэргүүд, онлайн төлөөс нэхдэг кибер хэргүүд Монгол улсын эрүүгийн хуулинд огт ороогүй байгаа нь гэмт этгээдүүд ял завших боломжийг олгож байна. Монгол Улсын эрүүгийн хуулийн 26-р бүлэгт заасан “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” —үүд нь ихэд хуучирсан ойлголт дээр тулгуурласан, орчин үеийн кибер гэмт хэргүүдийн шинжүүдийг огт зааж оруулаагүй, дээр үеийн компьютерийн гэмт хэргүүдийн зарим шинжийг хуульчилсан байгаа нь Монгол Улс кибер гэмт хэрэгтнүүдийн хувьд диваажингийн улс болж хувирсныг харуулж байна.

Хэдийгээр Эрүүгийн хуульд уламжлалт гэмт хэргүүдийг хуульчилсан боловч ижил төстэй кибер хэргүүдэд ял шийтгэл оноох боломжгүй, төсөөтэй хэрэглэх боломжгүй байна. Түүнээс гадна бодит ертөнцөд үйлдэгдэж буй ижил төстэй хэргүүдээс кибер гэмт хэргийн халдлагын зүйл нь ихэнхдээ ялгаатай байдаг. Кибер орон зай нь виртуаль хийсвэр шинжтэй учир бусдын хөрөнгө завших гэх мэт нийгмийн аюултай үйлдлүүд бодит эд зүйлсийг авахад бус, харин эдийн засгийн ижил үнэ цэнтэй бусад зүйлийг (тухайлбал бусдын итгэмжлэн хариуцуулсан крипто валют, цахим мөнгө, бэлэн бус мөнгө г.м) авч завшихад чиглэгдсэн байна. Үүний зэрэгцээ кибер орон зай нь бусдын компьютер, дэлгэцэн компьютер, гар утас гэх мэт бодит эд зүйлсэд онлайнгаар хандах, хортой код оруулах замаар гэмтээх, логик бөмбөг оруулах замаар бүрэн устгах боломжийг (ЭХ-ийн 17.8) мөн олгодог.

Объектив тал: Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийн объектив талын онцлогууд

нь заавал байх шинжүүдээр (энэ эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн гэмт хэргийн шинжүүдтэй ижил) биш харин нэмэлт шинжүүдээр, тухайлбал арга, байршил, үйлдэх хэрэгслээр тодорхойлогддог. Хамгийн гол ялгагдах шинж нь өмнө дурдсанаар зайнаас үйлдэх арга юм. Эдгээр гэмт хэрэг нь гэмт этгээд болон хохирогч хоорондоо уулзах, учрах боломжгүйгээр, өөр улсаас, гэрээсээ гаралгүй зөвхөн кибер орон зай ашиглан үйлдэгддэг. Зайнаас үйлдэж байна гээд нийгмийн аюул нь багасахгүй. Харин ч илүү аюултай, илүү төлөвлөгдсөн, илрэх боломж багатай байдаг. Тухайлбал итгэл олох, хууран мэхлэх замаар залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхийн тулд янз бүрийн нийгмийн сайтад өөр өөр хуурамч нэрээр бүртгүүлсэн байх, өөр өөр хуурамч нэрээр олон эмэйл хаяг нээлгэж удаан хугацаагаар хүмүүстэй харьцаж, итгэлийг нь олсны дараа төрөл бүрийн үнэмшилтэй шалтгаанаар мөнгө хүсэх замаар гэмт үйлдлээ гүйцэтгэдэг. Ганц нэгхэн хүнийг хууран залилах бус хэдэн мянган хүнийг залилж мөнгө, хөрөнгийг нь шилжүүлэн авч байгаа учир хохирол нь ч их байдаг.

Зайнаас үйлдэж байгаа учир биет ул мөр үлдээдэггүй, зөвхөн логик ул мөр үлдээдэг, мөн өөр улсаас ихэвчлэн үйлддэг, нотлох баримт нь тогтворгүй, амархан устгаж болдог, тэдгээрийг бэхжүүлэн авахд тусгай мэдлэг, програм хангамж, төхөөрөмж шаардагддаг, олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай болдог учир гэмт хэргийг нотлох, гэмт этгээдийг илрүүлэх үйл явц ихээхэн хүндрэлтэй байдаг. Үлдэж буй бараг цорын ганц ул мөр нь IP хаяг байдаг бөгөөд ихэнх гэмт хэрэгтнүүд IP хаягаа хуурамчаар үүсгэж бодит хаягаа нуудаг Anonimizer гэх мэт програмууд ашигладаг учир илрүүлэх боломж улам багасдаг. Түүнчлэн ихэнх гэмт хэрэгтэн үнэгүй WiFi бүхий кафе, талбай, байр орчноос кибер гэмт хэрэг үйлддэг учир MAC хаягаас өөр юу ч үлдэхгүй. Гэмт этгээд уг тооцоолох төхөөрөмж устгасан, хогонд хаясан бол өөр ямар ч нотолгоо үлдэхгүй болдог.

Зайнаас үйлддэг учир хэнд ч танигдахгүй, үзэгдэхгүй учир хохирогч гэмт этгээдийн талаар ямар ч мэдээлэл өгөх боломжгүй, хуурамч зураг, худал өгөгдөлтэй л үлдсэн байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн газар нь Интернет орчин гэж тооцогддог учир ямар улсын хуулийн дагуу шалгах, мөрдөх, хариуцлага тооцох нь тодорхойгүй болдог. Тиймээс хэрэг үйлдсэн газар ач холбогдолгүй



болж хувирдаг. Өнөөдрийн олон улсын практикаар кибер гэмт хэргийн дуусгавар болсон, хохирол учирсан, таслан зогсоосон улсын хуулинд хамааруулж шийддэг болсон. Түүнээс гадна хүний идэвхтэй үйлдэл хийгдсэн газар буюу гэмт хэргийг үйлдэхийн тулд компьютерт өгөгдөл оруулсан газрыг гэмт хэрэг үйлдсэн газар хэмээн тооцох болж байна. Гэхдээ аль ч тохиолдолд Монгол Улсын эрүүгийн хуулиар энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх, ял шийтгэл оноох үндэслэл тун муу байна.

Кибер орон зайд хандах боломжийг олгож буй тооцоолох төхөөрөмж (компьютер, планшет, гар утас г.м) нь туслах хэрэгсэл гэж тооцогддог, яагаад гэвэл кибер орон зайд хандахгүй тохиолдолд тэдгээр төхөөрөмж ач холбогдлоо алддаг.

Субъектив тал: Эдгээр бүх кибер гэмт хэргийг шууд санаатай үйлддэг. Арав гаруйхан жилийн өмнө өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргийн 66 хувь нь шунахай сэдэлтэй байсан бол 2016 он гэхэд 98 хувь нь шунахай сэдэлтэй болсон байна. Үүнээс харахад энэ төрлийн гэмт хэрэг тун удахгүй 100% шунахай сэдэлтэй болох нь тодорхой. Өнөөдөр цахим банкууд хөгжиж, мөнгө хөрөнгө кибер орон зайд шилжиж, цахим түрийвч мөнгө, крипто валют хөгжиж байгаа нь энэ төрлийн кибер гэмт хэргүүд улам олширч, арга техник нь хөгжих таамаглалыг бий болгож байна. Тиймээс Монгол Улсын эрүүгийн хуулинд эдгээр гэмт хэргийг нэн даруй хуульчлан тусгах шаардлага харагдаж байна.

Субъект. Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийн субъект нь уламжлалт гэмт хэргийн субъектуудаас онцын ялгаагүй. Зөвхөн МТ, компьютерийн зохих хэмжээний мэдлэг, боловсрол, туршлага, хэрэглээний чадвартай хүмүүс байдгаараа ялгагддаг.

Энэхүү нийтлэлийн зорилго нь өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргийн талаар үндсэн ойлголт өгөх, ухааруулах, хуралд илтгэл тавих зорилготой, цаг хугацаанд хязгаарлагдсан учир өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг бүрийг задлан авч үзэх, эрүүгийн хуулинд нэмж оруулах заалтуудыг томъёолох боломжгүй.

3. Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргээс сэргийлэх

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүд дэлхий даяар эрс хурдтай нэмэгдэж байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргээс зөвхөн сэргийлэх төдийгүй түүнийг сөрөн зогсох, хариу үйлдэл хийх шаардлагатай болж байна.

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийг үүсэн түүх, үндсэн төрөл, шалтгаан, нөхцлийг судалсны үндсэн дээр түүний эсрэг сөрөн зогсох, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг Монгол Улс хэрэгжүүлж болохоор байна. Эдгээр арга хэмжээ нь дараах зориулалттай:

- Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийн шалтгааныг сулруулах, арилгахыг оролдох;
- Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргийг үйлдэхэд түлхэж, хөнгөвчилж, сэдэлжүүлж буй нөхцөл байдлыг илрүүлэх, арилгах;
- Эрүүгийн өндөржүүлсэн эрсдэлтэй этгээдүүдийг илрүүлэх, энэ эрсдлийг бууруулах;
- Эдгээр эрсдэлтэй этгээдүүдэд чиглэсэн тогтоон барих, хязгаарлах нөлөөллийг хэрэгжүүлэх;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхийг бий болгох.

Үйлчлэх нөлөөллөөр нь эдгээр арга хэмжээг дараах гурван бүлэгт хувааж болно:

1. Эрх зүйн;
2. Зохион байгуулалтын;
3. Криминологийн.

Эрх зүйн арга хэмжээ нь өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргийн нэг үндсэн нөхцөл болох эрх зүйн зохицуулалтгүй байдал, эсхүл хууль тогтоомж боловсронгуй бус байдлыг арилгахад чиглэгдэнэ. Энд олон улсын зохицуулалт бий болгох, гэрээ конвенциудад нэгдэн орох, бусад улсын зохицуулалтыг боловсронгуй болгох, үндэсний хууль тогтоомж, эрх зүйн акт, заалтуудыг бий болгох, олон улсын зохицуулалттай нэг мөр болгон уялдуулах, эрүүгийн хариуцлага ноогдуулах үндэслэлийг бусад улстай нэг мөр болгон уялдуулах зэрэг олон арга хэмжээ багтаж болно. Эрх зүйн арга хэмжээ нь зохион байгуулалтын арга хэмжээтэй салшгүй холбоотой байна, яагаад гэвэл хууль тогтоомжийн биелэлтийг эдгээр арга хэмжээгээр дамжуулан хангана.

Зохион байгуулалтын арга хэмжээнд удирдан зохион байгуулах, төлөвлөх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө, нөөцөөр хангах зэрэг олон ажиллагаа багтахтаас гадна энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, шалгах, шийдвэрлэх үндэсний чадварыг бий болгох арга хэмжээ хамаарагдана. Энэ дундаас үндэсний чадвар бий болгох арга хэмжээ онцгой чухал ач холбогдолтой. Юуны өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч



нарт кибер гэмт хэргийн тухай мэдлэг, олгох, мөрдөн шалгах, нотлох чадвар төлөвшүүлэх сургалтууд зохион байгуулах, цагдаагийн хэлтэс, газар бүрт дижитал нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх тусгай чадвартай мэргэжилтний орон тоо бий болгож ажиллуулах, компьютерийн техникийн криминалистик шинжилгээний үндэсний лабораторийг Шүүхийн шинжилгээний үндэсний төвд, жижиг төвүүдийг нийслэл, аймагт бий болгох, үүрэн холбоо, интернетийн орчинд халдагчийг даруй мөшгөх, илрүүлэх техникийн тогтолцоог бий болгох, тусгай техник хэрэгсэл, програм хангамжаар хангах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Криминалогийн арга хэмжээнд кибер гэмт хэргийг тодорхойлогч хүчин зүйлс, тухайлбал кибер гэмт хэрэгтнүүдийн үл танигдах байдал, хил хязгааргүй шинж, хүн амын дунд мэдээллийн аюулгүй байдлын соёл төлөвшөөгүй байдал, кибер гэмтнүүдийн дэд соёл гэх мэт хүчин зүйлсийг бууруулах, зохистой болгоход чиглэгдсэн арга хэмжээнүүдийг багтааж болно.

Криминалогийн арга хэмжээ нь үндэсний стратеги бий болгох, хүн амын дундах мэдээллийн аюулгүй байдлын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, зөв, зохистой, аюулгүй хэрэглээний чадварыг төлөвшүүлэх, байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хяналт, эрсдлийн үнэлгээг бий болгох, технологийн хамгаалалт, хяналтууд хэрэгжүүлэх, мэдээллийн технологийг боловсронгуй болгох, энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх аргачлалыг хөгжүүлэх гэх мэт саналуудыг агуулж болно.

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдтэй тэмцэхийн тулд хэрэгжүүлж буй арга хэмжээг эсэргүүцэн нөлөөлж буй объектоор нь нийгмийн болон техникийн арга хэмжээ хэмээн хувааж болно.

Нийгмийн арга хэмжээ нь кибер орон зайн хэрэглэгчид болох иргэдийн нийгмийн чанарыг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын соёл, мэдээллийн мэдлэгийг хөгжүүлэх, хакеруудын дэд соёлыг арилгахад чиглэгдэнэ.

Нийгмийн арга хэмжээг үйлчлэн нөлөөлж буй аргаар нь мөн адил эрх зүйн болон криминалогийн хэмээн хуваана.

Мэргэжилтнүүдийн дүгнэж байгаагаар өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргүүдийг тусгай техник хэрэгслийн тусламжтайгаар илрүүлж, урьдчилан сэргийлж болно.

Техникийн арга хэмжээ нь хамгаалж буй объектийн шинж, онцлог болон хамгаалалтын хэрэгслийн зохион байгуулалт, суурилуулалт, тохируулгаар тодорхойлогдоно. Техникийн арга хэмжээ нь хамгаалалтын технологийг хөгжүүлэх, үндэсний антивирусын програм боловсруулах, дараа үеийн төхөөрөмж, галт хана, халдлага илрүүлэх системийг байгууллагуудад суурилуулах, интернетийн хэрэглэгчдийн үл танигдах шинжийг багасгахад чиглэгдэнэ.

Үндэсний шинжтэй дээрх арга хэмжээнээс гадна практик амьдралд мэдээллийн аюулгүй байдлын 5P-ийн буюу Precaution – анхаарал болгоомж, Prevention – урьдчилан сэргийлэлт, Protection – хамгаалалт, Preservation – хадгалалт болон Perseverance – тууштай байдал зарчмыг даруй нэвтрүүлэн төлөвшүүлэхэд төр, бизнесийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сургууль, их дээд сургуулиуд, иргэд хүчин зүтгэх хэрэгтэй болоод байна.

Дүгнэлт

Хүний оюун ухаан хязгааргүй. Мэдээллийн технологи хөгжихий зэрэгцээ кибер гэмт хэрэг даган өсөж, илүү нарийн төвөгтэй, шинэ төрөлтэй болон хувирч байгаа бөгөөд түүнийг ул мөргүй арилгах ямар ч боломжгүй. Ямар ч хууль тогтоомж, цогц арга хэмжээ гэмт үйлдлийг таслан зогсоож арилгаж чадахгүй ч тэдгээрийг үр дүнтэй, зөв зүйтэй хэрэгжүүлж чадсанаар кибер гэмт хэргүүдээс сэргийлж, сөрөн зогсож чадна.

Кибер гэмт хэрэгтнүүд технологийн ололт амжилтыг өөрсдийн гэмт зорилгод нийцүүлэн ашиглаж байгаа учир хууль, хяналтын байгууллагууд энэ төрлийн гэмт хэргийн эсрэг сөрөн зогсох, сэргийлэхэд бэлэн, түүнд сайн бэлтгэгдсэн байх ёстой. Гэмт хэрэгтнүүдээс хуулийн байгууллага байнга хоцорч буй энэ зохисгүй байдлыг арилгахын төлөө бүгд хамтрах шаардлагатай болжээ.

Кибер гэмт хэрэг нь компьютерийн гэмт хэргийн бие даасан шинэ төрөл, ахисан түвшин болон гарч ирсэн.

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг гэж өмчийн харилцаанд хор хохирол учруулу буй, мэдээллийн сүлжээ, тооцоолох төхөөрөмж ашиглан, кибер орон зайд зайнаас үйлддэг гэмт хэргүүдийг хэлж болно. Энэ төрлийн гэмт хэрэг нь Интернетийн орчинд хамгийн өргөн тархсан гэмт хэргүүд болсон.

Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэргийн



өсөлтийн үндсэн шалтгаан, нөхцөл нь кибер орон зайг ашиглагчдын үл танигдах шинж, сүлжээний үл танигдах шинж, хил хязгааргүй шинж, кибер орон зайн хамгаалалтын дутагдалтай шинжүүд, байгууллага, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын ойлголт, удирдлага, хяналт, хамгаалалтын хангалтгүй түвшин, эрх зүйн зохицуулалт, хамгаалалтын боловсронгуй бус байдал, хууль хяналтын байгууллагуудын хоцрогдол, мэргэжилтнүүдийн дутагдалтай байдал, кибер гэмт хэргийн илрүүлэлт муу байдагт оршиж байна.

Энэ бүхэн дээр дүгнэн тулгуурлаж эрх зүй, зохион байгуулалт, криминологийн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

Ашигласан материал:

- “Методология расследования компьютерных преступлений” PhD thesis. Т.Халтар. Москва, 1999
- “Дижитал шилжилтийн эриний мэдээллийн аюулгүй байдлын шинэ хандлага” – Т.Халтар. 2018
- “Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах” – Т.Халтар. 2016
- “Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын үзэл баримтлал” – Т.Халтар. 2008
- FBI training FIA officers on cyber crime, By A Khan, Thursday, September 30, 2004, / www.dailytimes.com.pk/default.asp?date9/30/2004%208:02:35%20PM
- Law and The Internet - Regulating Cyberspace, edited by Lillian Edwards and Charlotte Wealde, Oxford: Hart Publishing, 1997
- Computer Security Institute - CSI/FBI Computer Crime and Security Survey, 2001 - <http://www.gocsi.com/prelea/000321.html>
- Harassment Law in the UK - Neil Addison at: <http://www.harassment-law.co.uk/msindex.htm>
- The European Union On-Line: - http://europa.eu.int/rapid/start/cgi/guesten.ksh?p_action.gettxt=gt&doc=IP/01/273|0|RAPID&lg=EN
- Council of Europe Publishing - <http://conventions.coe.int/>
- Siemens Communications Limited - <http://www.siemenscomms.co.uk/>
- Her Majesty's Stationery Office - <http://www.hmsso.gov.uk/>
- The Copyright Licensing Agency Ltd - <http://www.cla.co.uk/>

- The University of Texas System - <http://www.utsystem.edu/ogc/intellectualproperty/napster.htm>
- Internet Watch Foundation - <http://www.iwf.org.uk/>
- The Joint Information Systems Committee (JISC) - <http://www.jisc.ac.uk/>
- University of Miami website- <http://www.miami.muohio.edu/>
- University of Denver website - <http://www.du.edu/>
- A. Koryagin, Computer and internet technologies crimes: urgency and problems of fighting with them. - <http://www.crime-research.ru/library/Koragin.html>
- V. Golubev, Investigating Computer crime / Monograph - Zaporozhye: University of Humanities “ZIGMU”, 2002
- T. Tropina, Cyber criminality and terrorism, - <http://www.crime-research.ru/library/Tropina.html>.

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ЯВДЛЫН СУУРЬ ШАЛТГААН, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Г.Оюунболд

УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн
судлаач, хяналтын прокурор

Нэг.Үндэслэл

Хүн хамтын хэлбэрээр амьдарч эхэлсэн цагаас амьдарлын хэрэгцээ, шаардлагын үүднээс зарим тохиолдолд шударга бус аргаар өмч хөрөнгө эзэмшиж хэрэгцээгээ хангаж байв. Өмчлөх эрхийн эсрэг гэмт явдал гэдэг нь /crime against property/ нь хүний өмч хөрөнгийн эсрэг идэвхитэйгээр хүч хэрэглэхгүйгээр болон хүч хэрэглэн халдсан үйлдлийг^[58] ойлгоно.

Суурь нөхцлийг үзвэл^[59] хүнд янз бүрийн хэрэгцээнүүд байх бөгөөд анхдагч хэрэгцээгээ нөхөж байж дараа нь дунд, дээд шатны хэрэгцээгээ хангадаг (Maslow,1970,1987). Мөн хүн өөрийн суурь хэрэгцээгээ хангах явдал нь эрүүл саруул, сэтгэл хангалуун амьдрах амьдралын гол нөхцөл болдог гэж үзээд амьдралын амин гол хэрэгцээний байнгын хомсдол дутагдал нь хүний биологийн түлхээсийг идэвхжүүлэх ба өөрөөр хэлбэл шунахай, түрэмгий, харгис хэрцгий зан, уур хилэнг хөдөлгөдөг гэжээ.



^[60]Физиологийн ба аюулгүй байдлын хэрэгцээ нь доод шатлалд хамаарах бөгөөд эдгээр хэрэгцээг хангасны дараа нийгмийн гишүүн болж өөрийн хувь нэмрээ оруулдаг байна. Нүүдлийн соёл иргэншлээс суурин

соёл иргэншилд шилжих явцад гэмт явдлын төлөв, байдал гэмт зан төлөв, ахуйн онцлогоос шалтгаалж өөрчлөгдсөн бөгөөд, энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжихэд огцом ажиглагдсан билээ. Гэтэл бид энэ явцад нийгмийн суурь болох “хүнийг төлөвшүүлэх, мэдлэг олгох” ажлыг орхигдуулснаас нийгэмд гэмт зан үйл үүсэх, улмаар энэ нь нийт массыг хамрах нөхцлийг бүрдүүлсэн байж болох талтай байна. Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлээр Монгол Улсын хэмжээнд хууль сахиулах байгууллагын түвшинд “шүдний өвчин” болсон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бодит суурь шалтгааныг тодорхойлж, түүнтэй тэмцэх, эртнээс урьдчилан сэргийлэх арга замыг дэвшүүлэхийг зорилоо.

Хоёр. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан

Монгол Улсын хэмжээнд гэмт явдлын төлөв байдлын талаар хоёр удаагийн томоохон хэмжээний криминологийн суурь судалгаа хийгдсэн бөгөөд 1994-2004 он болон /ХЗДХЯ, ХЗҮХ, ЭЗККС.2005 он/ 2005-2015 онуудыг /ХЗДХЯ, ГХУСА33, МКХ.2017 он/ дээрх судалгаануудын дүнгээс үзвэл “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” нийт гэмт хэргийн 35-40 орчим хувийг тогтмол эзэлж, цаашид буурах шинжгүй байна.

Хоёр ч удаагийн үечлэлтэйгээр тус тусдаа хийсэн дээрхи судалгааны дүгнэлт, зөвлөмжид гэмт хэргийн суурь шалтгааныг дурдсан боловч шийдвэрлэх арга замыг ажиглалтаар, ядууралтай тэмцэх гэх мэтээр хэт ерөнхий, макро түвшинд тодорхойсноос энэ нь “мөнхийн асуудал” болж хувирсан аж.


Шунахай сэдэлтээр үйлддэгддэг онцлогтой энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ иргэдэд ухуулга, сурталчилгаа хийх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч камержуулах зэрэг “гал унтраах шинжтэй” уламжлалт аргуудыг хэрэглэдэг боловч энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурахгүйгээр барахгүй илүү олон төрөл, хэлбэрт шилжиж байна. Үүнээс үзвэл бидний хэрэглэж байгаа урьдчилан сэргийлэх арга зам үр дүнд хүрэхгүй, бодит нөлөөлөл болж чадахгүйг илтгэнэ.

⁵⁸ Эрүүгийн загвар хууль, 2007 он /Model Criminal Code/

⁵⁹ Батболд Ш. Сэтгэл судлал, сонгодгууд. УБ. 2010. 121 дэх тал

⁶⁰ Мөн тэнд 122 дахь тал

График VII.11.3. 2010 оноос 2015 он хүртэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн дундаж тоо



Хүснэгт VII.11.2.3. 2010 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн тоо, хувь хэмжээ

Гэмт хэрэг	2010	2011	2012	2013	2014	2015	Дундаж тоо	Хувь хэмжээ
Бүртгэгдсэн гэмт хэрэг-Бүгд	19,825	19,197	22,089	25,362	27,318	27,757	23591	
Өмчлөх							10219	100.0%
Хулгайлах	5,777	5,276	6,266	7,884	8,424	9,169	7133	69.8%
Залилан мэхлэх	764	688	1,098	1,231	1,843	2,067	1282	12.5%
Дээрэмдэх	520	536	552	620	686	537	575	5.6%

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн^[61] 80 орчим хувийг хулгайлах, залилах гэмт хэрэг эзэлдэг тул дээрхи хоёр төрлийн гэмт хэргийн жишээн дээр судлан буй асуудлыг тодорхойлохыг оролдоё. Өөрөөр хэлбэл хулгайлах, залилах гэмт хэрэг нь түгээмэл үйлдэгддэг хэрэгт хамаарч Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдалд шууд нөлөөлдөг гэдгийг бид бүхэн мэдэх билээ.

Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2016 оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өсч үүнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт 4,840 (36.3%), голлон нөлөөлжээ.

“Хэдийгээр гэмт хэрэг өссөн үзүүлэлттэй байгаа боловч гэмт хэргийн статистик үзүүлэлт, цагдаагийн байгууллагын танилцуулгаас үзвэл гэмт хэргийн шинжтэй тохиолдол бүрийг бүртгэж, шинээр гэмт хэрэгт тооцогдсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хулгайлах, гэмтэл учруулах гэмт

⁶¹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. Хамтын бүтээл. ХЗДХЯ, ГХУСАЗЗ, МКХ.2017

хэргийн шинжийг тодорхой болгож, нуугдмал гэмт үйлдлээ ил гаргаж тэмцэж эхэлсэнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл хуулийн шинэчлэлээс хамаарч нуугдмал гэмт хэргийн гаралтыг бодитоор үнэлж, түүнтэй үр дүнтэй тэмцэх бодлого үнэн зөв тодорхойлох боломжийг олгож байгаа нь сайн тал” гэж^[62] бодлого тодорхойлогч үзэж байна.


2.1.Хулгайлах гэмт хэргийн суурь шалтгаан

Зах зээлийн тогтолцоонд шилжсэн 1990-өөд оны өөрчлөлтийн дараагаар бусдыг хулгайлах гэмт хэрэг огцом ихсэж, хүмүүсийн зах зээлийн нийгмийн шилжилтийн үр дагаварыг амсаж, ядуурч хоосорсон ажилгүй болсон хүмүүс ямар ч хамаагүй аргаар амьдрахын тулд гэмт хэрэг үйлдэх зам руу орсон байна. Энэ үед хулгайлах гэмт хэрэг 2.5 дахин нэмэгдэж, цагдаагийн

⁶² Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар танилцуулга.



байгууллагын хүч, нөөц дутагдаж байса



Зураг.100.000 хүн амд ногдох хулгайлах гэмт хэрэг сүүлийн 15 жилээр

Криминологийн судалгааны дүгнэлтээр^[63] амьдарлын боломж тааруу, өсвөр наснаас идэр залуу насны, эрхэлсэн ажилгүй хүмүүс хулгайлах гэмт хэргийг үйлдэж байгааг нотолж дүгнэсэн боловч тэр хүмүүс чухам яагаад хулгай хийгээд байгаа тухай дурьдаагүй байдаг.

Эд материалын болон амьдралын таагүй нөхцөл байдлын улмаас бие хүний ирээдүйдээ итгэх итгэл нь алдагдах, шунахай сэдэл бий болж амьдарлын төлөө яасан ч яадаг юм гэсэн санаа бодол тогтох хүртэл гэмт зан үйл хэрхэн бүрэлдэх үйл явцыг хэлээд байгаа хэрэг. “Олсон хүний олз, хаясан хүний хаяз” гэхчилэн гэмт зан үйлийг төрүүлэхүйц хэлц нь яваандаа эзэнгүй байгаа эд зүйлийг ямар ч шалтгаангүйгээр өөрийн өмчлөлдөө авахад хүргэдэг зан үйлийг суулгадаг нь үнэн. Хулгайлах гэмт хэргийн хувьд 100 мянган хүнд ногдох гаралтаар дэлхийд тэргүүлэх хэмжээнд эрэмблэгддэг^[64] бөгөөд зарим улс оронд “хулгайч үндэстэн” хэмээн нэрлэж байгаа нь эмзэглэм тохиолдол мөн. Хулгайлах гэмт үйлдэл гаргадаг хувь хүн бүрдэх учир шалтгааны ухан үзвэл дараахь нөхцөл тодорхойлогдоно. Үүнд:

1.Гэр бүлийн суурь хүмүүжил хангалтгүй байна. Тухайлбал, хүүхдийг хүмүүжүүлэхдээ бусдыг хүндэтгэх, хайрлах талаар муу зан үйл хийж болохгүй талаар хүмүүжүүлэхгүй зөвхөн өөрийгөө хамгаалах талаар буруу арга барил заах, түүнийг өөгшүүлэх хандлагатай хувь хүн болгон өсгөж байна.

⁶³ Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. УБ. 2011. ЦЕГ

⁶⁴ https://www.numbeo.com/crime/rankings_by_country.jsp сайтаас үзвэл 2018 оны байдлаар манай улс гэмт хэргийн гаралтаар 16 дугаар байранд явж байна.

2.Боловсорлын тогтолцооны гажуудлаас хамаарч зөвхөн заах сургах явцад анхаарал хандуулж зөв хандлагатай хувь хүн болгож сургах үйл явц бүхэлдээ орхигдсон. Энэ нь сургуулийн өмнөх боловсрол /СӨБ/ болон бага дунд боловсорлын явцад ихээхэн ажиглагддаг бөгөөд тодорхой хувь хүн бүрэлдсэн хойно нь хичнээн арга хэмжээ аваад ч гэмт зан үйлийг өөрчлөх боломжгүй гэдгийг бид мэдэх билээ.

3.Хүүхдийг өсч хүмүүжих, чөлөөт цагаа зарцуулах тодорхой орчин байхгүйгээс нэгнээсээ сөрөг зан үйлд суралцаж байна.

Гэтэл дэлхий дахинд хөгжиж буй болон өндөр хөгжилтэй улс орны тухайд хулгайлах гэмт хэргийн асуудлыг хэдийн шийдсэн бөгөөд цөөн тоотой гарч бүртгэгддэг аж.^[65] Үүний гол шийдэл хувь хүнээс хамаарсан суурь шалтгааныг бодитой олж тогтоосны үндсэн гэмт зан үйлийг төлөвшүүлэхгүй байх, дархлаатай хувь хүнийг бий болгоход чиглэсэн нийгмийн шинжтэй цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэнд байна. Энэхүү арга хэмжээ нь хамгийн багадаа 10-20 жилийн дараа үр дүнгээ өгдөг бөгөөд урт хугацааны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогод хамаардаг.

2.2.Залилах гэмт хэргийн суурь шалтгаан


Сүүлийн жилүүдэд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн гаралт, учруулсан хохирол жил дараалан байнга өсч, үйлдлийн арга нь улам нарийсч, зохион байгуулалттай үйлдэгдэх хандлагатай болж байна. Тухайлбал, урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцэл хийх замаар халхавчилж, эсхүл олон шатлалт маркетинг, пирамид сүлжээний аргаар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж

⁶⁵ Jianhong Liu, □Bill Heberton, □Susyan Jou “Handbook of Asian Criminology”


байна.^[66]

Урьд өмнө зөвхөн хувь хүн энэ төрлийн гэмт хэргийн халдлагад өртдөг байсан бол өнөө цагт хувь хүмүүсийн хүрэнээс хальж байгууллага, аж ахуйн нэгж цаашилбал, улс орон дамжин үйлдэгдэх болсон.

График VII.11.2. 2010 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн өсөлт



Залилах гэмт хэрэг нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин нь сүүлийн 10 жилийн дунжаар авч үзвэл 1084 буюу 4.8 хувь байгаа бөгөөд төв суурин газар гол төлөв үйлдэгдэж байна.



Хүснэгт VII.11.1. 2006 оноос 2015 он хүртэл бүртгэгдсэн нийт гэмт хэрэг болон залилан мэхлэх гэмт хэргийн тоо

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Дундаж тоо
Нийт гэмт хэрэг	18,253	21,268	20,704	20,373	19,825	19,197	22,089	25,362	27,318	27,757	22215
Залилан мэхлэх	669	816	866	801	764	688	1,098	1,231	1,843	2,067	1084
Хувь хэмжээ	3.67%	3.84%	4.18%	3.93%	3.85%	3.58%	4.97%	4.85%	6.75%	7.45%	4.88%

Урьд хийгдсэн криминологийн судалгаагаар “залилах” гэмт хэргийн суурь шалтгааныг иргэдийн гэнэн итгэмтгий байдал, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэтгэлгээ, хууль бус зар сурталчилгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна гэж тодорхойлсон боловч нийгэм эдийн засгийн болон хувь хүнээс үүдэлтэй суурь шалтгааныг үндсэндээ дурдаагүй байх юм. Залилах гэмт шалтгааныг тодруулсан судалгааны ажлаас болон шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн судалгаанаас үзвэл дараахь үндсэн суурь шалтгаан тодорхойлогдоно. Үүнд:

1.Иргэдэд иргэний эрх зүй, эдийн, санхүүгийн суурь мэдлэг дутмаг байгаагаас заилан мэхлэх гэмт хэрэгт өртөж байна. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах явцад энэ тухай хөндөгдсөн бөгөөд Иргэний хуульд хувь хүн мөнгө хүүлэх, зээл олгох үйл ажиллагаа явуулах эрхгүй байхаар зохицуулалт оруулсан боловч хожим нь энэ заалтыг Үндсэн хуулийн цэц хэлэлцэж ҮХ зөрчсөн гэж дүгнэсэн билээ.

2.Худалдаа үйлчилгээ, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө зуучлал зэргийн талаар суурь мэдлэггүйгээс хувь хүн өөрөө дур мэдэн хувь хүнээс зээл авах, зээлэх, эсхүл өөрийн ⁶⁶ ЦЕГ-аас зохион байгуулсан “Олон шатлалт, маркетинг, пирамид сүлжээний аргаар үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх нь” эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг.2018 он



үл хөдлөх хөрөнгөө эрсдэл үл харгалзан зарж борлуулах гэх зэргээр залилан мэхлэх гэмт хэрэгт ихээр өртөж байна. Дэлхий дахинд санхүүгийн суурь ойлголт, мөнгөтэй харьцах чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ гээч зүйлийг сургуулийн боловсролоор олгодог бөгөөд наад захын санхүүгийн эрсдэлийг тооцох чадвартай хувь хүн бий болсон цагт залилан мэхлэх гэмт хэрэгт жам ёсны дагуу буурдаг аж.

Гурав. Өмчлөх эрхийн эсрэг гэмт

явдлаас урьдчилан сэргийлэх арга зам

Орчин үеийн криминологийн чиг хандлага^[67] нь гэмт зан үйлийн уг гарвал, гэмт хэргийн карьер^[68] өсөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийн тухай илүү гүнзгий судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг нийгмийн хөгжилтэй уялдуулан тодорхойлж байна.

Үүнийг хийхдээ нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга^[69] зүйгээр явуулах шаардлагатай / crime prevention through social development/ Тухайн улс, орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа нийгмийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө эсхүл зорилтот бүлгүүдэд чиглэсэн ажил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тусламж дэмжлэгт тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг хэлэх бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах боломжтой байдаг.

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Энэ нь нийгмийн суурь асуудлыг шийдвэрлэх, хувь хүнийг бүрэлдэж бий болгоход нөлөөлөх, боловсрол хүмүүжлээр дамжуулж нөлөөлөх үндсэн зорилготой байх бөгөөд үр дүн нь зөвхөн гэмт хэргээс сэргийлээд зогсохгүй нийгмийн хөгжилд дорвитой нөлөөлдөг.

2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн төслийг боловсруулж байгаатай зэрэгцэн болвсрол, гэр бүлийн тухай хуульд суурь зохицуулалт оруулж гэмт хэрэгтэн бие хүн, гэмт зан үйлийг арилгах чиглэлд анхаарах

3. Өргөн нэвтрүүлэг, соёлын харилцааг хөгжүүлэхдээ урт хугацааны зорилтот суурилах зэрэг бөгөөд эдгээр хэт өргөн

сонсогдож болох боловч бүхэл бие хүн болж төлөвших нэг үе буюу 10-20 жилийн үр дүнгээ өгдөг арга хэмжээ юм. Хэрэв энэ арга хэмжээг бид хийж чадвал гэмт хэргийн гаралт наад зах нь 2 дахин багасгах боломжтой бөгөөд хууль сахиулах байгууллагын ачаалал буурч, ердийн горимоор ажиллах боломжтой болж нийгмэд шудрага ёс бэхжинэ гэж үзэж байна.

⁶⁷ Clive R.Hollin "Criminal Behaviour: A physiological approach to explanation and prevention". 1992 and 2001

⁶⁸ Alfred Blumstein "Criminal Careers and Career Criminals" 1986

⁶⁹ UNODC, "Handbook on the crime prevention guidelines. Making them work. 2010



НИЙСЛЭЛИЙН ХОТЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДСЭН ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ш.Мөнхбат


НЦГ-ийн Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн эрүүгийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл хулгайлах гэмт хэрэг нь Монгол Улс дахь гэмт явдлын бүтцэд дангаараа 31.34 хувийг эзэлж, нийт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 53 хувь нь Улаанбаатар хотод, 47 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа шунахайн сэдэлтэй нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.^[70]

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 28206 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7794 буюу 27.6 хувь нь хулгайлах төрлийн гомдол, мэдээлэл, 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна^[71]. Бүртгэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байна.

Хулгайлах гэмт хэргийн 2688 буюу 81.6 хувийг хувийн өмчийн хулгай, 450 буюу 13.6 хувийг халаасны хулгайн гэмт хэрэг, 19 буюу 0.5 хувийг мал хулгайлах, 109 буюу 3.3 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Хулгайлах гэмт хэрэг, нийт хэрэгт эзлэх хувийг цагдаагийн хэлтэс тус бүрээр нь графикаар үзүүлвэл:



Хулгайлах гэмт хэргийг гарсан газраар нь авч үзвэл:

Гэр орон сууцанд нийт хэргийн 1546 буюу 46,9 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэг гарсан газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Гэрт	458	29,6
2	Орон сууц байр	293	18,9
3	Зуслангийн байшин буюу хаус	70	4,5
4	Хувийн байшин	553	35,7
5	Нийтийн байр	60	3,8
6	Граж	16	1,0
7	Амбаар агуулах	17	1,0

⁷⁰ Б.Болдбаатар Бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал”. УБ 2004 он. 84-86 дахь тал

⁷¹ Нийслэлийн цагдаагийн газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ



8	Орц подвальд	28	1,8
9	Бусад газар	39	2,5
10	Нийт	1546	46,9

Гудамж талбайд нийт гэмт хэргийн 604 буюу 18,3 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэг гарсан газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Гэр хорооллийн гудамж	71	11,5
2	Орон сууцны хорооллийн гудам	160	26,4
3	Ил зогсоол	166	27,4
4	Автобусны буудал	117	19,3
5	Бусад газар	90	14,9
6	Нийт	604	18,3

Олон нийт газар нийт хэргийн 558 буюу 16,9 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэг гарсан газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Нийтийн зах, үзвэрийн газар, бөөний худалдааны төв, дэлгүүр, түүц	265	47,4
2	Зочид буудал	74	13,2
3	Саун баар	79	14,1
4	Зоогийн газар ресторан	34	6,9
5	Бусад	107	19,1
6	нийт	558	16,9

Нийтийн тээвэрт нийт хэргийн 68 буюу 2,0 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэг гарсан газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	том оврын автобусанд	48	70,5
2	микро автобусанд		
3	таксид	9	13,2
4	Бусад	5	7,3
5	Нийт	68	2,0

Төрийн байгууллагад нийт хэргийн 12 хэрэг буюу 0.03 хувь, төрийн бус байгууллагад 23 хэрэг буюу 0.6 хувь, аж ахуйн нэгжид 264 хэрэг буюу 8.0 хувь, бусад газар 212 хэрэг буюу 6.4 хувийг нь эзэлж байна.

Гэмт хэргийг гарсан цаг, гарагаар нь авч үзвэл:

Гэмт хэргийн 876 буюу 26.6 хувь нь 06:00-14:00 цагт, 1094 буюу 33.2 хувь нь 14:00-19:00 цаг буюу ажлын цагаар, 467 буюу 14.1 хувь нь 19:00-22:00 цагт, 856 буюу 25.9 хувь нь 22:00-06:00 цагт буюу шөнө оройн цагаар үйлдэгдэж, 512 хэрэг буюу 15.5 хувь нь даваа гарагт, 523 хэрэг буюу 15.8 хувь нь мягмар гарагт, 480 хэрэг буюу 14.5 хувь нь лхагва гарагт, 479 хэрэг буюу 14.5 хувь нь пүрэв гарагт, 486 хэрэг буюу 14.7 хувь нь баасан гарагт, 430 хэрэг буюу 13.0 хувь нь бямба гарагт, 383 хэрэг буюу 11.6 хувь нь ням гарагт бүртгэгдсэн байна.

Хэрэг бүртгэлтийн 3257 хэргээс 162 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 5.0 хувьтай. Урьд оны мөн үетэй харьцуулахад илрүүлэлт -40.2 хувиар буурсан.



Нийслэлийн хэмжээнд	ЭХ-ийн 17.1-р зүйлд заасан гэмт хэрэг							
	Бүх хэрэг		Хэрэг бүртгэлтийн хэрэг		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг		Илрүүлэлт хувь	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
	1345	3293	1306	3257	590	162	45,2%	5%

Хулгайлах гэмт хэргийн 19 буюу 0.5 хувийг мал хулгайлах, 109 буюу 3.3 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах, 264 буюу 8 хувийг аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хулгайлах, 429 буюу 13 хувийг автомашины эд анги хулгайлах, 214 буюу 6,5 хувийг алт мөнгө, үнэт эдлэл хулгайлах, 437 буюу 13,3 хувийг зурагт хулгайлах, 219 буюу 7 хувийг компьютер хулгайлах, 125 буюу 3,8 хувийг автомашинаас эд зүйл хулгайлах, 41 буюу 1,3 хувийг гэрийн тэжээмэл амьтан хулгайлах гэмт хэрэг тус тус эзэлж байна. Эртний эдлэл хулгайлах, галт зэвсэг хулгайлах гэмт хэрэг нийслэлийн хэмжээнд бүртгэгдээгүй байна.

Хүснэгтээр харуулбал:

д/д	Цагдаагийн хэлтэс	Нийт бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг Автомашини эд анги хулгайлсан гэмт хэрэг	Үүнээс										
			ААНБ-д үйлдэгдсэн хэрэг	Алт, мөнгө, үнэт эдлэл хулгайлах	Зурагтын хулгай	Компьютерийн хулгай	Алдагдсан гар угас		Автомашини хулгай	Автомашинаас эд зүйл хулгайлах	Малын хулгай	Шилмэл үүлдрийн гэрийн тэжээмэл амьтан	
1	БГД	1	291	30	32	16	21	30	47	4	12	-	
2		2	280	75	30	13	23	18	45	31	25	-	1
3	БЗД	1	346	34	21	25	31	15	43	8	21	-	
4		2	443	43	29	21	47	23	37	15	5	-	
5		3	269	29	6	17	51	21	29	7	9	3	4
6	СХД	1	247	63	8	22	30	12	37	12	11	3	16
7		2	172	26	2	15	57	17	28	8	6	1	
8		3	146	45	7	13	25	15	46	2	13	-	
9	СБД	1	209	10	44	2	4	9	52	2	2	-	
10		2	296	30	11	12	48	12	36	6	8	4	
11	ХУД	1	84	10	6	5	3	16	33	5	1	-	
12		2	124	19	7	19	24	10	29	2	6	2	20
13	ЧД	1	140	8	11	8	15	11	49	2	6	-	
14		2	170	6	4	23	51	10	38	2	1	-	
15	НД		54	-	-	2	7	-	24	3	-	4	
16	БНД		19	1	2	1	-	-	11	-	-	2	
17	БХД		3	-	-	-	-	-	2	-	-	-	
Нийт			3293	429	264	214	437	219	586	109	125	19	41



1. Автомашины эд анги хулгайлах гэмт хэрэг 429 бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн 72, зөрчлийн хэрэг нээсэн 135, хэрэг нээхээс татгалзсан 214 байна. Гэмт хэргийн улмаас аккумулятор 113, дугуй 35, зөөлөн яндан 10, толь 75, хучлага 50, гупер 8, копуд 5, бусад 112 тус тус алдагдсан байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Баянгол дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн нутаг дэвсгэрт 75 буюу 17,5 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 63 буюу 14,7 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст 45 буюу 10,5 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх хэргүүд ихэвчлэн харуул хамгаалалтгүй, хяналтын камергүй, гэрэлтүүлэг муутай гудамж, талбайд Баасан, Бямба, Ням гаригуудын 22:00-06:00 цагийн хооронд бүртгэгдсэн байна⁷².

2. Аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн хулгайн гэмт хэрэг 264 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 150 нэгжээр буюу 2,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 179, зөрчлийн хэрэг нээсэн 30, хэрэг нээхээс татгалзсан 13 байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 15,282,000 төгрөгний хохирол учирч, 179 хэрэгт 36 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт 44 буюу 16,6 хувь, Баянгол дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст 32 буюу 12,1 хувь, Баянгол дүүргийн хоёрдугаар хэлтэст 30 буюу 11,3 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх хэргүүд ихэвчлэн харуул хамгаалалтгүй, хяналтын камергүй дэлгүүр, эмнэлэг, зах, худалдааны төв зэрэг албан байгууллагуудад иргэдийн сонор сэрэмжгүй байдлыг далимдуулан үйлдэгдсэн байна.

3. Алт, мөнгө, үнэт эдлэл хулгайлах гэмт хэрэг 214 бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн 156, зөрчлийн хэрэг нээсэн 2, хэрэг нээхээс татгалзсан 55 байна. Энэ төрлийн гэмт хэрэг 12 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт 25 буюу 11,7 хувь, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 23 буюу 10,8 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 22 буюу 10,3 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх төрлийн гэмт хэргийг эрхэлсэн тодорхой аижлгүй, амьдралын эх үүсвэргүй иргэд хялбар аргаар мөнгө олох зорилгоор үйлдэж, Нарантуул, Хар хорин, Хүчит шонхор зэрэг худалдааны төв, томоохон захын гадна зогсдог чинжүүд болон алт, мөнгөний дархан, ломбардуудад зарагдаж байна.

4. Зурагт хулгайлах гэмт хэрэг 437 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 нэгж буюу 3,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ төрлийн гэмт хэрэг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёр, гурав, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт тус тус буурсан нь “Сонор” арга хэмжээний хүрээнд эргүүл шалгалтыг оновчтой зохион байгуулсаны үр дүн харагдаж байна. “Сонор” арга хэмжээний хүрээнд 12 удаагийн үйлдлийг халуун мөрөөр нь илрүүлэн ажилласан.

5. Компьютер хулгайлах гэмт хэрэг, үйлдэл 219 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 нэгж буюу 9,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 212, хэрэг нээхээс татгалзсан 7 байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэдэд 15,000,000 төгрөгний хохирол учирч, хэрэг бүртгэлтийн 3 хэрэгт 5 этгээдийг холбогдуулан шалгаж байна. Дээрх хэргүүд нь аж ахуй нэгж байгууллагын харуул хамгаалалт сул, гэрэлтүүлэг, хяналтын камергүй, иргэдийн анхаарал болгоомжгүй байдлаас шалтгаалж байна.

6. Эртний эдлэлийн хулгай бүртгэгдээгүй ба орон байр болон халаасны хулгай, дээрмийн гэмт хэргийн улмаас 586 ширхэг гар утас алдагдсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 72,8 хувь нь гудамж талбай, аж ахуй нэгжид 08:00-15:00 цагийн хооронд, 1,1 хувь нь 22:00-06:00 цагийн хооронд иргэдийн орон байранд нэвтэрч эд зүйл алдагдах явцад, 26,1 хувь нь бусдын эд зүйлийг дээрэмдэх, залилан мэхлэх аргаар үйлдэгдсэн байна. Алдагдсан гар утсыг төрлөөр нь үзвэл. Samsung маркийн гар утас 248 буюу 43%, I phone маркийн гар утас 148 буюу 25%, LG маркийн гар утас 45 буюу 8%, Nokia маркийн гар утас 28 буюу 5%, бусад маркийн гар утас 110 буюу 19% эзэлж байна. Алдагдсан гар утсууд ихэвчлэн барьцаалан зээлдүүлэх газар болон зах, худалдаа үйлчилгээний төвлөрсөн цэгүүдэд ажиллаж байгаа эд зүйл худалдан авч, борлуулдаг “ченж” гэх иргэдийн дамжин зах зээлд

⁷² Нийслэлийн цагдаагийн газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ



гарч, хууль бус нийлүүлэлт үүсгэж байгаа бөгөөд адил төстэй бараа, бүтээгдэхүүнээс бага үнэтэй худалдагддаг тул эрэлт нийлүүлэлт их байна гэж дүгнэж байна.

7. Галт зэвсэг хулгайлах гэмт хэрэг нийслэлийн хэмжээнд 2018 оны 01 дүгээр улиралд бүртгэгдээгүй байна. 2018 оны 01 дүгээр улирлын байдлаар алба хаагчдаас “Эрэн сурвалжлах ажлын АСАП систем”-д 29 мэдээллийг бүртгэлд оруулан зарлан мэдээлж, 16 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн явц урьд оны мөн үетэй харьцуулахад 15,3 хувиар буурсан, 29 хүн, мал эд зүйлийн мэдээллийг эрэн сурвалжлах санд зарласан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 68,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

8. Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 109 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 84 нэгжээр буюу 4.4 дахин өсч, илрүүлэлт 6.7 хувьтай өмнөх оны мөн үеэс илрүүлэлт - 14.3 хувиар буурсан. Алдагдсан автомашины 46 нь олдсон байна. Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлахад 39,8 хувь нь ах дүү, найз нөхөд, гэр бүлийн хоорондын эд хөрөнгийн маргаан, 15 хувь нь эзэмшигч нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслээ хаана тавьсанаа мэдэхгүй байх, 31 хувь нь сэжигтэй этгээд автомашинаар сэлгүүцэх, 14,2 хувь нь хулгайлсан тээврийн хэрэгслийн эд ангийг зарах шалтгаанаар үйлдэгдсэн байна. Автомашин хулгайлах гэмт хэрэг Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёр, Баянзүрх дүүргийн цагдаагийн нэг хоёр, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсүүдийн хариуцсан нутаг дэвсгэрт ихэвчлэн үйлдэгдсэн байна.

9. Автомашинаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг 125 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 12 нэгж буюу 9,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 49, зөрчлийн хэрэг нээсэн 46, хэрэг нээхээс татгалзсан 21 байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэдэд 11,650,000 төгрөгний хохирол учирч, хэрэг бүртгэлтийн 49 хэрэгт 18 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

10. Малын хулгайн гэмт хэрэг 19 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 6 нэгжээр буюу 1.5 дахин өсч, илрүүлэлт 5.6 хувьтай байна. Сонгинохайрхайн дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс 3 нэгж буюу 50 хувь, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс 1 нэгж буюу 25,7 хувиар буурсан, налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 4 хэрэг, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс 4, Сонгинохайрхайн дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс 1 хэрэг бүртгэгдсэн байна. Яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 2 хэрэг, хэрэгсэхгүй болгох саналтайгаар 1 хэргийг прокурорт шилжүүлж, ажиллагаанд 16 хэрэг байна.

11. Шилмэл үүлдрийн гэрийн тэжээмэл амьтан хулгайлах 41 бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн улмаас нохой 21, гахай 3, тахиа 17 алдагдсан байна. Энэ төрлийн гэмт хэрэг Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан –Уул дүүргүүдийн нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Хулгайлах гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлийг хүснэгтээр харуулбал:

№	Алдагдаж буй эд зүйлсийн төрөл	Алдагдаж буй эд зүйлс	Алдагдсан эдзүйлсийн тоо, ширхэг		
			2017 оны 1 дүгээр улирал	2018 оны 1 дүгээр улирал	
1	Автомашин	Автомашин		109	
2	Авто машины эд анги	Толь		75	
3		Дугуй		35	
4		Гэрэл, дохио		-	
5		Гупер		8	
6		Аккумулятор, зай		113	
7		Копут		5	
8		Хучлага		50	
9		Гарутас	Гарутас		586
10	Компьютер	Компьютер		219	



11	Шилмэл үүлдрийн гэрийн тэжээмэл амьтан	41	
12	Зурагт	437	

Хулгайлах гэмт хэргийн улмаас 2857 иргэнд 3,466,107,610 төгрөгийн хохирол учирсны 294,147,350 төгрөг буюу 8.5 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Нэг. Нийслэл хотод хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын талаар:

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, хэргийн илрүүлэлтийг дээшлүүлэх, дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд болон бусад төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 5 удаа зохион явуулж, үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга, Мөрдөн шалгах газрын дарга нарт тухай бүр танилцуулж ажилласан. Үүнд:

1. “Сонор” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 12-ны өдрийн хооронд зохион байгуулж, арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөний дагуу тус газрын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн алба хаагчид, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны хамгаалалтын газрын 20 алба хаагч, замын цагдаагийн 8 алба хаагч, дүүргүүд дэх цагдаагийн хэв журмын 13 алба хаагч нийт 41 алба хаагчид ажиллаж, нийслэл хотын нутаг дэвсгэрт байрлах төвлөрсөн зах худалдааны төв, хулгайн эд зүйлс худалдан авч болзошгүй аж ахуйн нэгж болон барьцаалан зээлдүүлэх газруудын орчим ажлын болон амралтын өдрүүдийн 09 цагаас 19:00 цагийн хооронд хяналт тавьж үүрэг гүйцэтгэсэн. Арга хэмжээний хүрээнд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид давхардсан тоогоор хулгайн эд зүйл худалдан авч болзошгүй барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газар 340, алт мөнгө үнэт эдлэл зарж борлуулдаг газар, дарханы цэг 250, хулгайн эд зүйлс тээвэрлэн явж болзошгүй сэжигтэй тээврийн хэрэгсэл 15100, овор ихтэй сэжиг бүхий эд зүйл авч явсан 240 иргэнийг Цагдаагийн байгууллагын нэгдсэн лавлагаанаас шалгаж, хяналт тавьж ажиллаж, орон сууцнаас хулгайлах 7, автомашины хучлага хулгайлах 2, халаасны хулгай 7, урьд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй хэргээс 3 тус тус нийт 19 гэмт

хэргийг шуурхай илрүүлэн, тухай бүрд нь хариуцсан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд шилжүүлсэн. Мөн Цагдаагийн байгууллагын “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 11 олж тогтоон ажилласан⁷³.

Тус арга хэмжээний хугацаанд хулгайлах гэмт хэргийн гаралт буураагүй боловч гэмт хэргийн улмаас хамгийн ихээр алдагддаг зурагт, цахилгаан бараа / арга хэмжээ эхлэхээс өмнө хоногт 8-12 ширхэг алдагдаж байсан бөгөөд арга хэмжээ эхлэхээс хойш 3-5 ширхэг алдагдах болсон/ алдагдах байдал багассан байна. Энэ нь цахилгаан бараа худалдан авдаг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрууд, худалдааны төвүүдэд тавих хяналт, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсаны үр дүн харагдаж байна.

2. “Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээ зохион явуулах удирдамж, төлөвлөгөөний дагуу 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 12-нийг хүртэлх хугацаанд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан этгээдүүдийг олж баривчлах ажлын үр дүнг сайжруулах, мэдээллийн сангийн зөрчлийг арилгах, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх зорилгоор нийслэл хотын хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцон дүн мэдээг нэгтгэж Нийслэлийн цагдаагийн газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын даргад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга нарт хүргүүлсэн.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээний хүрээнд урьд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй 628 хэрэг, тухайн оны 97 хэрэг, урьд онд үйлдэгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 536, халуун мөрөөр нь үйлдэл дээр нь илрүүлсэн 237 хэрэг нийт 1498 хэргийг нөхөн илрүүлж, асап санд эрэн сурвалжлагдсан оргодол 37, сэрдэгдсэн этгээд 690, нийт 727 этгээдийг

⁷³ Нийслэлийн цагдаагийн газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ



эрэн сурвалжилж олж тогтоосон ба урьд оны мөн үетэй харьцуулахад хулгайлах гэмт хэрэг 67 нэгж буюу 14,7 хувиар буурсан үр дүн гарсан байна.

3.Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа автомашинаас эд зүйл, эд анги, аккумулятор хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох, тээврийн хэрэгслийн эд анги худалдан авч, зарж борлуулдаг цэгүүдэд хяналт тавих, тэдгээрийг бүртгэн нэгдсэн санд оруулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Автомашин, Аккумулятор” хэсэгчилсэн арга хэмжээг Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт 2018 оны 03 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Арга хэмжээнд Мөрдөн шалгах газрын 56, НХЖХ, ОНАБХА-ын хамгаалалтын газрын 100, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нийт 850 алба хаагч, 49 автомашинтайгаар оролцож, 12 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлж, эрэн сурвалжлагдаж байсан оргодол этгээд 4 баривчлан, эрэн сурвалжлалтыг зогсоож, гэмт хэрэгт сэрдэгдсэн 10 иргэнийг олж тогтоон, нийт 2989 хүн, 2755 тээврийн хэрэгсэл, 712 аж ахуй нэгж, байгууллага, 273 эд зүйл, 220 дэн буудал, 40 барьцаалан зээлдүүлэх газар, 241 хүнсний дэлгүүр, 24 хоёрдогч түүхий эд авах цэг, 123 баар, караоке, 8 саун массажны газрыг шалгаж, нийт 57 зөрчил илрүүлж, 55 хүнийг 2,680,000 төгрөгөөр торгож, 9 хүнийг 103-т, 77 хүнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 33 хүнийг саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 4 иргэнийг Замын цагдаагийн албанд шилжүүлсэн. Эрүүгийн нөхцөл байдлыг зөв тодорхойлж хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнгээ өгч, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 50 хувь, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 17 хувиар тус тус буурсан үр дүн гарсан байна.

Хоёр. Дүгнэлт

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 28206 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7794 буюу 27.6 хувь нь хулгайлах төрлийн гомдол, мэдээлэл, 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байна.

Дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдээс Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт хамгийн их хулгайлах гэмт хэрэг буюу нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 13,5 хувь нь үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаанаас харахад аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 2,3 хувь, автомашин хулгайлах гэмт хэрэг 4,4 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 1,5 дахин, автомашинаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг 9,6 хувиар, компьютер хулгайлах гэмт хэрэг 9,8 хувиар тус тус өссөн, зурагт хулгайлах гэмт хэрэг 4,7 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Гурав. Санал

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байх тул урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион явуулах.

Нийслэл хотын хэмжээнд хулгайлах гэмт хэрэг гэр орон сууцанд өглөөний 06:00-14:00, өдрийн 14:00-19:00 цагуудад хамгийн ихээр бүртгэгдсэн байх тул эргүүлийн чиглэл маршрутыг зөв тодорхойлж, хяналт шалгалтыг сайжруулах

Аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, автомашин хулгайлах, мал хулгайлах, автомашинаас эд зүйл хулгайлах, компьютер хулгайлах гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй байх тул дээрх хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН ШАТЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ, ЧИГ ХАНДЛАГА, АНХААРАХ АСУУДАЛ

Д.Чимэддамба
Судлаач

Олон шатлалт маркетинг гэж юу вэ?

1. Пирамид тогтолцооны луйврын арга гэж вэ?
2. Яагаад хориглох болов?
3. Олон шатлалт маркетингийг хэд ангилдаг вэ?
4. Пирамид тогтолцоотой залиланг хэд ангилдаг вэ?
5. Хэрхэн ялгаж таних вэ?
6. Өнөөдрийн хууль тогтоомжид хэрхэн хуульчилсан бэ?
7. Хариуцдаг, хяналт шалгалт тогтоодог төрийн хууль хяналтын байгууллагууд байна уу?
8. Монгол Улсад хэрхэн, яаж цэгцлэх ёстой вэ?

9. Цаашид энэхүү залилах гэмт хэрэг гарахгүй байхад юунд анхаарах ёстой вэ? Зэрэг асуулт урган гарч ирж байна.

Эдгээр асуултад бүрэн хариулт олохын тулд худалдааны шинжлэх ухааныг ухахаас өөр аргагүй.


Олон жилийн судалгаанаас харахад дэлхий дээр 2 төрлийн үндсэн том худалдаа байна.

А. Уламжлалт буюу ченжийн худалдаа.

Уламжлалт худалдаа гэдэг нь өнөөгийн түгээмэл, бидний өдөр тутмын амьдралд ил байдаг аваад зардаг ченжийн худалдаа юм. Энэ худалдаанд чанар стандарт тийм ч сайн хангалттай бус, асуудал байнга дагуулдаг, бараа бүтээгдэхүүнээ зах зээлд реклам сурталчилгаагаар ихээхэн мөнгө заран үйлдвэрээс хэрэглэгчид хүрэх бүх шат дамжлага бүр дээр ашиг болон үйлчилгээний хөлс, сурталчилгаа тээврийн зардал нэмэгддэг хэрэглэгчийн төлөө бус чанарыг эрхэмлэдэггүй тооны араас явдаг уламжлалт ченжийн гэгддэг худалдаа юм.

В. Олон улсын чанар стандартууд болох /ISO, GMP, TGA, HALAL/ өндөр түвшний шаардлагыг тариалалтаасаа эхлээд үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, судалгааны лаборатори, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ гээд бүх шатандаа хэрэгжүүлж патентлагдаж

өөрөө үйлдвэрлэгч байдаг ба үйлдвэрээс гарсан барааг дундын ямар нэгэн чанар алдагдуулах болон үнэ нэмэх дамжлаггүйгээр эцсийн хэрэглэгч хүртэл бүх зардал тээвэрлэлт даатгал, татвар гээд шингээсэн хариуцлагатай, ямар нэгэн реклам сурталчилгаанд тодруулбал телевизийн болон сонин сайтууд, цахим орчиноор сурталчлахгүйгээргараас гарт хүнээс хүнд хаалганаас хаалганд хүргэдэг биечилсэн аман сурталчилгаан тулгуурласан худалдааг шууд худалдаа гэдэг байна. Шууд худалдаа нь ямар ч зах зээл дээр реклам зар сурталчилгаанд сохор зоос зарцуулдаггүй бөгөөд сурталчилгаанаас хэмнэсэн мөнгийг компанийнхаа бараа бүтээгдэхүүнүүдийг үнэн зөвөөр нь тайлбарлаж, гишүүнийхээ дүрэм журам, Дэлхийн шууд худалдааны нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны шууд худалдааны ёс зүйн кодексийгчанд мөрдөө ажилдаг өөрийн сонихолоороо гэрээлэгч болсон гишүүддээ ОЛОН ШАТЛАЛТ, ОЛОН YET /MLM буюу MULTI LEVEL MARKETING/ маркетингийнхаа дагуу урамшуулал, бонус болгон өгдөгөөрөө онцлогтой хэрэглэгч, гишүүнийхээ төлөө гэсэн худалдаа юм.



Эх сурвалжууд:

<https://wfdsa.org/> Дэлхийн Шууд Худалдааны Нийгэмлэгүүдийн Нэгдсэн Холбоо

<http://www.seldia.eu/> Европын Шууд Худалдааны нийгэмлэгүүдийн Нэгдсэн Холбоо

<http://www.rdsa.ru/> Оросын Холбооны Улсын Шууд Худалдааны Нийгэмлэг
<http://www.hkdsa.org.hk/> Хятад Улсын Шууд худалдааны Нийгэмлэг.

Олон шатлалт, олон үет, олон түвшинт маркетингийг дэлхий дээр Шууд худалдааны жинхэнэ компаниуд хэрэглэдэг бөгөөд тэр ч утгаараа бие даасан цогц Шинжлэх



ухаан болтолоо хөгжиж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдаг байна.

Харин Пирамид тогтолцоо гэдэг нь Шууд худалдаа-Олон шатлалт маркетингийн сүүдэртэй хар тал нь бөгөөд шууд худалдаа мэт харагдуулан улс үндэстэн дамнан, нарийн зохион байгуулалттайгаар мөнгө болон бараагаар өнгөлөн далдлагдаж эдийн засгийн томоохон хохирол учруулдаг онц ноцтой томоохон гэмт хэрэг юм.

Эх сурвалж: <https://www.investor.gov/investing-basics/avoiding-fraud/types-fraud/pyramid-scheme>

Түүхээс Чарльз Понзын, Сергей Мавроди, Бернард Мадофф гэх мэт олон улсад зартай залилангууд болон Монгол улсаас Жавхланг Бадруулагч, Шинэ Санаа Төв, Хадгаламж Зээлийн 200-гаран хоршоо, G Time гэх мэтээс бэлээхэн харж болно.

Эх сурвалжууд:

https://en.wikipedia.org/wiki/Ponzi_scheme

https://en.wikipedia.org/wiki/Sergei_Mavrodi

https://en.wikipedia.org/wiki/Bernard_Madoff

Нэг нэгнийхээ араас хэн нэгнээ элсүүлж гинжин хэлхээг өөр хооронд нь хамааралтай болгож үүсгэдэг учраас СҮЛЖЭЭНИЙ БИЗНЕС гэж хар хэллэгээр ярьж заншин ирсэн бөгөөд сонирхолтой нь олон улсад хуучин социалист орнууд ОХУ, монгол улсад л Сүлжээний бизнес гэж хараар ярьж ирсэн түүхтэй.

Тэгвэл өнөөдөр Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 2001-оны хуулиар зөв ч бай буруу ч бай оль алинг нь хуулиар хорилоод зогсохгүй шинэчилсэн эрүүгийн хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж ялтай болгож хэрэгжүүлж эхэлсэн эргээд хараарай. Энэ хууль гарах болсон шалтгаан

нь олон мянган хүн залилуулж, олон тэрбумын хохирол үүсдэг нийгэмд хортой үр дагавар бий болгодог томоохон хүчин зүйл учраас хар тамхи, садар самуун, мөрийтэй тоглоомтой адилтган СҮЛЖЭЭНИЙ БИЗНЕСИЙГ хориглосон байдаг.

Олон жилийн судалгаа хийсний үр дүнд 1972 оноос анх Пирамид тогтолцооны залилан нэвтэрч ирсэн байдаг бөгөөд өнөөдрийг хүртэл Монгол Улсад 2-4 жилд нэг удаа томоохон давалгаалан цэцэглэн залилан мэхэлж ирсэн түүхтэй төдийгүй энэ чиглэлийн 350-орчим сүлжээний гэх пирамид тогтолцоотой залилан гадаадаас орж ирэх болон дотоодоос үүсч байсан. Сонирхолтой нь энэхүү давалгаалж цэцэглэдэг үе нь дандаа эдийн засгийн хямралтай, ажилгүйдэл ядуурал ихтэй, хөдөлмөрийн үнэлэмж багатай, хууль байвч хэрэгжүүлж мөрддөггүй, төр засагтаа итгэхээ байсан ер нь бол замбараагүй үе байсан. Ийм үе, ийм газарт илүүтэй цэцэглэдэг түүхтэй.

Эдгээрийн нэрс болон хар жагсаалтууд мөн шууд худалдаа сүлжээний бизнес гэх тухай бүх цаг үеийн баримт, мэдээ, мэдээлэлүүдтэй энэ хуудаснаас дэлгэрэнгүйгээр нь танилцах боломжтой: <https://www.facebook.com/chimeddamba/>

Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны залиланг дотор нь:

Ямар ч бизнесийг судалж мэдэхэд тулгын 3-н чулуун дээр нь суурилж судалж үзэж мэддэг бөгөөд тэдгээр 3 чулуу болох 1-т Компани, 2-т Бүтээгдэхүүн, 3-т Маркетинг гээд энэ 3-ыг нэг нэгнээс салгаж ойлгож мэдэх ямар ч боломжгүй хэт өрөөсгөл хандах аюултай. Өөр хоорондоо нягт салшгүй холбоотой 3-н зүйл...

Олон шатлалт маркетинг буюу пирамид

ХООРОНД НЬ ЯЛГАЖ ТАНИХАД ИХ ХЯЛБАРХАН	САНХҮҮГИЙН ПИРАМИД	БАРААТАЙ ПИРАМИД	ӨНГӨЛӨН ДАЛДЛАГДСАН ШУУД ХУДАЛДАА	ЖИНХЭНЭ ШУУД ХУДАЛДАА
1-Т КОМПАНИ	Х	Х	+/-	+
2-Т БҮТЭЭГДЭХҮҮН	Х	+/-	+	+
3-Т МАРКЕТИНГ	+	+	+	+
ТАТВАР	Х	+/-	+/-	+


тогтолцоог өөрөөр хэлбэл, сүлжээний маркетингийг ашигласан компанийг судалгааны үндсэн дээр Монголд үндсэн 4 том хэсэгт хуваагдаж байна:

1. САНХҮҮГИЙН ПИРАМИДЫН КОМПАНИ, ямар ч бараагүй, сурталчилгаа нь МӨНГӨ л ярина, бинар маркетингтай. Ихэнхидээ ямар ч ААН-байдаггүй. Байсан ч дотоодын хувь хүний төдийхөн компани байдаг. Гол зорилго нь хүн элсүүлэх бөгөөд санхүүжилтийнх нь эх үүсвэр нь хүн элсүүлэхээс эхтэй. Өгөөш нь олон улсынх, ирээдүйн төлбөр тооцооны хэрэгсэл, хувьцаа, ноогдол ашиг, алт, даатгал, аялал жуулчлал, онгоцны хямд тийз, төсөл, ядуурлыг бууруулах, зочид буудал, сайн үйлсийн аян, машин, бартай болох, сургалт, сургуульд явах гэх мэтчилэн. Уран чамин үгтэй, сургалтууд нь дандаа нууцлагдмал, хэзээ ч ил явуулдаггүй, ихэнхидээ сэтгэл зүйн асар хүчтэй сургалтуудаар мэдэхгүй, мэдлэггүй хүмүүсийн итгэл олж замаар тархи угаалт хийж шуналыг хөдөлгөж дэврээж турхирсанаар элсүүлж хамсаатнаа болгодог. Ямар ч төрлийн татвар төлдөггүй, байнга байрлалаа сольж нүүдэллэн залилдаг. Үүнийг хийдэг мэргэшсэн хэд хэдэн бүлэглэл байдаг.

Олон улсад нэг нэгнээс салбарлаж хүн элсүүлдэггүйг нь ПОНЗЫН СИСТЕМИЙН залилан гэж, араасаа хүн элсүүлдэг маркетингтайг нь ПИРАМИД ТОГТОЛЦООТОЙ залилан гэж нэрлэдэг байна.

Маркетинг нь БИНАР /BINARY marketing/ буюу хоёрлосон, хосолсон, hybrid, эрлийз маркетинг. Олон улсад энэхүү маркетингийг зөвхөн залилан луйварт түгээмэл хэрэглэдэг учраас хориглосон байдаг.

Эх сурвалж: <https://www.investor.gov/>





[investing-basics/avoiding-fraud/types-fraud/binary-options-fraud](https://www.investor.gov/investing-basics/avoiding-fraud/types-fraud/binary-options-fraud)

2. БАРААТАЙ ПИРАМИДЫН КОМПАНИ, бараатай ч юм шиг үгүй ч юм шиг мөн бараа байсан ч хүнд нэг их онцын шаардлаггүй 20 орчим тооны бүтээгдэхүүнтэй бөгөөд сурталчилахдаа гайхамшигтай, шидэт, дэлхийд ганц гэх мэтээр хэлдэг, бинар, матриц, буюу холимог маркетингтай аж ахуйн нэгж байж ч магад байхгүй ч байдаг. Байлаа гэхэд дотоодын хөрөнгө оруулалттай хувь хүний байдаг л нэг компани төдийхөн. Хэдийгээр бараатай ч гол зорилго нь болсон болоогүй бараагаар өгөөшилж хүн элсүүлэх бөгөөд санхүүжилтийнх нь эх үүсвэр нь мөн л хүн элсүүлэхээс эхтэй. Цэвэр мөнгөн дээр бус иргэнээс мөнгийг нь авахын тулд бараагаар өгөөшилдөг, ихэвчлэн тухайн бараа нь гайхамшигтай, супер, дахин давтагдашгүй, цор ганц, ганц хэрэглээд л эдгэнэ, хорт хавдарыг эдгэнэ, анагаана гэж телевиз болон сонин, сайтуудаар сурталчилдаг байна. Сүүлийн жилүүдэд Монголчууд өөрсдөө энэ зэлиланг зохион үндэсний үйлдвэрлэлийн бараагаар өгөөшлөн үндэсний үйлдвэрлэл дэмжих нэрийн ард нуугдан интернэт худалдаа, онлайн худалдаагаар залилан мэхлэн луйварддаг болсон. Хуулинд тодорхой зааж тусгайлан нарийвчлан зааж өгөөгүйгээс болоод бусдын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр өгөөшлөн пирамид тогтолцоог санаатайгаар зохион хориглосон хуулийг зөрчин залилах гэмт хэрэг ихэссэн. Бараатай пирамидыг нарийвчлан судлахад Дэлхийн болон тивүүдийн мөн бусад орнуудын шууд худалдааны нийгэмлэгүүдэд бүртгэлгүй байдаг төдийгүй өөрөө бараагаа үйлдвэрлэдэггүй бусдын бараанд шошгоо хэвлэн зах зээл дээр тоглолт хийдэг байна. Тэдэнд бүтээгдэхүүн борлуулах нь чухаг бус ганган чамин сурталчилгаатай өндөр үнэтэй бараагаар өгөөшлөн мөнгө салгах нь чухал. Үүнийг мөн л мэргэшсэн хүмүүс, бүлэглэл олон жил хийсээр ирсэн.

Маркетинг нь БИНАР, МАТРИЦ хоёрыг хосолдог. Мөн л олон улсад эдгээр маркетингийг зөвхөн залилан луйварт л ашигладаг. Матриц гэдэг нь өөрийгөө дахин хувилдаг системийг хэлдэг байна.

3. ӨНГӨЛӨН ДАЛДЛАГДСАН ШУУД ХУДАЛДААНЫ КОМПАНИ


Мэдээж Дэлхийн болон тивүүдийн бусад орны шууд худалдааны нийгэмлэгүүдэд бүртгэлтэй олон улсын чанар стандартын



шаардлагыг хангасан олон нэрийн бараа бүтээгдэхүүнтэй байдаг, олон үет маркетингтай. Хамгийн аюултай нь тухайн компанийн хөрөнгө оруулалтыг бодитоор оруулаад ирсэн мэт маш өндөр түвшинд өнгөлөн далдлалт хийсэн байдаг бөгөөд энгийн иргэн байтугай тухайн компанийн томоохон лидер нь ч ялгаж салгаж чаддаггүй. Монголд тухайн компанийг үүсгэн байгуулсан хүн нь Монгол хүн байгаагаар л мэдэж болдог. Ихэвчлэн сурталчилгаагаа телевизээр эмч нараар сурталчлуулан хийдэг. Ямар ч хөрөнгө оруулалт тухайн компаниас нь байдаггүй бөгөөд харин хөрөнгө оруулалтыг хийсэн мэт далдалдаг, ихэвчлэн бүтээгдэхүүнээрээ түрий барьж хэрэглэхээс өөр гарцгүй болтол нь итгүүлдэг байна. Сайн анзаарч харвал дандаа эмч, доктор, эрдэмтэд гээд эрүүл мэнд талруу илүүтэй хүмүүс элсүүлж тэдгээр хүмүүсээр өөрсдийгөө хамгаалуулсан байдаг. Гол зорилго нь бараагаа зарах хүн элсүүлэх бөгөөд санхүүжилтийнх нь эх үүсвэр нь хүн элсүүлэхээс гадна бараа эргэлтээс эхтэй. Үүний сул тал нь тухайн компанийн бараа бүтээгдэхүүний үнийг хэт нэмэх, оноог нь багасгах, маркетинг болон олон улсад явагддаг үйл ажиллагааг нь үүсгэн байгуулсан хүн нь өөрийн дур сонирхолдоо нийцүүлэн өөрчилдөг, шууд худалдааны ёс зүй баримталдаггүй дураараа хөгждөг ба хамгийн аюултай нь БИХНТБ-ийг буруу сурталчилдаг байна. Энэхүү буруу сурталчилгаанаас болж эрдэнэт хүний алтан амь эрсдсэн хэд хэдэн тохиолдлоуд байдаг. Мөн хөрөнгө оруулалтгүй учраас эхэндээ баахан пижигнүүлж байгаад сүүлрүүгээ ажмаар замхарч дампуурсан

олон жишээнүүдээс бэлээхэн харж болно. Тогтворгүй, найдваргүй, баталгаагүй.

Маркетинг нь нэг үет болон олон үет маркетингтай. Эдгээр маркетингийг дэлхий дээр зөвхөн шууд худалдааны жинхэнэ компани хэрэглэдэг байна. Хамгийн аюултай нь эдгээр 4-н төрлөөс энэ нь. Учир нь эхнийх хоёрт хохирогч мөнгөө алддаг бол энд мөнгө болон эрүүл мэндээ давхар алддаг байна.



4. Шууд худалдааны жинхэнэ компани олон үет маркетингтай, 100-аас дээш нэр төрлийн бараа бүтээгдэхүүнтэй, өөрөө үйлдвэрлэгч байдаг ба бүтээгдэхүүн нь олон улсын чанар стандартуудыг тариалалт, үйлдвэрлэл, лаборатори, тээвэрлэлт, гээд бүх шатандаа хангаж, баталгаажиж хэрэглэгчид хүргэдэг бөгөөд дэлхийн шууд худалдааны нийгэмлэгээдийн нэгдсэн холбооны ёс зүйн кодекс болон тухайн компани нь гишүүний дүрэм журмыг чанд баримталж, олон улсад хүлээсэн үүргийнхээ дагуу шууд худалдааг бодит утгаар нь гараас гарт,




хүнээс хүнд гэж биечилсэн дундын ямар нэгэн дамжлагагүйгээр хэрэглэчид аман сурталчилгаан дээр тулгуурлаж хүргэдэг гэж тус тус хуваадаг. Үүнийг тухайн компанийнх нь жинхэнэ хөрөнгө оруулалтыг оруулж ирсэнээр хэрэгжүүлж чаддаг. Гол зорилго нь хүн элсүүлэх бус бараа эргэлт нь чухал байдаг тул байнгийн найдвартай үнэнч хэрэглэгчийг илүүтэй нэгтгэж чаддаг байна. Иймдээ ч олон жил тогтвор суурьшилтай баталгаатай оршин тогтнож чаддаг төдийгүй хэрэглэгч гишүүдээ бүрэн хамгаалах чадвартай байдаг байна.

Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/Multi-level_marketing


Эдгээрээс эхний 3-ийнх нь эхэнд нь орсон хүмүүс нь араасаа элсүүлсэн хүмүүсийн мөнгөөр бэлжиж, хэдхэн сарын дараа асар олон хохирогчдыг дагуулж муугаар төгссөн жишээ баримтууд олон байна...

Ингээд миний судалгаанд тэмдэглэгдэн үлдсэн зарим тоон баримтуудаас сонирхуулахад:


1- 4-н жилийн давтамжаас харахад сүлжээний маркетингийг ашигласан бизнесүүд нэмэгдсээр байна.



2- Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны залилах гэмт хэрэгт хохирсон иргэдийн тоо эрс өссөөр.



3- Хохирлын мөнгөн дүн өссөөр.



Дээрхи тоон үзүүлэлтүүд өсөх нь дамжиггүй.

Тэгвэл өнөөдрийн баталгаатай найдвартай гэх сүлжээний маркетингаар ажиллаад байгаа компаниуд хэрхэн яаж хууль эрх зүйн орчиноо бүрдүүлж татвар төлөгч болсон байдаг юм бол гэсэн асуулт урган гарч байна.

Өнөөдөр ихэнхи нь тухайн сүлжээний компанийнх нь албан ёсны жинхэнэ хөрөнгө оруулалтыг монгол улсад албан ёсоор оруулж ирээгүй бөгөөд тухайн нэртэй компани аж ахуйн нэгжийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулж гэрчилгээгээ авахдаа аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээ гадаад, дотоод худалдаа эсвэл олон улсын худалдаа гэж аваад татвар төлөгч болж хяналтанд орж, компанийнхаа нэр дээр бараа бүтээгдэхүүнээ оруулж ирж УМХЕГ-аар лаборатороор баталгаажуулж, ЭМЯ-наас гэрчилгээ авч хянагддаг хэдий ч сүлжээний маркетингаар үйл ажиллагаа явуулдаг нь ямар нэгэн хууль хяналтгүйгээр явж ирсэн. Энэ бол хуулийн цоорхойг ашигласан явдал юм. Мөн дотоодоосоо хөрөнгө оруулалттай бол тухайн компанийн нэрийг ашигласан мөнгөтэй нэгний хувь хүний компани юм байгаам. Гадаадын хөрөнгө оруулалттай бол гадаадын хөрөнгө оруулагч нь хувь хүн байна уу үнэхээр цаад компаниас нь хөрөнгө оруулалт хийсэн байна уу гэдгээс асар их зүйл шалтгаалдаг байна.

Ихэнхи сүлжээний компанийн үүсгэн байгуулагчид болон захирал нь тухайн сүлжээнийхээ оройн хүмүүс байдаг нь тухайн компанийн нэрийг барьсан хувь хүний компани төдийхөн гэдгийг баталсан явдал юм. Тиймдээ ч компанийн үндсэн бодлогыг дураараа өөрчилж, бүтээгдэхүүний үнийг нэмэх, оноог нь багасгах, маркетинг төлөвлөгөөг нь өөрчлөх гээд компанийн эзний хүслээр өөрчлөх боломжтой... Үнэхээр хөрөнгө оруулалт нь бодитоор орж ирсэн



компанийн захиралыг цаад төв компаниас нь томилдог бөгөөд компанийн ажилчид нь сүлжээний маркетингаар ажилдаггүй, сүлжээний маркетингаар ажилдаг гишүүд нь компанийн дотоод ажилд ажилдаггүйгээр олон улсын худалдааны гэрээ конвенцийн хууль дүрэм журмын дагуу баримтаар баталгаажив явдаг.

Нөгөөтэйгүүр тухайн улсын хууль тогтоомжид нийцсэнээр тухайн сүлжээний маркетингаар ажилдаг компанийг найдвартай баталгаатай гэж үзэх боломжгүй. Жич: Оюуны өмч улсын бүртгэлийн газрын дарга хадагтай Болормаа нэгэн хэлэлцүүлэгт өгсөн яриандаа Монгол Улс нэг ч олон шатлалт маркетингийн аргаар үйл ажиллагаа явуулдаг компанид одоогоор зөвшөөрөл өгөөгүй бөгөөд өнөөгийн ажиллаж байгаа гэрчилгээ авсан компаниуд үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг гадаад дотоод худалдаа гэдэг нэрийн ард өнгөлөн далдалж хориотой хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа нь үнэн гэдгийг онцолсон байдаг.

Хуулиар хүлээсэн хяналт тавьж ажиллах ёстой чиг үүргийн дагуу Монгол улсын хууль хяналтын байгууллагууд болох СЗХ, УМХЕГ, ШӨХТГ, НЭМХ, УТЕГ, ЦЕГ гэх мэтчилэн мэгжлийн мэргэшсэн байгууллагууд Монгол улсад байгаа хэдий ч өнөөдөр бодит байдал дээр ЦЕГ-ганцаараа биечлэн энэхүү олон шатлалт маркетинг пирамид тогтолцоотой залилан луйварын гэмт хэрэгт гар бие оролцож ирсэн нь нууц биш. Бусад байгууллагууд нь одоо болтол манай чиг үүрэгт хамааралгүй асуудлаа хэмээн сүүлийн 2-жил хэлсээр ирсэн. Гэвч тийм юм уу гээд хуулийг судлаад нягтлаад үзэхээр жишээ нь зөрчлийн хуулийн 11.6-д зааснаар санхүүтэй холбоотой бүх асуудалд СЗХ-хяналт тавьж ажиллах үүрэгтэй гэж заасан байдаг бол ШӨХТГ-нь реклам зар сурталчилгаанд хяналт тавих ёстой гэж байх жишээний. УТЕГ-татвар төлдөггүй газруудад хяналт тавих үүрэгтэй, МХЕГ, НЭМХ мөн л олгосон гэрчилгээ, зөвшөөрөлдөө хяналт тавих ёстой гэж заагдсан байдаг. Эдгээр чиг үүргээ биелүүлдэггүй хяналт шалгалтаа сайн тавьдаггүй шулуухан хэлэхэд Шууд худалдаа сүлжээний тухай огт мэдлэггүй учраас яахаа мэдэхгүй бултсаар ирсэнтэй шууд холбоотой.

2008 онд 7 сүлжээний залилан, 2012-онд 13 сүлжээний залилан, 2017-онд 45 сүлжээний залиланг тус тус цагдаагийн

байгууллагад илчилэн өгч байсан бөгөөд 2018-он он гарсаар одоогийн байдлаар 42-н сүлжээг ил болгосон баримтуудаас харахад цаашид энэ төрлийн гэмт хэрэг хэр зэрэг далайцтай цэцэглэх нь тодорхой байгаа юм.

Өнгөрөгч 4-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний хугацаанд ЦЕГ-ын УСГХТХ-ээе зохион байгуулах залилах хгэмт хэргээс сэргийлэх аяны хүрээнд нийгэмд урьдчилан сэргийлэх нөлөөлөлийн ажлыг амжилттай зохион байгуулсаны хүчинд улсын хэмжээнд сүлжээний гэх тодотголтой залилан луйваруудыг МБА хазаарлаад зогсохгүй хайрцаглаж чадсан билээ. Энэ удаагийн сүлжээний давалгаа түүхэндээ 7-дахиа давалгаалж байгаа бөгөөд өнөөдрийн энд илтгэл тавьж та бүхэнд анхааруулж байгаа маань дахин 8-дахь давалгааг гаргахгүйн тулд, цаашид эзэнтэй болгож, төрийн хууль хяналтын байгууллагууд нягт уялдаа холбоотой ажиллаасай гэсний үндсэн дээр Монгол улс дахь бүх сүлжээний маркетингаар ажилдаг компаниудыг нэг мөр бүрэн цэгцлэх цаг нь ирчихсэн гэдгийг судлаач хүнийхээ хувьд дуулгаж байна. Хохирогчдыг тоо, хохиролын хэмжээг дурдаад ч ч хэрэггүй.

Хяналтаа сайжруулаад зогсоож чадах уу гэж!!!

Хэрхэн цэгцэлж урьдчилан сэргийлж ажиллах вэ?

Нэн яаралтай төрийн хууль хяналтын байгууллагуудаас тус бүр 3 хүнийг нэгтгэн олон шатлалт маркетинг пирамид тогтолцооны асуудал эрхэлсэн түр комиссыг ХЗДХЯ-ны дэргэд байгуулах шаардлагатай байна.

Өмнө нь АНУ энэ аргаар 1970-1976 онд, ОХУ-мөн энэ аргаар 1995-1999 онд цэгцэлж байсан түүхтэй.

Мөн хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж эзэнтэй хяналттай болгох шаардлагатай. Жишээ нь:

– Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 8.1.4-т заасан хориглосон үйл ажиллагаа бүхий хуулиас олон шатлалт маркетинг гэдэг үгийг хасах. Ингэснээр зөв буруу хоёуланг хориглосон хуулиас зөвийг нь авч цаашид шинжлэх ухааны үндэслэлтэй зөв хөгжих, далд биш ил тод болж хөгжих эхлэл нь тавигдана.

– Мөн Эрүүгийн хуулийн 17.3.2.3-т заагдсан залилах гэмт хэргийн хуулиас олон шатлалт маркетинг гэдэг үгийг хасах, эргээд пирамид тогтолцооны залилангын хэрэгт



өгдөг ялыг чангатгах, эд хөрөнгийг нь улсын орлого болгох. Ингэснээр Пирамид тогтолцоо Понзын систем дахин гадаадаас орж ирэх болон дотоодоос үүсэх боломж бүрэн хязгаарлагдаж дархлаатай болно. ХЗДХЯ-ны дэргэдэх олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны асуудал эрхэлсэн комиссын шийдвэрээр олон шатлалт маркетингаар үйл ажиллагаа явуулахад өндөр шалгуур тогтоон, шалгалтаар орж өндөр хяналтын дор тусгай зөвшөөрөл өгч зөвшөөрөх. Ингэснээр олон шатлалт маркетингаар үйл ажиллагаа явуулдаг зөв компаниуд нь галгалтаар тогтоогдож энэ чиглэлийн тун цөөхөн шууд худалдааны компани үйл ажиллагаа явуулдаг болно, яваандаа Монголын гэх анхны шууд худалдааны жинхэнэ компани байгуулагдаж тив дэлхийд Монголынхоо бараа борлуулах боломж нээгдэнэ.

– Бүртгэлийн тухай хуулинд олон шатлалт маркетингаар үйл ажиллагаа явуулах нэршлийг оруулах, Ингэснээр одоогийн гадаад дотоод худалдаа гэдэг нэрийн ардах өнгөлөн далдлагдсан үйл ажиллагаа бүрэн зогсоно.

– Зар сурталчилгааны тухай хуулинд хуулиар хориотой үйл ажиллагааг сурталчлахыг хатуу хориглох, сурталчилсан бол тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгож чангаруулах. Ингэснээр өнөөдрийн пирамид тогтолцооны телевизийн болон сайтуудын, сонингуудын сурталчилгаа бүрэн зогсож шууд худалдаа жинхэнэ зөв замаараа хөгжих эхлэл тавигдана.

– БИХНТБ-ний тухай хуулинд БИХНТБ-ний аливаа өвчинг эдгээж анагаах гэж сурталчлах, анагаах ухааны дүгнэлт гаргахыг хориглосон журмыг хуулинд оруулан дахин чангатгах. Ингэснээр өнөөдрийн БИХНТБ-ний худал хуурмаг сурталчилгаа бүрэн зогсож эрдэнэт хүн алтан амиа алдахгүй болно.

– Төрийн албан хаагчын тухай хуулинд хуулиар хориотой үйл ажиллагаанд оролцсон нь нотлогдвол төрийн албанаас хөөдөг болгох. Төрийн албан хаагч нь ямар нэгэн бизнестэй хутгалдахгүй бие даасан хувь хүн байх ёстой. Сонирхолтой нь өнөөдөр пирамид тогтолцоотой залиланд орсон хүмүүсийн 3/1-нь төрийн албан хаагчид байгааг анхааруулах юун.

– Татварын тухай хуулинд Шууд худалдаа, олон шатлалт маркетингийн салбарт ажилдаг гэрээ хийсэн хүмүүсийг нэг бүрчлэн бүгдийг нь ХХОАТ-төлүүлдэг

болгох. Ингэснээр шударгаар татвараа төлж улс орныхоо хөгжилд хувь нэмрээ нэр төртэйгээр оруулдаг болно.

– Энэ чиглэлийн өмчлөх эрхийн гэмт хэргийн мэдээлэгчийг өндөрөөр шагнадаг болох. Ингэснээр Монгол улсын хаана ч ямар нэгэн сүлжээний маркетингийг ашигласан хууль бус үйлдэлийн тухай мэдээлэлийг авч богино хугацаанд таслан зогсоох боломж бүрдэх бөгөөд үндэстний дархлаатай болно.

– Пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олдог залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сар бүр хийж байх. Ингэснээр аливаа ямар ч хэргийг болсоны дараагаар нь бус, асар их хохирогчид, хохирол үүссэний дараагаар нь бус болохоос нь өмнө таслан сэргийлдэг учраас өнгөрсөн 1-сарын аяны үр дүн маш сайн эерэг үзүүлэлт авчирсан нь цаашлаад энэ хэргийг гаргахгүй байхад их нөлөөлсөн.

– Энэ хэргийг шалгаж нягтлахад хамгийн их саад болж байгаа хохирогч гарч ирсэний дараагаар шалгадаг зогсоодог барилыг арилгаж харин асуудал үүсэхээс түрүүлж хөдлөн таслан зогсоодог хуулийн нарийн механизмтай болгох. Ингэснээр мөн л асуудлыг болсоны дараа бус болохоос нь өмнө таслан зогсоох боломж бүрдэнэ. Нэн ялангуяа эдийн засгийн онц ноцтой, улс үндэстэн дамнаж, зохион байгуулалттайгаар үгсэн хуйвалдаж бүлэглэн олуул үйлддэг хохирогч олонтой хохиролын хэмжээ асар өндөр, хяналтгүй мөнгө гадагш урсдаг, бохир мөнгө угаадаг энэ хэргийг түрүүлж хөдөлж таслан зогсоодог байх шаардлагатай.

– Монгол Улс худалдааны хуульгүй орон. Худалдааны хуулийг нарийн судалгаатай, шууд худалдааг дотор нь оруулж батлуулж хэрэгжүүлэх. Миний мэдэхийн худалдааны хууль 2004-оноос дуншсаар хамгийн сүүлд 2015-онд УИХ-д нэг орж ирээд сураг тасарсан. Энэ хуулийг гаргуулахгүй байх сонирхолтой монополь компаниуд олон байдаг нь ч нууц биш. Хэрэв хуультай болчихвол худалдаатай холбоотой маш олон асуудал цэгцэрч хэрэглэгчийн эрх ашиг өндөрт яригдах нигууртай.

– Хэрэглэгчийн тухай хуульд “Бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийн үйл ажиллагааг хууль бус пирамид тогтолцооны луйвар” гэж нарийвлан зааж оруулан түүнчлэн дараах үйлдлийг хориглох. Үүнд:



• Ямар нэгэн пирамид тогтолцооны луйврыг үүсгэн байгуулах, удирдан ажиллуулах, идэвхжүүлэх;

• Пирамид тогтолцооны луйварт санаатайгаар оролцох;

• Пирамид тогтолцооны луйварт бусдыг орохыг ятгах, хүчлэх;

Хэрэглэгчид хэрвээ пирамид тогтолцоонд оролцох буюу түүнийг идэвхжүүлбэл хөрөнгө оруулсан мөнгөө алдаад зогсохгүй, хуулийн дагуу хариуцлага хүлээдэг байна.

Ингэснээр Пирамид тогтолцоог чухам юу гэдгийг нэг бүрчлэн задалж, иргэд ч ойлгоход дөхөм хялбар болж байгаа юм. Мөн ШӨХТГ- хянах үүрэгтэй эзэнтэй болно.

– Төрийн хууль хяналтын мэргэшсэн байгууллагуудаар энэ төрлийн мэдэх ёстой хичээл сургалтуудыг үе шаттай бүх нэгжид улсын хэмжээнд зохион байгуулах.

Ингэснээр төрийн байгууллагын албан хаагчид мэдлэгтэй болоод зогсохгүй төрийн албан хаагчын дархлаатай болно.

– Энэ чиглэлийн тодруулбал Шууд худалдааны асуудлыг анхаардаг ТББ-уудтай хамтран ажиллах,

Олон Улсад ямар олон шатлалт маркетинг, пирамид тогтолцоог хэрхэн зохицуулсан тухай хэд хэдэн жишээнүүдээс татахад “Бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийн үйл ажиллагааг хууль бус пирамид тогтолцооны луйвар” гэж Дэлхийн олон улс орнуудад, тухайлбал, Албани, Австрали, Австри, Бельги, Бразил, Хятад, Колумб, Дани, Доминикан улс, Финлянд, Франц, Герман, Хонг Конг, Унгар, Исланд, Энэтхэг, Иран, Ирландын Бүгд Найрамдах улс, Итали, Япон, Малайз, Мальдив, Монгол, Мексик, Непал, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Перу, Филиппин, Польш, Португал, Румын, Африк, Испани, Шри Ланка, Швед, Швейцар, Тай, Тайланд, Турк, Украин, Нэгдсэн Вант Улс, АНУ, Англи, Канад, Колумб, Польш, Норвеги, Болгар, Япон, Итали, Непал, Филиппин, Өмнөд африк, Шри-Ланк, Мексик, Голланд, ОХУ зэрэг улсуудад пирамид тогтолцооны луйврыг хуулиар хориглосон байна. Ихэвчлэн эдгээр улс орнуудын “Хэрэглэгчийг хамгаалах” хуулинд дээрх заалтыг тусгасан байдаг байна. Түүнчлэн хууль тогтоомжуудадаа дараах үйлдлийг хориглосон байдаг. Үүнд:

• Ямар нэгэн пирамид тогтолцооны

луйврыг үүсгэн байгуулах, удирдан ажиллуулах, идэвхжүүлэх;

• Пирамид тогтолцооны луйварт санаатайгаар оролцох;

• Пирамид тогтолцооны луйварт бусдыг орохыг ятгах, хүчлэх

• Хэрэглэгчид хэрвээ пирамид тогтолцоонд оролцох буюу түүнийг идэвхжүүлбэл хөрөнгө оруулсан мөнгөө алдаад зогсохгүй, хуулийн дагуу хариуцлага хүлээдэг байна. Тухайлбал, АНУ-д пирамид тогтолцоог үүсгэн байгуулсан, түүнийг явуулж гүйцэтгэхэд тусалсан хүнийг арван мянган доллараар торгох, албадлагын хөдөлмөр хийлгэх, эсвэл арван жил хорих ялаар шийтгэх хуулийн заалттай (АНУ, Луизиана муж, “Competition Act”, зүйл 363)

• ОХУ-д 1990-ээд оноос эхлэн сүлжээний бизнес ихээхэн эрчимтэй хөгжиж, хууль ёсны томоохон компаниуд салбар, нэгжээ байгуулах ажиллаж байгаагын зэрэгцээ, үндэсний цөөнгүй компаниуд бий болсон байдаг.

Үүний зэрэгцээгээр хууль бус санхүүгийн пирамидууд ч олноор төрөн гарч, хүн амд үлэмж хэмжээний хохирол учруулсан олон жишээнүүд байна.

Энэ салбарт ОХУ-д манай улстай ижил төстэй нөхцөл байдал үүссэн нь сүлжээний бизнесийн хууль эрх зүйн бүрдээгүйтэй холбоотой байсан.

1998 онд Москва хотын захирагчийн “Москва хотын нутаг дэвсгэр дээр олон шатлалт, сүлжээний маркетингийн үйл ажиллагаа явуулах, түүнийг зохицуулах тухай”(1998.07.21, N754-PM) гэсэн тушаал гаргасан.

Энэхүү баримт бичигт “олон шатлалт, сүлжээний маркетинг гэдэг нь бараа, үйлчилгээг эцсийн хэрэглэгчдэд борлуулах, томоохон дистрибьюторүүдийг татах үйл ажиллагаа явуулсны төлөө дистрибьюторүүдэд урамшил олгож, бараа, үйлчилгээний борлуулалтын сүлжээ үүсгэж ажиллах сайн дураараа гэрээ байгуулсан хуулийн этгээд болон хувь хүний бизнесийн үйл ажиллагаа юм” гэж заажээ. Түүнчлэн, уг тушаалаар хотын захирагчийн албаны дэргэд олон шатлалт, сүлжээний маркетингийн хүрээнд тулгарч буй асуудлуудыг судалж шийдвэрлэх үндсэн чиг үүрэг бүхий зөвлөл байгуулж, ажиллуулахаар заасан байна. Мөн 1998. 07.21-ний өдрөөс эхлэн Москва хотод олон шатлалт, сүлжээний маркетингийн үйл ажиллагаа явуулах хувь, хуулийн этгээдэд



тусгай лиценз олгохоор тогтоол гаргасан байдаг байна...

Хятад улс олон шатлалт маркетингийг саяхнаас зөвшөөрч эхэлсэн бөгөөд мөн л тусгай зөвшөөрөл лицензээр шийдсэн байна. Лиценз нь 5-н жилийн хугацаанд үйлдвэрээ барьж 80 сая юаниар тусгай зөвшөөрлөө авдаг байна. Пирамид тогтолцоог хатуу хориглож цаазын хэмжээнд хүрсэн хатуу ялтай.

Ингээд эцэст нь Монгол улсад дотоодоос үүсэн сүлжээний маркетингаар үйл ажиллагаа явуулж байсан хар жагсаалттай танилцана уу.

д/д	Нэрс	Монголд нэгжтэй	Бүтээгдэхүүн	Маркетинг нь
1	1᠒-ний Аз жаргалын захиа	байхгүй	байхгүй	Понзын схем
2	Жавхланг Бадруулагч	байхгүй	байхгүй	Понзын схем
3	Олимп	байхгүй	байхгүй	Понзын схем
4	Зөөлөн эх	байхгүй	байхгүй	Понзын схем
5	Шинэ Санаа Төв	байсан	байхгүй	Понзын схем
6	ХЗХ-оод /200-орчим/	байсан	байхгүй	Понзын схем
207	Холливиуд	байхгүй	байхгүй	Понзын схем
208	Глобал Ньюс	байхгүй	байхгүй	Понзын схем
209	Байгалийн Нөхөр Сан	байсан	байхгүй	бинар
210	Математикийн Үйлдлийн Шинжилгээний Нийгэмлэг	байсан	байхгүй	бинар
211	Монголын Буддист Залуучуудын Холбоо	байсан	байхгүй	бинар
212	Итгэл Сан	байсан	байхгүй	бинар
213	Хоёр Эрдэм Сургалтын Төв	байсан	байхгүй	бинар
214	Эрдмийн Ундарга Сургалтын Төв	байсан	байхгүй	бинар
215	Оюуны Төв Сан	байсан	байхгүй	бинар
216	Элсэн Цаг	байхгүй	байхгүй	бинар
217	Швейцарь цаг	байхгүй	байхгүй	бинар
218	Дэбо ХХК	байсан	байхгүй	бинар
219	Байгаль ХХК	байсан	байхгүй	бинар
220	Эмба ХХК	байсан	байхгүй	бинар
221	Оюуны Зууч ХХК	байсан	байхгүй	бинар
222	Оюуны Хөтөч ХХК	байсан	байхгүй	бинар
223	Лаки Зон ХХК	байсан	байхгүй	бинар
224	ЖТД ХХК	байсан	байхгүй	бинар
225	Ундрэм Цацрах ХХК	байсан	байхгүй	бинар
226	Даяар Хишигтэн ХХК	байсан	байхгүй	бинар
227	Эрүүл амьдралын төлөө хөгжлийн хөтөч ТББ	байсан	байхгүй	бинар
228	Айсуй жаргал ТББ	байсан	байхгүй	бинар
229	Барагдашгүй алмаз ХХК	байсан	байхгүй	бинар
230	Чингис Хаан Дэлхийн Академи	байсан	байхгүй	бинар
231	Хөгжлийн хөтөч ТББ	байсан	байхгүй	бинар
232	Говийн хөгжлийн ирээдүй ТББ	байсан	байхгүй	бинар
233	Байгаль эрдэнэ сан	байсан	байхгүй	бинар
234	Хүсэл мөрөөдлийн хүч ХХК	байсан	байхгүй	бинар
235	Монгол максимум ХХК	байсан	байхгүй	бинар
236	Ундрэм цацрах ХХК	байсан	байхгүй	бинар
237	Түшигт хаан цэцээ ТББ	байсан	байхгүй	бинар
238	Мон Үндэс-44 ХХК	байсан	байхгүй	бинар
239	Хүслийн хүч ТББ	байсан	байхгүй	бинар
240	Дэлхийг тойрон аялагчдын клуб ТББ	байсан	байхгүй	бинар
241	Ерхөг ХХК	байсан	үндэсний үйлдвэрлэлийн болон хүнсний бараа	бинар, матриц



243	Арвай ХХК	байсан	үндэсний үйлдвэрлэлийн болон хүнсний бараа	бинар, матриц
244	Талын сувд ХХК	байсан	Үндэсний үйлдвэрлэлийн бараа	бинар, матриц
245	Их Баяндалай ХХК	байсан	Үндэсний үйлдвэрлэлийн бараа	бинар, матриц
246	Алтан өндөг	байхгүй	байхгүй	Понзын схем
247	Хоох.mn	байсан	Үндэсний үйлдвэрлэлийн бараа	бинар, матриц
248	Юнит циклер ХХК	байсан	байхгүй	бинар, матриц
249	Зэс Эрдэнийн Хувь ХХК	байсан	байхгүй	Понзын схем
250	Соломо Монгол	байхгүй	байхгүй	бинар
251	МЕЕС.mn MONGOLIAN EKO PROJECT	байсан	Үндэсний үйлдвэрлэлийн бараа	бинар
252	ШАР АЙ ГАЛ ХХК	байсан	байхгүй	бинар
253	GOLDEN STYLE ХХК	байсан	байхгүй	матриц
254	МОНГОЛЫН ШУУД ХУДАЛДААНЫ НИЙГЭМЛЭГ ТББ	байгаа	байхгүй	Понзын схем
255	ТОС КОЙН	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем

Монгол Улсад гадаадаас орж ирсэн сүлжээний маркетингаар үйл ажиллагаа явуулж байсан хар жагсаалт.

д/д	Нэрс	Монголд нэгжтэй	Бүтээгдэхүүн	Маркетинг
1	Vision	байхгүй	байхгүй	бинар
2	Ipsumconcert	байхгүй	байхгүй	бинар
3	One to one	байхгүй	байхгүй	бинар
4	Zibycom	байхгүй	байхгүй	бинар
5	Gold Quest	байхгүй	байхгүй	бинар
6	Golden Cikal	байхгүй	Бугуйн цаг	бинар
7	My Lexxus Europe	байхгүй	Алура тос, нүүрний маск	бинар
8	KGC	байхгүй	Алура тос, нүүрний маск	бинар
9	Argo	байгаа	100-орчим нэрийн гоо сайхан, БИХНТБ	олон үет
10	Vladimir Dovgan	байсан	40-орчим нэрийн гоо сайхан, БИХНТБ	матриц
11	Lexxus international	байхгүй	Алура тос, нүүрний маск	бинар
12	Липин	байхгүй	10-орчим нэрийн цахилгаан бараа	бинар
13	Glorion	байхгүй	5-орчим нэр төрлийн магниттай зүүлт	бинар
14	None	байхгүй	5-н төрлийн жүүс	бинар
15	Prime Gold Bank	байхгүй	байхгүй	бинар
16	Tin tile	байхгүй	10-н төрлийн БИХНТБ	бинар
17	Mageric	байхгүй	5-н төрлийн БИХНТБ	бинар
18	Меридиан Арт	байхгүй	уран зураг	бинар
19	Enleven international	байхгүй	5-н төрлийн бараа	бинар
20	Ялма	байхгүй	200-орчим нэрийн БИХНТБ	матриц
21	Фарма	байхгүй	300-орчим нэрийн БИХНТБ	матриц
22	INFINTY	байсан	500-гаран нэрийн Гоо сайхан, БИХНТБ	Олон үет
23	G-Time	байсан	10-орчим нэрийн гоо сайхан, цаг, сувенир	Бинар, матриц
24	Хонг конгын 520\$	байхгүй	Аялал	бинар
25	Onecoin, Onelife	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
26	Easy lup	байхгүй	байхгүй	бинар
27	Канген	байсан	Ус цэвэршүүлэгч	бинар
28	Bitcoin	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
29	Redex	байхгүй	байхгүй	Понзын схем



30	GBS	байхгүй	байхгүй	Бинар, матриц
31	Услада хаан	байгаа	Дэр, ахуйн хэрэглээ	матриц
32	Ultimatecycler	байхгүй	байхгүй	Бинар матриц
33	BML буюу Phyto Science	байгаа	Үүдэл эс гэх жүүс	Бинар, матриц
34	LR	байхгүй	Гоо сайхан	Олон үет
35	1-9-90	Байхгүй	байхгүй	Бинар, матриц
36	ORGANO GOLD	байхгүй	байхгүй	Понзын схем
37	QUESTRA WORLD	байхгүй	байхгүй	Понзын схем
38	QNET	байгаа	бараатай	Бинар матриц
39	ALIVEMAX	байгаа	4-төрлийн жимсний охь, хүнс	бинар
40	Atlanticgam	байхгүй	байхгүй	Понзын схем
41	Savvy safe	байхгүй	байхгүй	Бинар матриц
42	ШИ РИУ АЙН ХХК	байгаа	10-нэрийн БИХНТБ	бинар
43	LUCK LIFE	байгаа	10-нэрийн БИХНТБ	бинар
44	FOHOW	байгаа	30-нэрийн бараатай	бинар
45	3-H SSS	байгаа	10-нэрийн бараатай	Бинар, матриц
46	GLOBAL INTER GOLD	байхгүй	байхгүй	Понзын схем
47	GLOBAL CONVENTION GOLD EXHIBITION	байхгүй	байхгүй	Понзын схем
48	FIVE WINDS ASSET MANAGEMENT	байхгүй	байхгүй	Понзын схем
49	BILLCOIN	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
50	STAMFORD	байхгүй	байхгүй	Понзын схем
51	ISEIKO WORLD	байхгүй	байхгүй	Понзын схем
52	ALTYN NURLY GASYR	байхгүй	Казахын гар урлалын бараа	бинар
53	ШИНЬ ШИ МИН ХХК	байгаа	10-нэрийн БИХНТБ	бинар
54	NANO ECO	байгаа	наалт	Бинар матриц
55	RESONANCE CAPITAL	байхгүй	байхгүй	Понзын схем
56	TNT	байхгүй	байхгүй	Понзын схем
57	ABA MARKETING	байхгүй	байхгүй	Понзын схем
58	STERIUM	байхгүй	байхгүй	Понзын схем
59	ENTERIUM	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
60	PLATINCOIN	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
61	MASSCOIN	байхгүй	Цахим мөнгө	Понзын схем
62	TRANSFER FACTOR буюу 4LIFE	байгаа	бараатай	Олон үет
63	FABERLIC	байгаа	бараатай	Олон үет
64	UNICITY	байгаа	бараатай	Олон үет
65	NSP	байгаа	бараатай	Олон үет
66	GANO EXCEL	байгаа	бараатай	Олон үет
67	СИБИРИЙН ЭРҮҮЛ МЭНД.	байгаа	бараатай	Олон үет
68	MARY KAY	байгаа	бараатай	Олон үет
69	HERBALIFE	байгаа	бараатай	Олон үет
70	AVON	байгаа	бараатай	Олон үет
71	NU SKIN	байгаа	бараатай	Олон үет
72	IVES ROCHERS	байгаа	бараатай	Олон үет
73	AMWAY	байгаа	бараатай	Олон үет
74	FOREVER	байгаа	бараатай	Олон үет
75	DXN	байгаа	бараатай	Олон үет
76	ORIFLAME	байгаа	бараатай	Олон үет



ХИЛИЙН МАНАА БИЕИЙН ХҮЧ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ АЛДАА, ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Б.Зулбадрах

ХСИС-ийн ЭШХ-ийн Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант, дэд хурандаа

Хураангуй: 2016-2017 онд Монгол Улсын Хилийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Дотоодын цэргийн тухай болон Батлан хамгаалах багц хуулиудын шинэчилсэн найруулга, шинэ хууль Улсын Их Хурлаар батлагдаж, тус хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон Засгийн газар, яам, агентлагийн сайд, дарга нарын тушаал, зааврууд гарч, эдгээр хууль, тушаал, зааврууд нь Улсын хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагаанд эрх зүйн шинэ орчин, өөрчлөлтийг бий болгож байна. Улсын хил хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа хилийн анги, салбар, харуул, манаанаас хилийн болон хил орчмын дэглэм зөрчигч, зөрчихийг завдагч, түүний хамсаатан, гэмт этгээдийг илрүүлэх, саатуулах, хуяглан хүргэх явцад биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх хэрэгцээ, шаардлага үүсч байдаг. Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө хилчдийн зүгээс биеийн хүч, тусгай хэрэгсэл, албаны нохой хэрэглэх хэм хэмжээг заагаагүй, тэр нь тодорхой бус, хууль эрх зүйн хувьд баталгаажгаагүй байсан тул галт зэвсэг хэрэглэж, тэр нь их хэмжээний хор уршиг дагуулж, хүний алтан амь эрсдэх, хилчид өөрсдөө эрүүгийн хариуцлага хүлээх явдал гарч байсан. Хилийн тухай хууль, дүрэм, зааврууд шинэчлэгдэж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар шинэ заалтууд орсон тул үүссэн нөхцөл байдал тохирсон зөв шийдвэр гаргах өргөн боломж, нарийн шаардлага тулгарч байна. Иймд хилчдийн гаргаж болзошгүй алдаа, зөрчлөөс сэргийлэх, улсын хил дээр үүссэн нөхцөл байдлыг зөв үнэлж, зөв шийдвэр гаргахад туслах зорилгоор Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг энэхүү илтгэлд тусгасан.

Түлхүүр үг: Хил хамгаалалттай

холбогдолтой хууль, эрх зүйн шинэчлэл, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрх зүйн акт, гарч болзошгүй эрх зүйн зөрчил, сэргийлэх арга зам.

Хил хамгаалах байгууллагаас шинээр батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд “Хил хамгаалах байгууллагын алба хаагч, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар”^[74], “Хил хамгаалах байгууллагад хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт”^[75], “Хил хамгаалах албаны бэлэн байдлын журам”^[76], “Хилийн төлөөлөгчийн албаны заавар”^[77], “Хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”^[77], “Монгол Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх журам”^[78], “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”^[79], “Штамп эзэмших, ашиглах, хадгалах журам”^[79], “Хилийн хуудасашиглах, хэвлүүлэх журам”^[80], “Шалган нэвтрүүлэх албаны үйлчилгээний стандарт”^[81], “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”^[82], “Албаны нохой бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”, Хилийн отряд, заставын зэрэглэлийг тогтоох тухай, Хилчний хувцас хэрэглэл, хүнсний хангамжийн норм, хилийн нэмэгдлийг тогтоох тухай, Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл тогтоох тухай... зэрэг 20 орчим эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал,

⁷⁴ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт,

⁷⁵ Мөн тушаалын 2 дугаар хавсралт

⁷⁶ ХХЕГ-ын даргын 07 дугаар сарын 26-ны өдрийн Н/56 дугаар тушаал.

⁷⁷ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/49 дугаар тушаал

⁷⁸ ХХЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/131 дугаар тушаал.

⁷⁹ ХХЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/112 дугаар тушаал.

⁸⁰ ХХЕГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/83 дугаар тушаалын 2 дугаар хавсралт.

⁸¹ ХХЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/45 дугаар тушаал

⁸² Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/70, А/174 дугаар хамтарсан тушаал.



улсын хил халдашгүй дархан байна”^[83] гэж заасан бөгөөд улсын хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээж, хил хамгаалах албан үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч Хилийн тухай хуулийн дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхийг хуулиар баталгаажуулсан.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, тохиолдлуудыг зааж өгсөн боловч хил хамгаалалтын практикт эргэлзээтэй олон асуудлуудтай тулгардаг. Үүнд: хилийн манаанаас 500 м зайтай газраар хил зөрчихөөр явж байгаа автомашиныг яах вэ? Мал нь хил даваад араас нь малаа авахаар хил зөрчин орж ирсэн хил залгаа улсын малчныг яах вэ? Хилийн манааны шаардлагыг үл биелүүлсэн этгээд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийн алиныг эхлэн хэрэглэх вэ? Хил зөрчигч явган зугатаагаад, хилийн манаанд гүйцэгдэхгүй хил давах гэж байвал яах вэ? Хил зөрчигчийн биед үзлэг хийх үед эсэргүүцэл үзүүлбэл яах вэ? Олон нохой дагуулсан буутай хил зөрчигчийг саатуулах үед нохойгоо турхирч дайруулсан тохиолдолд яах вэ? Хил зөрчөөд нутгийн гүн рүү зугатаасан хурд, хүч, туулах чадвар сайтай автомашиныг яах вэ? Хил зөрчиж, хил орчмын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж байгаа онгоц, нисдэг тэргийг яах вэ? Хил даван застав, харуулын байрлалд нислэг үйлдэж байгаа нисгэгчгүй нисэх хэрэгслийг яах вэ? Богино зайд хил зөрчин ан хийж байгаа хил залгаа улсын хилийн албаны хүмүүсийг яах вэ? Хилийн манаа тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэсний дараа ямар арга хэмжээ авах вэ? Үүнтэй төсөөтэй олон тохиолдлуудад хилийн манаа харилцан адилгүй шийдвэр гаргаж, зарим тохиолдолд шийдвэр мэргэн байдаг бол зарим тохиолдолд бурууддаг. Иймд хилийн манаа нь хил залгаа улсын Хил хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа, цэрэг, улс төрийн байдал, улсын хил дээр үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийж, Олон Улсын гэрээ, хэлэлцээр, Хилийн тухай хууль, тогтоомж, дүрэм, зааврууд, бусад хууль, журмыг зөрчихгүйгээр үүссэн нөхцөл байдалд тохирсон зөв шийдвэрийг богино хугацаанд гаргахад туслах зорилгоор энэхүү өгүүлэлд эрх зүйн зарим тайлбарыг

оруулсан.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж^[84], тус хуулиар хилчид биеийн хүч хэрэглэх^[85], нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх^[86], тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл^[87] болон албаны нохой ашиглах^[88] талаар шинээр заалт оруулж, Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаанаас галт зэвсэг хэрэглэх талаарх заалтад өөрчлөлт оруулсан^[89] зэрэг эрх зүйн шинэ зохицуулалтыг хуульчилж өгсөн нь галт зэвсэг хэрэглэх явдлыг бууруулах, түүнээс үүдэн гарч болзошгүй хохирлыг багасгах ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хилийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ тавдугаар бүлгийн 40-48 дугаар зүйлд заасны дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, албаны нохой, галт зэвсэг хэрэглэхийг хуулиар зөвшөөрсөн хэдий боловч буруу хэрэглэсэн тохиолдолд залруулж болохгүй алдаа, хор уршгийг дагуулдаг болохыг хатуу анхаарч энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан журам, зааврыг хилийн манаа, хилчин нэг бүрд хүргэж, сургалт дадлага явуулах нь болзошгүй ажиллагааны үед ажиллах дадлага чадварыг бий болгодог. Энэхүү дадлагыг заставын дарга өөрөө биечлэн хариуцаж өдөр бүр томилгооны хуваарийн дараа 5-10 минут жагсаалын талбайд хилийн албаны тактикийн бодлого бодуулах жүжигчилсэн тоглолт байдлаар явуулахад бүрэлдэхүүн амархан дадлагаждаг, отрядын төвд тусгай хөтөлбөрөөр сургалтыг явуулж, үзүүлэх хичээл, хээрийн гаралтаар бататгаж байх нь оновчтой байдаг.

Нэг. Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх. Улсын хилд үүрэг гүйцэтгэж байгаа хилчин үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж, нэг бүрийн тусгай хэрэгслийг Монгол улсын Хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр бие даан шийдвэр гаргаж хэрэглэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх явцад эсхүл нэг бүрийн тусгай хэрэгсэл байхгүй, түүнийг хэрэглэх боломжгүй үед Хилийн

⁸⁴ Төрийн мэдээлэл. Дугаар 06. 2017 он., УБ.

⁸⁵ Монгол Улсын Хилийн тухай хууль. /шинэчилсэн найруулга/ 40 дүгээр зүйл., 2016 он. УБ.

⁸⁶ Хилийн тухай хуулийн 41, 42, 43, 44, 45 дугаар зүйл.

⁸⁷ Хилийн тухай хуулийн 46 дугаар зүйл.

⁸⁸ Хилийн тухай хуулийн 47 дугаар зүйл.

⁸⁹ Хилийн тухай хуулийн 48 дугаар зүйл.

⁸³ Монгол Улсын Үндсэн хууль. Нэгдүгээр бүлэг. 4 дүгээр зүйл. 1 дэх заалт. 1992 он., УБ.



тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр биеийн хүч хэрэглэнэ. Биеийн хүч хэрэглэх гэж хилчин өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг ойлгоно.^[90]

Тусгай хэрэгсэл гэж хилийн манаа, бүлэг улсын хилийн бүс, зурвас, боомтод албан үүрэг гүйцэтгэх үед хил орчмын иргэд, байгууллага, хилчдийн амь нас, эрүүл мэндэд хил зөрчигч, гэмт этгээдийн зүгээс халдлага үйлдэх, боомтын аюулгүй байдлыг сахиулах, таслан зогсоох үед хэрэглэх зориулалт бүхий тусгай хэрэгсэл, төхөөрөмж^[91] -ийг хэлнэ.

Хилийн манаа нь хил зөрчигчийг саатуулах, баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд биеийн хүч хэрэглэхийг урьтал болгохгүйгээр урьдчилан сануулж, нэг бүрийн тусгай хэрэгслээ хэрэглэж аюулгүй байдлаа хангана. Учир нь хил зөрчигч тулааны болон самбо, жудогийн хориотой техник эзэмшсэн, бэлтгэгдсэн хүн байж болох талтай.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг Хилийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр хэрэглэнэ. /ХЗДХ-ийн сайдын А/160 дугаар тушаалаас/

Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч тусгай хэрэгслийг хэрэглэх зааварт дараах шаардлагууд тавигддаг^[92] Үүнд:

1. Алба хаагч нь биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамрагдсан байх. Хил хамгаалах, хууль сахиулах албан үүргээ гүйцэтгэхийн тулд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, өрсөлдөгч этгээдийг гэмтээж эрхшээлдээ оруулах, барьж баривчлахад биеийн хүч, тусгай хэрэгсэл ашиглах сургалт нь чиглэгддэг^[93]. Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалт нь гүйцэтгэх үүргээрээ саатуулах, баривчлах, үзлэг хийх, өөрийгөө хамгаалах, бусдыг

хамгаалах, журам сахиулах, амьд үлдэх..., сургалтын төрлөөрөө үндэсний бөх, жудо, байлдааны самбо, карате ... гэх мэт олон хэлбэртэй байдаг бөгөөд тухай бүрдээ өөрийн гэсэн онцлогтой тул сургалтын хөтөлбөрийг боловсруулахад анхаарах шаардлагатай. Хамгийн гол нь эрх зүйн мэдлэг буюу Хилийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн бүх заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/160 дугаар тушаал, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг нарийн судлуулж, дадлага хийлгэж хэвшил болгосноор болзошгүй аюулаас сэргийлнэ.

2. Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах. Урьдчилан сануулснаар Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 40 дүгээр зүйлд заасан биеийн хүч хэрэглэх, 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2, 43.1.3, 43.1.7, 43.2-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхээр заасан нөхцөл байдал өөрчлөгдөж улмаар биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх шаардлагагүй болох боломжтой. Иймд урьдчилан анхааруулах нь чухал ач холбогдолтой.

3. Үүссэн нөхцөл байдалд иргэд, байгууллагад хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх. Иргэд байгууллагад хамгийн бага хохирол учруулах боломж нь нөхцөл байдалд тохирсон зөв шийдвэр гаргахаас шууд шалтгаалдаг.

4. Хүнлэг бус харьцаанаас ангид байх. Хилчид ёс суртахуунгүй үйлдэл гаргахгүй, хараалын үг хэллэг хэрэглэхгүйгээр хуулийг хэрэгжүүлж, үүссэн нөхцөл байдлыг арилгана гэсэн үг. Биеийн хүч, тусгай хэрэгслийг хэрэглэх гэдэг нь бусдын амь нас, эрүүл мэндийг хохирооно гэсэн үг биш. Энэ шийдвэр залруушгүй алдаанд хүргэж мэднэ. Хил зөрчигч, гэм буруутай этгээд ч гэсэн хүн. Магадгүй, нэгэн өрхийн амьдралыг үүрч яваа хүн байж болох тул тэднийг өнчрүүлж хэрэггүй, хүнлэг бай. Хүнлэг байснаар болзошгүй гэмт хэргээс өөрийгөө хамгаална.

5. Бусдын биед гэмтэл, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх. Гэмтэж, эрүүл мэндэд хохирол учирсан хүн нь хэн ч байлаа гэсэн эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, хамгийн ойрхон байгаа эмнэлэг, эмчийн үзлэгт оруулах шаардлагатай. Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол шууд захирах даргад даруй илтгэж, илтгэх хуудсаар танилцуулна. Шууд захирах дарга^[94]

⁹⁰ Монгол Улсын Хилийн тухай хууль. Тавдугаар бүлэг. Тайлбар хэсэг. 2016 он. УБ.

⁹¹ Монгол Улсын Хилийн тухай хууль. Тавдугаар бүлэг. Тайлбар хэсэг. 2016 он. УБ.

⁹² Монгол Улсын Хилийн тухай хууль. Тавдугаар бүлэг. Тайлбар хэсэг. 2016 он. УБ.

⁹³ С.Хаянгарваа. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 407 дугаар тал. 2016 он., УБ.

⁹⁴ Цэргийн дотоод албаны дүрэм. Хоёрдугаар бүлэг. 21



харьяа нутаг дэвсгэрийн прокурорт нэн даруй мэдэгдэнэ. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг эмнэлгийн тусламж, үйлчилгээг яаралтай үзүүлж чадах тийм нөхцөлд ашиглах хэрэгтэй. Учир нь тэдний дунд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бэртэл гэмтэлтэй, хууч өвчтэй хүмүүс байх тул амь насаа алдаж болох өндөр эрсдэлтэй юм. Хэрэв командлагчаас шийдвэр ирж олон хүнд нөлөөлөх хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд үйл ажиллагааны явцыг гэрэл зураг, дуудүрсний бичлэгээр баримтжуулах бүлгийг томилж ажиллуулна. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэсэн даруй тухайн ажиллагааг удирдсан албан тушаалтан Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагчид илтгэнэ^[95]

Хил хамгаалах байгууллагад хэрэглэгдэх тусгай хэрэгслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/160 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан бөгөөд хүн нэг бүрийн тусгай хэрэгсэлд 25, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд 5, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэлд 2 төрлийн тусгай хэрэгслийг зааж өгсөн. Эдгээр тусгай хэрэгсэлд ороогүй хэрэгслийг ашиглах, гарын доорхи материалыг тусгай хэрэгслийг орлуулан хэрэглэх талаар хуульд заагаагүй, зааварт тусгагдаагүй тул аргагүй хамгаалалтаас бусад тохиолдолд хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Хилийн заставын тусгай хэрэгсэлд шаардлагатай зүйлсийн талаар ХСИС-ийн сургуулийн Удирдлагын академийн 24, Хил судлалын магистрын ангийн 36, Хилийн 0146 дугаар ангийн 56 офицер, нийт 116 хүнээс судалгаа авч, үр дүнг нэгтгэсэн. Хилийн тухай хууль, Хил хамгаалах байгууллагад ашиглах тусгай хэрэгслийн жагсаалтад ороогүй, судалгаанд хамгийн их санал өгсөн дараах тусгай хэрэгслүүд байгааг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Хар тамхины сорьц, хурууны хээ авах хэрэгсэл, ул мөр баримтжуулах хэв, биеийн дулаан хэмжих багаж, томруулагч шил, шүгэл, GPS, энгэрийн нууц дуу дүрс бичигч, нүдний боолт, чанга яригч, камертай дуулга малгай, уян камер, сансрын холбоо, олс /бөөн иргэдийг хэсэгчлэн хуваах/, уул, цасанд авирах улавч, гутлын гинж, муурын хумс, цан, байршил мэдээлэгч чип, хийлдэг гудас, бороо цаснаас хамгаалах нөмрөг, дүгээр заалт. Шууд захирах дарга.

⁹⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 1 дүгээр хавсралт. 5.10 дугаар заалт.

торон буу, нүүрний будаг, талбай тусгаарлах тууз, усны хамгаалалттай хайрцаг, флаш диск, толгойн гэрэл гэгсэн нь жагсаалтад ороогүй хил хамгаалалтад хэрэгцээтэй тусгай хэрэгслүүд олон байгааг харуулж байна.

Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчин биеийн хүч хэрэглэх үед гаргаж болзошгүй алдаа, түүнээс сэргийлэх. Үүнд:

- Тухайн нөхцөл байдлыг дутуу үнэлж, хүч хэрэглэх сонголтоо буруу хийх. Энэ нь тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх нөхцөл байдлыг дутуу үнэлснээс хилчид хариу халдлага довтолгоонд өртөх аюултай.

- Харилцаж байгаа этгээдийн нас, хүйс, биеийн хэмжээ, эсэргүүцэл үзүүлэх чадварыг буруу үнэлэх. Энэ тохиолдолд бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах, аль эсвэл хариу үйлдэлд өртөх аюултай.

- Тухайн этгээдийн ойр орчиндоо болон бусдад учруулж болох аюул, эрсдэл, биедээ нуусан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг дутуу тооцоолох. Тиймээс биеийн хүч хэрэглэхээс өмнө биедээ авч яваа бүх зүйлийг газарт хаяулан түүнээс 10 м холдуулсны дараа биеийн хүч хэрэглэж баривчлах, саатуулах ажиллагааг явуулах хэрэгтэй.

- Амьд үлдэх тулааны хориотой мэх хэрэглэж, харилцагч этгээдийн бие махбодид хүнд гэмтэл учруулах. Тухайн нөхцөл байдал, харилцагч этгээдэд тохирсон биеийн хүчний арга хэлбэрийг сонгож баривчлах, саатуулах, аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Биеийн хүч хэрэглэсний дараа харилцагч этгээдэд зовиуртай шинж илэрсэн үед эмнэлгийн тусламжийг яаралтай үзүүлэх, эмч, эмнэлгийн байгууллагад хандах. Харилцагч этгээд суурь өвчтэй, гэмтэл бэртэлтэй байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчин тусгай хэрэгсэл хэрэглэх үед гаргаж болзошгүй алдаа, зөрчил түүнээс сэргийлэх. Үүнд:

- Тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг буруу гаргах. Нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг улсын хилд үүрэг гүйцэтгэж байгаа хилчин бие даан гаргадаг байхад тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг хилийн анги /салбар/-ийн захирагч, эсхүл тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг Хил



хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч тус тус гаргадаг.

- Тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэр нь үүссэн нөхцөл байдал, хуульд заасан үндэслэлтэй тохироогүй байх. Нэг бүрийн тусгай хэрэгслийг Монгол Улсын хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1-д заасан 8 тохиолдол, 2-д заасан 3 тохиолдолд хэрэглэдэг байхад олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг тус хуулийн 45.2-д заасан 5 тохиолдолд 45.3.1, 45.3.2, 45.4 -д заасан анхааруулга, мэдээлэл хийж, 45.5-д заасан хугацаанд, үйлдлээ зогсоогоогүй, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн бол хэрэглэдэг. Харин тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг Хилийн тухай хуулийн 46.1-д заасан 3 тохиолдолд хэрэглэхийг зөвшөөрдөг бол 46.2-д заасан тохиолдолд хориглодог.

- Хүний биеийн хориглосон хэсэгт тусгай хэрэгсэл хэрэглэх, тусгай хэрэгслийг хэрэглэх хугацаа, зай, хэмжээ, орчин нөхцөл, аргаа буруу сонгох. Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх зааварт гав, хүлэг, ороох цамц, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резин болон хуванцар, үрлэн сумтай буу, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх^[96] талаар тодорхой заавруудыг тусган оруулсан байгаа бөгөөд хэрэглэх явцад эдгээр зааврын зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ^[97] гэж заасан. Иймд эдгээр заалтуудыг хилчин бүр мэдэж, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ баримталж хэвшсэнээр эрх зүйн зөрчил гаргахгүй байх нөхцөл бүрэлдэнэ.

Хоёр. Галт зэвсэг хэрэглэх. Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь Хилийн тухай хуульд зааснаар урьдчилан анхааруулж болон анхааруулахгүйгээр галт зэвсгийг хэрэглэдэг. ХХЕГ-ын даргын н/24 тоот тушаалд хилийн манааны ахлагчийн шийдвэрээр галт зэвсэг хэрэглэхээр зааж өгсөн. Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд “галт зэвсэг” гэж даринь шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу

⁹⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 3, 4, 5 дугаар заалт

⁹⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 6 дугаар заалт

болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг^[98], “байлдааны зориулалтай галт зэвсэг” гэж байлдааны болон тусгай ажиллагаандашиглах зэвсэг, галт хэрэгсэл, түүний эд ангийг^[99] тус тус заасан байдаг.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь урьдчилан анхааруулахгүйгээр дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ^[100] гэж заасан.

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг няцаахын тулд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. Энэ заалт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн аюулгүй байдалд цэрэг, зэвсгийн хүчээр түрэмгийлэл үйлдсэн тохиолдолд дайсан этгээдэд байлдааны зэвсгээр боломжит бүх хөнөөлийг гэнэт учруулах талаар тусгасан.

2. Улсын хил дээр үүссэн зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоохын тулд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. Хилийн тухай хуульд зэвсэгт өдөөн хатгалгын үед урьдчилан анхааруулахгүйгээр^[101], өдөөн хатгалгын үед урьдчилан анхааруулж зэвсэг хэрэглэхээр заасан.^[102]

Монгол Улсын цэргийн номлолд “Зэвсэгт өдөөн хатгалга”-ыг дайн, зэвсэгт түрэмгийлэлд турхирч буй анхны хэлбэр гэж үздэг бөгөөд энэ нь улсын хил давж, зэвсэг хэрэглэн дээрэм, тонуул хийх хэлбэрээр илэрдэг. “Хорлон сүйтгэх” гэдгийг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор барилга байгууламж, зам, мэдээлэл, холбооны хэрэгсэл, үндэсний шинж чанартай мэдээллийн сан, архив, хүн амын амьдралыг хангах объектыг сүйтгэсэн, гэмтээсэн, үйл ажиллагааг нь доголдуулсан; хүн, амьтан, ургамлын гоц халдварт өвчин тараасан^[103]...” гэж Эрүүгийн хуульд заажээ. Эндээс дүгнэлт хийхэд Монгол Улсын үндэсний

⁹⁸ Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль. 1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт. 2015 он., УБ.

⁹⁹ Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль. 1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт.

¹⁰⁰ Монгол Улсын Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 48 дугаар зүйлийн 48.1 дүгээр заалт.

¹⁰¹ Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.1.2 дугаар заалт.

¹⁰² Монгол Улсын Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дүгээр заалт.

¹⁰³ Монгол Улсын Эрүүгийн хууль. 19.6 дугаар зүйл. Хорлон сүйтгэх. 2015 он., УБ.



аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор улсын хил давж, дайн түрэмгийлэлд турхирсан үйлдлийг урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэж таслан зогсооно гэсэн үг.

3. Хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоохын тулд урьдчилан анхааруулахгүйгээр зэвсэг хэрэглэх.

Эрүүгийн хуульд “Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно^[104]. Эсэргүүцэл гэдэг нь хил зөрчигч, гэм буруутай этгээдийг саатуулах явцад өөрийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул, хор уршиг учруулахаар хийж буй үйлдлийг хэлнэ. Эсэргүүцэл нь эс үйлдлийн шинжтэй байж болохгүй. Өөрөөр хэлбэл хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцэл бодитоор үүссэн үед аргагүй хамгаалалтын хэлбэрээр галт зэвсэг хэрэглэнэ гэсэн үг. Энэ тохиолдолд зэвсэг хэрэглэхдээ хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг эхний сумаар таслан зогсоосон бол дахин нэг удаа хий буудаж анхааруулах нь зүйтэй. Энэ нь хил зөрчигчийн дахин зэвсэгт эсэргүүцэл үзүүлэх санаархлыг дарахаас гадна, хуулийн өмнө хил зөрчигчийн зүгээс зэвсэгт эсэргүүцэл үзүүлээгүй гэсэн буруу дүгнэлт гарсан үед урьдчилан нэг удаа буудаж анхааруулсан гэж үзэх боломжтой болно. Хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоохын тулд галт зэвсэг хэрэглэхдээ өөрийнхөө аюулгүй байдлыг бүрэн хангахын зэрэгцээ, хил зөрчигчийн амь нас, эрүүл мэндэд аль болох бага хохиролтой байхаар тооцоолох нь зүйтэй. Жишээ нь: эсэргүүцэл үзүүлж буй зэвсгийг нь устгах, боломжгүй бол амь наснаас аль болох хол хөндий хуруу, гар, хөл зэрэг эрхтэнд галт зэвсэг хэрэглэх бөгөөд хэрэв галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд нэн даруй хил зөрчигчийг зэвсгээс нь холдуулан аюулгүй болгож, эмнэлгийн

¹⁰⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль. тайлбар хэсэг. 2015 он., УБ.

анхны тусламжийг гарын доорхи материал ашиглаж, яаралтай үзүүлнэ. Хугацаа алдвал хил зөрчигчийн амь насанд аюултай тул хамгийн ойрхон байгаа отряд, застав, харуул, хөрш манаа болон сум, суурин, ард иргэдээс яаралтай тусламж авна.

4. Хилийн зурвас, хилийн боомт, бүсэд хүн, тээврийн хэрэгслийг барьцаалсан болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. /Хилийн тухай хуульд шинээр нэмэгдсэн заалт. 2016 он/

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн барьцаалах гэмт хэргийг “Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан^[105] ...”, террор үйлдэх гэмт хэргийг “Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галдан шатаах, цахим сүлжээ, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан; хүнийг алсан, эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан; зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодид халдсан^[106] ...” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хуульд “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг^[107] “террорист үйлдэл” гэж хүн амд айдас төрүүлэх, эсхүл энэ зорилгоор иргэнийг төрийн байгууллага, олон улсын байгууллагаас аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардах, эсхүл зэвсэгт

¹⁰⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль. 13.3 дугаар зүйл. Хүн барьцаалах. 2015 он., УБ.

¹⁰⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. 29.8 дугаар зүйл. Террор үйлдэх. 2015 он., УБ.

¹⁰⁷ Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт. 2004 он., УБ.



мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй иргэний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах санаатай үйлдлийг¹⁰⁸, “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа” гэж террор ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэн таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах зорилгоор цагдаа, тагнуулын болон цэргийн салбар, байгууллагын хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагаар гүйцэтгэх ажиллагааг¹⁰⁹ тус тус нэрлэсэн байдаг. Эдгээр хуулийн заалтуудаас харахад хилийн зурвас, хилийн боомт, бүсэд хүн, тээврийн хэрэгслийг барьцаалсан болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед галт зэвсэг хэрэглэх нь нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагын дор явагдах нь харагдаж байна.

5. Улсын хил хамгаалах байгууллагын хамгаалалтад байгаа объектод хүч хэрэглэн халдсан, халдахыг завдсан тохиолдолд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. /Хилийн тухай хуульд шинээр нэмэгдсэн заалт. 2016 он/

“Объектын хамгаалалт” гэж улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг¹¹⁰ хэлдэг. Хил хамгаалах байгууллагын зарим анги /салбар/-ууд цэргийн зориулалттай онц чухал объект, зэвсэг, галт хэрэглэлийн агуулахын хамгаалалтад үүрэг гүйцэтгэдэг. Хамгаалалтад байгаа объектод хүч хэрэглэн халдсан гэж заасан нь тухайн объектыг дээрэмдэх, булаан эзлэх, устгах зорилго агуулж байгаа тул галт зэвсэг хэрэглэх шаардлага болж байна гэж үзэх хэрэгтэй. Дээрхи зорилго агуулаагүй төөрч будилсан, андуурч бухимдсан, согтуурч мансуурсан этгээдийн объектод ойртон ирсэн үйлдлийг галт зэвсэг хэрэглэн зогсоож хэрхэвч болохгүйг хатуу анхаарах хэрэгтэй бөгөөд анхааруулга, санамж өгч үйлдлийг зогсоогоод холбооны хэрэгслээр удирдлагад яаралтай илтгэнэ.

¹⁰⁸ Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.4 дүгээр заалт. 2004 он., УБ.

¹⁰⁹ Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.9 дүгээр заалт. 2004 он., УБ.

¹¹⁰ Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль. Нийтлэг үндэслэл. 4 дүгээр зүйл. 4.1.4 дүгээр заалт. 2017 он., УБ.

Хил хамгаалах байгууллагын хамгаалалтад байгаа объектод нисгэгчгүй нисэх хэрэгслээр зураг авах, бичлэг хийх нь хүч хэрэглэн халдахыг завдаж байгаа үйлдэл гэж үзэх үндэслэлтэй тул галт зэвсэг хэрэглэж, тус үйлдлийг таслан зогсоох шаардлагатай.

Хилийн манаа урьдчилан анхааруулах дохио өгсөн боловч уг халдлага, довтолгоон үргэлжилбэл дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ¹¹¹.


1. Улсын хил дээр үүссэн өдөөн хатгалга, хил зөрчигчийн үйлдлийг өөр арга, хэрэгслээр зогсоох боломжгүй тохиолдолд урьдчилан анхааруулж, галт зэвсэг хэрэглэх. Хил зөрчигчийн өдөөн хатгасан /богино зайд хил зөрчиж, хилчдийг даллаж дуудах, хил зөрчихийн тулд эд зүйл өгөхөөр амлах, дохио зангаа үзүүлэх гэх мэт/ ажиллагаа, хил зөрчсөн болон зөрчихөөр завдсан үйлдэл хөдөлгөөн нь гүн тийш болон хил даван зугатаахаар чиглэгдсэн түүнийг хилийн манаа зогсоох боломжгүй болсон үед урьдчилан анхааруулах зорилгоор галт зэвсэг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл хилийн манаа тухайн этгээдийг зогсохыг шаардаж анхааруулан 3 хүртэл удаа хий буудах бөгөөд зогсохгүй тохиолдолд уналгыг нь галт зэвсэг хэрэглэж зогсооно гэсэн үг. Гэвч холын зайд уналгыг нь буудахдаа алдаж буудах, хад чулуу, газрын хатуу гадаргуйд сум ойх зэргээс хамааран зөрчил гаргагч этгээд, түүний хамсаатанг онож гэмтээх, улмаар амь насаа алдаж, хилийн манаа зэвсэг хэрэглэсний улмаас буруудах, хариуцлага хүлээх тохиолдол байдаг тул урьдчилан анхааруулж, хий буудан зогсохыг шаардаад зөрчил гаргагч этгээдийн уналгыг мэргэн онож зогсоох боломжгүй тохиолдолд галт зэвсгээр чиглүүлэн буудахгүйгээр, улсын хил зөрчсөн, зөрчихийг завдсан мэдээг отряд, застав, харуулын даргад яаралтай илтгэх хэрэгтэй. Гүн тийш зугатсан хөдөлгөөнийг харилцан ажиллагаатай байгууллага, орон нутгийн иргэд, ХХТХГ-тэй хамтран саатуулах бөгөөд хил зөрчсөн/давсан/ хөдөлгөөнийг Хилийн төлөөлөгчийн холбоогоор хил залгаа улсын хил хамгаалах салбарт шуурхай мэдэгдэж саатуулах арга хэмжээ авах нь хилийн төлөөлөгчийн хамтын ажиллагаа өргөжсөн өнөө үед илүү үр дүнтэй арга юм. /Зураг 1/ Ачааны автомашиныг дугуй болон явах эд анги, түлшний саванд галт зэвсэг

¹¹¹ Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2 дугаар заалт.



хэрэглэж зогсоох боломжтой, харин суудлын жижиг тэрэгний жолооч, зорчигчид суманд өртөх магадлал өндөр байдаг.

Зураг 1. Хил залгаа улстай хамтран хил зөрчигчийг саатуулах.



Хил зөрчигч гэм буруутай ч хүн гэдэг үүднээс хүндэтгэлтэй хандах, галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулахгүй байх хүнлэг ёсны зарчмыг баримтлах хэрэгтэй. Хил зөрчигчийн зугатааж байгаа үйлдлийг галт зэвсэг хэрэглэн зогсоох нь тийм ч оновчтой шийдэл биш бөгөөд аль болох зайлсхийх хэрэгтэйг зөвлөж байна.

2. Иргэний өмчийг зэвсэгт халдлагаас хамгаалах арга хэмжээ авсан боловч таслан зогсоогдохгүй тохиолдолд урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэх.^[112]

Хил зөрчин байгалийн баялаг, ашигт малтмал ашиглах, ховордсон ан амьтан агнах, хил орчмын ард иргэдийг дээрэмдэх, адуу мал хил давуулан хулгайлах гэх мэт хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг галт зэвсэг хэрэглэхгүйгээр таслан зогсоох ямар ч боломжгүй үед эцсийн арга хэмжээ болгон хилийн манаа нь урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэнэ. Урьдчилан анхааруулж дээш хий буудахад уг халдлага зогсоогдож, хил зөрчигч, гэмт этгээд бултан зугатаасан үед дахин галт зэвсэг хэрэглэх шаардлагагүй гэсэн үг. Харин таслан зогсоогдохгүй уг халдлага довтолгоон үргэлжилбэл хил зөрчигч, гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор тэдний халдлагад ашиглаж байгаа зэвсэг, уналга хэрэгсэлд галт зэвсэг хэрэглэнэ. Халдлага зогсоогдвол нэмэлт хүч дуудаж, саатуулах, баримтжуулах ажиллагаа явуулна.

¹¹² Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2.2 дугаар заалт.

Халдлага таслан зогсоогдохгүй бол хил зөрчигч, гэмт этгээдийн хуруу, гар, хөл зэрэг амьнаас зайтай эрхтэнд галт зэвсэг хэрэглэн халдлагыг даамжруулахгүйгээр таслан зогсоож, яаралтай тусламж дуудан, эмнэлгийн анхны тусламж үзүүлнэ. Аж ахуйн зорилгоор хил зөрчих гэж байгаа үйлдлийг харсан хилийн манааг хил зөрчигчид буц, улсын хил гэсэн дохиог харуулж хил зөрчихөөс сэргийлнэ. Хил давж байгаа малыг хилийн манаа уг чиглэлээр нь буцааж гаргана. Зарим тохиолдолд хилийн манаа хил зөрчигч барих хүсэл сонирхолдоо хөтлөгдөж, хил давж ирсэн малын хажууд отолт хийж байгаад хил залгаа улсын малчин малаа авахаар хил зөрчих үед саатуулдаг, саатуулах үед буцаад зугатаахад анхааруулж, галт зэвсэг хэрэглэдэг нь Олон Улсын гэрээ, хэлэлцээрийг ноцтой зөрчиж байгаа хэлбэр гэдгийг хатуу анхаарна уу.

3. Хилчин, иргэний амь нас, аюулгүй байдалд заналхийлсэн нь зэвсэг хэрэглэхгүйгээр зогсоох бололцоогүй тохиолдолд урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэх.^[113]

Энэхүү заалтын дагуу хилчин, иргэний амь нас, аюулгүй байдлыг хамгаалахын тулд хилийн манаа хуулиар олгогдсон эрх, хүлээсэн үүргийн хүрээнд өөр арга хэрэгслээр зогсоох бололцоогүй үед урьдчилан анхааруулж, галт зэвсэг хэрэглэнэ. Энэ аргагүй хамгаалалтын нөхцөлтэй ижилхэн байна гэсэн үг. Монгол Улсын Эрүүгийн хуульд аргагүй хамгаалалт гэж өөрийн, ойр

¹¹³ Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2.3 дугаар заалт.



дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хэлэх бөгөөд гэмт хэрэгт тооцохгүй. Аливаа хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай довтолгооноос зайлсхийх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Аргагүй хамгаалалтыг бусдын хууль бус халдлага эхэлсэн, эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хийнэ. Довтолгоо төгссөн хойно хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй. Хуульд заасны дагуу галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх, хэрэг шалган шийдвэрлэх явцдаа, харуул хамгаалалтын албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж хуулийн дагуу хийсэн үйлдлийг эсэргүүцсэн хариу үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй гэж заасан байдаг.^[14]

Хилийн манааны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл саатуулах, баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн этгээдэд биеийн хүч, галт зэвсэг хэрэглэснээс тусгай хэрэгсэл хэрэглэх нь аюулгүй байдлаа хангахад үр дүнтэйгээс гадна, тухайн харилцагчид бага гэмтэл учруулдаг давуу талтай. Жишээ нь: Байлдааны хүрэээр гар хөл рүү нь довтолох, нулимс асгаруулагч болон амьсгал боогдуулагч буу, шүршүүр ашиглах.

Хилийн манаа нь зэрлэг амьтнаас өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилгоор галт зэвсэг хэрэглэж болно. Харин ан хийх, хил давуулан буудахыг хориглоно гэж заасан.

Монгол Улсын Хилийн тухай хуульд Хил хамгаалах байгууллага, хилийн манаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой, биеийн хүч хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй гэж заасан. Хилчид биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхэд зөвхөн Хилийн тухай хуулийн үндэслэл заалтыг мэддэг байх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэглэх журам, заавруудыг судлах шаардлагатай байдаг. Хуульд заасан үндэслэлээр галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ журам, зааврын дагуу хэрэглээгүй тохиолдолд хууль, тогтоомжид

заасан хариуцлага хүлээдэг.

Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэмд хилийн манаанаас зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар зааж өгсөн бөгөөд Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заалттай зөрчилдөж байгаа тул хил хамгаалалтын дүрмийг шинэчлэх шаардлага байгааг харуулж байна. Иймд хил хамгаалалтын дүрмийн энэхүү заалтыг мөрдөхгүйгээр биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ Монгол Улсын Хилийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн А/160 тоот тушаалыг, галт зэвсэг хэрэглэхдээ Хилийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэл болгох нь зүйтэй.

Харин галт зэвсгийн хангалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг зохион байгуулахдаа Монгол Улсын Хил хамгаалалтын дүрмийн холбогдох заалтууд, ХХЕГ-ын даргын н/24, 1177 дугаар тушаалыг үндсэн удирдлага болгоно.

Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэрэгт Хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй мөрдөн шалгах, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хил орчмын дэглэмийн зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах болсон тул эдгээр албан тушаалтнуудад хууль эрх зүйн түргэвчилсэн сургалт явуулан хууль, эрх зүйн мэдлэг, гэрчилгээ олгох асуудал тулгамдсан асуудал болж байна.

Хуулийн энэхүү шинэчлэлттэй холбоотойгоор хүний нөөцийг бэлтгэх асуудалд онцгой анхаарч, Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн сонсогчийн сургалтын хөтөлбөрт хууль эрх зүйн хичээлийг нэмж тусгах, төгсөгчдөд хилийн албаны ажилтан-эрх зүйч мэргэжил олгох нь өнөөгийн Хил хамгаалах байгууллагын хэрэгцээ болж байна.

Хил хамгаалалтын хууль, дүрэм, зааврууд шинэчлэгдэж, хил зөрчигчийг саатуулах, баривчлах, хуяглан хүргэх, эсэргүүцлийг нь таслан зогсооход биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар шинэ заалтууд орсон тул үүссэн нөхцөл байдал тохирсон зөв шийдвэр гаргах шаардлага тулгарч байна. Хилийн манаа нь хил зөрчигч, гэмт этгээдүүдтэй тулгарсан үед

¹⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль. 4.1 дүгээр заалт. Аргагүй хамгаалалт. 2015 он., УБ.



шийдвэрийг асар богино хугацаанд, бодох завдалгүй, өөрт тогтсон дадлаараа бие даан гаргадаг бөгөөд энэ шийдвэр эрх зүйн зөрчилгүй, зөв байх шаардлагатай байдаг. Хэрэв шийдвэр гаргахдаа хугацаа алдвал өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарах эсхүл хил зөрчигч, довтлогч этгээд оргон зугатах боломж үүсдэг бол буруу шийдвэр гаргасан үед бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж, хариуцлага хүлээдэг. Иймд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар шинээр гарсан хууль, дүрэм, заавруудаар хилийн анги, салбарт сургалт явуулан хилийн манаа, хилчин нэг бүрт тайлбарлан ойлгуулах болзошгүй алдаа, зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой.

Хил хамгаалалттай холбогдолтой хууль эрх зүйн актууд шинэчлэгдэж, түүнтэй холбоотойгоо хил хамгаалах байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон тул Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийг бүрэн эхээр нь шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн.

Санал

1. Хил хамгаалах байгууллагын хилийн застав, салбарын албан хаагчдад хууль, эрх зүйн түргэвчилсэн сургалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, гэрчилгээ олгох.

2. Хилийн сургуулийн сургалтын хөтөлбөрт хууль, эрх зүйн хичээлийг нэмэлтээр тусган өгч, бүх төгсөгчдөд эрх зүйч мэргэжил давхар олгох.

3. Хилийн анги, салбарууд хуулийн шинэчилсэн заалтаар театрчилсан сургалт, дадлага хийх болон хилийн албаны бодлогыг дадлага хэлбэрээр богино хугацаанд шийдвэр гаргаж бодуулах зэргээр болзошгүй цагийн байдалд зөв хариу үйлдэл үзүүлэх дадлыг хилчин нэг бүрт бий болгох.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он., УБ.

2. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хилийн дэглэмийн гэрээ. 2006 он., УБ.

3. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ. 2010 он., УБ.

4. Хилийн тухай хууль. 2016 он., УБ.

5. Эрүүгийн хууль. 2015 он., УБ.

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он., УБ.

7. Зөрчлийн тухай хууль. 2017 он., УБ.

8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай

хууль. 2017 он., УБ.

9. Галт зэвсгийн тухай хууль. 2015 он., УБ.

10. Терроризмтай тэмцэх тухай хууль. 2004 он., УБ.

11. Дотоодын цэргийн тухай хууль. 2017 он., УБ.

12. Төрийн мэдээлэл. Хууль тогтоомжийн эмхэтгэл. Дугаар 06. 2017 он., УБ.

13. Цэргийн дүрэм. 2008 он., УБ.

14. Хил хамгаалалтын дүрэм. 2007 он., УБ.

15. Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал. А/160. Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар. 2017 он., УБ.

16. Хаянгарваа.С. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 2016 он., УБ.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Т.Мөнхдалай

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант

Хүний нийгэм анх бий болсон түүхэн тэр цаг үеэс нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал нэгэн зэрэг үүссэн гэж эрдэмтэн судлаачид үздэг.

Улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах ажлын хүрээнд тулгамдаж байгаа олон асуудлуудын нэг нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Монгол түмэн бид эцэг өвгөдөөс өвлөгдөн ирсэн эрдэнэт мал сүргээ үеийн үед өсгөн үржүүлж, хайрлан хамгаалсаар ирсэн түүхэн баялаг уламжлалтай билээ.

Тиймээс ч Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалтанд байна”^[58] гэж онцлон заасан байдаг хэдий ч Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд нууц, далд аргаар халдаж хохирол, хор уршиг учруулдаг хулгайлах гэм хэргийг халдлагын зүйлээр нь өөр өөр төрөлд хуваан үзэж шинээр гэмт хэрэгт тооцож хариуцлага оногдуулах нь “... хууль шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байна”, “хүнийг ... нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажлаар ... нь ялгаварлан гадуурхаж үл болно”^[59] гэсэн Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилдсөн хэрэг бөгөөд мал хулгайлсан үйлдлийг тусгайлан гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан нь онол, практикийн хувьд буруу шийдвэр болсон гэж зарим судлаачдийн зүгээс үздэг ба энэ үзэл онолыг судлаач миний бие дэмждэг болно.

Сүүлийн жилүүдэд хулгайлах гэмт хэргийн гаралт тоон болон чанарын үзүүлэлтээр байнга өсөн нэмэгдэж байгаа бөгөөд чанарын хувьд ч нарийн зохион байгуулалтанд орж хэрэг үйлдсэн арга, сэдэлт нь улам бүр ноцтой шинжтэй болж нийгмийн хор аюулыг улам бүр нэмэгдүүлж байна.

Мал хулгайлах гэмт хэрэг улирлын чанартай үйлдэгддэг байсан нь өнөөдөр улирал, цаг хугацаа, нутаг дэвсгэр, орон зайнаас үл хамаарах болов.

⁵⁸ “Төрийн мэдээлэл” сэтгүүл.1992 он.№1

⁵⁹ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он, II бүлэг, XIY зүйл

Малын хулгайчид гэмт үйлдлээ хийхээр урьдчилан бэлтгэхдээ хулгайлах малаа сонгон олж, хариулга маллагаагүй байх цаг үе, өглөө бэлчээрт гардаг, орой хотондоо ирдэг цаг хугацаа, хээр эзэнгүй хонодог үе, малын эзэд хол ойр хонуут өнжүүдээр явсан, малаа эргэж тойрдог, харж хамгаалдаг эсэх, хашаа саравчны байдал, хөөж туух зам харгуй, нуугдаж зугтаж болох бартаа саад, уулзах дамжуулах газар, алж нядлах болон машин унаагаа зогсоож ачиж болох газар, мал махыг худалдан авах хүмүүс зэргийг нарийн судлаж товлосон байдаг.

Шинэчлэн найруулж баталсан 2015 оны Эрүүгийн хуульд^[60] дээрхи нөхцөл байдлуудыг тусгайлан авч үзэхийг хууль тогтоогчоос эрхэмлэсэн хэдий ч Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зорилт, агуулгыг нэг мөр ойлгох, тайлбарлах, хэрэглэхэд хүндрэл учраад байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Хууль тогтоогчоос шударга, хууль ёсны зарчмуудыг Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлсон атлаа түүнийг хэрэгжүүлэх, мөрдөн сахихад хуулийн тусгай ангийн зүйл заалтууд өөр хоорондоо зөрчилдсөн хэм хэмжээг агуулсан байгаа нь хүний тэгш эрхийн зарчмыг зөрчсөн үйл ажиллагаа болно.

Тодруулбал: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлэгт “Хулгайлах” гэмт хэргийн ердийн буюу үндсэн шинжийг 17.1 дүгээр зүйлийн 17.1.1 дэх хэсэгт авч үзэхдээ “хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсны улмаас бага хэмжээний хохирол^[61] учирсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй”^[62] гэж тодорхойлсон байна.

Энэ нь тухайн бүлгийн 17.12 дугаар зүйлийн 17.12.1-д заасан “бусдын малыг хулгайлсан” үйлдэлд учруулсан хохирлын

⁶⁰ Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2017 он.№23

⁶¹ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 2 дугаар бүлэг. 2.5 дугаар зүйлийн 2.5.4.3 дах хэсэгт “бага хэмжээний хохирол гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг” ойлгоно гэжээ.

⁶² Дурьдсан хуулийн 17 дугаар бүлгийн 17.1 дэх хэсгийн тайлбар “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учирсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй” гэжээ.



хэмжээг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй нь шударга ёсны зарчмыг зөрчсөн хэрэг юм.

Тухайлбал: Хэн нэг хүн бусдын өмчлөлд байгаа хурга эсхүл ишиг, төлөг эсхүл борлонг хулгайлан авсан байхад түүний зах зээлийн үнэлгээ ердөө л 20.000-50.000 төгрөг байдаг нь хуульд заасан бага хэмжээний хохирлоос даруй 15-6 дахин бага байгаа бөгөөд тухайн хүн хэдийгээр хулгай хийсэн гэм буруутай ч, бусдын өмчлөлд байгаа хөрөнгө болох малыг хулгайлан авсан үйлдэлдээ учруулсан хохирлын хэмжээг үл харгалзан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй, ял шийтгэл хүлээж байгаа нь “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй”^[63] гэсэн хуулийн зарчим, заалтуудыг зөрчиж байгаа асуудал болно.

Нөгөө талаар хулгайлах гэмт хэргийн ердийн буюу үндсэн шинжийг хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.1 дэх хэсэгт тайлбарын дамт маш тодорхой, ойлгомжтой авч үзсэн мөртлөө мөн зүйлийн хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинжид нь бага хэмжээний хохирол учирсан эсэхийг үл харгалзан гэмт хэрэгт тооцохоор тайлбарлаж^[64] хуульчилсан нь буруу бөгөөд гэмт хэргийн үндсэн шинжийг хангаж байж хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцлийг хэрэглэх нь эрүүгийн хуулийн үзэл баримтлал байдаг.

Үлгэрлэвэл барьж буй байшингийнхаа суурийг чанартай сайн тавиагүй эсхүл огт суурь тавиагүй байж олон давхар барилга барихтай адил ойлголт төрүүлж байна.

Энэ нь Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэргийн үндсэн болон хөнгөрүүлэх, хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл шинжүүдийн хоорондын харилцан уялдаа, хамаарлыг авч үзэхдээ логикийн хуулийг зөрчиж ойлгомжгүйгээр хуульчилсан нь хуулийг хэрэглэхэд хүндрэл учруулж, улмаар хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг бий болгож уг чанартаа хүний эрхийг хамгаалах биш ноцтой хохирооход хүргэж байна.

⁶³ Дурьдсан хуулийн 1 дүгээр бүлгийн 1.3. дугаар зүйлийн 1.3.1 дэх заалт

⁶⁴ Дурьдсан хуулийн 17 дугаар бүлгийн 17.1 дэх хэсгийн тайлбар “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайлбар нь 2.3 дахь хэсэгт хамаарахгүй” гэжээ.

Мөн түүнчлэн “Бусдын олон тооны малыг хулгайлсан бол” гэж гэм буруутай үйлдлийг нь хүндрүүлэх нөхцөлтэйгээр хуульчилсан бөгөөд “Олон тооны мал” гэж хорин дөрвөн бог, эсхүл найман бодоос дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг гурван богоор тооцно” гэж хууль тогтоогчоос тайлбарлажээ.

Шигтгээ: Гэмт хүн бусдын өмчлөлд байгаа малаас 5 бод, 20 тооны бог хулгайлсан үйлдэлд хохирлын хэмжээг тооцохдоо дээрхи хуулийн заалтыг хэрэглэн хохирлын хэмжээг тооцвол 5 бод х 3 бог = 15 бог эсхүл 20 бог : 3 бог = 6 бод болно.

Үүнийг тус бүрд нь нэмж тооцвол 20 бог + 15 бог = 35 бог эсхүл 5 бод + 6 бод = 11 бод болно. Энэ нь аль ч тохиолдолд “олон тооны мал” хулгайлсан болж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг хуулийн тохирох зүйл ангиар шалгаж шийдвэрлэхэд зүйлчлэлийн асуудал чухал бөгөөд дээр дурьдсан “Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг гурван богоор тооцно” гэсэн заалт нь Эрүүгийн хуулийн нэгдүгээр бүлэгт заасан хууль ёсны зарчмын “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, шударга ёсны зарчмын “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, хоёрдугаар бүлэгт заасан “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний ... эд хөрөнгөнд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно” гэсэн хуулийн заалттай тус тус зөрчилдөж байна.

Зүй нь дээр дурьдсан хүний гэмт үйлдлийн улмаас учирсан бодит хохирлыг тооцохдоо тухайн орон нутагт баримтлаж буй зах зээлийн үнэлгээгээр 5 бод, 20 богийн үнэлгээний нийлбэр ямар хэмжээтэй болох тэр нь “Мал хулгайлах” гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хуульчлан заасан хохирлын хэмжээтэй тохирсон эсэхийг харгалзан зүйлчлэх нь зөв болно.

Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ “Олон тооны мал хулгайлсан” бол хүндрүүлэх нөхцөлд тооцох, “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол” онц хүндрүүлж үзэх нөхцөлд тооцохоор тус тус хуульчилсан.

Хүндрүүлэх нөхцөлд гэмт хэрэг үйлдсэн бол хэрхэх талаар дээр дурьдсан тул онц хүндрүүлэн үзэх нөхцлийн талаар тайлбар хийхийг оролдоё.



Мал хулгайлах гэмт хэргийг:

➤ байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэдэг нь хулгайлах гэмт хэргийг гурав буюу түүнээс дээш удаа үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж олсон мал, хөрөнгийг ашиглах, эзэмших, худалдан борлуулах зэргээр хөрөнгөжиж амьжиргаагаа залгуулдаг, түүнээс өөр цалин, орлогогүй байхыг ойлгох

➤ зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэдэг нь Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлгийн 3.8 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг” ойлгоно гэжээ.

Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэхийн тулд зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан үйлдэлд нь ба зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулна^[65] гээд

Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн орсон үйлдэл дээр ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялыг нэмж нэгтгэн хариуцлага тооцно^[66] гэж хуульчилсан бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 17.12.3.2-т заасан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа ерөнхий ангийн 3.8 дугаар зүйлийг журамлан мөн хуулийн 20.3 дугаар зүйлд заасанг нэмж давхар зүйлчлэн шийдвэрлэнэ.

Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ тусгай ангид тусгайлан заагаагүй хүндрүүлэн үзэх нөхцөлд үйлдсэн бол Ерөнхий ангийн 6 дугаар бүлгийн 6.6 дугаар зүйлийн 1.2-т заасан “энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн бол хүндрүүлэн үзэх нөхцөл болно.

➤ бүлэглэж үйлдсэн гэдгийг “Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ”^[67] гэж тодорхойлсон.

Хулгайлах гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш тооны хүн урьдаас үгсэн тохиролцоогүй

⁶⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 3 дугаар бүлэг.3.8 дугаар зүйлийн 3.8.2 дах хэсэг.

⁶⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 3 дугаар бүлэг. 3.8 дугаар зүйлийн 3.8.3 дах хэсэг.

⁶⁷ Дурьдсан хуулийн 3 дугаар бүлэг. 3.7 дугаар зүйлийн 3.7.1 дэх хэсэгт “бүлэглэн гүйцэтгэх” гэж заасан.

боловч хүч бололцоо, санаа сэтгэлээ хамтруулан үйлдэхийг бүлэглэн үйлдсэн гэж үздэг ба гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн гүйцэтгэгчдийн үйлдлийг нэгтгэн зүйлчилж гүйцэтгэгч тус бүрийн гэмт хэргийг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан ялыг ялгамжтай оногдуулах нь чухал юм.

Мөн зүйлийн 1.7 дах хэсэгт “онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн бол^[68] хүндрүүлэх нөхцөлд тооцохоор хуульчилсан.

Онц байдлын тухай хуульд^[69] Онц байдал гэдэг нь – “Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг хэлнэ” гэжээ.

Онц байдал зарласан буюу

1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;

2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон нөхцөл байдал үүссэн үед гэмт хэрэг үйлдсэнийг хүндрүүлэн авч үздэг.

Гамшиг, аюулт үзэгдлийн үед гэмт хэрэг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл болох ба Гамшигаас хамгаалах тухай хуульд^[70]

➤ гамшиг гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод

⁶⁸ Дурьдсан хуулийн 6 дугаар бүлэг. 6.6 дугаар зүйлийн 6.1.7 дах хэсэгт заасан

⁶⁹ Төрийн мэдээлэл. 1996.№2

⁷⁰ Төрийн мэдээлэл.2017.№7



нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

➤ аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг тус тус ойлгоно гэжээ.

Нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдсэн гэдэгт – олон хүмүүс нийгмийн аюулгүй байдал, дэг журамд халдаж бусад хүмүүст хүч хэрэглэх, эд хөрөнгө устгах, эвдэх, сүйтгэх, шатаах, галт зэвсэг болон тэсэрч дэлбэрэх зүйл, төхөөрөмжийг хэрэглэх, засгийн төлөөлөгчийг зэвсэг хэрэглэн эсэргүүцэхийг^[71] ойлгоно гэж тодорхойлсон.

Онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэдгийг дээрхи нөхцөл байдлын улмаас хүмүүсийн анхаарал сарнисан, болгоомж, сэрэмж алдсанг далимдуулан мал хулгайлсныг ойлгоно.

Мал хулгайлах гэмт хэрэг нь бусдын өмчлөлд байгаа мал сүргийг нууц далд аргаар өөрийн эзэмшилд, үнэ төлбөргүйгээр, гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр, ашиг олох зорилготой, шунахай сэдэлтээр авсан үйлдэл, эс үйлдэхүй байна.

Мал хулгайлах гэмт хэрэг нь хулгайлсан малаа өөрийн эзэмшилд бүрэн авч захиран зарцуулах боломжийг бий болгосноор төгс үйлдэгдсэнд тооцогдох бөгөөд өөрийн эзэмшилд бүрэн авч чадаагүй үйлдэл нь мал хулгайлахаар завдсан үйлдэл болно.

Гэмт хүн бусдын малыг хулгайлахдаа шунахайн сэдэлтээр бус өс хонзонгийн болон бусад хувийн сэдэлтээр нууц далд аргаар хулгайлан авсан бол хулгайлах гэмт хэрэг үйлдсэнд тооцогдохгүй тул эрүүгийн хуульд заасан тохирох зүйл хэсгээр зүйлчлэх шаардлагатай болно.

Мал хулгайлах гэмт хэргийг нэг хүн гардан гүйцэтгэж бусад нь зохион байгуулагч, хатгагч, хамжигчаар оролцсон бол гүйцэтгэгч болон бусад оролцогчдод Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 17.12.3.2-д зааснаар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй.

Малын хөлийг чөлөөтэй явахыг нь хориглосон, хязгаарласан агуулах сав, хашаа саравчинд хэрхэн нэвтэрч орон хулгайлах талаар зааварласан, зөвлөсөн,

⁷¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар.УБ.2010 он.466 дах тал

хулгайн малыг нууж далдлах, хадгалах, зарж борлуулахаар амалсан, хулгай хийхэд учрах саад тотгорыг арилгахад туслаж дэмжсэн хүнийг хамжигч гэж үзэн хуулийн 3.5 дугаар зүйлд заасанг журамлан хариуцлага хүлээлгэнэ.

Хохирогчид ноцтой хохирол учруулсан буюу хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан гэдгийг тогтоохдоо хулгайлагдсан малын үнэ өртөг, уг мал нь хохирогчийн амьдралынх нь ганц эх үүсвэр мөн эсэх, түүнд цалин, тэтгэвэр, нөхөн олговор зэрэг амьдралын эх үүсвэр байхгүй зөвхөн тухайн малын ашиг шим амьжиргааных нь гол сурвалж болж байсан, гэр бүлд нь хамаарал бүхий хүмүүсийн тоо, тэдний ажил эрхлэлтийн байдал, цалин орлогын хэмжээ зэргийг нарийвчлан тогтоох шаардлагатай байдаг.

Түүнчлэн хохирогч тухайн малыг алдсанаар амьдралын баталгаа нь алдагдаж амьжиргаа залгуулах бололцоогүй болсныг сум дүүрэг хороо багийн засаг дарга түүний тамгын газар, нийгмийн даатгалын байгууллага, татварын албаны тодорхойлолт, улсын мал тооллогын бүртгэл, хохирогч, гэрчийн мэдүүлэг зэргээр нотолсон байвал зохино.

Бусдын малыг булаах дээрэмдэх, залилах, завших, алдуул мал ашиглах, заналхийлэх, устгах, гэмтээх, хамгаалахад хайнга хандсан зэрэг үйлдэлд Эрүүгийн хуулийн 17.2.1, 17.2.2, 17.3, 17.4, 17.5, 17.6, 17.8, 17.9 дүгээр зүйлийн аль тохирохоор зүйлчлэх бөгөөд эдгээр нь мөн зүйлийн 17.12 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн^[72] гэж зүйлчлэх үндэслэл болохгүй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулинд мал хулгайлах гэмт хэргийг үйлдсэн этгээд бусдын өмчид бага, үлэмж, их хэмжээ, ноцтой^[73] хохирол учруулсан бол хэрхэх талаар тусгай ангидаа тусгайлан хуульчлаагүй байгаа нь учир дутагдалтай бөгөөд шүүхээс ял оногдуулахдаа харгалзан үзэх нөхцөл буюу шүүгдэгчийн үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдал, хэрэг үйлдэх үеийн бусад нөхцөл байдалд тохирсон, оновчтой байх шударга ёсны

⁷² Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 6 дугаар бүлэг.6.6 дугаар зүйлийн 1.2 дах хэсэг.

⁷³ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 2 дугаар бүлэг. 2.5 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “ноцтой хохирол” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно гэжээ.



зарчмыг зөрчсөн хэрэг юм.

Үүнээс гадна мал хулгайлахдаа машин механизм, тусгайлан бэлтгэсэн бугуйл, уурга, чөдөр, ногт, тушаа ашигласан, малыг бэлчээрээс болон хашаа саравч, пүнз, аргамжаанаас, хотноос хулгайлсан бол хэргийг зүйлчлэхэд баримтлах чиглэл байхгүйгээр хуульчилсан нь хэргийг мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

Жишээлбэл: Гэмт хүн айлын пүнз буюу амбаараас нэг хонь, нэг хонины гулууз махыг нэг удаагийн үйлдлээр хулгайлан авсан тохиолдолд уг үйлдийг хэрхэн зүйлчлэж хариуцлага тооцох нь ойлгомжгүй бөгөөд зөвхөн амьд хонь, хонины гулууз мах гэсэн халдлагын зүйлийн шинжээрээ ялгагдан хонь хулгайлсан үйлдэлд нь Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 17.12.1 дэх хэсэгт /мал хулгайлах/ зааснаар, хонины гулууз мах хулгайлсан үйлдэлд нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.2 дах хэсэгт заасан /хулгайлах/ гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлтэйгөөр үйлдсэн гэж үзэн халдлагын зүйл тус бүрд нь ял оногдуулаад оногдуулсан ялыг хөнгөнийг хүндэд нь нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл хэмжээг тогтоох болж байна.

Энэ нь “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг алдагдуулсан, зөрчсөн үйл явдал болох юм.

Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй бүхий л арга болон оролцогч нэг бүрийн үйлдэл, оролцооны талаар нарийвчлан судлаж, энэ талын гүнзгий мэдлэгтэй байх нь онол, практикийн чухал ач холбогдолтой бөгөөд хэргийг зөв зүйлчлэж шийдвэрлэхэд дөхөм болно.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Мал хулгайлах гэмт хэргийн үндсэн шинжид буюу ЭХТА-ийн 17.12 дугаар зүйлийн 17.12.1-д хулгайлах үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учирсан бол гэмт хэрэгт тооцохгүй байх, Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох

2. Мал хулгайлах гэмт хэргийн улмаас бусдын өмчид үлэмж, их хэмжээний хохирол учирсан бол хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинж гэж үзэн хуульчлах, зүйлчлэх

3. Мал хулгайлахдаа машин механизм,

тусгайлан бэлтгэсэн зүйл хэрэглэсэн, хашаа саравч, пүнз, аргамжаанаас, хотноос хулгайлсан бол хэргийг зүйлчлэхэд хүндрүүлэн үзэж хуульчлах шаардлагатай.



БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХЭЭЛ ХАХУУЛЬ, АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Ван.Сарнай

Баруун хойд мужийн Улс төр, хууль зүйн их
сургуулийн магистрант

Г.Урангоо

Өвөр Монголын Их сургуулийн Хууль зүйн
сургуулийн магистрант

Хураангуй: Авлига, хээл хахуулийн гэмт хэрэг нь төрийн албан хаагчид эрх мэдлээ ашиглан улс болон иргэдэд ноцтой хохирол учруулдаг эдийн засгийн гэмт хэрэг юм. Хятад Улсын Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт өөрчлөлтөөр авлига, хээл хахуулийн гэмт хэргийн талаар дараах өөрчлөлтүүдийг хийсэн. Үүнд:

1. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг талаарх хэм хэмжээнд өөрчлөлт оруулж, мөнгөний хэмжээнд/авлига, хээл хахуулийн гэмт хэргийн хохирлын хэмжээг гэмт хэргийн байдал болон мөнгөний хэмжээгээр тооцно/ өөрчлөлт оруулж, хүндрүүлэх нөхцөл байдлыг бие даасан гэмт хэрэг болгосон;

2. Авлига, хээл хахуулийн хүнд гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтэнг бүх насаар нь хорих ялаар шийтгэх тогтолцоог бий болгон, мөрдөж эхэлсэн.

Хуулийн өөрчлөлт батлагдах үед нийгмийн зүгээс бүх насаар нь хорих ял эдлүүлэх тогтолцоо бүрдээгүйд, мөн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх талаар шүүмжлэлтэй хандаж байсан боловч өөрчлөлтийг олон жилийн шүүхийн таслан шийдвэрлэх ажиллагаан дээр үндэслэсэн оруулсан тул авлига, хээл хахуулийн гэмт хэргийг таслан зогсоож, шүүхээр шийдвэрлэхэд чухал ач холбогдол үзүүлж байна.

Түлхүүр үг: Авлига, хээл хахууль авах, Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт өөрчлөлт

Abstract: Corruption and bribery crimes are economic crimes committed by state workers using their powers and authorities, which have brought serious harm to both the country and the people. In this regard, China's Criminal Law Amendment 9 has made significant changes to corruption and bribery crimes. First, amendments have been made to the standards of corruption and bribery crimes, and the corruption and bribery of money and plots have

been judged. However, there is controversy over whether the increase in the amount of money is reasonable. Second, the system of life imprisonment was established in corruption and bribery crimes. The life imprisonment system has strict application conditions, but it has been criticized by scholars for lack of social mechanisms. However, this revision is based on years of experience in judicial practice and has made a success in suppressing corruption and bribery crimes. It is of great significance to judicial practice.

Key words: Corruption; Bribe; Criminal Law Amendment

Удиртгал

Сүүлийн жилүүдэд Хятад улсад хүнд гэмт хэргийн тоо тогтмол өсөж байна. Төрийн албан тушаалтан албан тушаалаа ашиглан хувийн ашиг олох, эрх мэдэл буюу албан тушаалын арилжаа хийх зэргээр эрх мэдэл бүхий албан тушаалтны материаллаг ашиг сонирхол нэмэгдсэнээс авлига, хээл хахуулийн гэмт хэргийн тоо нэмэгдэхэд хүргэсэн. Үүнээс үүдэн авлига, хээл хахуулийн гэмт хэргийн өсөлт нь улс орны эдийн засгийн аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд хүрсэн нь гэмт хэргийг таслан зайлшгүй таслан зогсоох үндэслэл болсон.

2015 оны 8 дугаар сарын 29-нд БНХАУ-ын Ардын Бүгд Найрамдах Улсын Их Хурлын Байнгын Хорооны 16 дугаар хуралдаанаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 9-р нэмэлт, өөрчлөлтийг баталж, тус нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг эсрэг эрх зүйн хэм хэмжээний шинэчлэлтийн чухал хэсэг нь дээрх 9-р нэмэлт, өөрчлөлт бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлахаас өмнө, баталж хуульд өөрчлөлт оруулсны дараа ч гэсэн бүх нийтийн анхаарлын хамгийн их татаж байсан юм. 9-р нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлсний дараа олон нийтийн авлига, хээл хахуулийн гэмт хэргийн эсрэг авч буй арга хэмжээг үнэлэх үнэлэмж нь харилцан адилгүй байсантай холбогдуулж энэ нийтлэлд авлига, хээл хахуулийн гэмт хэргийн эрх зүйн хэм хэмжээний шинэчлэлт, БНХАУ-ын Ардын дээд шүүх болон Ардын дээд прокурорын авлига, хээл хахуулийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх талаарх тайлбарыг үндэслэн нэмэлт, өөрчлөлтийн ололт, алдагдлыг харьцуулан үзнэ.

БНХАУ-ын авлига, хээл хахууль авах



гэмт хэргийн тухай хууль тогтоомжийн тойм БНХАУ-ын Эрүүгийн хуулийн VIII бүлэг, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт, өөрчлөлтөөр тусгай төлбөр ногдуулсан авлига, хээл хахууль гэмт хэрэгт холбогдох нийт 13 зүйл байна. Эдгээр Эрүүгийн хуулийн 13 зүйлийг хоёр ангилалд хувааж болно:

1.1. Авлигын гэмт хэрэг

Хятад улсын Эрүүгийн хуулийн 382, 383-р зүйлд авлигын гэмт хэргийг хуульчилсан. Хуулийн 384-р зүйлд төрийн санг буруугаар ашиглах, 395-р зүйлд хууль бусаар хөрөнгөжих, хөрөнгө нууц дарагдуулах, 396-р зүйлд төрийн эзэмшлийн хөрөнгө, торгуулийн орлого хувьдаа завших гэмт хэргийг тус тус заасан.

Хуульд заасны дагуу авлигын гэмт хэрэгт дараах ял шийтгэлийг оногдуулж байна. Үүнд:

Хятад улсын Эрүүгийн хуулийн 382 дугаар зүйлийн 382.1-д төрийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглан төрийн өмчөөс хулгайлах, залилан мэхэлж авах болон бусад хууль бус арга хэрэглэн төрийн өмчөөс завшихыг авлигад тооцно гэж заасан.

382.2-д төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгж, байгууллагын итгэмжлэгдэн хариуцсан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглан төрийн өмчөөс завших хулгайлах, залилан мэхэлж авах болон бусад хууль бус арга хэрэглэн төрийн өмчөөс завшихыг авлигад тооцно.

382.3-д энэ хуулийн 382.1 болон 382.2-д заасан этгээдтэй бүлэглэж үйлдсэнийг авлигад хамтран оролцох гэнэ гэж тус тус заасан.

383.1-д авлигын хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан дараах ял оногдуулна:

383.1.1. Ихэвтэр хэмжээний авлига буюу бусад хүндэвтэр нөхцөл байдалтай бол торгож, гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу баривчлах ял шийтгэнэ.

383.1.2. Их хэмжээний авлига буюу бусад хүнд нөхцөл байдалтай бол торгох буюу эд хөрөнгө хурааж, гурваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих буюу баривчлах ял шийтгэнэ.

383.1.3. Онц их хэмжээний авлига буюу бусад онц хүнд нөхцөл байдалтай бол торгох буюу эд хөрөнгө хурааж, арван жилээс дээш хугацаагаар хорих буюу хугацаагүйгээр хорих ял шийтгэнэ. Авлигын хэмжээ онц

их бөгөөд төрийн эсвэл ард иргэдийн ашиг сонирхолд онц хүнд хохирол учруулсан бол эд хөрөнгө хурааж, хугацаагүйгээр хорих буюу цаазаар авах ял шийтгэнэ.

383.2. Энэ гэмт хэргийг давтан үйлдэж, ял шийтгүүлээгүй бол авлигын хэмжээг нэмж нэгтгэнэ.

383.3. Энэ хуулийн 383.1.1-д заасан гэмт хэргийн үйлдсэн хэрэг үйлдэж, ял шийтгүүлэхээс өмнө үйлдсэн гэмт хэрэгтэй чин санаанаас гэмшсэн буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг идэвхтэй буцаасан, гэм хорыг арилгах буюу багасгасан бол Эрүүгийн хуульд зааснаас хөнгөнөөр шийтгэж, ял хөнгөрүүлж эсвэл ялаас чөлөөлнө. Энэ хуулийн 383.1.2. болон 383.1.3-д заасан гэмт хэргийг үйлдсэн бол ял хөнгөрүүлж болно.

383.4. Энэ хэргийн 383.1.3-д заасан гэмт хэрэг үйлдсэн ялтны цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулан, шүүхээс гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан хоёр жилийн хугацаа дууссаны дараа хугацаагүй хорих ялаар сольж болно. Бүх насаар нь хорих ял оногдуулсан тохиолдолд ялын хэмжээнээс бууруулах эсвэл тэнсэн суллаж болохгүй.

394.1. Төрийн албан тушаалтан дотоод, гадаадын албан ёсны үйл ажиллагаанд оролцож, дипломат үйл ажиллагааны дагуу бэлэг хүлээн авсан тохиолдолд улсад шилжүүлэн өгөх ёстой. Шилжүүлээгүй эд зүйл их хэмжээний бол хуулийн 382, 383 дугаар зүйлд заасны баримтлан ял оногдуулна.

1.2. Хээл хахуулийн гэмт хэрэг

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 385-р зүйлд хээл хахууль авах гэмт хэргийг хуульчилсан. Тус хуулийн 387, 388-р зүйлд хуулийн этгээдээс хээл хахууль авах, 389, 390-р зүйлд хээл хахууль өгөх, 391-р зүйлд хуулийн этгээд хээл хахууль өгөх, 392-р зүйлд хээл хахууль зуучлах, 393-р зүйлд хуулийн этгээдэд хээл хахууль өгөх гэмт хэргийг тус тус хуульчилсан. БНХАУ-ын төрийн албан тушаалтан хээл хахууль авах гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд доорх зүйлийг үндэслэн ял шийтгэл оногдуулна. Үүнд:

385.1. Төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглан бусдаас хээл хахууль авах буюу хууль бусаар хээл хахууль хүлээн авах, хээл хахууль өгөгчид давуу байдал олгох.

385.2. Төрийн албан тушаалтан эдийн



засгийн харилцан үйлчлэлд хууль зөрчсөн аливаа хэлбэрийн төлбөрийг хүлээн авч, хувийн ашиг хонжоо олсон бол хээл хахууль авсанд тооцно.

386.1.Хээл хахууль авсан хэргийн хэмжээ болон нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 383 дугаар зүйлийн дагуу ял оногдуулж, бусдаас хээл хахууль авсан этгээдийг хүндрүүлж шийтгэнэ.

387.1.Төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгж, байгууллага бусдаас хээл хахууль авах буюу хууль бусаар хээл хахууль хүлээн зөвшөөрч, хээл хахууль өгөгчид давуу байдал олгон хүнд нөхцөл байдал үүсгэсэн бол хуулийн этгээдийг торгож, хариуцсан удирдах ажилтан болон шууд хариуцсан ажилтанг таван жил хүртэл хугацаагаар хорих буюу баривчилна.

387.2.Энд заасан хуулийн этгээд эдийн засгийн хэлцэлд хууль зөрчсөн аливаа хэлбэрийн төлбөрийг хүлээн авсан бол энэ хуулийн 387.1-д заасны дагуу ял оногдуулна.

388.1.Төрийн албан тушаалтан өөрийн албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглан бусад албан тушаалтны ажил үүргийн дагуух үйлдэл, эс үйлдэхүйгээр хээл хахууль өгөгчид давуу байдал олгохоор бусдаас хээл хахууль авах буюу хээл хахууль хууль бусаар хүлээн зөвшөөрсөн бол хээл хахууль авах гэмт хэрэгт тооцож ял оногдуулна.

388.1.1.Төрийн албан тушаалтны төрөл садан буюу түүнтэй нягт харилцаа холбоо бүхий этгээд төрийн албан тушаалтны ажил үүргийн дагуух үйлдэл, эс үйлдэхүйгээр дамжуулан эсвэл төрийн албан тушаалтан эрх мэдлийн нөлөөгөө урвуулан ашиглаж, бусад төрийн албан тушаалтны ажил үүргийн дагуух үйлдэл, эс үйлдэхүйгээр дамжуулан хээл хахууль өгөгчид давуу байдал олгохоор бусдаас хээл хахууль авах буюу хээл хахууль хүлээн зөвшөөрсөн бол хээл хахууль авсан хэмжээ ихэвтэр буюу бусад хүндэвтэр нөхцөл байдалтай бол торгож, гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу баривчлах ял шийтгэнэ. Хээл хахууль авсан хэмжээ их буюу бусад хүнд нөхцөл байдалтай бол торгож, гурваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хээл хахууль авсан хэмжээ онц их буюу бусад онц хүнд нөхцөл байдалтай бол торгох буюу эд хөрөнгө хурааж, долоон жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.

388.2.Энэ хуулийн 388.1-д заасан төрийн албан тушаалаас огцорсон этгээд өөрийн

шууд эрх мэдэл эсвэл эрх мэдлийнхээ шууд үр нөлөөг урвуулан ашиглан 388.1-д заасан гэмт хэрэг үйлдвэл 388.1-д заасны дагуу ял оногдуулна.

БНХАУ-ын авлига, хээл хахуулийн гэмт хэргийн талаарх энэхүү нийтлэлтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээ нь БНХАУ-ын Эрүүгийн хуулийн дээрх зүйл, заалтууд болно. Ерөнхийдөө БНХАУ-ын Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт, өөрчлөлт 383-р зүйлд өөрчлөлт оруулж, мөнгөний хэмжээнд тулгуурлан авлига, хээл хахуулийн гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхойлдог байсныг больж, тухайн хэргээс үүдэлтэй нөхцөл байдлыг давхар авч үзэж байна. Ял шийтгэл хувьд авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт насан турш хорих ял оногдуулах ялын төрөл шинээр нэмэгдсэн. 9 дүгээр нэмэлтэд тусгагдсан хуулийн өөрчлөлтийг дараах байдлаар авч үзье. Үүнд:

1. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ ба нөхцөл байдлын харилцаа холбоо

1.1. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулахаас өмнө болон дараах байдал

9-р нэмэлт, өөрчлөлт батлагдахаас өмнө Эрүүгийн хуулийн 383-р зүйлд зааснаар дараах дөрвөн төвшинд хувааж үзсэн.

➤ Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ нэг зуун мянган юаниас дээш бол торгож эсвэл арван жилээс дээш хугацаагаар хорих эсвэл хугацаагүй хорих ял шийтгэнэ. Нэг зуун мянган юаниас дээш бөгөөд онц хүнд нөхцөл байдал үүссэн бол эд хөрөнгө хурааж, цаазаар авах ялаар онооно.

➤ Тавин мянган юаниас дээш зуун мянган юань хүртэл бол эд хөрөнгө хурааж болно. Мөн таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тавин мянган юаниас дээш зуун мянган юань хүртэл бөгөөд онц хүнд нөхцөл байдал үүсгэсэн бол эд хөрөнгө хурааж, хугацаагүй хорих ял шийтгэнэ.

➤ Таван мянган юаниас дээш тавин мянган юань хүртэл бол нэгээс дээш долоон жил хүртэл хугацаагаар хорино. Таван мянган юаниас дээш тавин мянган юань хүртэл бөгөөд хүнд нөхцөл байдал үүсгэсэн бол долоогоос арван жил хүртэл хугацаагаар хорино.

➤ Таван мянгаас бага, хүндэвтэр нөхцөл байдалтай бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу баривчлах ялаар шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 9-р нэмэлт, өөрчлөлтөөр мөнгөний хэмжээний



тодорхойлох тодорхой хэмжээг хүчингүй болгож, ихэвтэр, их, онц их хэмжээний гэх нэршлээр мөнгөний хэмжээг тодорхойлсон. Дан мөнгөний тоон хэмжээгээр хохирол үнэлэхийн оронд “мөнгөний хэмжээ болон нөхцөл байдал” болгон өөрчилсөн нь гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож, хариуцлагыг бэхжүүлсэн. Энэ өөрчлөлт нь авлига, хээл хахуулийн гэмт хэргүүдэд ял шийтгэл оноох хэм хэмжээг өөрчлөхөд чиглэсэн бөгөөд авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шинжлэх ухааны зүгээс илүү үр дүнтэй, гүн рүү нь орж шийдвэрлэдэг ухаалаг тогтолцоог бүрдүүлж байна гэж сүүлийн жилүүдэд эрдэмтэд өндөр үнэлгээ өгч байна.^[58]

Уг нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө 383 дугаар зүйл нь заасны дагуу уг хэргийн улмаас үүссэн нөхцөл байдлыг бие даан шинж болгож үзэлгүй, зөвхөн авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээний дагуу үнэлж үзэх ёстой байв. Энэ нь нөхцөл байдал нь эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах гол шалтгааны нэг болсон.^[59] Өөрөөр хэлбэл өөрчлөлт орохоос өмнө авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ зуун мянган юань хүрээгүй тохиолдолд нөхцөл байдлыг онц хүнд гэж үнэлэх боломжгүй. Одоо практикт шүүн шийдвэрлэх ажиллагааны үед тулгарч буй асуудал нь мөнгөний хэмжээ зуун мянган юаниас дээш тохиолдолд шүүхээс хүнд нөхцөл байдлаар тооцон шийдвэрлэж байгаа бөгөөд авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ ихэвчлэн 5 сая гаруй юань/1891600000 тухай төгрөг/ хүрдэг боловч мөн нөхцөл байдлыг хүндээр тооцон ял оноож байна.^[60]

Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ болон нөхцөл байдлыг харьцуулан үзвэл:

➤ Эрүүгийн хуульд өөрчлөлт орохоос өмнө нөхцөл байдлыг мөнгөний хэмжээгээр тооцон шүүхээс шударга бус шийдвэр гаргадаг байсан.

➤ 9-р нэмэлт өөрчлөлт орсноор нөхцөл байдал нь бие даасан шинжийг агуулж, мөнгөний хэмжээ болон нөхцөл

байдал хоёрын аль нэгийг сонгох бололцоо нээгдсэн.

Ингэснээр авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ болон нөхцөл байдлыг бүрэн тооцож, албан тушаалтны буруутай үйлдлийг гэмт хэрэгт тооцох боломж нэмэгдсэн тул төрийн албан тушаалтан авлига, хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж, албан үүргээ шударгаар гүйцэтгэнэ гэж үзэж байна.^[61]

1.2. Шүүхээс авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт тооцон ял оногдуулж буй мөнгөний хэмжээ

Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт өөрчлөлт батлагдсантай холбогдуулж 2016 оны 4-р сарын 18-нд БНХАУ-ын Ардын дээд шүүх, Ардын дээд прокуророос «Авлигатай тэмцэх, хээл хахуулийн хэргийн хуулийг хэрэглэх талаарх хэд хэдэн асуудлыг тайлбарлах нь /цаашид “тайлбар” гэх/» тайлбарыг гаргасан. Энэ тайлбар нь 9-р нэмэлтэд өөрчлөлт оруулах зорилготой хийгдсэн бөгөөд “авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт” гэсэн хоёр ойлголтын хууль тогтоомжийг дэлгэрэнгүй тайлбарласан.

Тайлбарт авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний ихэвтэр, их, онц их хэмжээг хэрхэн тооцохыг тогтоосон. Авлига, хээл хахуулийн мөнгөний ихэвтэр хэмжээг Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулахаас өмнө таван мянган юаниар тооцож байсныг гучин мянган юаньд, мөнгөний их хэмжээг тавин мянган юаниас хорин мянган юаньд хүргэж, мөнгөний онц их хэмжээг зуун мянгаас гурван сая юань хүртэл гэж тогтоосон. Сүүлийн арав гаруй жилийн эдийн засаг, нийгмийн хөгжлөөс үүдэн тус тайлбарын авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээг дээрх байдлаар өөрчлөлт оруулахаас өмнөх хэмжээнээс зөрүүтэй тогтоож өгсөн байна.

Зарим эрдэмтэд тайлбар дээрх өөрчлөлтөд шүүмжлэлтэй хандсан байсан юм. Учир нь авлига, хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн гол зорилго бол төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд оршино.^[62] Өөрөөр хэлбэл авлига, хээл хахуулийн гэмт хэргийн объект нь төрийн албан тушаалын арилжааны бус, цэвэр шударга эрх мэдэл учир нийгэм,

⁶¹ Жан Шэнийн. Эрүүгийн хуулийн 9-р нэмэлт өөрчлөлтийн авлига, хээл хахуулийн гэмт хэргийн өөрчлөлт дахь тайлбар., Жүн жэү их сургуулийн сэтгүүл, 2016№6, 29-р тал.

⁶² Жан Минкай. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн практик ба хууль тогтоомжийн хөгжлийн чиглэл., Улс төр, хууль зүйн форум, 2017№1,7-р хуудас.

⁵⁸ Жао бэнзи. Авлига, хээл хахуулийн гэмт хэргүүдэд ял шийтгэл оноох стандартыг судлах., Хятадын хууль, 2015 №1, 25-р тал.

⁵⁹ :Эү Яанвэнци. Эрүүгийн хуулийн 383 дугаар зүйлийн тайлбар., Орчин үеийн хууль, 2016№1, 14-р тал.

⁶⁰ Сүн Гөшийн. Хээл хахууль авах шийтгэлийг чангатгаж, хязгаарлах тухай асуудал., 2010 онд өндөр албан тушаалтнууд болон сайдын хээл хахуулийн хэргийг судлах нь., Хууль, 2011 №8, 143-р тал.



эдийн засгийн хөгжил болон нэг хүнд ногдох ДНБ өсөлттэй хамааралгүй. Авлига, хээл хахуулийн гэмт хэрэг нь өмчийн эсрэг гэмт хэрэг биш бөгөөд үндэсний эрх ашиг, төрийн албатай холбоотой тул авлига хээл хахуулийн гэмт хэргийг ялын хамгийн гол зорилго бол төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд зорилготой байна. Тиймээс эдийн засгийн өсөлтөөс үүдэн авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээнд их хэмжээний өөрчлөлт оруулж, өсгөх нь бага хэмжээний авлига, хээл хахуулийг гэмт хэргийг хүлээн зөвшөөрсөнтэй адил тул авлига, хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнгүй, тохиромжгүй гэж үзэж байв.

2. Бүх насаар нь хорих ял нэмэгдэв.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт, өөрчлөлтөөр бүх насаар нь хорих ялын тогтолцоог бий болгон, тайлбарласан нь эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явуулсан. Судалгаагаар Хятад улс дахь бүх насаар нь хорих ялын тогтолцооны практик хэрэгцээ, хууль эрх зүйн хэм хэмжээ, үнэ цэнийн чиг баримжаа, хууль эрх зүйн чиг хандлага, ирээдүйн чиг хандлага зэрэг асуудлууд дээр голчлон анхаарал хандуулж байв.

2.1. Бүх насаар нь хорих ялын эрх зүйн шинж чанар

Авлигийн хэмжээ онц их/гурван сая юань/ бөгөөд төр, ард иргэдийн ашиг сонирхолд онц хүнд хохирол учруулсан ялтанд цаазаар авах ялаар шийтгэж, хоёр жилийн хугацаанд биелүүлэхийг хойшлуулна. Шүүх гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан хоёр жилийн хугацаа дууссаны дараа хугацаагүй хорих ялаар сольж, бүх насаар нь хорино. Оногдуулсан ялын хэмжээнээс бууруулах буюу тэнсэн суллаж болохгүй. Энэ бол бүх насаар нь хорих ялыг гүйцэтгэх нөхцөл юм. Бүх насаар нь хорих ялын түрүүнд БНХАУ-ын цаазаар авах ялыг тогтолцоог тодорхой тайлбарлая. Түүхэн явц болон үндэсний онцлог нөхцөл байдлаас үүдэн цаазаар авах ялыг богино хугацааны дотор халах боломжгүй. Мөн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхдээ цаазаар авах ялыг цаашид удаан хугацаанд хэрэглэх нь ажиглагдаж байна. Иймээс Эрүүгийн хуулийн 9-р нэмэлт өөрчлөлтийн дагуу авлига, хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэж, цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээдийг бүх насаар нь хорих ялаар сольж байгаа

нь эрүүгийн ял шийтгэлийн хүмүүнлэгийн үйл ажиллагаа, эрүүгийн ял шийтгэлийн зарчмуудын шаардлагыг хангаж, олон улсын ялын тогтолцооны жишигт нийцүүлсэн.

Хятадын хууль ёсны эрүүгийн хариуцлагад нийтийн хяналт, баривчлах, хугацаатай хорих, хугацаагүй хорих, цаазаар авах ял, торгох, эд хөрөнгө хураах, улс төрийн эрхийг хасах долоон төрлийн ял шийтгэл байна. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ялын талаарх тусгайлсан зохицуулалт байхгүй учир уг ялын тогтолцооны эрх зүйн шинж чанарт нэлээн эргэлзээтэй асуудал юм. Үүнтэй холбоотойгоор олон эрдэмтэд цаазаар авах ялын шинэчлэлийн үүднээс богино хугацаанд цаазаар авах ялыг халах нь хэцүү тул, бүх насаар нь хорих ялын тогтолцоог бий болгож, цаазаар авах ялыг аажмаар халах хувилбар гэж үзэж болох юм гэсэн өөрсдийн тайлбарыг дэвшүүлээд байна.^[63]

Хятадын цаазаар авах ялын гүйцэтгэл нь эрс ялгаатай хоёр аргаар гүйцэтгэгддэг. Шүүхээс цаазаар авах ял оноосны дараа нэн даруй цаазаар авах ялыг даруй гүйцэтгэх болон цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулан гүйцэтгэх хоёр арга. Авлига, хээл хахуулийн гэмт хэрэгтэнд оногдуулсан цаазаар авах ял оногдуулж, бүх насаар нь хорих ялаар сольж, гэмт хэрэгтний хувийн эрх чөлөөг хорьж буй нь одоо хэрэгжиж буй хоёр жилийн хугацаатай хойшлуулан гүйцэтгэдэг цаазаар авах ялаас огт өөр гүйцэтгэлийн арга юм гэж зарим эрдэмтэд үзэж байна.^[64] Мөн цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулан гүйцэтгэх болон нэн даруй гүйцэтгэх нь өөр арга боловч хоёр жилийн хугацаанд хойшлуулан, бүх насаар нь хорих ялаар сольж буй нь цаазаар авах ялыг хойшлуулж гүйцэтгэдэг аргын нэг төрөл нь гэж үзэх ч зарим эрдэмтэд байна.^[65] Цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулж, бүх насаар нь хорих ялын хоорондын харилцаа нь цаазаар авах ялыг халах боломжгүй нөхцөлд цаазаар авах ялыг хэрэглэхийг хязгаарлах оролдлого гэж үзэж болох юм. Хуульд өөрчлөлт оруулснаас

⁶³ Жао Бинзи, Шан Хаун., Цаазаар авах ялын шинэчлэлийн тухайд насан турш баривчлах системд, Зүүн Хятадын улс төрийн шинжлэх ухааны бакалаврын дээд сургуулийн сэтгүүл, 2017N№1, хуудас129-136.

⁶⁴ Лй Хун. Насан турш баривчлахын хэрэглээний эрх зүйн шинж чанар, Эрх зүйн судалгаа, 2017N№1, хуудас 23.

⁶⁵ Ши Яанан., Цаазаар авах ялыг даруй гүйцэтгэхийн өөр арга хэмжээний практик ба тусгал, Эрх зүйн шинжлэх ухаан, 2017N№2, хуудас 186.



хойших одоогийн нөхцөл байдлаас харахад ялтанг бүх насаар нь хорих ял нь шүүхээс цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулахын урьдчилсан нөхцөл болж байна. Өөрөөр хэлбэл авлига, хээл хахуулийн гэмт хэргийн ялтанг бүх насаар нь хорих нь зөвхөн цаазаар авах ялыг хоёр жилийн хугацаатай хойшлуулан гүйцэтгэх нэг хэрэгжилтийн арга юм.

2.2. Бүх насаар нь хорих ялыг хэрэглэхэд тулгамдаж буй асуудлууд

Авлига, хээл хахуулийн хэргийн хувьд л бүх насаар нь хорих ял оногдуулахаар ялгаварлан тогтоосон нь 9-р нэмэлтийн өөрчлөлт оруулах гол шинэлэг санаа, онцлог нь болсон. Гэсэн хэдий ч бүх насаар нь хорих ялыг анхлан хэрэгжүүлэхэд олон тооны алдаа дутагдал гарсаар байна.

Юуны түрүүнд холбогдох хэм хэмжээ тодорхойгүй байна. Эрүүгийн хуулийн дагуу бүх насаар нь хорих тогтолцоонд хэрэглэх дөрвөн нөхцөл байдаг. Үүнд:

1) Авлига авсан буюу хээл хахууль авч шийтгэл хүлээсэн гэмт хэрэгтнүүд;

2) Авлига, хээл хахуулийн хэмжээ онц их \гурван сая юань\;

3) Авлига, хээл хахууль нь улс орон, ард түмний ашиг сонирхолд онц их хохирол учруулсан;

4) Гэмт хэрэгтэнд хуулийн дагуу цаазаар авах ял \хоёр жилийн хугацаатай хойшлуулан гүйцэтгэх\ оноосон.

Эндээс гарч буй асуудал нь “Улс орон ба ард түмний эрх ашгийг хөндөж, онц их хохирол учруулсан” гэсэн нөхцөл хэтэрхий хийсвэр. Учир нь Хятад улсын эрүүгийн хууль тогтоомж, холбогдох шүүхийн тайлбарт “тусгай онц хүнд хохирол” гэсэн ойлголтыг тогтоогоогүй. Тиймээс хуульд тодорхойгүй байдлаар тусгасан зохицуулалт нь шүүхээс хууль хэрэглэх явцад маш их хүндрэл учруулахаас гадна шүүгчид хэргийг шийдвэрлэхэд тодорхой бус байгаагаас шүүгчийн шунахай, байдал, гэмт хэрэгтний буруутай үйлдэл зэргээс хамаарч шүүхэд авлига амархан гарах эрсдэлтэй байна.

Түүнчлэн бүх насаар нь хорих ялын тогтолцооний хамрах хүрээ тодорхой бус. Одоогийн байдлаар Хятадад бүх насаар нь хорих ялын тогтолцоо нь зөвхөн авлига, хээл хахуулийн гэмт хэрэг хамааралтай байгаа нт тогтолцооны хамрах хүрээг багасгаж байна. БНХАУ-ын Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг хэрэглэх 46 төрлийн гэмт хэрэг байдаг бөгөөд ихэнх гэмт хэрэг

нь хувь хүний болон эд хөрөнгийн аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдалд заналхийлсэн ноцтой гэмт хэрэг юм. Авлига, хээл хахуулийн гэмт хэрэг нь ноцтой гэмт хэрэг биш бөгөөд тэдний хувийн аюул занал, нийгмийн хор хохирол нь ноцтой гэмт хэргээс хамаагүй бага байдаг. Практикт бага эрсдэлтэй, нийгмийн хор хөнөөл нь бага гэмт хэрэгтнүүд илүү хүнд шийтгэл оногдуулах шаардлагатай байгаа нь БНХАУ-ын Эрүүгийн хуулийн гэмт хэргийн нэгдмэл зарчмыг зөрчиж буй харуулж байна.

Эцэст нь нэмж хэлэхэд бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн ялтанд нийгэмд эргэн орох боломж байхгүй. Эрүүгийн хуулийн 8-р нэмэлт өөрчлөлтийн дагуу бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгтний ялыг төрлийг бууруулж, хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах нөхцөлийг хангасан тохиолдолд хугацаанаас нь өмнө ял эдлэхээс чөлөөлж болно. Харин 9-р нэмэлт өөрчлөлтийн 44 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Бүх насаар нь хорих ял оногдуулсан ялтанд ялын төрлийг бууруулах эсвэл тэнсэн суллаж болохгүй” гэж заажээ. Өөрөөр хэлбэл дээрх хэсгийн дагуу бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгтэнг ялын төрлийг бууруулах буюу суллах боломжгүй.

Хятадын шүүн таслах ажиллагааны одоогийн бүх насаар нь хорих ялын тогтолцоо нь үнэндээ гэмт хэрэгтэнг “насан турш” нь шоронд хорьж байна. Авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт үйлдсэн хоригдлууд шоронгоос суллагдах ямар ч найдваргүй байгаа нь хүний эрхийг хамгаалахад үр дүнтэй түлхэц болж чадахгүй байна.

Дүгнэлт

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн есдүгээр нэмэлт өөрчлөлтөөр авлигын гэмт хэргийн шийтгэлийг бэхжүүлэн, авлига, хээл хахуулийн гэмт хэргийн тодорхой мөнгөний хэмжээг устгаж, мөнгөний хэмжээ буюу нөхцөл байдлыг тусад нь авч үзэх болсон. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн мөнгөний хэмжээ болон нөхцөл байдал нь авлига, хээл хахуулийн гэмт хэргийн нийгмийн хор уршгийн хэмжээг хэмжих үндэслэл бөгөөд эдгээр нь авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шийтгэх, яллахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс энэ арга нь гэмт хэргийг шийтгэх зарчимтай илүү нийцдэг. Есдүгээр нэмэлт өөрчлөлтийн дагуу цаазаар авах ялын тоог багасгаж, 9 хэрэгт



цаазаар авах ялыг хэрэглэхийг хүчингүй болгож, авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт бүх насаар нь хорих ял оногдуулахыг нэмэгдүүлсэн байна. Хамтад нь авч үзвэл бүх насаар нь хорих ялын тогтолцоог бий болгох нь цаазаар авах ялыг багасгаж, цаашид уг ялыг халах байнгын оролдлогын үр дүн юм. Хэдийгээр 9 дүгээр нэмэлтээр орсон өөрчлөлтүүд нь хэрэглэх явцад эргэлзээтэй, шүүмжлэлтэй асуудал дагуулж буй боловч нь сул талаасаа илүү давамгайлсан давуу талтай юм.

Үүнээс гадна уг есдүгээр нэмэлт өөрчлөлтөөр террорист гэмт хэргийг шийтгэх ажиллагааг нэмэгдүүлж, террорист гэмт хэрэг үйлдсэн бол эд хөрөнгийн шийтгэлийг оноох болсон. Мөн мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хамгаалахын тулд иргэдийн хувийн мэдээллийн хамгаалалтыг бэхжүүлэн, буруу мэдээлэл гаргах, хуурамчаар үйлдэх гэмт хэргийг шинэчилжээ.



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ПРОКУРОРООС ТАВИХ ХЯНАЛТ

3. Сансарзолбоо

Улсын Ерөнхий прокурорын газрын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл,
дүн шинжилгээний төвийн хяналтын прокурор

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудал Монгол Улсын төдийгүй олон улсын түвшинд томоохон байр суурийг эзэлдэг.

1990-2000-аад оны үед бид залилах гэмт хэргийг өөрөөр ярьдаг байсан. Тухайн үед хувь хүн энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болдог байсан бол өнөө цагт хувь хүмүүсийн хүрээллээс хальж, байгууллага, аж ахуйн нэгжүүд болон банк санхүүгийн байгууллагын эрх ашигт халдан томоохон хохирол учруулж байна.

Энэ нь тус улсад үүссэн нийгэм, эдийн засгийн өсөлт дэвшил, хөгжлийн чиг хандлага, мөнгөний инфляцийн өөрчлөлт, гадаад дотоод харилцаанд гарсан дэвшил, нийгмийн сэтгэлгээний өөрчлөлттэй холбоотой. Сүүлийн үед залилах гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр улам нарийсч бусдыг хохироох хохирлын хэмжээ ч ихсэх хандлагатай болж байна.

Ер нь ирээдүй рүү харвал хэзээ ч нүүр тулаагүй, сонсож байгаагүй, хүний санаанд багтмааргүй, улс үндэстнийг дамнасан, цахим сүлжээ, шинжлэх ухаан техникийн дэвшлийг ашигласан олон төрлийн залилангийн гэмт хэргүүд ирж яваа. Энэ нь даяарчлалтай ч бас холбоотой. Мөн гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг зогсоож, улс орны эдийн засгийн өсөлт, тогтвортой, ашигтай байдалд нөлөөлөх аюултай нөхцөл байдалд хүргэхийг үгүйсгэхээргүй болоод байна.

Хуульч бид олон хүний эрх ашиг зөрчигдөж, их хэмжээгээр хохирсных нь дараа биш урьдчилан харж, оновчтой сэтгэж, бэлтгэлтэй байж хүмүүст хандан мэдрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь чухал юм. Ингэхийн тулд олон улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг хэрхэн үйлдэгдэж байна, үүнтэй яаж тэмцэж байгааг цаг алдалгүй судлан, хууль тогтоомжид тусгах нь хуульч бидний үүрэг юм.

Монгол Улсад үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн дийлэнх хэсгийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дотроос хулгайлах, залилах гэмт хэргүүд их хувийг эзэлж буй талаар Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016 дурдагдсан билээ.

Залилах гэмт хэргийн талаар шинжлэх ухааны анхны тайлбарыг доктор Г.Совд хийсэн бөгөөд тэрээр “Залилан мэхлэх гэмт хэрэг бол иргэдийн амины өмч ба өмчийн эрхийг залилан мэхлэх буюу итгэлийг эвдэх замаар өөртөө шилжүүлэн авсан хууль бус ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Манай улсын хууль тогтоох байгууллага бодит байдал дээр үүссэн нөхцөл байдалд тулгуурлан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульдаа энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга хэлбэр, хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг өмнөх хуульд байснаас өөрчлөн дэлгэрэнгүй ойлгомжтой болгон тайлбарлаж хуульчилсан.

Тухайлбал: 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.1 дэх хэсэгт “Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан...”, 148.2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан...”, 148.3 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан...” , 148.4 дэх хэсэгт “Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан...” гэж байсан бол одоогийн дагаж мөрдөж буй



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан” гэж үйлдлийн арга хэлбэрээр нь гэмт хэргийн шинжийг тодорхой болгож, 2 дахь хэсэгт “албан тушаалын байдлаа ашиглаж”, “бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж...” гэж хүндрүүлэх нөхцөл байдлыг тусгаад, 3 дахь хэсэгт: “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон”, “олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн”, “зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн...” гэж онц хүндрүүлэх шинжүүдийг нарийвчлан тусгаж өгсөн нь хуулийн заалтыг боловсронгуй болгосноос гадна дээр дурдсанчлан ирээдүй рүү харсан оновчтой өөрчлөлт болсон нь сайшаалтай юм.

Мөн энэ төрлийн хэрэг бусад олон улсын хэмжээнд ямар байдаг талаар судалгаа хийхэд дэлхийн өндөр хөгжилтэй, эрх зүйн орчин сайтай зарим улс оронд залиланг илрүүлэх, урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан хүмүүсийг төр, хувийн хэвшлийн аль алинд нь авч ажиллуулах хэрэгцээ нэмэгдэж иймэрхүү ажил үүргийг гүйцэтгэх чадвартай хүмүүст нэмэлт цалин өгч ажиллуулдаг байна. Учир нь залилан болон бусад эдийн засгийн гэмт хэргүүд нь олон улсын байгууллагуудын санаа зовоосон асуудлын нэг болоод байна. Жишээ нь: 2015-2017 онд гаргасан “Global Corruption Report”-ийн тайланд «Нийт компаниудын 80% нь аль нэг төрлийн залилангийн үйлдэлтэй нүүр тулж байсан» гэж мэдээлэгдсэн байдаг юм байна.

Монгол Улсад үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг үйлдэгдэж буй арга хэлбэр талаас нь авч үзвэл:

- Урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцэл хийх замаар халхавчилж;

- Цахим хэлбэрээр буюу олон нийтийн сүлжээ ашиглаж улс дамнан;

- Өөрийн ажил, мэргэжил, авъяас чадвар, нэр хүндээ ашиглаж;

- Гадаадад ажиллах хүч гаргахад зуучлах нэрээр, мөн Монгол улсын цалин хангамж

өндөртэй аж ахуй нэгж байгууллагуудад ажилд оруулж өгнө гэж амлаж;

- Урьдын харьцааг урвуулан шашин шүтлэг, сүсэг бишрэл, хобби, танил талын хүрээллийг ашиглаж;

- Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар;

- Эрх зүйн олон төрлийн харилцаа болон нийгэм, эдийн засгийн харилцааг холилдуулан гадаад дотоодын хөрөнгө оруулагч, гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг залилах ...гэх мэт олон төрлийн арга хэлбэрээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/67 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба, Замын цагдаагийн алба, Нийслэлийн цагдаагийн газар, Төмөр зам дахь Цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсээс гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл, гэмт хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяалал”-ыг тогтоосон. Үүнд: Улсын Ерөнхий прокурорын газраас шалгах харъяалал тогтоосон “Залилах” / Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/ дахь хэсэгт заасан мөрдөн байцаалтын хэргийг Цагдаагийн Ерөнхий газрын Мөрдөн байцаах алба мөрдөн байцаалт явуулахаар, прокурорын хяналтын харъяаллыг Нийслэлийн прокурорын газар, харъяалал тогтоосон Дүүргийн прокурорын газар хяналт тавихаар тус тус тогтоосон.

Энэ төрлийн гэмт хэргийн зарим нэг тоон баримтуудыг товчхон танилцуулъя. Үүнд:

1. Залилах гэмт хэргийн гаралт

Улсын хэмжээнд залилах гэмт хэрэг 2013 онд 1360, 2014 онд 2055, 2015 онд 2375, 2016 онд 2453, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 1203 гарсан бол, 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд буюу 2017 оны сүүлийн хагас жилийн байдлаар 2099 хэрэгт хэрэг бүртгэлт, 431 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа тус тус явуулжээ.

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд 1701 залилангийн хэрэгт хэрэг бүртгэлт, 285 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулаад байна.

Дээрх статистик тоон үзүүлэлтийг өнгөц хараад дүгнэлт хийвэл Монгол улс “залилах” гэмт хэргийн үүр уурхай болжээ



гэж харагдан гадаад дотоодын хөрөнгө оруулагч, эдийн засаг, өмч хөрөнгийн хамаарлаар харилцагч нарт таагүй сэтгэгдэл төрүүлэхүйц байдлыг үүсгэхээр болоод байна. Мөн иргэдийн амьжиргааны түвшин буурсан болон амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэтгэхүй давамгайлсантай холбоотой байх боломжтой юм.

2. Залилах гэмт хэргийн шийдвэрлэлт

Энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийг улсын хэмжээнд авч үзвэл 2013 оноос 2017 оны эхний хагас жилийн байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 9540 хэргийн 845 буюу нийт хэргийн 8.8 хувийг яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлж, 5157 буюу 54 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 1-нээс хойш шийдвэрлэгдсэн хэргийн хувьд 431 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж 46 буюу 11 хувийг хэрэгсэхгүй болгож, 184 буюу 43 хувийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, гэм буруугийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.

Шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн хэргийн тоо өссөн шалтгаан нь өмнөх 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хөнгөн хэргийг хохирогч, яллагдагчтай эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсныг шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар өөрчилж нотлогдсон гэмт хэргийг заавал шүүхээр шийдвэрлэж гэм буруу, хохирлын асуудлыг эцэслэн шийдвэрлүүлж байгаатай холбоотой бөгөөд, энэ нь хохирогчийн эрхийг хангах үндсэн нөхцөл болсон байна.

Мөн энэ төрлийн гэмт хэрэг хохирлын хэмжээний хувьд 2002 оны Эрүүгийн хуульд бага бус хэмжээний хохирол буюу 192.000 төгрөгнөөс дээш хохирол учирсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор хууль эрх зүйн орчин хязгаарлагдмал байсан бол шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулиар залилах гэмт хэргийн хамрах хүрээг өргөтгөж, зөвхөн үйлдлээр нь зүйлчилдэг болсон нь сайшаалтай юм. Тухайлбал: бусдаас худал хэлээд нэг ширхэг үзэг авсан ч гэмт хэрэгт тооцохоор байгаа юм. Хэдийгээр энэ нь гэмт хэргийн тоог асар их өсгөж, улсын хэмжээний эрүүгийн нөхцөл байдал хүндэрч харагдаж байгаа хэдий ч хохирогчийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн зохицуулалт болсон.

Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол

улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахад орших бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт ч хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэгддэг. Гэмт этгээдийг шийтгэхээс илүү чухал асуудал бол хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах асуудал байдаг. Одоогийн практикт гэмт хэрэгтнийг шийтгүүлчихээд иргэд хохирсон чигээр үлдээд байна.

Иймд ч шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд "Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээг хэрэглэх" тухай заагаад хамгийн гол нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу төлөхөө илэрхийлсэн байх нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулахдаа харгалзан үзэх нэг гол асуудал гэж үзсэн нь дээрх зорилгод нийцэж байгаа юм.

3. Хэргийг шалгаж, шийдвэрлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээл

Энэ төрлийн гэмт хэрэг нь иргэний эрх зүйн төрөл бүрийн /зээлийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, ажил үүрэг гүйцэтгэх гэрээ, үүргийн гүйцэтгэлийг шилжүүлэх гэрээ ...гэх мэт/ гэрээгээр халхавчилж үйлдэгддэг тул иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх талаар нарийвчилсан зохицуулалт, нэгдсэн ойлголт дутмаг байгаагаас мөрдөгч, прокурор нар гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж байгаад тухайн үйлдэлд нь гэмт хэргийн шинжгүй "иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлэх асуудал байна, иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүл" гэсэн хариуг хохирогч талд өгдөгөөс шалтгаалж хууль сахиулагчдад болон хуульчдад итгэх иргэдийн итгэл алдарч "хуйвалдлаа, авилгад өртлөө, нэг талыг барьж шалгаж шийдлээ" гэсэн хардлагад өртөж, нэр хүнд нь унаж байгаагаас гадна шат шатны прокурорыг дамжин гомдол гаргаж, гэмт этгээдүүдтэй хийх тэмцлээсээ илүү хуулийнхантай хохирогч талаас тэмцэн дургүйцэх явдал их гаргадаг байна.

Тухайлбал: Прокурорын байгууллагаас дотооддоо дээд шатны прокуророос хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан /эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан/ шийдвэрийг хүчингүй болгон хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хэрэгсэхгүй



болгож шийдвэрлэсэн хэргийг сэргээсэн байдлыг тогтмол хугацаанд судалж, дүн шинжилгээ хийхэд сэргээгдэж буй хэргийн ихэнх хувийг залилах гэмт хэрэг эзэлж байдаг талаар тоон баримтууд байна. Энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтэд гомдол олноор гараад байгаа шалтгаан нь:

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр хариуцагч этгээдийн нэр дээрх эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс гэм хорыг арилгуулахаар тусгаж шийдвэрлэдэг ч шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үе шатанд түүний нэр дээр төлбөр гаргуулах өмч хөрөнгө байхгүйгээс шалтгаалж, хариуцагчийг дахин хөрөнгөжтөл хүлээхээс өөр аргагүй байдгаас шалтгаалж нэхэмжлэгчийн эрх ашиг Иргэний хуулиар хамгаалагддаггүйтэй холбоотой юм.

Нөгөөтэйгүүр цахим сүлжээ ашиглаж болон гэрээгээр халхавчлан олон эрх зүйн харилцааны хэлбэрийг ашиглан гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийн хэргийг шалгах мөрдөгч нар бэлтгэгдээгүй байдал нь залилуулж хохирсон хүмүүсийн эрх ашгийг хамгаалж чадахгүйд хүргэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нар гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд хэргийг шалгаж шийдвэрлэх эрх бүхий байгууллагад ханддаггүй, мөнгө эд зүйлсээ өгч алдаад эргүүлж авахаар янз бүрийн аргаар урт хугацаагаар гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй харьцаж явсаар эцэст нь өөрөө хохирлоо эргүүлэн авах боломжгүй болсон үедээ хуулийн байгууллагад ханддаг. Энэ үедээ “надаас авсан мөнгө, хөрөнгөөрөө босгосон объект энэ байна, хөрөнгө шингээсэн газар нь энэ байна” гэх мэтээр шууд зааж хэлдэг бөгөөд хохирогч, холбогдогч талын урт хугацаагаар хоорондоо харьцсан харьцаа, мөнгө төгрөг, эд зүйлээ өгөлцөж авалцсан асуудал нь иргэний эрх зүйгээр шийдвэрлэгдэх асуудал байна уу?, эрүүгийн эрх зүйгээр шийдвэрлэгдэх асуудал уу? гэдгийг ялгаж салгахын тулд багагүй хугацаанд хэрэг бүртгэлт явуулан шалгах шаардлага гардаг.

Мөн хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээг нарийвчлан тогтоох, хохирогч нар иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлсэн асуудлаа эрүүгийн журмаар шалгуулах хүсэлтэй байдаг тул уг асуудлыг нарийвчлан шалгах, зарим тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах зэргээр багагүй хугацаанд хэрэг бүртгэлт явуулан шалгах шаардлага тулгардаг тул

гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах 5 хоногийн хугацаанд дээрх ажиллагааг шалгаж тогтоох боломжгүй, зайлшгүй хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаж байна.

Сүүлийн үед үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн тухайд хохирогч интернэт орчинд хувийн мэдээллээ алдсанаас, гэмт этгээд цахим хуудас руу хууль бусаар нэвтрэн хамаатан садан, найз нөхөд нь болж “яаралтай мөнгө хэрэгтэй байна, зээлээч” гэх мэтээр бусдад эд хөрөнгө, мөнгөө зальдуулж, энэ төрлийн гэмт хэргийн золиос болох явдал цөөнгүй байна. Энэ тохиолдолд залилагч этгээд хэн болох, хаанаас, ямар төхөөрөмжөөс хохирогчийн мэдээллийг хэрхэн олж авч нэвтрэж байгааг тогтоох боломжгүй, энэ талаар мэргэжлийн байгууллагаас болон цахим сүлжээний операторч мэргэжилтнээс тусламж хүсэхэд үнэ төлбөргүй, хурдан хугацаанд мөрдөгчид тусалчихмаар мэргэжилтэн байхгүй байгаа зэрэг бэрхшээл тулгардаг байна.

Мөн залилах гэмт хэргүүд нь цахим мэдээллийг ашиглаад зогсохгүй гадаад улс орон, үндэстнүүдийг дамнаж байгууллага аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд орж /прамид сүлжээ/ уг гэмт хэргийг хэн хэзээ хаанаас яаж эхлүүлсэн нь тодорхой бус байдал үүсч, хэргийг дундаас нь тасалж шийдэх боломжгүй, гадаадад нэр заагдсан субъектийг шууд холбогдуулан шалгах боломжгүй, гадаадад эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлт тэр бүр богино хугацаанд биелэгдэж ирдэггүй зэргээс шалтгаалан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдсан хохирогсдын эрх ашиг хамгаалагдахгүй байх явдал гарч байна.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн гол онцлог нь 2 буюу түүнээс дээш улс дамнан үйлдэгддэг бөгөөд гэмт этгээд халдлагийг өөр улсаас үйлдэж гэмт хэргийн замаар олдсон хөрөнгө гуравдагч улсад шилжигдэж байна. Үүнтэй холбоотойгоор үүсэж байгаа 2 буюу түүнээс дээш улсад зэргэцэн мөрдөн байцаалт явуулах, гэмт хэргийн замаар олдсон эд хөрөнгийг хамгаалах, буцаан авах ажиллагаа нэн тэргүүнд тавигддаг.

Дээрх ажиллагаа нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хүрээнд явагдах боломжтой. Гэхдээ өнөөдөр бид 20 гаруй улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй бөгөөд дээрх



төрлийн гэмт хэргүүд нь эрх зүйн гэрээгүй орнууд буюу Америк, Европын улсуудад үйлдэгдсэн тохиолдлууд гарсаар байна. Энэ тохиолдолд бид олон талт олон улсын гэрээ, тухайн гэмт хэрэг нь олон талт гэрээгээр зохицуулагдаагүй тохиолдолд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим буюу харилцан туслалцаа үзүүлэх зарчимд тулгуурлан авах боломжтой юм.

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримт цуглуулах албан ёсны шугам боловч түүнийг илгээхэд анхдагч мэдээллийг цуглуулсан байхыг шаарддаг, түүнчлэн харилцах сувгийн хувьд эрх бүхий төв байгууллага хооронд харилцаж уг байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэх байгууллагад очдог, эрх зүйн хэлбэрийн хувьд албан ёсны хэлбэржүүлэлт шаарддаг учраас цаг хугацаа алдаж байгаа бэрхшээлүүд цөөнгүй байна.

Цахим залилах гэмт хэргийн хувьд ихэвчлэн их хэмжээний мөнгөн дүнтэй гүйлгээ хийгддэг, залилагч этгээдүүдийн хувьд гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хувиргаж мөнгө угаах гэмт хэргийг давхар үйлддэг байна. Энэ тохиолдолд дэлхийн 150 орны Санхүүгийн мэдээллийн албанд нэгдсэн Эгмонтын сүлжээг ашиглаж хөрөнгийг царцаах, гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг шалгуулах зэрэг арга хэмжээ авах боломжтой юм.

Энэ төрлийн гэмт хэргийн хувьд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хожуу мэдээлэгддэг, гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой байдаг зэргээс шалтгаалж хэрэгт хийгдэх хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, шалгах үе шатуудын хувьд хэргийн онцлогоос хамаарч өөр байх шаардлага зүй ёсоор сүлжээг ёстой юм. Өөрөөр хэлбэл: Энэ төрлийн гэмт хэргийг шалгахдаа нэн тэргүүнд мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг даруй шалгаж, эзэн холбогдогч нь тодорхой тохиолдолд прокуророос гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, залилагч этгээдийн хөрөнгийг түр хураах, захиран зарцуулах эрхийг хянах, хязгаарлах зэрэг арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх нь хохилогчийн эрхийг хамгаалах нэг гол нөхцөл болно.

Мөн цахим хэлбэрээр, олон нийтийн сүлжээ ашиглаж улс дамнан үйлдэгдсэн залилах гэмт хэргийг шалгахдаа гэмт

хэргийн ул мөрийг бэхжүүлэх, гэмт хэргийн замаар олдсон хөрөнгийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд дараахь ажиллагааг шуурхай явуулах нь зүйтэй юм. Үүнд:

- Цагдаагийн байгууллага хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд шууд харилцаж мэдээлэл солилцох;

- Албан бус шугам буюу Интерполын, Санхүүгийн мэдээллийн албаны шугамаар мэдээлэл солилцох;

- Гүйлгээ хийгдсэн банкинд хандаж, хөрөнгийг зарцаах, хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг хязгаарлах... гэх мэт.

Дээрх ажиллагааг түргэн шуурхай хийж гүйцэтгээгүйгээс гэмт хэрэг үйлдэгч этгээд залилсан зүйлээ үрэн таран хийж, хэд хэд дамжуулах, нуух, өөр зүйлд хөрвүүлэх зэрэг таатай боломж бүрддэг байна.

Мөн шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас хамаарч мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүдийн дийлэнх буюу 70 гаруй хувь нь хэрэг бүртгэлтийн хэргүүд эзэлж байгаа бөгөөд, эдгээр хэргүүд нь бүгд эрүүгийн мөрдөгч нар дээр төвлөрч, мөрдөгч нарын ажлын ачааллаас шаардлагын хэмжээнд хүрэхгүй, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийг этгээдийг олж тогтоон хэргийг мөрдөн байцаалтанд шилжүүлэн шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй явагдаж байна.

4. *Залилах гэмт хэргийг шалган шийдвэрлэх* ажиллагаанд прокуророос тавих хяналт

Прокурор эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэргийн талаар шийдвэрийг гаргадаг, эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлох үүрэгтэй өндөр хариуцлага бүхий албан тушаалтны хувьд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас эхэлж хэргийг шалгаж шийдвэрлэх бүхий л явцад байнга тасралтгүй хяналт тавих ёстой юм.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар прокурор гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг бүртгэлдээ авч, эрүүгийн хэргийг үүсэх үед нь дугаар олгосноор прокурорын хяналтыг хэрэгжүүлж байна гэж үзэж өөрийн санаачлагаараа эрүүгийн хэргийг татаж хянаж байгаа хэлбэр нь байцаан шийтгэх ажиллагаанд



оролцогчдоос гаргасан гомдол, хүсэлт, шалгалт, судалгааны явцад хэргийн материалыг татаж хянадаг, биечлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тэр бүр оролцдоггүй, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас хэргийг шалгаж дуусаад санал гаргаж ирүүлсэн хойно нь сая хийгдсэн ажиллагаатай нь танилцаж шийдвэр гаргадаг байсан бол шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, хэргийг нэгтгэх, тусгаарлах шийдвэр гаргахаар, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэхээр, мөрдөн шалгах тодорхой ажиллагаануудад зөвшөөрөл өгөхөөр тус тус хуульчилж өгснөөр прокурор хэргийг анхнаас нь тасралтгүй хянах нөхцөл бүрдэж байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд прокурор биечлэн оролцох нь уг ажиллагааг хуулийн хүрээнд явуулах, түүнд оролцогчдийн эрхийг хангахад нөлөөлөөд зогсохгүй тухайн хэргийг шүүн таслах ажиллагаанд прокуророос яллах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх хамгийн бодитой, үр дүнтэй хэлбэр гэж ойлгож болно.

Залилах гэмт хэргийн тухайд үйлдсэн эзэн нь ихэвчлэн тодорхой байдаг ч ялангуяа сүлжээ хэлбэрээр, зохион байгуулалттайгаар, гадны улс орон, үндэстэн дамнан үйлдэгдэж буй тохиолдолд гэмт хэрэгт оролцож буй этгээдүүдийг бүрэн хамруулж шалгаагүй, тэдгээрийн гэмт хэрэг үйлдэхэд ямар хэлбэрээр оролцсон оролцоог тодруулан тогтоож эрүүгийн хариуцлагад татахгүй орхигдуулах явдал байдаг нь мөрдөгчийн хэргийг шалгах арга барил, мэдлэг, мэргэжлийн ур чадвараас шалтгаалдаг тул прокурор хэрэг бүртгэлт нээсэн хэрэгт тасралтгүй хяналт тавьж, мөрдөгчийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах нь зүйтэй.

Дээрх төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн олон хохирогчтой, гэмт этгээд зөвхөн нэг газар нутагт гэмт хэргээ үйлддэггүй, дүүрэг, орон нутаг дамжин үйлддэг, хэрэг үйлдэх цаг хугацаа нь харилцан адилгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж хэрэг шалгах хугацаа удааширдаг. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар

татах хуулийн зохицуулалтыг үндэслэн яллагдагчид холбогдох хэргийг бусад хэргүүдтэй нь нэгтгэхгүйгээр нотлогдсон хэргийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж байх нь зүйтэй юм.

Иргэний эрх зүй дэх маргааныг шийдвэрлэх хуулийн зохицуулалт иргэдийн эрх ашгийг хамгаалж чадахгүй байгаагаас иргэд асуудлаа шийдүүлэхийн тулд эрүүгийн журмаар гомдол гаргаж төрийн албадлагаар өөрийн эд хөрөнгөө буцааж авах сонирхол их байдаг тул хохирогчийн сэтгэл зүй, санаархал, зорилгыг тодорхойлж, хэргийг зөв зүйлчилж шалгаж байгаа эсэхэд прокурорын хяналтыг чиглүүлж ажиллах шаардлагатай.

5. Дүгнэлт, санал

Залилах гэмт хэрэг нь нийгмийн хөгжлийг даган илрэх хэлбэр, үйлдлийн арга, криминалоги шинж нь хувьсан өөрчлөгдөж шинээр бэрхшээл, тулгамдсан асуудлууд үүсэн гарсаар байгаагийн зэрэгцээ эрх зүйн хөгжлийн өнөөгийн түвшинд залилах гэмт хэргийг зарим төрлийн хувийн эрх зүйн гэрээний харилцаанаас үүдэлтэй маргаанаас ялган зүйлчлэхтэй холбоотой хууль зүйн шинжлэх ухааны түвшинд шийдвэрлэбэл зохих асуудлууд байсаар байна.

Нөгөөтэйгөөр залилах гэмт хэргийн шинжүүдийг иргэний эрх зүйгээс ялган зүйлчлэх талаар практикт тулгуурласан онолын нэгдсэн ойлголт, тайлбар байхгүй, зарим газарт иргэний хэрэг гээд шүүхийн шийдвэр гаргачихсан байхад, зарим газарт Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд шалгаж байх жишээтэй. Энэ нь залилах гэмт хэргийг зүйлчлэх, шалгах, шийдвэрлэх талаархи эрүүгийн хууль тогтоомжийг болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэг мөр ойлгож хэрэгжүүлж чадахгүй байгаагийн илрэл гэж дүгнэж байна.

Гэрээгээр халхавчилж залилсан тохиолдолд шууд харахад иргэний шинжтэй маргаан мэт харагддаг боловч залилагч этгээдийн мөнгөө өгөхгүй байх гэсэн башир арга цаана нь байдаг тул үүнийг шалгаж тогтоохын тулд мөрдөгч, прокурорууд Иргэний гэрээний талаар ойлголттой байх буюу илүү мэргэшсэн байх шаардлага гарч ирж байгаа юм.

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоож, хохирогсдын хууртагдаж буй байдал, гэмт хэргийг илрүүлэлт, учирсан хохирол, хохирол



төлөгдсөн байдал, хэргийн шийдвэрлэлт, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байдлыг ил тод байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслэлд нийтлүүлж, гэмт хэргийн золиос болохгүй байх талаар иргэдэд санамж анхааруулга байдлаар мэдээлэн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах шаардлага бодит байдлаас үүдэлтэйгээр хуульч бидний өмнө хурцаар тавигдаж байна. Ингээд эрдэм шинжилгээний хурлын үр дүнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналыг гаргаж байна. Үүнд:

- Мөрдөгч, прокуроруудыг цахим сүлжээ ашиглан мөрдлөг явуулах, төхөөрөмжийг ашиглаж чаддаг арга техникт сургах, энэ чиглэлээр мэргэшүүлэх;

- Гэрээний эрх зүйн талаар мөрдөгч, прокуроруудад сургалт зохион байгуулах;

- Энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх талаар заавар зөвлөмж гаргаж гарын авлага бэлтгэж өгөх зэрэг саналтай байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он
4. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 он
5. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
6. Монгол Улсын Иргэний хууль 2002 он
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 1997 он
8. Г.Совд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” УБ 2002 он
9. С. Нарангэрэл “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ УБ 1998 он
10. С.Должин, Д.Бадам “Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан” 2018 он
11. С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” 2009 он
12. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016” 2017 он
13. Хууль зүйн үндэсний төв “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” 2008 он



ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ АЖИЛЛАГАА, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

А.Пүрэвдорж

ЭЗГХТГ-ын ахлах мөрдөгч,
цагдаагийн дэд хурандаа

Удиртгал

Манай улсын эдийн засгийн тогтворгүй байдал, нийгмийн өөрчлөн байгуулалт, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр “Эдийн засгийн” гэх тодотголтой өмчийн болон аж ахуйн эсрэг шинэ төрлийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэх болсон бөгөөд үйлдлийн арга нь улам нарийсч хэлбэрийн хувьд зохион байгуулалтанд орж байгаа. Эдийн засгийн гэмт хэргүүдийг олон хоног сар жил баримтжуулах, хөрөнгө мөнгө, цаг хугацаа их шаардаж, алба хаагчидын уйгагүй бүтээлч ажлын үр дүнд илрүүлдэг. Нэгэнт илэрсэн хэргийг мөрдөн шалгаж, хөдөлбөргүйгээр нотлох нь ч ихээхэн хүндрэлтэй байдаг.

Эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх,

нотлох ажиллагааг шинэ шатанд гаргах, хэргийг шийдвэрлэлтийг ахиулах шаардлагын үүднээс цагдаагийн байгууллагаас шат дараалсан арга хэмжээнүүдийг авч энэ төрлийн гэмт хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн шалгаж, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцлийг тогтоож, мөрдөн шалгах ажиллагааг түргэн шуурхай явуулах болон хэргийг шийдвэрлэх зорилгоор бүтцийн өөрчлөлт хийж хуучнаар УМБГ-ын ЭЗГХМХ, ЭЦГ-ын ЭЗГХТХ-ийг нэгтгэн, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар болгон зохион байгуулж уг бүтцээр өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын бүтэц /схем-1/



Тус газар нь “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяалал тогтоох тухай” Улсын ерөнхий прокурорын 2017 оны 06 сарын 30-ний өдрийн А/67 дугаартай тушаалд заасны дагуу Эрүүгийн цагдаагийн албанаас илрүүлсэн Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт хуульчилсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, болон 18 дугаар бүлэгт хуульчилсан эдийн засгийн гэмт хэргээс зохион байгуулалттай, онц их хэмжээний хохиролтой, олон холбогдогчтой, улс дамжсан, ээдрээ төвөгтэй хүндрүүлсэн бүрэлдэхүүнтэй эрүүгийн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

2.Өмчлөх эрхийн эсрэг болон эдийн

засгийн гэмт хэргийн онцлог:

Энэ төрлийн хэргүүд нь цогц гэмт хэрэгт тооцогддог. Өөрөөр хэлбэл авлига, албан тушаал, аж ахуйн, байгаль орчны, татвар төлөхөөс зайлсхийх, улсын хилээр бараа, бүтээгдэхүүн хууль бусаар нэвтрүүлэх, мөнгө угаах, хуурамч мөнгөн тэмдэгт зэрэгтэй холбоотой хэргүүд ордог.

– Гэмт хэргийн нийгмийн хор аюул их, өөрөөр хэлбэл зөвхөн гэмт хэргийн хохирогчдод мөнгөн хохирол учруулаад зогсохгүй үндэсний эдийн засагт ноцтой гарз хохирол учруулж байдаг. Тухайлбал улсын мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдвэрлэх, санхүүгийн залилан, мөнгө угаах, мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг



зэрэг нь аливаа үндэстний аюулгүй байдал, засаглалын асуудлын хэмжээнд нөлөөлж чадахуйц ноцтой хэргүүд байдаг.

– Албан тушаалтнууд холбогдсон байдаг. Сүүлийн 3 жилд манай улсад түгээмэл гарч бүртгэгддэг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах мөнгө угаах, банкны хууль тогтоомж зөрчих, хэргүүдэд төрийн өндөр албан тушаалтнууд хамтран оролцох, зохион байгуулах хандлага ажиглагдаж байна.

– Шинжлэх ухаан, техникийн дэвшлийг гэмт хэрэг үйлдэхдээ ашигладаг.

– Авлига эдийн засгийн гэмт хэрэг хоёр салшгүй холбоотой., нэг нь нөгөөгийнхөө хэргийн бааз суурь нь болж байдаг. Эдийн засгийн гэмт хэргийн хамаарал буюу сул хяналтгүй мөнгөний урсгал бол авлигын суурь болдог.

– Олон салбарыг хамарч үйлдэгддэг. / Цагдаагийн байгууллагаас эдийн засгийн тэр тусмаа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг илрүүлэх, нэгэнт илэрсэн хэргийг мөрдөн байцаалтын шатанд хөдөлбөргүйгээр нотлохын тулд тухайн салбар мэргэжлийн алба хаагч нартай нягт холбоотой ажиллаж, харилцан мэдээлэл солилцож ажиллах шаардлагатай./

3.Шалтгаан нөхцөл

Эдийн засгийн хямрал, аж ахуйн нэгжийн өмчлөл, банк санхүү, зээлийн хүрээн дэх элдэв зөрчил гажуудлууд

Зах зээл дээрх мөнгөний эргэлт удааширсан, дотоод аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд төлбөрийн чадвар доройтож өр зээлийн гинжин холбоо үүссэн

Зарим хууль тогтоомжууд нь амьдралд нийцэхгүй, иргэд, аж ахуйн нэгжийн шударга үнэнээр бизнес эрхлэх нөхцөл бололцоог хаан боогдуулсан.

Хөрөнгийн баталгаагүй, эргүүлж төлөх найдваргүй хүмүүст их хэмжээний бэлэн мөнгөөр банкны хууль тогтоомж зөрчиж зээл өгч тэдгээрийн ихэнхийг эргүүлж авч чадаагүй байдал улсын эдийн засгийн хүчин чадлыг тамирдуулахад хүргэсэн, үүнтэй холбоотой банк, санхүүгийн зөрчил хавтгайрсан, банкны гүйлгээ үнэт цаас, ялангуяа чек бусад төлбөрийн баримтыг хууль бусаар ашиглах явдал жирийн үзэгдэл болсон

Нийгмийн хүрээнд хүмүүсийн эд хөрөнгийн тэгш бус байдал, амар хялбар аргаар ажил бүтээх, мөнгө олох хүсэл, хүний

эрх, төрийн албаны ёс зүйг бүдүүлэгээр зөрчих явдал Монгол Улсад ямар ч хориг саадгүй болсон /сонгууль/

Манай улс Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах, нэмүү өртөг шингээх зорилго дэвшүүлсэн. Энэ нь маш өндөр өртөгтэй хийгддэг ажил ба зөвлөх үйлчилгээ үзүүлэх нэртэй гадаадын хөрөнгө оруулалттай гэх компаниуд албан тушаалтнуудтай бүлэглэн хууль бусаар шалгарах, тэдэнд шан харамж өгөх зэрэг авлига албан тушаалын хэргүүд ихээр үйлдэгдэж байна.

Залилан мэхлэх, завших үрэгдүүлэх гэмт хэрэг нь онлайн, интернет хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох, гэмт хэргээ далдлахын тулд санаатайгаар болон зохиомлоор дампуурах, сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироох, бусдын дансыг ашиглах, албан тушаалын /сүүлийн үед банк санхүүгийн салбарт/ давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэгдэж байна. Эдийн засаг, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих хяналт сул, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зохицуулалт дутмаг зэрэг нь эдгээр гэмт хэрэг гарах суурь шалтгаан /төрийн байгууллагын хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт илт дутагдсан байдаг/ болж байна.

Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, иргэдийн аж ахуй, үйлдвэрлэл эрхлэх боломж, эрх зүйн орчин байхгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл болж байна.

4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нотлох ажиллагаа:

Өнөөдөр би та бүхэнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, түүний дотроос залилан мэхлэх гэмт хэргийн зүйлчлэл, нотлох ажиллагаа, түүний онцлог, арга тактикийн талаар ярилцах болно. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэдэг нь эд хөрөнгөө өмчлөх, эзэмших, захиран зарцуулах эрхэд халдсан, нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдэл юм. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэргийн талаарх ойлголт,



нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх ажиллагаа чухал байр суурьтай бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах зүйл их байдаг.

Уг гэмт хэргийн объект нь бусдын эд хөрөнгөө өмчлөх эрх буюу Иргэний хуулийн 101 дүгээр зүйлд заан тодорхойлсон, өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрх, халдлагын зүйл нь бусдын өмчлөлийн эд зүйл байна. Тэгвэл объектив тал нь бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг

Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсанаар төгсөдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

Хуурч мэхлэх гэдэг нь эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, хадгалах үүрэгтэй хүмүүсийг элдэв хуурамч аргаар төөрөгдүүлэх замаар эд хөрөнгөө өөрөө өгөхөд хүргэдэг, үнэн бодит мэдээлэл фактыг гуйвуулсан, тухайлбал, залилагч өөрийн ажил албан тушаал, үйл ажиллагааны боломжийг дөвийлгөн ойлгуулах замаар эд хөрөнгийг нь авах /виз гаргуулж өгнө, гадаадад гаргана гэх мэт / түүнчлэн хуурамч бичиг баримт, тусгай албаны хувцас, цол, тэмдэг ашиглан төөрөгдүүлэх /үнэмшүүлэх/ замаар эд хөрөнгө, түүнийг эзэмших эрхийг олж авах хэлбэртэй байж болно. Жишээ нь: Субъект өөрийгөө эрх мэдэл бүхий албан тушаалтан гэж ойлгуулан хахууль авах, төрийн албан хаагч болж торгох, хуурамч бичиг баримт ашиглан тэтгэвэр, тэтгэмж авах зэрэг хэлбэртэй байна.

Итгэл эвдэх гэдэг нь залилагч этгээд өмчлөгчтэй өмнө нь тогтоосон итгэлцлийн харилцааг ашиглан түүний эд хөрөнгө өмчлөх эрхийг эзэмшдэг. Итгэлцэл нь эд хөрөнгө худалдах, худалдан авах, солилцох, хөлслөх, зээлдэх ажил гүйцэтгэх, барьцаалан зээлдэх зэрэг иргэний эрх зүйн харилцаанд үндэслэгдэх жишээтэй. Итгэл эвдэх нь а/ямар

нэгэн бараа таваар олж өгөхөд зуучлахдаа үүргээ биелүүлэхгүй байх

б/мөнгө эд хөрөнгийг зээлээр авахдаа буцааж өгөх бодолгүй байх

в/гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ гэж урьдчилгаа мөнгө аваад өгөхгүй байх.

г/Барьцаалан зээлдүүлэх газраас эд зүйл техник хэрэгсэл аваад өгөх бодолгүй байх

д/банкнаас хуурамч бичиг баримтаар зээл аваад өгөхгүй байх зэрэг олон хэлбэртэй байна.

Субъектив тал нь Шууд санаатай, шунахай сэдэлттэй, сүбъектнь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд байна. Хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг албан тушаалын байдлаа ашиглаж, эсхүл бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол гэж, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол гэж хуульд тусгайлан зааж өгсөн

Хэргийн дээрх онцлог шинжүүдээс шалтгаалж мөрдөн шалгах нууц ажиллагаа болон нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх, илрүүлэх ил ажиллагаа хамтдаа явж байж үр дүнд хүрдэг. ЭХХШТХ-ийн 22 дугаар бүлэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах нийтлэг үндэслэлийг хуульчилж өгсөн байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл буюу Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсанаар иргэд, байгууллагын хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, тусгай эрхэнд шууд хохирол учруулдагаараа онцлог, их хор уршигтай, олны анхаарал татаж байдаг.

Мөн сүүлийн үед Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-д заасан ...Олон шатлалт маркетинг буюу хууль бус пирамид тогтолцооны үйл ажиллагаа явуулахыг хориглоно... гэсэн заалтыг зөрчин компани, төрийн бус байгууллага байгуулан сүлжээний бизнес эрхлэх нэрийн дор иргэдийг орон сууц, автомашинтай болгоно,



урамшуулалд мөнгө, эд зүйл өгнө гэж итгэл үнэмшил төрүүлэн элсүүлж залилан мэхлэх гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Сүлжээний бизнес нь богино хугацаанд олон хүнийг хамарч хохирол учруулдаг, нийгэмд сөрөг үзэгдэл бий болгодог, олны анхаарал татдаг онцлогтой хэрэг.

Сүүлийн үед ихээр үйлдэгдэж олон нийтийн анхаарлыг татсан залилан мэхлэх гэмт хэргийн обектив талын шинж болох цахим хэрэгсэл ашиглаж эсхүл олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн хэргүүд нь иргэдийг төөрөгдүүлж маш их хэмжээний хохирол учруулж байна. Алт сүлжээ нь хууль ёсных, аль нь луйврийн гэдгийг ялгаж салгаж нэг мөр ойлголтыг нийгэмд түгээж энэ төлрийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх нь бидний тулгамдсан асуудал болоод байна.

Шууд борлуулалтын олон шатлалт хэлбэр буюу пирамид нь эдийн засгийнхаа нэр томъёоны хувьд мөн сүлжээний маркетинг гэж нэрлэдэг. Энэ нь хүн амын маш бага хүрээнд бүлэг үүсгэн явагддаг арилжааны зохион байгуулалт бөгөөд уг тогтолцооны санал болгож буй бүтээгдэхүүнийг худалдан авснаар тухайн хүн цаашид зах зээлийн нийтлэг зохицуулалтын бус, тусгайлан боловсруулсан дүрмийн дагуу давуу байдал олж авах, орлого олох, боломжоор хангагдан, гишүүнчлэлийн статус нь сүлжээндэх борлуулалтын байдлаас шалтгаалан өөрчлөгдөх зарчим бүхий борлуулалтын үйл ажиллагаа юм.

Сүлжээний пирамид болон матриц гэгдэх ойлголтуудын хувьд матриц хэвтээ ижил түвшинд байх ба эхний элсэгчид болон сүүлд орсон түншлэгчдийн хувьд ижил боломжуудтай.

Харин пирамидын хувьд босоо зохион байгуулалттай сүүлд элссэн оролцогчид нь хохирогчид болон үлддэг, үндсэн үйл ажиллагааны зарчим нь адилхан байдаг.

Шууд борлуулалтын олон шатлалт хэлбэрийн хувьд бүтээгдэхүүний борлуулалт нь гол агуулга бус харин төлбөртэйгээр гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ба энэхүү замаар босоо пирамид болон хэвтээ матриц үүсгэх замаар ашиг орлого хийх явдал нь түүний хууль ёсны байх буюу олон шатлалт маркетинг /“Multi-Level marketing”/-ийн мөн чанарыг үгүйсгэдэг.

Иймд дэлхийн улс орнуудад төлбөр авах замаар тухайн сүлжээний гишүүнчлэлд

элсүүлэх буюу “Пирамид” хэлбэртэй сүлжээний бизнесийг хориглосон байна.

“Барууны харилцаа холбоо” сэтгүүлд Уолтер Дж.Карл бичихдээ пирамид буюу сүлжээний бизнес нь зөвхөн хууль бус замаар ашиг олж байгаа төдийгүй Баттерфилд, Фицпатрик ба Рейнольдс, Норфиба Маддрелл, Carter зэрэг культуудыг төрүүлэх ба эдгээр нь хууль бус шашны үзэл баримтлалыг хүртэл гишүүдэд тулгах сөрөг үр дагаврууд гаргаж байсан тухай дурьджээ.

Сүлжээний пирамидийг үүсгэн байгуулагчид нь ихэнх гишүүдийн өмнө өөрсдийн хүлээсэн үүргийг биелүүлдэггүй, ингэхдээ тухайн асуудлыг гишүүний хувийн байдал, зохион байгуулалт, хүчин чармайлттай холбон тайлбарлаж, хариуцлагаас зайлсхийхийг оролддог байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, түүний дотор олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн залилан мэхлэх хэргийг нотлохын тулд шууд борлуулалтын олон шатлалт хэлбэр, пирамид тогтолцооны ойлголт, сүлжээний пирамид, матрицийн ойлголтууд, эдгээр нь ямар шинж чанараараа хууль ёсны болон хууль ёсны бус үйл ажиллагаа болох талаар нэг мөр ойлголттой байх шаардлагатай ба энэ талаар ярилцъя.

4.1 Шууд борлуулалт (direct selling) ба олон үет /шатлалт маркетинг (Multi-level marketing/ MLM): Бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх хуваарилалт буюу түгээлт (distribution)-ын суваг нь 2 үндсэн хэлбэртэй байх ба эдгээрийг шууд хуваарилалтын суваг (Direct marketing channel), шууд бус хуваарилалтын суваг (Indirect marketing channel) гэж нэрлэдэг. Шууд хуваарилалтын сувгаар шууд борлуулалтын үйл ажиллагаа явагдана. Шууд борлуулалт (direct selling) гэж бараа, бүтээгдэхүүнийг завсарын зуучлагч, худалдааны байгууллага (дэлгүүр)-ын оролцоогүйгээр хэрэглэгчээс хэрэглэгчид, түгээгчээс түгээгч (дистрибьютор)-д борлуулах үйл ажиллагаа бөгөөд түгээлт-хуваарилалтын нэгхэлбэр юм.

Шууд борлуулалтын сувгийг нэг шатлалт (Single-level direct selling) ба олон шатлалт (Multi-level direct selling) гэж ангилж байна. Шууд борлуулалтын энэхүү олон шатлалт хэлбэрийг сүлжээний бизнес /сүлжээний маркетинг (Network marketing) / олон үет (шатлалт) маркетинг (Multi-level marketing/ MLM) гэж нэрлэж байна. Дээрх



ойлголтуудын уялдаа холбоог тодорхой, ойлгомжтой болгох үүднээс дор зураглан үзүүлэв (1-р зураг).

Хуваарилалт/ Түгээлт (Distribution)

Шууд хуваарилалтын суваг (Direct marketing channel)

Шууд борлуулалт
(Direct selling)

Нэг шатлалт шууд борлуулалт (Single-level direct selling)

Шууд бус хуваарилалтын суваг (Indirect marketing channel)

Олон шатлалт шууд борлуулалтбуюу
Сүлжээний бизнес

(Multi-level direct selling/ Network marketing/ Multi-level marketing/ MLM)

1-р зураг. Хуваарилалт, шууд борлуулалт ба олон шатлалт маркетинг

Олон шатлалт /үет маркетинг (MLM)/ нь сүлжээний бизнесийн хууль ёсны хэлбэр бөгөөд бараа бүтээгдэхүүний түгээлтийн нэг арга юм.

Өнөө үед хууль ёсны “сүлжээний бизнес” нь бараа бүтээгдэхүүнийг борлуулах шууд худалдааны нэг хэлбэр байгаад зогсохгүй дэлхий дахинд бизнесийн нэг бие даасан салбар болон амжилттай хөгжиж байна. 2007 оны байдлаар дэлхий дахинд сүлжээний бизнесийн салбарт 114 тэрбумам. Долларын бараа эргэлт хийгдэж, 62 сая хүн сүлжээний бие даасан борлуулагч (дистрибьютор)-аар ажиллажээ. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хууль ёсны сүлжээний бизнесийн зарим томоохон компанийг дурьдвал, “Amway” “Herbilife”, “Орифлейм” зэрэг юм. АНУ-д 1978 онд байгуулагдсан Дэлхийн шууд худалдааны нийгэмлэгүүдийн холбоо (World Federation Direct Selling Associations/ WFDSA) нь 59 орныг эгнээндээ нэгтгэдэг бөгөөд сүлжээний бизнесийн нэрийн дор хүмүүсийг хууран мэхлэх, санхүүгийн пирамид үүсгэх замаар хууль бус үйл ажиллагааг явуулахын эсрэг ажилладаг.

4.2 Пирамид тогтолцоо (Pyramid scheme). Сүлжээний хууль бус бизнес буюу луйврын сүлжээ нь пирамид тогтолцоотой байдаг байна. Тиймээс “сүлжээний пирамид”, “луйврын пирамид”, “санхүүгийн пирамид” гэж нэрлэгддэг ба хууль бус үйл ажиллагаа болдог тул олон улс оронд хоригложээ. Тухайлбал, АНУ-ын Вашингтон мужийн хуулинд “Бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө урамшуулал олгодог бизнесийн үйл ажиллагааг хууль бус луйврын пирамид гэнэ” гэсэн заалт байдаг ажээ. Луйврын пирамидыг ялгах хэд хэдэн онцлог бий. Үүнд:

- Борлуулалт хийхээс гишүүн элсүүлэх нь илүү чухал. Үйл ажиллагаа нь бараа бүтээгдэхүүний борлуулалтанд бус шинээр гишүүн элсүүлэхэд голлон чиглэгддэг. Халхавчилж буй бараа бүтээгдэхүүн үйлчилгээ нь зах зээлийн үнээс хэт өндөр,

- Элсэлтийн хураамж хэт өндөр. Үүнийг сургалтын материал, эсвэл онцгой бүтээгдэхүүнээр өнгөлөн далдалсан байж болзошгүй байдаг.
- Бараа бүтээгдэхүүний үлдэгдлийг буцааж авдаггүй. Шууд худалдааны нийгэмлэгийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд зааснаар хүн сүлжээнээс гарахыг хүссэн тохиолдолд түүнд байгаа сүүлийн 1 жилд авсан, борлогдоогүй барааны үлдэгдэл, сургалт, сурталчилгааны материал зэргийг тэдгээрийн үнийн дүнгийн 90%-иас доошгүйгээр компани буцаан авах журамтай байдаг байна.

- Бараа бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид зориулж борлуулдаггүй. Хууль ёсны сүлжээний бизнест чанартай, онцгой бараа бүтээгдэхүүнийг хүмүүсийн хэрэглээнд зориулан нийлүүлж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хангах замаар хэрэглэгчийн зах зээлийн бүрдүүлдэг бол луйврын пирамид тогтолцооны нөхцөлд хүмүүсийн хэрэгцээг хангах нь гол нь биш, харин ямар нэг аргаар гишүүн элсүүлэх нь чухал байх ба бараа бүтээгдэхүүнийг зөвхөн өнгөлөн далдлалт маягаар ашигладаг.

- Бараа бүтээгдэхүүн үйлчилгээг чанар, үзүүлэлтээс нь давсан, хэт хийсвэр байдлаар, хэрэглэгчийг хуурч мэхлэн итгэл эвдэх аргаар сурталчидаг. /Бараг л энэ бүтээгдэхүүнийг хэрэглэвэл гэгээрэлд хүрнэ гэх мэт/

Матриц (Matrix). Сүлжээний бизнесийн хүрээнд маркетингийн буюу урамшууллын төлөвлөгөө чухал үүрэгтэй. Энэ нь нэг ёсны тоглоомын дүрэм болдог. Сүлжээний



маркетингийн төлөвлөгөөний хэд хэдэн хувилбар байдаг байна. Үүнд:

1. Шаталсан-тусгаарласан төлөвлөгөө
2. Матриц төлөвлөгөө
3. Нэг үет төлөвлөгөө
4. Хосолмол /бинар/ төлөвлөгөө

Матриц гэдэг нь сүлжээний бизнесийн маркетингийн төлөвлөгөөний нэг хэлбэр юм. Олон жил тогтвортой ажиллаж, амжилт олсон сүлжээний компаниудын дийлэнх хэсэг нь маркетингийн шаталсан-тусгаарласан төлөвлөгөөг ашигладаг гэж судлаачид үзжээ. Жишээнь: Oriflame, Amway гэх мэт.

Бараа, үйлчилгээний түгээлт, хуваарилалтын систем болох сүлжээний бизнес буюу сүлжээний маркетингийн нийгэм-эдийн засгийн мөнчланар нь борлуулж буй бараа бүтээгдэхүүн нь сүлжээний бизнес эрхлэгчид буюу худалдааны агентуудын амьдралын нэг салшгүй хэсэг болдог бөгөөд тэдгээрийг өөрсдөө өргөнөөр хэрэглэж, бусдад түүнийгээ сурталчилж, хэрэглээнд татан оруулсанаа төлөө хөнгөлөлт, урамшуулал авдаг оршино.

Сүлжээний бизнес нь дэлхий дахинд сүүлийн хагас зуун жилд эрчимтэй хөгжиж, түгээлтийн дэвшилтэт арга технологи хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөгдөөд байгаа билээ. Өнөө үед худалдаа, борлуулалтын уламжлалт арга хэлбэрийн хүчтэй өрсөлдөгч болоод зогсохгүй, борлуулалтын бүхий л хэлбэрүүд, тухайлбал, жижиглэнгийн худалдаа, шууд худалдаа, франчайзинг, электрон-худалдааны хэлбэрүүдийг өөртөө шингээн нэвтрүүлж, улам бүр өргөжин тэлэх хандлагатай болж байна. Сүлжээний маркетингийн явцад:

Нэгд. Хэрэглэгч нь борлуулагч /түгээгч болдог бөгөөд дистрибьюторууд нь үйл ажиллагаа явуулахдаа хүмүүсийн хувийн харилцаа, хувь хүний онцлог, чадвар, нэр хүндэд тулгуурладаг. Оролцогчид өөрсдийн хувийн харилцааны сувгуудаа ашиглан бараа бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээний үр дүнгийн талаарх мэдээллийг түгээх замаар сүлжээний хүрээг тэлж, нийгмийн сүлжээнүүдийг өөр хооронд нь холбодог. Түүнчлэн сүлжээний бизнес эрхлэгчид хөгжих, харилцан биенээсээ суралцах өргөн боломж нээгддэг. Сургалт бол энэ бизнесийн нэг чухал шинж болоод байна.

Хоёрт. Энэ хүрээнд франчайзингийн зарчимыг ашиглах болсноор асар том, бараг хил хязгааргүй сүлжээг бий болгож,

нийгмийн нэг шинэ төрлийн зохион байгуулалтын нэгж-байгууллагыг бүрдүүлж, үйлдвэрлэгч-хэрэглэгчдийн хоорондын харилцааны шинэ хэлбэр гарч ирээд байна.

4.3 “Олон улсын гэрээ, конвенц, Монгол улсын хуулиудад олон шатлалт хэлбэр буюу пирамид тогтолцооны ямар хэлбэрийг хориглосон байдаг” талаар:

Өмнө дурьдсанаар “бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийн үйл ажиллагааг хууль бус пирамид тогтолцооны луйвар” гэж үздэг талаар ярилцсан. Дэлхийн олон улс орнуудад, тухайлбал, АНУ, Англи, Франц, Герман, Канад, Румын, Колумб, Малайз, Польш, Норвеги, Болгар, Австрали, Шинэ Зеланд, Япон, Итали, Непал, Исланд, Филиппин, Өмнөафрик, Шри-Ланк, Тайланд, Иран, Хятад, Мексик, Португал, Голланд зэрэг улсуудад пирамид тогтолцооны луйврыг хуулиар хориглосон байна. Ихэвчлэн эдгээр улс орнуудын “Хэрэглэгчийг хамгаалах” хуулинд дээрх заалтыг тусгасан байдаг байна. Түүнчлэн хууль тогтоомжуудад дараах үйлдлийг хориглосон байдаг. Үүнд:

- Ямар нэгэн пирамид тогтолцооны луйврыг үүсгэн байгуулах, удирдан ажиллуулах, идэвхжүүлэх;
- Пирамид тогтолцооны луйварт санаатайгаар оролцох;
- Пирамид тогтолцооны луйварт бусдыг орохыг ятагх, хүчлэх;

Хэрэглэгчид хэрвээ пирамид тогтолцоонд оролцох буюу түүнийг идэвхжүүлбэл хөрөнгө оруулсан мөнгөө алдаад зогсохгүй, хуулийн дагуу хариуцлага хүлээдэг байна. Тухайлбал, АНУ-д пирамид тогтолцоог үүсгэн байгуулсан, түүнийг явуулж гүйцэтгэхэд тусалсан хүнийг арван мянган доллараар торгох, албадлагын хөдөлмөр хийлгэх, эсвэл арван жил хорих ялаар шийтгэх хуулийн заалттай (АНУ, Луизиана муж, “Competition Act”, зүйл 363).

ОХУ-д 1990-ээд оноос сүлжээний бизнес ихээхэн эрчимтэй хөгжиж, хууль ёсны томоохон компаниуд салбар, нэгжээ байгуулах ажиллаж байгаагийн зэрэгцээ, үндэсний цөөнгүй компаниуд бий болжээ. Үүний зэрэгцээгээр хууль бус санхүүгийн пирамидууд ч олноор төрөн гарч, хүн амд үлэмж хэмжээний хохирол учруулжээ. Энэ салбарт ОХУ-д манай улстай ижил



төстэй нөхцөл байдал үүссэн нь сүлжээний бизнесийн хууль эрх зүйн бүрдээгүйтэй холбоотой юм. 1998 онд Москва хотын захирагчийн “Москва хотын нутаг дэвсгэр дээр олон шатлалт, сүлжээний маркетингийн үйл ажиллагаа явуулах, түүнийг зохицуулах тухай” (1998.07.21, N754-PM) гэсэн тушаал гарчээ. Энэхүү баримт бичигт олон шатлалт, сүлжээний маркетинг гэдэг нь бараа, үйлчилгээг эцсийн хэрэглэгчдэд борлуулах, томоохон дистрибьюторүүдийг татах үйл ажиллагаа явуулсны төлөө дистрибьюторүүдэд урамшил олгож, бараа, үйлчилгээний борлуулалтын сүлжээ үүсгэж ажиллах гэрээ байгуулсан хуулийн этгээд болон хувь хүний бизнесийн үйл ажиллагаа юм” гэж заажээ. Түүнчлэн уг тушаалаар хотын захирагчийн албаны дэргэд олон шатлалт, сүлжээний маркетингийн хүрээнд тулгарч буй асуудлуудыг судалж шийдвэрлэх үндсэн чиг үүрэг бүхий зөвлөл байгуулж, ажиллуулахаар заасан байна. Мөн 1998.07.21–ний өдрөөс эхлэн Москва хотод олон шатлалт, сүлжээний маркетингийн үйл ажиллагаа явуулах хувь, хуулийн этгээдэд лизенц олгохоор тогтоожээ.

Харин Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2-р бүлэг (Тусгай зөвшөөрлийн голгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох)-ийн 8 дугаар зүйл (Хориглох аж ахуйн үйл ажиллагаа)-ийн 8.1.4.-д “олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйлажиллагаа”-г хориглох заалт байна,

4.4 Практикт олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн гэмт хэргүүдийн талаар:


Өмнө үйлчилж байсан МУ-ын ЭХТА-ын 148-р зүйлд залилан хууль бус үйл ажиллагаа явуулан залилан мэхлэх гэмт хэрэг хуульчлагдсан практикт “Шинэ санаа төв”, “Жавхланг бадруулагч”, Зөөлөн эх” зэрэг хадгаламж зээлийн хоршоонууд дээрхи төрлийн хууль бус үйл ажиллагаа явуулсаны улмаас шүүхээр шийтгэгдэж байсан байна. Тухайлбал, Т.Уранчимэг нарт холбогдох эрүүгийн 21140777 дугаартай “Байгаль-Эрдэнэ сан” ТББ-ын явуулсан үйл ажиллагааны ямар үе шат хэлбэрүүд нь хууль бус олон шатлалт тогтолцооны хэлбэр болох, төлбөртэйгөөр гишүүн элсүүлж, автомашин олгож байсан нь бараа бүтээгдэхүүнээ борлуулахын тулд төлбөртэйгөөр гишүүн элсүүлж, түүний үр дүнд бараагаа олгож

байсан, эсвэл төлбөртэйгөөр гишүүн элсүүлсний дүнд урамшуулал болгон автомашин олгож байсны аль болох талаар дүгнэлт хийхэд:

“Байгаль эрдэнэ сан” ТББ нь 2011 оны 06 дугаар сарын 04-ээс 2011 оны 06 дугаар сарын 16-ны хооронд агаарын бохирдлыг багасгах зорилгоор хууль дүрэмд заасан моторын багтаамжтай шинээр үйлдвэрлэсэн хорт утаа бага ялгаруулдаг автомашиныг жижиг, дунд орлоготой иргэдэд хүргэх зорилготой ажиллаж, өөрсдийн зохиосон маркетингийн төлөвлөгөөгөөр дамжуулан 3 чиглэлээр дэмжигч гишүүдийг төлбөртэйгээр элсүүлэх үйлажиллагаа явуулсан байна.

1-рт: 650.000 төгрөгийн төлбөртэй жижиг суудлын автомашины сүлжээ. Энэ сүлжээ нь 2 үе шаттай бөгөөд үе шатуудаа гүйцээж байж машинаа авах ёстой. 1-р үе шатанд эхний хүн 650.000 төгрөгийн төлбөр төлж гишүүнээр элсэж, уг гишүүн доороо 6 гишүүнийг тус бүрийг 650.000 төгрөгийн төлбөртэйгээр элсүүлсэн тохиолдолд 2 дахь үе шат руу шилжиж, улмаар доор нь өөртэй нь адил доороо 6 гишүүнбүрдүүлэн “үсэрсэн” 3 гишүүн орж ирсэн тохиолдолд 6.5 сая төгрөгийн үнэ бүхий суудлын автомашин өгөх, машинаа авахгүй гэсэн хүнд 5.7 сая төгрөгийг бэлнээр олгож байсан байна. Тус байгууллага нь Да хүрээ зах дээр зарагдаж байгаа автомашинуудыг худалдан авч ирж гишүүддээ тараасан байна. “Байгаль эрдэнэсан” ТББ-ын явуулсан үйл ажиллагааг схемээр үзүүлье (2-р зураг).

1-р шат:




2-р зураг. “Байгаль эрдэнэ сан” ТББ-ын явуулсан үйлажиллагааны 1-р шат

1-р шатанд “Байгаль эрдэнэ сан”-д 6 гишүүний нийт 3.900.000 төгрөг очиж байна ($650.000 \times 6 = 3.900.000$ төгрөг). Энэ схемээр бол “Байгаль эрдэнэ сан” 1-р үе шатаа биелүүлсэн байна. Ингээд 2-рүе шат руу орох болзол хангагдаж, өөрсдийнх нь тайлбарласнаар “үсэрч” байна. Одоо

650.000 төгрөгөө өгсөн оролцогч Байгаль эрдэнэ сан шиг болзол хангаж байж 2-р үе шат руу орно (3-р зураг)..

2-р үешат:



3-р зураг. "Байгаль эрдэнэ сан" ТББ-ын явуулсан үйлжиллэгийн 2-р шат

2-р шатанд 1 шатыг биелүүлсэн 3 оролцогч дарааллаар орж ирэхэд "Байгаль эрдэнэ сан"- 6.5 сая төгрөгийн үнэ бүхий суудлын автомашин авах шаардлагатай болно. Энэ үе шатанд нийт 21 оролцогчийн 13.650.000 төгрөг "Байгаль эрдэнэ сан"-д очиж байна ($650.000 \times 21 = 13.650.000$ төгрөг). Дээрх схемээр "Байгаль эрдэнэ сан" 2-р үе шатаа биелүүлснээр 7.150.000 төгрөгтэй болсон байна ($13.650.000 - 6.500.000 = 7.150.000$).

2-рт: 1.3 сая төгрөгийн дунд гарын жип автомашины сүлжээ. Энэ нь мөн өмнөх үе шаттай адил схемээр явагдсан ба машин авахгүй гэсэн хүнд 13.2 сая төгрөгийг бэлнээр олгожээ.


3-рт: 4.0 сая төгрөгийн орон сууцны сүлжээ. Энэ нь мөн өмнөх үе шатуудтай ижил төстэй схемээр явагдсан ба эхний хүн 4.0 сая төгрөг төлөн гишүүнээр элсэж, түүний араас гинжин хэлбэрээр 15 хүн тус бүрдээ 4.0 сая төгрөг төлж элссэн нөхцөлд эхний хүн бэлнээр 34.0 сая төгрөг авах болзол хагах ба 4.0 сая төгрөгийн орчны хэлбэлзлэлийн долгион цэвэршүүлэх аппарат өгнө гэсэн болзолтой зохион байгуулжээ.

Пирамид тогтолцооны луйврын компаниуд маркетингийн төлөвлөгөөний бинар буюу хосолсон хэлбэрийг гол төлөв ашигладаг гэж үздэг. Энэ байгууллага нь маркетинг төлөвлөгөөгөө матрицаар хийсэн гэж байгаа бөгөөд энэ нь пирамид тогтолцооны луйврын шинжтэй юм. Бинар маркетингийн төлөвлөгөө болон матриц төлөвлөгөөний гол ялгаа нь бинар нь 2 хүн элсүүлдэг, матриц нь 3 хүн элсүүлдэгт оршиж байгаа бөгөөд уг байгууллагын хувьд өөрсөддөө ашигтай байлгах үүднээс 1-р шатандаа бинар маркетингийн төлөвлөгөөг,

2-р шатандаа матрицыг сонгожээ.

"Байгаль эрдэнэ сан" төрийн бусбайгууллагын пирамид тогтолцооны луйврын онол, арга зүйн үндсийг пирамидын шатлалууд 1, 2, 4, 8, 16, 32, 64 гишүүдээс тогтоогоор тайлбарлаж болно (4-р зураг).

4-р зураг. Луйврын пирамид тогтолцооны бүдүүвч



Энэхүү пирамид тогтолцоо нь хичнээн том, олон гишүүнтэй байсанч, нийт гишүүнээр элсэгчдийн ойролцоогоор 88% хувь нь оруулсан мөнгөө алддаг байна. Өөрөөр хэлбэл, пирамид нурах үед 1, 2, 4, 8-р эгнээнийхэн л зөвхөн ашиг хүртэх магадлалтай. Харин үлдсэн 16, 32, 64-р үеийн гишүүд бүгдийг алдана. Нийт 127 гишүүнээс 112 буюу 88% нь оруулсан мөнгөө алддаг гэсэн тооцоо бий.

Дээр өгүүлсэн зүйлсийг үндэслэн "Байгаль эрдэнэ сан" ТББ үйл ажиллагааны талаар дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

1. "Байгаль эрдэнэ сан" ТББ үйл ажиллагаагаа дээрх пирамид тогтолцоотой адил загвараар явуулжээ. Тус байгууллага нь 650.000, 1.300.000, 4.000.000 төг. Гэх зэргээр өндөр төлбөртэйгээр гишүүн элсүүлж, машинтай, орон сууцтай болгоно хэмээн амалж, олон иргэдийг хохироосон байна. Машин, орон сууц зэрэг бүтээгдэхүүн нь зөвхөн өнгөлөн далдлалтын үүрэг гүйцэтгэж байсан гэж үзэж байна.

2. Энэхүү ТББ-ын явуулсан эдгээр үйл ажиллагаа нь Олон улсын худалдааны танхим (ICC), Дэлхийн шууд худалдааны нийгэмлэг (WFDSA)-ийн бизнесийн ёс зүйн дүрэм, зарим өндөр хөгжилтэй орнуудад үйлчилж буй сүлжээний бизнес, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн баримт бичгүүдийн холбогдох заалтууд, Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (8.1.4-д тусгасан



“олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйлажиллагаа”)-иудын дагуу сүлжээний хууль бус бизнес болох” пирамид тогтолцоо”-ны шинжүүдийг агуулж байгаа тул эрх зүйн талаасаа ч, бизнесийн ёс зүйн, сүлжээний маркетингийн арга хэлбэрийн хувьд хууль бус үйл ажиллагаа болох нь харагдаж байна.

Залилан мэхлэх, завших үрэгдүүлэх гэмт хэрэг нь онлайн, интернет хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох, гэмт хэргээ далдлахын тулд санаатайгаар болон зохиомлоор дампуурах, сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироох, бусдын дансыг ашиглах, албан тушаалын /сүүлийн үед банк санхүүгийн салбарт/ давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэгдэж байна. Эдийн засаг, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих хяналт сул, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зохицуулалт дутмаг зэрэг нь эдгээр гэмт хэрэг гарах суурь шалтгаан /Хадгаламж зээлийн хоршоодын хэргийг шалгах явцад төрийн байгууллагын хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт илт дутагдсан байдаг/ болж байна. Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, иргэдийн аж ахуй, үйлдвэрлэл эрхлэх боломж, эрх зүйн орчин байхгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл болж байна.

5.Хуурамч Чекээр Залилан Мэхлүүлэх Эрсдэлээс Сэргийлэх

Бэлэн мөнгийг бодвол илүү найдвартай төлбөрийн хэрэгсэл болох American Express, Thomas Cook компаниудаас гаргасан аялалын буюу замын чек, бэлэглэлийн чекүүдийг Монголын томоохон арилжааны банкууд хүлээн зөвшөөрч бэлэн мөнгөтэй адилтган сольж өгдөг төдийгүй хэрэглэгч чекээ хулгайд алдсан, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд чек гаргагч компани нөхөн олговор өгдөгөөрөө чек нь бэлэн мөнгөнөөс давуу талтай юм. Гэвч сүүлийн жилүүдэд иргэд, харилцагчдын чекийн талаарх бүрэн мэдээлэл, ойлголтгүй байдлыг ашиглан, аялалын болон бэлэглэлийн чекийг

хуурамчаар үйлдэж, хуурч мэхлэх явдал дэлхий нийтэд түгээмэл болоод байна.

Энэ байдал манай оронд нэвтрэх хандлага ажиглагдаж, иргэд, харилцагчдад гадаадын байгууллага, иргэдээс хамтарч бизнес хийх санал, сугалаанд хожсон байна гэх зэргээр их хэмжээний дүнтэй хуурамч чек шуудангаар илгээх, буцаан бага хэмжээний бэлэн мөнгө шилжүүлэхийг хүсэх, иргэд тэдэнд итгэн бэлэн мөнгө шилжүүлчихээд чекээ банкинд солиулах үедээ хуурамч гэдгийг мэдээд багагүй хэмжээний хохирол амсах явдал цөөнгүй гарч байна. Иймд дараах зөвлөгөө, сэрэмжлүүлгийг хүргүүлж байна.

Хэрэв таны и-мэйл, шуудангийн хаягаар, эсвэл хэн нэгэн үл таних этгээд танд доор дурдсан зүйлсийг санал болгон, их хэмжээний чек үзүүлэх, танд өгөхийг амлах, оронд нь таныг тодорхой хэмжээний шимтгэл төлөх, эсвэл чекийн үнийн дүнгээс харьцангуй бага хэмжээтэй мөнгийг буцаан Moneygram, Western Union, гуйвуулга хийдэг банк, банк бус санхүүгийн байгууллага, карго компани, хувь хүнээр дамжуулан шилжүүлэхийг хүсвэл Та бусдын залилан мэхлэх ажиллагаанд өртөх гэж байгааг анхаарна уу.

Иргэдэд санал болгодог хувилбарууд:

Гадаадаас бизнес санал болгох: Танд гадаадаас гэнэт хэн нэгэн хүн өөрийгөө бизнесмэн, эсвэл засгийн газрын ажилтан, төлөөлөгч гэх зэргээр танилцуулан аливаа бизнесийг санал болгох, таны хөрөнгө хүрэлцэхгүй байгаа бизнесийн төсөлд чинь хөрөнгө оруулах, хамтран ажиллахыг санал болгох. Анхаар:Хариуцлагатай компани, бизнесмэн, Засгийн газар нь хэзээ ч танихгүй хүний бизнесийг санхүүжүүлэхээр мөнгө санал болгодоггүй.

Гэнэт баяжуулах: Таны хувийн мэйл, гар утас, эсвэл шуудангийн хаягаар тань захиа илгээж, Таныг “Сугалаанд аз таарлаа ..., бэлэн мөнгө хожлоо..., өв залгамжилсан хөрөнгөнөөсөө хувь хүртээж бэлэн мөнгө өгөх гэж байна...” гэх мэт мэдээллүүдийг илгээж, урьдчилгаа болгон танд чек илгээж байна, үлдсэнийг нь авахын тулд татвар, шимтгэл, шуудангийн зардалд гэх зэргээр тодорхой хэмжээний мөнгийг шилжүүлэхийг хүсэх.

Анхаар:Бодит амьдралд сугалаанд та оролцоогүй байхад хонжвор таарах, хэрэв оролцсон бол хонжворыг олон нийтэд



мэдээлэхгүйгээр танд хэзээ ч өгөхгүй, мөн өв залгамжлалын хөрөнгийг хуульч, өмгөөлөгчгүйгээр хэзээ ч хэн нэгэнд өгдөггүй.

Илүү төлбөр амлах: Таны бэлэн мөнгөөр зарж байгаа эд юмс, барааг тань их хэмжээний мөнгө амлаж, чекээр худалдан авахыг санал болгох, эсвэл гадаад явах болсон тул солиулж амжихгүй боллоо, тэдэн төгрөг өгөөд үүнийг банкинд солиулаад та илүү ихийг авч болно гэж итгүүлэх.


Анхаар: Хэрэв жинхэнэ чек бөгөөд уг хүн өөрөө эзэмшигч нь мөн бол банкинд солиулах ажиллагаа нь шуурхай явагддаг, гэтэл тэд яагаад өөрөө солиулахгүйгээр их хэмжээний мөнгөө танд зүгээр өгнө гэдэгт дүгнэлтийх хэрэгтэй.

Хууран мэхлэгч, залилагч нарын арга улам нарийсч байдаг тул бүх зүйлийг жинхэнэ, ном журмын дагуу явагдаж байгаа мэтээр харагдуулах, ойлгуулахаас гадна дээр дурдсанаас өөр аргуудыг ч ашиглаж болзошгүй. Иймд Та зүгээр сууж байгаад багахан мөнгө төлөх буюу төлөхгүйгээр гэнэт их мөнгө олох, өв хөрөнгө хүлээн авах, онгоцны сүйрэл, Африкийн аль нэгэн орны иргэний дайн, цэргийн эргэлтийн улмаас тухайн улсдаа ашиглах боломжгүй байгаа мөнгийг эх орондоо оруулж ирж, бизнесийх, үүнийхээ төлөө нэлээд хэсгийг нь зүгээр авах гэх мэт гэнэн итгэлээр бусдад хууртаж, өөрийн мөнгөө алддаг.

6.Эдийн засгийн шинжилгээ хийхэд тулгамдсан асуудал:

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд болон эдийн засгийн гэмт хэргүүдийг нотлох ажиллагааны нэг гол хэсэг бол эдийн засгийн шинжилгээ юм. Шүүхийн шинжилгээний гол зорилго нь хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг шинжилэх ухааны үндэслэлтэй тогтоох явдал бөгөөд шинжилгээ нь үнэнийг танин мэдэх, бодит байдлыг тогтоох процессын нэмэлт боломж төдийгүй баримт сэлт мэдээллийг шалгах, шинэ мэдээлэл олж авах хэрэгслэл болдог. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах практикт эдийн засгийн шинжилгээ хийлгэх шаардлага өсөн нэмэгдсээр байна.

ШШҮХийн Эдийн засгийн шинжилгээний хэлтэст хийгдсэн өмчлөх эрхийн эсрэг хэрэгт хийгдсэн шинжилгээний статистик /сүүлийн 3 жилээр/



Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар Эрүү, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баримтын шалгалтаар тогтоосон эд хөрөнгийн дутагдал буюу илүүдэл нь тухайн хэргийн бодит байдалтай тохирохгүй байгаа, эд хөрөнгийн дутагдал буюу илүүдлийн хэмжээг баримтын шалгалт хийсэн улсын байцаагч үнэн зөв, бодитой тодорхойлж чадаагүй нь мөрдөн шалгах ажиллагааны явцад илэрсэн тохиолдолд эдийн засгийн шинжилгээ хийлгэх ба шинжилгээний объектийг шинжилгээ хийлгэх тогтоол, захирамж, хүсэлтийн хамт шүүхийн шинжилгээний байгууллага, эсвэл шинжээчид хүргүүлнэ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдэд хийгдэж байгаа эдийн засгийн шинжилгээ нь ашиглал дутагдал, өмч хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор хийгддэг ба шинжилгээ удааширнаас шалтгаалж хэргийн шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлдөг. Шинжилгээний зорилт биелэх эсэх нь шинжээчид тавьж буй асуултаас шууд хамааралтай байдаг. Иймд шинжээчид зөв, үндэслэлтэй асуулт тавих нь шинжилгээний үр дүн бодитой, үнэн зөв гарах нөхцөл болдог.

Иймээс дүгнэлт гаргуулахаар тавьж буй асуулт нь

- 1.Тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой байх
- 2.Тодорхой байх
- 3.Ойлгомжтой байх гэсэн 3 үндсэн нөхцлийг хангасан байх шаардлагатай.

Эдийн засгийн шинжилгээ хийхэд учирдаг бас нэг хүндрэлтэй зүйл нь мөрдөгч нар шинжилгээ хийлгэх тогтоолыг ирүүлэхдээ шинжилгээний объектыг бүрэн ирүүлдэггүйгээс шинжилгээг буцаах, шинжээчээс асуусан асуултанд хариулт өгөхөд хангалтгүй байгаагаас дутуу дүгнэлт гарах шалтгаан нөхцөл байлж байдаг байна..



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ӨМГӨӨЛӨХӨД ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Х.Баатарбилэг

Хуульч, өмгөөлөгч, Жастис консалтинг
ХХН-ийн захирал

Хураангуй: Энэхүү илтгэлд хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж буй арга хэлбэр, уг гэмт хэргийн улмаас бие болон сэтгэл санааны хохирол хүлээсэн хохирогч нарт үүссэн сэтгэцийн эмгэгүүд үүнд чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа болон хууль зүйн туслалцаа үзүүлэх бололцоо Монгол Улсын хууль эрх зүйн орчин болон практикт хэрхэн бүрдсэн цаашид хэрхэн сайжруулах талаар өгүүллээ.

Abstract: In this presentation expressions of the current status of human trafficking, the fighting methods against human trafficking, the psychological changes in the victims of human trafficking, the investigation methods accordance with the victims conditions and the legal aid in Mongolian constitution, therefore the appropriate approaches are discussed.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах, хохирогч, өмгөөлөл

Key words: Human trafficking, victim, advocacy

Удиртгал

Хүн худалдаалах гэж (англ. trade of in (trafficking in/of) people; ор.торговля людьми) Олон улсын эрх зүйн боловсруулсан номлолоор тодорхой этгээд (буюу ийм бүлэг этгээдийг) элсүүлэх, тэдгээрийг нэг улсын дотор буюу хилийн чанадад тээвэрлэх, тэрчлэн худалдах, худалдан авах шилжүүлэх, эдгээр үйлдлээс орлого олж авах буюу хууран мэхлэх замаар цаашид ашиглах, (хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж) албадах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж буюу өөрийн оронд боолчлолын тулд байлгах, түүнчлэн ажлын хөлс төлсөн эсэхээс шалтгаалахгүйгээр өөрийн мэдэлгүй буюу боолчлолын нөхцөлд тухайн этгээдийг байлгасантай холбогдсон бүх үйлдэл ба санаа хэмээн тодорхойлсон^[58].

Дэлхийд жил тутам хүн худалдаалах гэмт хэргээс олж буй хууль бус ашиг орлого 31.6 тэрбум ам доллар байна гэсэн судалгаа байна.

⁵⁸ С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” УБ хот., 2007, 561 дэх тал

Үүний 49% нь аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орнуудад, 30.6% нь Ази, Номхон далайн орнуудад, 4.1% нь Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад, 5% нь Африкийн Сахарын орнууд, 4.7% нь Ойрхи Дорнод болон Хойд Африкийн бүс нутгуудад явагдаж байна.^[59]

Монгол дэлхийн улс орнуудтай эдийн засгийн болон бусад салбарт чөлөөт харилцаанд оролцох бололцоо бүрдсэн үеэс эхлэн үндэстэн дамнасан олон улсын шинж бүхий гэмт хэргүүд гарах хандлага бий болж 2000 оны эхээр хүн худалдаалах гэмт бүртгэгдэж эхэлсэн. Энэ нөхцөл байдлын үүднээс УИХ-аас 2000 оны эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ЭХ-н 111.1 хэсэгт анхлан Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх талаар зохицуулалт хийж 2002 оны шинэ эрүүгийн хуулийн 113 зүйлд хүн худалдах, худалдан авах хэмээн хуульчилсанаас ажиглагдаж байна.^[60]

Төрөөс хүн худалдах, худалдан авах гэмт хэрэгтэй тэмцэх үүднээс эрх зүйн орчинг сайжруулахын тулд 2002 оны эрүүгийн хуулийн 2008, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинжийг зөв тодорхойлох бусад гэмт хэргээс ялган зүйлчлэхэд дөхөм болсон бөгөөд Монгол улсад хийгдэж буй эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2015 онд шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар бүлгийн 13.1 дэх хэсэгт Хүн худалдаалах гэж хуульчлагдсан бөгөөд уг хууль 2017 оны 07 сарын 01 нээс хэрэгжиж байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэг хуулийн байгууллагад бүртгэгдэн шалгагаж байгаа талаар сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл (2010-2016 он) хүн худалдаалах /ЭХ-ийн 113 дугаар зүйл/ 49 хохирогчтой, 44 гэмт хэрэг, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах /ЭХ-ийн 124 дүгээр зүйл/ 49 хохирогчтой, 89 гэмт хэрэг тус тус цагдаагийн байгууллагад бүргэгдсэн шалгагдсан байна^[61].

Харин 2017 онд хүн худалдаалах гэмт хэрэг 12, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг

⁵⁹ www.humantrafficking.change.org

⁶⁰ Х.Баатарбилэг “Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал, түүний хэрэгцээ шаардлага” илтгэл 2008 он

⁶¹ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр

16 тус тус бүртгэгдэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна^[62]. Гэвч хүн худалдаалах гэмт хэрэг нь нуугдмал далд үйлдэгддэг учир гэмт хэргийн статистик тоо баримт бодит бус, мөн хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа хэрэг цөөн байгааг дурьдах зүйтэй юм.

Хүн худалдаах гэмт хэргийн улмаас хохирч байгаа иргэдийн тоо үйлдэгдэж буй гэмт хэргийн тооноос хамаарч жил ирэх тусам өсөж байна. Иймд өнөөдөр тэдгээр хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцаа буюу өмгөөлөх эрхийг зөв оновчтой хангах талаар зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт хэр үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэхэд дүгнэлт шинжилгээ хийж эдгээр хохирогч нар т чиглэсэн бусад арга хэмжээнүүдийг нэгдсэн байдлаар зохион байгуулах цаг болжээ.

Өнгөрсөн хугацаанд Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж ижил төстэй гэмт хэргээс хэрхэн ялган зүйлчлэх, уг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох, нотлох ажиллагааг хэрхэн оновчтой зохион байгуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хэрхэн оногдуулах тал дээр голлон анхаарч байснаас бус хохирогчийн эрхийг хэрхэн хамгаалах түүнд гэмт хэргийн улмаас учирсан хор уршигийг хэрхэн арилгах, хууль эрх зүйн болон бусад туслалцааг хэрхэн зөв оновчтой өгөх тал дээр төр засаг, хууль сахиулах байгууллага болон бусад уг чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд хангалтгүй ажилласан гэж ажиглагдаж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл эрх бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр үрхэх бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”^[63] гэж заасан бөгөөд уг эрхийг Монгол улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах”^[64] гэж баталгаажуулсан.

Монгол улсад хийгдэж буй эрх зүйн

⁶² ЦЕГ-н МНБГ-с гаргасан 2017 оны гэмт хэргийн статистик мэдээлэл

⁶³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал

⁶⁴ Монгол Улсын Үндсэн хууль

шинэчлэлийн хүрээнд УИХ-с баталсан 2015 оны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч”^[65] гэнэ гэж тодорхойлжээ.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.”^[66]

Эдгээр эрх зүйн зохицуулалт нь гэмт хэрэг ялангуяа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрийн зөрчигдсөн эрхээ хамгаалуулах эрх зүйн механизмүүд юм.

Эрүүгийн хэрэгт өмгөөлөгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж хууль зүйн туслалцаа үзүүлж байцаан шийтгэх ажиллагаанд оролцох бөгөөд бололцоотой гэж үзсэн бүх арга хэрэгслийг ашиглан эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.^[67]

Энэ нь өмгөөлөгч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой гэрээ байгуулан өмгөөллийн үйл ажиллагаагаа эхлэх бөгөөд нэгэнт гэрээ байгуулж өмгөөлөгчөөр оролцсон л бол хуульд заасан болон бусад байдлаар бүхий л зүйлийг ашиглан хохирогчийн зөрчигдөж буй эрх ашгийг хамгаалах шаардлага тулгардаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж хохирсон хохирогч нар ялангуяа эмэгтэйчүүд, бага насны хүүхдүүд үргэлжилсэн хугацаанд хүчирийлэл, зодуур тарчлал, тэвчишгүй хөдөлмөр эрхэлж хүнд нөхцөлд байдаг зэргээрээ бусад гэмт хэргийн хохирогч нартай харьцуулахад бие мах бодийн болон сэтгэл зүйн асар их дарамтанд өртөж сэтгэцийн хувьд ямар нэгэн эмгэг авсан байдаг боловч өнөөгийн практикт ажиллаж байгаа мөрдөгч, прокурор, өмгөөлөгч нар сайн ойлгохгүй, ойлгож байгаа ч тэдэнд чиглэсэн ажиллагааг

⁶⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

⁶⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

⁶⁷ Г.Наранбаатар “Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа” УБ., 2016, 123 дахь тал



зөв зохион байгуулж чадахгүй байгаа нь хохирогч нар дахин хохирох мөн сэтгэл зүйд улам их дарамт үүсгэдэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нарт сэтгэцийн хувьд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын өвчний олон улсын 10 дугаар ангилалаар F.43.1^[68] буюу Гэмтлийн дараах стрессийн эмгэг (Post-traumatic stress reaction) үүсдэг^[69].

Гай гамшгийн аюул заналыг, айлган сүрдүүлэхийг, тамлан тарчилгахыг буюу амьд байхад заналхийлж, айлган сүрдүүлж байгаа бусад бие махбодын гэмтэл хийгээд сэтгэлийн цохилтыг тухайн цаг мөчид нүдээрээ харж, сэтгэлээрээ мэдэрч, биеэрээ туулж өнгөрөөсөн нэрвэгдэгсэд хожим хойно, гамшгаас хойш хэдэн 7 хоног, сар, жилийн дараа айдас, үзэн ядалт мэтийн маш хүчтэй сэтгэлийн дарамттай байж болно. Ийм гарал үүсэлтэй сэтгэлийн дарамтыг гэмтлийн дараах стресс (сэтгэлийн дарамт) гэдэг.

Гэмтлийн дараах стрессийн эмгэгийн эмнэлзүйн дараах шинж тэмдгүүд илэрдэг. Үүнд

- Стрессорын цохилтонд өртөх (сэтгэцийн гэмтэл авах) үед үүсэж байсан тайламжгүй мэдрэмжүүд, тухайлбал айдас, уур омог, үзэн ядалт, сэтгэл түгшилт буюу бусад сөрөг сэтгэл хөдлөл байн байн хурцдан илэрнэ.

- Шөнийн айдас, хар дарсан зүүд сэтгэл түгшилттэй нойр үе үе ажиглагдана.

- Чанга дуу авиа гарахад үргэлж цочих буюу айна.

- Салганан чичрэнэ.

- Хөлрөх, зүрх хүчтэй дэлсэх, амьсгаа давчдах зэрэг илрэл бүхий вегетатив мэдрэлийн хөөрлийн шинжүүд ажиглагдана.

- Сэтгэл түгшээсэн дурсамж (ялимгүй зовлонт дурсамж) илэрнэ. Тодруулбаас стрессорын цохилтонд өртөх үед сонссон, харсан, үнэртсэн буюу мэдэрсэн, бас аймшигтай хийгээд тааламжгүй сэтгэгдэл төрүүлсэн тийм зүйлсийн тухай дурсамжууд өөрийн эрхгүй хар аяндаа, байн байн үүсэж нэрвэгдэгсдийн санаа сэтгэлийг зовооно.

- Нойр хямрана.

- Анхаарал төвлөрүүлэх хийгээд тунгаан бодох чадвар буурна.

- Сэтгэл зовниж сэрэмжтэй болох шинж илэрнэ.

- Эргэн тойрны үзэгдэл юмс хачин

⁶⁸ <http://www.who.int/classifications/icd/en/>

⁶⁹ С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ.,2013, 610 дахь тал

хийгээд бодит биш санагдана.

- Урьд өмнө нь баяр баясгалан үүсгэдэг байсан зүйлээс одоо сэтгэлийн таашаал авахаа болино.

- Энд тэнд болж буй аливаа үйл явдлаас зайлсхийнэ.

- Бусад хүмүүст хайхрамжгүй хандана.

- Идэвхигүй болно.

- Нөхөрсөг дотно бус харьцаатай болно^[70].

Урьд өмнө нь сэтгэцийн өвчнөөр өвчилж байгаагүй хүмүүст бий болж байгаа

стресст өгөх цочмог хариу урвал илүү удаан хугацаагаар хадгалагдан гамшигт нэрвэгдэгсдийн дасан зохицолтод саад тодгор учруулахыг дасан зохицолтын хямрал хэмээн ойлгоно.

Гамшгийн уршигт өртөж дасан зохицолтын хямралтай болсон нэрвэгдэгсдийн зарим нь сэтгэл түгшилтээр, нөгөө зарим нь сэтгэл гутралтаар, гурав дахь хэсэг нь ичихийн зовлонгоор, тав дахь нь харамсах сэтгэлээр, зургаад дахь нь бусал тааламжгүй сэтгэл хөдлөлөөр, долоо дахь нь төрх үйлийн хямралаар, найм дахь нь сэтгэл хөдлөл, төрх үйлийн хямрал хосолсон шинжүүдээр хариу урвал өгнө.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийн өмгөөлөгчөөр оролцохдоо өмгөөлөгч хохирогчийг маш сайн судалж дээрх шинж тэмдэг илэрч байгаа тал дээр ихээхэн анхаарал хандуулж ажиллах зүйтэй. Учир нь уг гэмт хэргийн хохирогч хууль сахиулагчийг бодвол өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэйгээ илүү илэн далангүй харилцах боломжтой бөгөөд сэтгэл зүйн анхан шатны тусламжийг зөв үзүүлэхгүй бол хохирогч амиа хорлох хүртэл эрсдэл үүсэх магадлалтай байдаг.

Өмнөд Лондонгийн сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагаас 2006 оноос 2012 оны хооронд 33 улсын 84 хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нар дээр даган судлах аргаг судалгаа хийхэд 33 хувь нь амиа хорлох тухай бодож ямар нэг амиа хорлох оролдлого хийсэн бөгөөд ердийн түвшинд 100 иргэдийн 3 хувьд л амиа хорлох бодол төрж ямар нэг үйлдэл бөгөөд харьцуулахад 30 дахин их байгаа нь харьцангуй өндөр байна^[71].

Өмгөөлөгч хохирогчийг хууль ёсны эрх ашгийг хамгаалахын тулд хууль зүйн

⁷⁰ С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ.,2013, 611 дахь тал

⁷¹ ps.psychiatryonline.org/doi/full/10.1176/appi.ps.201500509



ярилцлага хийх нь зайлшгүй юм.

Хууль зүйн ярилцлага гэдэг нь үйлчлүүлэгч ба өмгөөлөгч хоёрын хооронд мэдээлэл цуглуулах ба солилцох үйл ажиллагаа бөгөөд үүний тулд ярилцлагын явцад өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй харилцаа тогтоох, түүнээс шаардлагатай мэдээлэл авах үйлчлүүлэгчийн зорилго юунд чиглэгдэж байгааг судалж түүнд зөвлөгөө өгөхөд чиглэгдэнэ^[72].

Хууль зүйн ярилцлагыг оновчтой хийхийн тулд юуны түрүүнд хохирогчийн сэтгэл зүйд оновчтой тусламж үзүүлж хэргийн хэрхэн зөв сэргээн дүрсэлж мэдүүлэг өгөх гэмт хэргийг бүрэн дүүрэн илрүүлэх мэдээлэл баримт сэлт гаргаж өгөх бэлтгэл байдлыг хангуулах нь зүйтэй юм. Практик дээр ажиглахад өмгөөлөгч нар уг байдлыг орхигдуулж шууд хэргийн байдлыг тодруулаад ярилцлага өрнүүлдэг нь хэргийн нөхцөл байдлыг бүрэн тодруулахад саад болж байдаг.

Өмгөөлөгч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой гэрээ байгуулсан даруйдаа сэтгэл зүйн байдалд ажиглалт хийж хэрвээ хохирогч айдсаар, сэтгэл түгшилтээр, буюу бусад таарамжгүй сэтгэл хөдлөлөөр хариу урвал өгч байгаа бол харилцан ярилцлага хийж сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэн дараах зөвлөгөөг хохирогч болон түүний гэр бүлд өгөх шаардлагатай. Үүнд

- Одоо гаргаж байгаа үзэгдэл нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөн хохирсоноос үүдэлтэй бөгөөд айж уурлах бусад таарамжгүй харьцаа гаргаж байгаа нь жам ёсны асуудал гэдгийг сайн хэлж ойлгуулах.

- Хохирогч айдас, сэтгэл түгшилт, бусад тааламжгүй зүйл түүнд стрессыг үүсгэж байгаа талаар ойлгуулж стрессээс ангижрах анхан шатны зөвлөгөө өгөх

- Гэмт хэргийн улмаас сэтгэл хөдлөлөөр хариу урвал өгөхийг хүлээн зөвшөөрөх нь стресс тайлах анхны алхам мөн.

- Гэмт хэргийн хохирогч болсонд тааламжгүй сэтгэл хөдлөлөөр хариу өгөх үйл явц ихэнх тохиолдолд хэдхэн өдөр буюу долоо хоногоор үргэлжлээд алга болдог тул уг байдлыг сайн ойлгуулах.

- Айх, түгших, сандрах нь амьсгал давхцах, зүрх дэлсэх, мэтийн биеийн шинжүүдийг үүсгэж болно. Эдгээр биеийн шинжүүд эргээд айдас, сэтгэлийн түгшилт, сандралыг ч төрүүлж мэднэ. Амьсгал давхцах, толгой эргэх, зүрх дэлсэх нь биеийн

өвчний зайлшгүй шинжүүд биш харин тэдгээр нь айдас, түгшилтийн гаралтай байж болох талаар зөвлөж өөрийн биедээ маш сайн хяналт тавих талаар хэлж өгөх.

- Айснаас буюу сэтгэл түгшилтээс болж сандрах нь айлган сүрдүүлэх бодлыг ч, тухайлбал “үхэх вий”, “галзуурах вий”, “өөрийн хяналтаа алдах вий” хэмээх бодлуудыг ч төрүүлж болох бөгөөд ийм зүйл ажиглагдаж байгаа бол биеэ зөв барьж сурах талаар зөвлөх.

- Хэрвээ гэрт гадаа гудамжинд ер нь хаа нэг газар ямар нэгэн байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал сэргээн дүрслэгдэж ямар нэгэн сэтгэл зүйн дайралтанд өртөж сэтгэл хөдлөлийн хариу урвал (айх, сандрах, цочих, бухимдах) илэрвэл дараах алхам хийх талаар ойлгуулах.

- Байгаа газраа ямар нэгэн зүйл хийхгүй дайралтыг өнгөртөл байж би сэтгэл зүйн дайралтанд өртөж байна, энэ дайралт удахгүй дуусна, амьсгал давцах зэрэг мэдрэмж, ямар нэг муухай бодлууд удахгүй арилгана гэдэг зүйлүүдийг бодох эсвэл амандаа шивнэн хэлэхэд аяндаа тайвшрах талаар

- Айдас түгшүүр үүсэхэд анхаарлаа, биеийн шинжүүдэд төвлөрүүлэхгүйгээр биеэ барих

- Амьсгалын дасгал хийх

- Сэтгэлийн түгшилт, айдас, сандралыг даван туулах зорилгоор архи буюу тайвруулах эм аль болох хэрэглэхгүй байх талаар анхааруулах

- Өөртөө үүсэж байгаа сэтгэл зовинох, түгшил, эргэлзэн тээнэгэлзэх, айдас хүрэх мэтийн тааламжгүй сэтгэл хөдлөлүүдийг, бас зүрх дэлсэх, толгой өвдөх, алга хөлрөх, амьсгаа давчдах, ходоод орчим өвдөх зэрэг зовиур шаналгаануудыг дотроо хадгалалгүй бусдад ярьж сэтгэлээ онгойлгож байх нь сэтгэл түгшилтыг тайлах нэгэн арга мөн гэдгийг ойлгуулж хэзээ хамаагүй хүссэн үед ярилцахад бэлэн гэдгийг ойлгуулах.

- Сресс үүсэхэд нөлөөлж байгаа хандлага сэтгэлгээгээ өөрчлөхийг хохирогч болон түүний гэр бүлд зөвлөх.

Мөн өмгөөлөгч хохирогчтой хийх ярилцлагынхаа явцад /итгэлийг олсоны дараа/ дараах асуултыг заавал асуух шаардлагатай Үүнд

- Ямар нэг байдлаар амиа хорлох боломж байгаа эсэх?

- Амиа хорлох тусгай төлөвлөгөөтэй эсэх?

⁷² Өмгөөлөл судлал “Нэгдүгээр боть” УБ.,2015, 582 дахь тал



• Өнгөрсөн хугацаанд амиа хорлох ноцтой оролдлого хийж байсан эсэх?

• Бусдын амь насанд хор хохирол учруулах бодолтой эсэх?

Дээр дурьдсан асуултуудын аль нэгэнд нь “Тийм” гэсэн хариулт өгч байгаа тохиолдлыг амиа хорлох эрсдэлтэй хэмээн тооцож түүнээс сэргийлэх зорилгоор ойр дотны найз нөхөд гэр бүлд нь анхааруулж хэлж сэтгэцийн нарийн мэргэжлийн хяналтанд байлгаж эмчилгээ хийлгүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч хэвших.

Өмгөөлөгч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой маш нягт сэтгэл зүйн холбоо үүсгэж түүний хамгийн ойрын дотны туслагч болж чадах хамгийн гол хүчин зүйл бол өмгөөллийн нууцлал юм.

Өмгөөллийн нууцлалын талаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч болон хэргийн бусад оролцогч хохирогчийн хувийн байдлын тухай өөртөө ил болсон мэдээллийг бусдад тараахыг хориглоно”^[73], Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Хуульчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууцад хамаарна. Хуульч үйлчлүүлэгчийнхээ зөвшөөрөлгүйгээр мэдээллийг задруулах эрхгүй”^[74] гэж тус тус хуульчсан байна.

Хэрвээ өмгөөлөгч дээрх заалтуудыг зөрчсөн бол эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар зүйлийн 13.11.2 дах хэсэгт зааснаар эрүүгийн хариулцлага хүлээлгэхээр заасан байна. Иймд өмгөөлөгч нар дээр хуулийн заалтуудыг чандлан биелүүлвэл нууцлал задрах эрсдэл учрахгүй бөгөөд гаргавар байдлаа харин мэргэжлийн ур чадвар гаргаж үйлчлүүлэгчдээ тайлбарлан нууцлал алдагдах эрсдэл байхгүйг ойлгуулах нь чухал юм.

Мөн өмгөөллийн нууцлалыг хамгаалах зорилгоор өмгөөлөгчийг гэрчээр болон бусад байдлаар мэдүүлэг авах, нууц мөрдөн шалгах ажиллагаа хийхийг хориглодог^[75].

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг өмгөөлөх асуудал зөвхөн өмгөөлөгчийн хийж гүйцэтгэх асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд нөгөө талаас мөрдөгч, прокурорын үүрэг чухал байдаг.

⁷³ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

⁷⁴ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

⁷⁵ С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ., 2013204 дэх тал

Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааж бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”^[76] гэж заасан бөгөөд хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээх нь мөрдөгч, прокурорын үндсэн үүрэг мөн.

Тийм учраас Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бүрэн дүүрэн өмгөөлөхөд өмгөөлөгч, мөрдөгч, прокурор нарын уялдаа холбоо маш чухал юм.

Үүний тулд мөрдөгч, прокурор хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөхдөө дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй.

• Хэрэг хянан шийдвэрлэж ажиллагааны аль ч үе шатанд өөрийг нь хохироосон хүнийг харах, бүр нэрийг сонсох нь хохирогчийг дахин хохирч буй мэтээр шаналгаж болзошгүй.

• Шүүх хурлын бэлтгэл үе болон шүүх хуралд зориулан хохирогчийн сэтгэл санааг бэлтгэх, боломжгүй бол хамгийн аюулгүй төлөвлөгөөг гаргах хэрэгтэй.

• Хохирогчтой ойр холбоотой ажиллаж, хэргийн явц, тэдний эрхийг хамгаалан хийж буй ажлууд, хоног хугацаа, цагийн хуваарийн талаар мэдээлэх. Энэ ажлыг хохирогчид туслах үйлчилгээний ажилтан эсвэл өмгөөлөгчөөр хийлгэх нь оновчтой.

• Хохирогчид тайвшрах, тайтгарах хугацаа хэрэгтэй байдгийг ямагт санах хэрэгтэй. Өөрийг нь хохироосон хүнтэй байнга, завсар амралтгүй шүүх дээр учраад байх нь хохирогчийн сэтгэл санаа, оюуны эрүүл мэндэд, цаашлаад хэргийн үр дүнд муугаар нөлөөлнө. Хэрвээ ингэх хууль зүйн боломж олдохгүй бол, хохирогчийн сэтгэл санааг сайтар бэлтгэж, шүүгдэгчийг цагдан хоригдсон гэх мэт тайтгаруулах мэдээллийг байнга сануулах

• Боломжит бүх байгууллага, албадтай хамтран гэм буруутныг яллах гэсэн ганц зорилгоос илүү өргөн хүрээнд ажиллах

• Хохирогчийн мэдүүлгийг хангалттай дэмжихүйц хүчирхэг нотлох баримт бүхий хавтас хэрэг бүрдүүлэх

• Шүүх хурлын дараа хохирогчид туслалцаа үзүүлэхэд бэлтгэх^[77].

Дүгнэлт

⁷⁶ Монгол Улсын Үндсэн хууль

⁷⁷ www.ovcttac.gov/taskforceguide/eguide



Хүн худалдаалах гэмт хэрэг Монгол Улсад анх бүртгэгдсэнээс хойш бараг 18 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд манай улс уг гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх, уг гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хэрхэн оногдуулах зэрэгт ихээхэн анхаарал хандуулж хууль эрх зүйн орчингоо боловсруулж ирсэн нь Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд, мөн Хүн худалдаалахтай тэмцэх тухай тусгай хууль, хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль эрхийн актууд гаргасан зэргээс ажиглагдаж болохоор байна.

Харин дээрх хууль эрхийн актуудад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, Үндсэн хууль бусад хуульд заасан хууль зүйн туслалцаа авч өмгөөлөх эрхээр хангах, эрүүл мэндийн болон сэтгэл заслын эмчилгээг үр дүнтэй хийх талаар зохицуулалтуудыг нарийн тусгаагүй нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цогц байдлыг хангаж чадахгүй байна гэж бид үзэж байна.

Монгол улсын Засгийн газраас 2012 оноос хойш шат дараалан эрх зүйн шинэчлэл хийж эхэлсэн бөгөөд уг эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг шинээр баталсан нь сайшаалтай шинэлэг зүйл болсон нь энэ хууль хэтэрхий ерөнхий нарийвчилсан зохицуулалт хангалтгүй мөн эдийн засгийн баталгааг шийдвэрлэж өгөөгүй нь өнөөдөр тулгамдсан асуудал болж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг бүрэн дүүрэн нотолж баримтжуулахад хохирогчийн мэдүүлэг маш чухал улмаар хэрэгт ач холбогдолтой мэдээлэл гаргуулж авахад өмгөөлөгчийн оролцоо чухал гэдэг нь дээр өгүүлснээр батлагдаж байна.

Өнөөгийн байдлаар Монгол улсад бүртгэлтэй 2500 орчим өмгөөлөгч нар үйл ажиллагаа явуулж байгаагаас 58 улсын өмгөөлөгч^[78] бусад нь хувиараа өмгөөллийн үйлчилгээ явуулж байна. Эдгээр өмгөөлөгч нараас яг хүн худалдаалах гэмт хэргийг хохирогчийг өмгөөлөх тал дээр нарийн мэргэшиж тогтвортой ажиллаж байгаа өмгөөлөгч байхгүй байгаа нь уг гэмт хэргийн хохирогчид нийцсэн тэдэнд чиглэсэн чанартай өмгөөллийн үйлчилгээ үзүүлж чадахгүй байна гэж хэлж болохоор байна. Энэ нь эргээд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нар Үндсэн хуульд заасан

өмгөөлүүлэх эрхээ бүрэн дүүрэн хангалттай хэмжээнд эдэлж чадахгүй байгааг харуулж байгаа хэрэг мөн.

Нөгөөтэйгүүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нар ихэвчлэн мөнгө санхүүгийн хувьд боломж муу байдаг нь өөрт тохирсон сайн өмгөөлөгч нар авах нөхцөлийг хаадаг учир нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчээс хөлс авах бөгөөд өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг өмгөөлөгч, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.” гэж заасан үүнтэй уялдаж өмгөөллийн хөлс харьцангуй өндөр байгаагаар холбоотой юм.

Харин эсрэгээрээ хүн худалдаалах гэмт хэргийг голчлон санхүүгийн хувьд боломжтой болсон гэмт бүлэглэл үйлддэг бөгөөд өндөр үнээр сайн өмгөөлөгч авах нь элбэг байна.

Иймд дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн өмгөөлөх эрхийг хангах талаар системтэй цогц байдлаар хандах цаг нь болсон гэж судлаачийн хувьд дүгнэн хэлэхийг хүсэж байна.

Санал

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг өмгөөлүүлэх эрхээ эдлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох, аюулгүй байдлыг өндөр хэмжээнд хангах талаар нарийвчилсан зохицуулалтыг хийх.

2. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд болон бусад хуулийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг өмгөөлүүлэх эрхээ эдлэхтэй холбогдуулан өмгөөллийн хөлсөнд зориулж тодорхой санхүүжилт тусгаж өгөх.

3. Хуульчдын холбооноос жил болгон явуулдаг багц цаг тооцох сургалтанд сэтгэл заслын сургалтыг түлхүү оруулж өгөх.

4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид чиглэсэн чанартай өмгөөлөх арга тактикийг цааш нь хөгжүүлэн судалж тодорхой нарийн мэргэшсэн өмгөөлөгч нарыг бэлтгэн ажиллуулах.

5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх. Үүнд ялангуяа хохирогчийн

⁷⁸https://huulichmn.blogspot.com/2017/11/blog-post_54.html?m=1



өмгөөлөгч, мөрдөгч, улсын яллагч нарын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Хууль эрхийн актууд:
 - Хүний эрхийн түгээмэл тунхаглал
 - Монгол Улсын Үндсэн хууль
 - Эрүүгийн хууль 2002 он
 - Эрүүгийн хууль 2015 он
 - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
 - Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль
 - Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
 - Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
 - Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр
2. **Ном, зохиол:**
 - С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” УБ хот., 2007
 - С.Жанцан “Эрүүгийн эрх зүй” УБ хот., 2010 он
 - Г.Наранбаатар “Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа” УБ., 2016
 - С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ., 2013
 - С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ., 2013
3. **Цахим эх сурвал:**
 - www.humantrafficking.change.org
 - www.who.int/classifications/icd/en/
 - ps.psychiatryonline.org/doi/full/10.1176/appi.ps.201500509
 - www.ovcttac.gov/taskforceguide/eguide
4. **Бусад эх сурвалж**
 - ЦЕГ-н МНБГ-с гаргасан 2017 оны гэмт хэргийн статистик мэдээлэл



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Т.Очирбат

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Хууль сахиулахуйн инновацийн төвийн эрхлэгч,
докторант, цагдаагийн хурандаа

Хураангуй:

Аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад гаргасан шинжээчийн дүгнэлтийн ерөнхий статистик үзүүлэлт болон дүгнэлтийн агуулгаас үндэслэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай сургаал” нь олон улсад шинжлэн магадлахуйн ерөнхий онолын нэг элемент болон хөгжиж байна. Манай улсын хувьд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тэр дундаа хулгайлах, дээрэмдэх, залилах гэмт хэргийг шийдвэрлэхэд шинжилгээний байгууллага болон шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах нь тухайн хэргийг шийдвэрлэхэд голлох үүрэг гүйцэтгэсээр иржээ. Энэхүү судалгааны ажлаар өмчлөх эрхэд халдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг шийдвэрлэхэд шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй ашиглах боломжийн талаар хөндөж авч үзлээ

Түлхүүр үг: Шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай сургаал, шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

Гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгаа шалтгаан, нөхцлийг олж, түүнийг арилгах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол арга мөн. Манай улсын хувьд өмчлөх эрхэд халдах гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал гэж бүх нийтээр хүлээн зөвшөөрдөг. Ажилгүйдэл, ядуурлыг багасгах нь дурдсан гэмт хэргийг бууруулах улс орны хэмжээний асуудал. Гэвч үүнийг хүлээхгүйгээр хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах үүрэгтэй. Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг нотлоход чиглэдэг боловч шинжилгээ хийх явцад илэрсэн нөхцөл байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглагдаж болох тухай асуудлыг судалдаг

мэдлэгийн салбар хүртэл бий болон хөгжиж байна. Түүнчлэн, гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг нь юуны түрүүнд түүний шинж тэмдэгтэй тэмцэх тухай асуудал байдаг. Энэ талаас нь харвал шинжээчийн үйл ажиллагаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шууд бусаар маш их нөлөө үзүүлнэ. Энэ нь шүүхийн шинжилгээний байгууллага, мэргэжлийн хяналт, гаалийн байгууллага зэрэг зөрчил, маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад дүгнэлт гаргаж оролцож байгаа нь тухайн зөрчил нь гэмт хэрэг болон даамжрахаас өмнө таслан зогсоож байгаагаар илэрдэг байна.

Шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны онол, эрх зүйн үндэс:

Шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай сургаал нь цоо шинээр бий болсон мэдлэгийн салбар биш юм. Энэ сургаал нь шинжлэн магадлахуйн ерөнхий онолын бүтцэд багтаж, тусгай онолын түвшинд хөгжиж байгаа мэдлэгийн салбар бөгөөд 50 гаруй жилийн өмнөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд криминалистикийн шинжилгээний мэдлэгийг ашиглах боломжтой талаар тэмдэглэгдэж байв. Тухайлбал, тухайн үеийн Зөвлөлтийн эрдэмтэн В.П.Колмаков, И.Я.Фридман, Ю.Г.Корухов, В.Ф.Зудин, Б.А.Матийченко^[58] нарыг дурдаж болно. Эдгээр эрдэмтдээс И.Я.Фридман “Магадлах шинжилгээ ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал”^[59] сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан нь энэхүү судалгааг шинэ шатанд гаргасан байдаг.

Сүүлийн жилүүдэд шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн талаар И.А.Алиев

⁵⁸ Тухайлбал, Колмаков В.П. Некоторые вопросы криминалистической профилактики // Советское государство и право. 1969. №12. 96-108 дахь тал; Фридман И.Я. Вопросы профилактики преступлений при криминалистическом исследовании документов // Криминалистика и судебная экспертиза. Киев., 1988. 28-33 дахь тал.

⁵⁹ Фридман И.Я. Судебная экспертиза и вопросы предупреждения преступлений: Дисс. ... д-ра юрид. наук. Киев., 1974.



идэвхтэй судалгаа хийж, үзэл баримтлалыг тодорхойлсон. Тэрээр “шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэл”, “шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”^[60] гэсэн ойлголтуудыг тодорхойлж, тусгай онолын бүтцийг томъёолсон байна. И.А.Алиев шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэл гэдэг нь гэмт хэргийн үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэх боломж олгосон нөхцөл байдлыг шинжээч өөрийн тусгай мэдлэгийн үндсэн дээр тодорхойлох нарийн төвөгтэй систем гэж үзжээ. Харин шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэдэг нь түүнийг хэрэгжүүлэгч субект, тэдгээрийн үүрэг, үйл ажиллагааны арга, үр дүнтэй байдал, эрх зүйн зохицуулалт, бүтэц, арга зүй, зохион байгуулалтын холбоо, хамаарал гэх мэт олон хүчин зүйлийн нийлбэр гэсэн утгаар тодорхойлсон байна^[61]. Харин Т.В.Аверьянова эдгээр ойлголтууд нь тусдаа зүйл биш, нэг ойлголт^[62] гэж дүгнэснээс үзэхэд шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай онолын асуудал өнөө хэр маргаантай сэдэв болох нь харагдаж байна.

Түүнчлэн шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай асуудлыг Р.С.Белкин, Е.Р.Россинская, С.А.Смирнова нар өөрсдийн байр сууринаас авч үзжээ. Р.С.Белкин шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэсэн ойлголт нь шинжлэн магадлахуйн ерөнхий онолын нэг элемент гэдгийг онцлон дурдаад, энэхүү ажиллагаа нь процессийн болон процессийн бус хэлбэрээр илэрнэ гэж үзжээ. Түүний тодорхойлсноор процессийн хэлбэр нь шинжээч шинжилгээ хийх үедээ гэмт хэрэг үйлдэх боломж олгосон нөхцөл байдлыг тогтоож, өөрийн санаачлагаар дүгнэлтэд тусгах хэлбэр, харин шинжээч олж тогтоосон нөхцөл байдлыг эрх бүхий этгээдэд (өөрийн удирдлагадаа) мэдээлэл, илтгэх хуудас, зөвлөмж хэлбэрээр гаргаж болох ба энэ нь процессийн бус хэлбэрт тооцогдоно^[63]. Е.Р.Россинская “магадлах шинжилгээний үр дүнг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах асуудал нь криминалистикийн чиглэлд түгээмэл тохиолддог бөгөөд

криминалистикийн тусгай онолын нэг юм”^[64] гэсэн бол С.А.Смирнова арай дэлгэрэнгүй тодорхойлжээ. Тэрээр шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэл бол гэмт хэрэг (маргаан) гарах бололцоо олгосон нөхцөл байдлыг илрүүлэх, түүнийг арилгах арга хэмжээ авах зөвлөмж боловсруулах үйл ажиллагаа мөн гэж үзээд энэхүү үйл ажиллагаа нь процессийн болон процессийн бус хэлбэрээр явагдана гэсэн байна. Түүнчлэн, шинжлэн магадлахуйн процессийн хэлбэр нь тодорхой хэрэгт шинжилгээ хийх үед, харин процессийн бус хэлбэр нь шинжилгээний болон мөрдөн байцаалтын, шүүхийн практикт шинжлэх ухааны судалгааны ерөнхийлсөн дүгнэлт гаргах хэлбэрээр илрэх ба шинжээч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж агуулсан дүгнэлт гаргах, эрх бүхий байгууллага шинжээчийн дүгнэлтэд хийсэн судалгааны үр дүнд үндэслэсэн ерөнхий дүгнэлт-санал гаргах арга замаар хэрэгжинэ гэж үзжээ^[65].

ОХУ-ын судлаачид шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг онолын түвшинд судлаж, түүнээс үндэслэсэн практик хэрэглээг жишээ, баримтаар харуулж байгаа боловч эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаад шүүмжлэлтэй хандсан байна. Энэхүү үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь ОХУ-ын Эрүүгийн процессийн хуулийн 158 дугаар зүйлд заасан “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэрэг үйлдэх боломж олгосон нөхцөл байдлыг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, этгээдэд сануулах эрхтэй”^[66] гэсэн заалт, түүнчлэн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн актууд юм.

Барууны орнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг криминологийн шинжлэх ухаанд төвлөрүүлэн судлахаас гадна Forensic Criminology гэсэн ойлголт бий болсон талаар судлаачид дурджээ^[67]. Гэхдээ энэ ойлголт нь дээр дурдсанчлан бүхий л хэрэг, зөрчлийг үйлдэх бололцоо олгосон нөхцөл байдлыг илрүүлэх, түүнийг арилгах арга хэмжээ авах зөвлөмж боловсруулах гэхээсээ илүү хүний сэтгэл зүй, сэтгэцийн байдалд судалгаа хийх, улмаар тухайн

⁶⁰ “Экспертная профилактика”, “Экспертная профилактическая деятельность”

⁶¹ Алиев И.А. Проблемы экспертной профилактики. Баку., 1991. 51 дэх тал.

⁶² Аверьянова Т.В. Судебная экспертиза (Курс общей теории). М., 2009. 398 дахь тал.

⁶³ Белкин Р.С. Криминалистическая энциклопедия. М., 2000. 176 дахь тал.

⁶⁴ Россинская Е.Р. Теория судебной экспертизы. М., 2015. 76 дахь тал.

⁶⁵ Смирнова С.А. Энциклопедический словарь. М., 2012. 420 дахь тал.

⁶⁶ ОХУ-ын Эрүүгийн процессийн хууль. 2001. 158 дугаар зүйлийн 2 дахь заалт.

⁶⁷ Монголын криминологичдын холбоо. Гэмт хэргийн цагаан ном //Нээлттэй нийгэм форум. -Уб., 2017.128-129 дэх тал.



хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Түүнчлэн магадлах криминологич (forensic criminologists) гэсэн ажил мэргэжил байдаг бөгөөд тэдгээр хүмүүс эрүүгийн хэрэг, хэргийн газраас олдсон биет баримтад дүн шинжилгээ хийж, болсон процессийг сэргээн дүрслэх үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл Forensic Criminology нь бидний судалгааны хүрээнд хамаарах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинжлэн магадлахуйн үүргээс явцуу хүрээгээр тодорхойлогдож байна.

Германд эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессийн эрх зүй, криминалистик, криминологи, шинжлэн магадлах ухаан нь бүхэлдээ System der Kriminalwissenschaften буюу "Гэмт явдал судлал" гэсэн нэг системд хамаарагдах бөгөөд ингэснээрээ гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх үүргийг бүхэлд нь цогц байдлаар авч үзэх боломж олгодог байна.

Харин манай улсын хувьд Ж.Хурцгэрэл, Б.Бат-Эрдэнэ нар криминалистикийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар өөрсдийн бүтээлд дурдсан байна. Ж.Хурцгэрэл "мөрдөн байцаагч гэмт хэрэг үйлдэх бололцоо олгосон нөхцлийг илрүүлэх, түүнийг арилгах практик үйл ажиллагаандаа зөвхөн криминалистик биш ЭБШЭЗ, ЭЭЗ, криминологи, шүүх сэтгэгч, гэм судлал, шүүх эмнэлгийн зөвлөмжийг ашигладаг"^[68] гэсэн бол Б.Бат-Эрдэнэ "криминалистикийн тусгай зорилгын нэг нь гэмт хэргийг таслан зогсоох"^[69] криминалистикийн арга, хэрэгслийг боловсруулах явдал"^[70] гэжээ. Түүнчлэн криминалистикийн тогтолцоонд шинээр нэмэгдэх^[71] элемент нь гэмт хэрэгтэй тэмцэх зохион байгуулалт, удирдлага зүй байх болно гэж үзэж байна^[72] гэсэн санал дэвшүүлсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гэж мэт олон үйл ажиллагааг криминалистикийн онолын хүрээнд судлаж, зөвлөмж боловсруулах шаардлагатай болохыг олж харсны илрэл байж болох юм.

Тэгэхээр, шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа (экспертная профилактическая деятельность) гэдгийг гэмт хэрэг, зөрчил

үйлдэгдэх боломж олгож байгаа нөхцлийг илрүүлэх, түүнийг арилгах зөвлөмж боловсруулах үйл ажиллагаа гэж онолын үүднээс тодорхойлж болох бөгөөд энэ нь дараахь хэлбэртэй байна. Үүнд:

- Процессийн хэлбэр;
- Процессийн бус хэлбэр;

Процессийн хэлбэр нь тодорхой хэрэгт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үед илэрнэ. Тухайлбал, банкны гүйлгээний баримт дээрх теллерийн гарын үсэг жинхэнэ эсэхийг тогтоох адилтгалын шинжилгээ хийх үед уг гарын үсэг нь хэт богино, шинж тэмдгийн хувьд хангалтгүй байх нь нийтлэг тохиолдоно. Энэ тохиолдолд шинжээч өөрийн дүгнэлтэд энэ тухай дурдаж, дүгнэлтийн "нэгтгэн дүгнэж" хэсэгт бичиж болно. Энэ санааг харин шинжээчийн дүгнэлтийн асуултад хариулсан хэсэгт бичиж болохгүй бөгөөд тэр хэсэгт зөвхөн тогтоолд тавьсан асуултын хариуг бичнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж агуулсан дүгнэлт гаргах боломжтой юм. Гэхдээ манай улсын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зорилт^[73] нь урьдчилан сэргийлэх чиг үүрэг агуулаагүй тул энэ нь практикт төдийлөн тохиромжтой бус хувилбар гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд байгаатай ижил зохицуулалт буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах эрхийг мөрдөгчид болон шинжээчид олгосон хэм хэмжээ Монгол Улсын ЭХХШТХ-д байхгүй юм. Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа ч гэсэн урьдчилан сэргийлэх зорилт агуулаагүй. Шүүхийн шинжилгээний тухай хуульд "шүүхийн шинжилгээ" гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, түүх, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг хэлнэ гэж заасан^[74].

Процессийн бус хэлбэр нь шинжлэн

⁶⁸ Хурцгэрэл Ж. Криминалистик I. -УБ., 2002. 42 дахь тал.
⁶⁹ "Гэмт хэргийг таслан зогсоох" гэсэн ойлголтыг өргөн хүрээнд авч үзвэл урьдчилан сэргийлэх ойлголт түүнд хамаарна гэж үзэж байна.

⁷⁰ Бат-Эрдэнэ Б. Криминалистик (Лекцүүд). -УБ., 2003. 7 дахь тал.

⁷¹ Криминалистикийн онол, техник, тактик, арга зүй гэсэн элементүүд.

⁷² Мөн тэнд. 19 дэх тал.

⁷³ ЭХХШТХ-д Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэж тодорхойлсон.

⁷⁴ Шүүхийн шинжилгээний тухай хууль. 2009. 6 дугаар зүйл. 6.1.1.



магадлахуйн болон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн практикт шинжээчийн дүгнэлт, статистик үзүүлэлтэд судалгаа хийсний үр дүнгээр илэрнэ. Тухайлбал, шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтүүдэд судалгаа явуулсны үндсэн дээр зам тээврийн осолд өртсөн хүмүүс чухам ямар нөхцлийн улмаас гэмтсэнийг тогтоох гэх мэт. Энэхүү судалгааг шүүхийн шинжилгээний байгууллага эсвэл бусад хэлбэрээр үүрэг хүлээсэн байгууллага гүйцэтгэж, цаашид судалгааны үр дүнд тулгуурласан арга хэмжээ авч хэрэгжүүлэх байдлаар ашиглана. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шинжлэн магадлах үйл ажиллагааны дэмжлэгийг бий болгох хамгийн тохиромжтой хувилбар бөгөөд Гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна. Тус хуульд “Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, захиргааны хяналтын албад эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах үүрэгтэй”^[75] гэсэн зохицуулалтын хүрээнд цагдаа, шүүхийн шинжилгээний болон хууль зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд шинжээчийн дүгнэлтээр илэрсэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг шийдвэрлэх явцад шинжилгээ хийж байгаа өнөөгийн байдал

Шүүхийн шинжилгээний байгууллага сүүлийн жилүүдэд жилд дунджаар 60 орчим мянган шинжилгээ хийсэн байх бөгөөд тэдгээрийн 60 гаруй хувь нь шүүх эмнэлгийн шинжилгээ, үлдэж буй хувийг криминалистик, биологи, хими, физик, эдийн засгийн шинжилгээ эзэлж байна.




⁷⁵ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997. 7 дугаар зүйлийн 7.5.

Бидний судалгааны ажлын гол зорилго нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байгаа тул өмчлөх эрхэд халдсан гэмт хэрэгт хийсэн шинжилгээний хүрээнд судалгаа явуулав.


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг шалган шийдвэрлэх явцад 2017 онд нийт 3220 шинжилгээ хийсний 92 хувийг хулгайлах гэмт хэрэг, түүн дотроо орон байрны хулгайн хэрэг дийлэнх хувийг эзэлж байна. Дээрэмдэх хэрэг 5 хувь, залилах гэмт хэрэгт хийсэн шинжилгээ 3 хувь, үлдэх хувийг хөрөнгө завших, нотариатч өмчлөгчийн эрхийг зөрчих хэргүүдэд хийсэн шинжилгээ эзэлж байна.



Хулгайлах хэргийг шийдвэрлэх явцад хамгийн олон шинжилгээ буюу 3006 шинжилгээ хийлгэсэн байх бөгөөд эдгээр шинжилгээний 93 хувийг гарын мөрний шинжилгээ, бусдыг нь мөр судлал, ДНХ, дүрс бичлэг, галт зэвсэг, физик, химийн шинжилгээнүүд эзэлжээ.




Дээрэмдэх гэмт хэрэгт 161 шинжилгээ хийсний дийлэнх нь гарын мөр, ДНХ-ийн шинжилгээ, бусад нь мөр судлал, дүрс зураг (ам зураг), дүрс бичлэг, галт зэвсэг, компьютер техник, химийн шинжилгээ байна.



Залилах гэмт хэрэгт 92 шинжилгээ хийсний дийлэнх нь бичиг судлал, бичиг техник, бусад нь дүр зураг (ам зураг), компьютер техник, дүрс бичлэг, мөр судлал, дуу авиа, гарын мөр, физикийн шинжилгээ байна.



Хөрөнгө завших гэмт хэрэгт нийт 11 удаа шинжээч томилсон байна.



Мал хулгайлах гэмт хэрэгт 47 удаа шинжээч томилсон байх ба ихэвчлэн адуу, үхэр нядалж авч явсан хэргүүд дээр тамхины ишнээс шүлс илрүүлэх ДНХ-ийн шинжилгээ хийсэн байна. Мөн гарын мөр, мөр судлал, галт зэвсэг, компьютер судлал, дүрс бичлэгийн шинжилгээ хийжээ.



Дээрх шинжээчийн дүгнэлтийн агуулгаас

үзэхэд судалгааны ажлын нэгдүгээр хэсэгт дурдсан процессийн хэлбэр буюу шинжээчийн дүгнэлтэд урьдчилан сэргийлэх зөвлөмж тусгасан байдал байхгүй байна.

Мөн процессийн бус урьдчилан сэргийлэх хэлбэр болох шинжээчийн дүгнэлтээс үндэслэн гэмт хэрэг үйлдэх боломж олгож байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт сүүлийн жилүүдэд бүртгэгдээгүй байна. Харин хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг Шүүхийн шинжилгээний байгууллагын зүгээс УБЕГ-ын бүртгэгч нарт явуулж байсан баримт байгаагаас гадна гарын үсгийн шинжилгээтэй холбоотой, өөрөөр хэлбэл үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд хуурамчаар гарын үсэг зурах (Залилах) хэргүүд ихсэж байгаатай холбогдуулан 2010 онд Монголын нотариатчдын танхимд Шүүхийн шинжилгээний байгууллагаас зөвлөмж хүргүүлж байжээ. Тус зөвлөмжийн агуулга нь аливаа гэрээг баталгаажуулахдаа гарын үсгээс гадна, хурууны хээг давхар авч байх талаар зөвлөж, хурууны хээ авах аргачилсан зааврыг хавсаргасан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг хэлбэр болсон байна.

Дүгнэлт, санал

1. Хуримтлуулсан практик туршлагад тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулсаар ирсэн нь судалгааны явцад харагдаж байна. Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргах явцад гэмт хэрэг үйлдэгдэх боломж олгосон олон нөхцлийг олж харж байдаг. Ялангуяа, халдлагад өртсөн сейф, хаалга, цонх, цоож, түгжээ хялбар эвдэрсэн шалтгаан, бичиг баримт, гарын үсгийг хуурамчаар үйлдсэн аргууд гэх мэт. Иймд шинжилгээ хийх явцад олж авсан эдгээр мэдлэгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ямар хэлбэрээр ашиглаж болох тухай мэдлэгийн салбар болох "шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэлийн тухай сургаал"-ыг шинжилгээний байгууллага болон бусад холбогдох байгууллагын алба хаагчид судлах, хөгжүүлэх шаардлагатай юм. Ингэснээр хэргээс урьдчилан сэргийлэхэд шинжилгээний байгууллагын дэмжлэгийг авах боломж бүрдэнэ.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шинжилгээний тухай,



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд авч үзвэл шинжлэн магадлахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа процессийн бус хэлбэрээр, өөрөөр хэлбэл холбогдох байгууллага (Шинжилгээний байгууллага, Цагдаагийн байгууллага, Эрдэм шинжилгээний байгууллагууд) шинжээчийн дүгнэлт, түүний агуулгад судалгаа хийсний үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байх нь чухал байна.

3. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг шийдвэрлэх явцад гаргасан шинжээчийн дүгнэлтүүдийн ерөнхий статистик ба дүгнэлтүүдийн агуулгаас үндэслэн дээрх гэмт хэргийн зонхилох хувийг эзэлж буй хулгайлах, дээрэмдэх залилах гэмт хэрэг үйлдэх бололцоо олгож буй хэд хэдэн хүчин зүйлийг тогтоосон бөгөөд эдгээрийг арилгах зөвлөмжийг жишээ болгон авч үзлээ.

- Иргэдэд чиглэсэн: Хулгайлах гэмт хэргийн дийлэнх нь гэр, байгууллагын орон байранд халдсан хэргүүд бөгөөд ихэнх тохиолдолд вакум цонхыг эвдэж оржээ. Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл, шинжээчийн дүгнэлтээс үзэхэд тухайн вакум цонхыг түлхэх үед түүний түгжээний тээглүүр төмөр (хайлш) хугарч цонх саадгүй онгойход хүргэсэн байна. Иймд иргэд цонхондоо хамгаалалт хийх, түүнчлэн вакум цонх үйлдвэрлэгчид цонхны түгжээний тээглүүр төмрийг сайжруулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Мөн залилах гэмт хэрэг шийдвэрлэх явцад гаргасан шинжээчийн дүгнэлтээс үзэхэд гарын үсэгтэй холбоотой маргаан дийлэнх хувийг эзэлсэн байх бөгөөд шинжилгээний байгууллагад дахин хийлгэж байгаа шинжилгээний дийлэнх нь юм. Ялангуяа үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээ нь шинжилгээний гол объект болжээ. Шинжээч гарын үсгийг хуурамчаар үйлдсэн эсэхийг тогтоох хамгийн гол нөхцөл нь тухайн гарын үсгийн шинж тэмдгүүд байдаг. Гэвч түүний шинж тэмдэг хангалтгүй байснаас шалтгаалж гарын үсгийг хуурамчаар үйлдсэн эсэхийг бүрэн дүүрэн тогтоох шинжээчийн дотоод итгэл бүрдэж чадаагүй гэж үзэхээр байна. Гарын үсэг нь тухайн иргэн, албан тушаалтныг төлөөлөх баталгаа гэдгийг сайтар ойлгох ёстой бөгөөд түүнийг зурахдаа бодолтой (буурьтай) хандах ёстой

юм. Ялангуяа банкны гүйлгээний ажилтны гарын үсэг, нотариатын газрын тохиромжгүй нөхцөлд зурсан гарын үсгүүдэд хийсэн шинжилгээнд маш их цаг зарцуулсан нь судалгаанаас харагдсан. Иймд иргэд өөрийн гарын үсгийг зурахдаа бусад этгээд хуурамчаар үйлдэх боломжгүй байх ёстой гэсэн үүднээс ханддаг байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг нөхцөл болно.

- Эрх бүхий байгууллагад чиглэсэн: Залилах гэмт хэрэгтэй холбогдуулан авч үзэхэд зөвлөмж хүргэх эрх бүхий байгууллагын тоонд Нотариатчдын танхим орно. Учир нь хамгийн өндөр хохиролтой залилах гэмт хэрэгт хийсэн шинжилгээний объект нь үл хөдлөх хөрөнгийн гэрээнүүд байх ба тэдгээрийн ихэнх нь нотариатын баталгаатай байдаг. Иймд гэрээг талуудын гарын үсгээс гадна, хурууны хээгээр баталгаажуулж байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг алхам болно гэж үзэж байна (Нотариатчийн тэмдгийн загварын төслийг хавсаргав).

Бодлого боловсруулагчдад чиглэсэн: Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчид хэргийн газрын үзлэгт оролцсон байдал, сүүлийн 6 жилд хийсэн шинжилгээний төрөл, шинжээчийн дүгнэлтийн агуулгад судалгаа хийж үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил огт сайжраагүй болох нь харагдаж байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ямар нэгэн хэмжээгээр ашиглах шаардлагатай гэж үзэж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн захиргааны байгууллага голлох үүрэгтэй оролцохоор тусгасан⁷⁶ байх боловч түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн механизм дутагдалтай байдаг байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагад хийгддэг шинжилгээг төлбөртэй болгож, тухайн төлбөрийг гэмт хэрэг үйлдэгдсэн орон нутгийн төсвөөс төлдөг зохион байгуулалтыг бий болгож болох юм. Ингэснээр нутгийн захиргааны байгууллагууд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарлаа хандуулдаг тогтолцоо бүрдэх боломжтой.

⁷⁶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 7.7.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батална.



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД АНХААРАХ АСУУДАЛ

Б.Эрдэнэжаргал

Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн
Замын цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн ахмад

Хураангуй: Цагдаагийн албаны хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, Цагдаагийн алба хаагчийг гадаад болон дотоод эх үүсвэрээс бүрдүүлэхийн давуу болон сул тал, мөн хүний нөөцийн мэргэжилтэн менежерийн гүйцэтгэх үүргийн талаар, цаашид анхаарах асуудлын талаар өөрийн саналыг дэвшүүлсэн.

Түлхүүр үг: Цагдаагийн байгууллага, хүний нөөц, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт

Цагдаагийн албаны тухай хууль шинээр батлагдан гарч, мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Цагдаагийн албаны хүний нөөцийн төлөвлөлт, тус албанд ажиллах боловсон хүчний шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, алба хаагчдыг шударгаар сонгон шалгаруулж ажиллуулах нь иргэдийн өмнө хүлээсэн “Амар тайван амьдралын төлөө хамтдаа”уриан доор хэрэгжих, үүргээ биелүүлэх баталгаа хангагдана хэмээн үзэж байгаа юм.

Төрийн албаны тухай хуулийн 17-р зүйлийн Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.

Мөн хуулийн 17.3-д Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэн сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага

сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ...хэмээн заасан байдаг.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 20-р зүйлийн 1.11-д Цагдаагийн төв байгууллагын дарга нь “Хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, үйл ажиллагааны журмын 900.3.1-д зааснаар “Цагдаагийн байгууллагын дарга нь хүний нөөцтэй холбоотой асуудлаар Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь хэсэг болон Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн холбогдох заалтад зааснаас гадна дараах ажил зохион байгуулна хэмээн заасан байдаг. Үүнд:

а/ цагдаа, дотоодын /2014.04.01-ний өдрөөс Дотоодын цэргийн анги татан буугдсан/ цэргийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тэдний хууль ёсны эрх ашиг, нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээний саналыг талаар авах арга хэмжээний саналыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлж болно.

б/ Гадаад, дотоодын их дээд сургууль, академи төгсөгч, тусгай албаны цагдаа, офицер алба хаагчийг томилох, албанаас чөлөөлөх, халах

и/ ахлагч орон тоонд ажиллах алба хаагчийг томилох, цол олгох эрхийг төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дарга, захирагч нарт тушаалаар шилжүүлж болно.

Дээрхи хууль, тогтоомжид зааснаар төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан удирдамжийн дагуу цагдаагийн алба хаагчаар ажилд орох хүсэлтэй иргэнийг судалсны үндсэн дээр сонгон шалгаруулалт явуулж, сургалтад хамруулан, тодорхой албан тушаалд томилж байна.

Мөн Засгийн газрын 2014 оны 3-р сарын 14-ний өдрийн 79-р тогтоолоор батлагдсан



“Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг 2014-2017 он, 2017-2019 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр батлан гаргасан.

Уг хөтөлбөрийн 8.1.3-д заасан “Боловсон хүчний сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдэнэ”... үр дүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтөд нэн түрүүн тавигдаж байгаа шинэ шаардлагуудын ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна.

Нэгдүгээрт: Хүний нөөцийн төлөвлөлтийн хуучин арга барил цагдаагийн байгууллагын хөгжлийн өнөөгийн шатанд төдийлөн тохирохгүй байгаагийн дээр хүний нөөцийн төлөвлөлтийн шинэ нэгдсэн бодлого хараахан томъёологдож нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй, шинэ нөхцөлд тохирсон аргачлал үндсэндээ нэвтрээгүй байна.

Хоёрдугаарт: Хүний нөөцийн төлөвлөлтийн орчин сүүлийн хэдэн жилд өөрчлөгдсөн бөгөөд тухайлбал, Цагдаагийн байгууллагын зорилго, зорилт өөрчлөгдөж «Хүчний байгууллагын тогтолцооноос», «Үйлчилгээний байгууллагын» тогтолцоонд шилжиж байгаа нь тооны үзүүлэлтийг голлох бус, иргэдээс Цагдаагийн албанд ажиллах алба хаагчаар ажилд авах шалгуур үзүүлэлтийг нарийвчлан гаргаж, сонгож авахыг чухалчлахыг шаардаж байгаа юм.

Ингээд Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтийн талаар авч үзье.

“Бүрдүүлэлт гэдэг нь тухайн байгууллагад сул байгаа албан тушаал, ажлын орон тоонд тодорхой шаардлага хангасан хүмүүсийг сонгож авахын тулд ажиллахыг хүссэн хүмүүсийг бүртгэж судлах үйл явц юм”.

Аливаа байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтийг:

а/ Гадаад

б/ Дотоод гэсэн хоёр эх үүсвэрээс бүрдүүлдэг.

Гадаад эх үүсвэр: Урьд өмнө тухайн байгууллагатай хөдөлмөрийн эрх зүйн ямар нэгэн харилцаагүй байсан хүмүүс байдаг.

2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Цагдаагийн албаны тухай хуулийн 6-р зүйлийн 5-д “... хотын цагдаагийн байгууллагын даргыг Цагдаагийн төв байгууллагын даргатай зөвшилцөн хотын захирагч томилно” хэмээн заасны дагуу Улаанбаатар хотын цагдаагийн даргыг ард нийтийн өмнө нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж, томилно гэж

зохицуулсан нь дэвшилттэй асуудлуудын нэг бөгөөд “Та бүгдийн амар тайван амьдралын баталгааг хангахын төлөө тодорхой хөтөлбөр дэвшүүлж, хэрэгжүүлнэ” гэж амлан өрсөлдсөн нь ардчилсан тогтолцооны нэг хэлбэр юм.

Улаанбаатар хотын цагдаагийн газрын даргын албан тушаал дээр 6 хүн сонгон шалгаруулалтад орж өрсөлдсөнөөс НЦГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч, цагдаагийн хурандаа Ч.Болдбаатар шалгаран, Улаанбаатар хотын цагдаагийн даргаар батламжлагдан томилогдоод байна.

Энэ нь Улаанбаатар хотын оршин суугчид, ард иргэдээс өөрсдийн аюулгүй байдлыг ханган ажиллах байгууллагын удирдах хүнийг санал асуулгын болон ярилцлага хийх мөн бусад хэлбэрээр шалгаруулж сонгож байгаа нь дэвшилттэй, шударга, хариуцлагатайгаар хийгдэж буй зөв сонголт юм.

Нөгөө талаас Улаанбаатар хотын амар тайван байдлын баталгааг хангах, сахих, бэхжүүлэх ажлыг хийж гүйцэтгэдэг цагдаагийн удирдлага, Нийслэлийн Засаг даргын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн хүрээнд нийт иргэдэд шууд амлана, хэрэгжүүлнэ, эс биелүүлсэн тохиолдолд жилийн дараа нийт иргэдэд тайлангаа тавьж, огцрох өргөдлөө шууд өгөх хариуцлагатай ухамсрын тогтолцоо байдаг.

Тийм ч учраас энэ нь зүгээр нэг хүний албан тушаал хөөсөн, карьерийн тогтолцоо биш хэмээн ойлгогдож байна.

-Бэлтгэл цагдаагийн хурандаа Д.Базаргүр гуйан өгсөн нэгэн ярилцлагад:

...Б.Пүрэв генерал цагдаагийн байгууллагад тулгамдаад байгаа асуудлыг судалж үзсэн юм билээ. Тэгсэн дуулиант онц ноцтой хэргүүд илрэхгүй байгаад байсан. Мөн цагдаа нар танхай нөхдүүдээс айж зугтаадаг. Хэн нэгэн танхайраад, дийлдэхгүй үед нь зогсоож чадахгүй байх тохиолдол гардаг л байсан. Тэгээд хоёр тасаг байгуулсан. Тусгай тасаг байгуулагдаж, даргаар нь Ц.Уугангэрэл томилогдсон.

Харин би онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга болсон юм. Бид хоёрт Б.Пүрэв дарга давуу эрх өгч байсан. Ц.Уугангэрэлд: бие хаа сайтай, надаас өндөр залуусыг сонгож ав. Надад болохоор хэрэг илрүүлж чаддаг л бол ямар ч хамаагүй хүний ажилд ав. Тэгээд л багаа бүрдүүл гэсэн. Бид ч багаа бүрдүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын дарга асан Д.Мөрөн, Цагдаагийн



ерөнхий газрын дэд дарга асан, бригадын генерал А.Дулаанжаргал, Б.Болдбаатар, С.Эзэннайрамдах нарыг олж ирсэн. Ёстой л гар нийлсэн залуус мөн ч олон хэргийн араас орж илрүүлж байлаа... хэмээн дурссан байдаг.

Дээрхи хэлбэрүүд нь Цагдаагийн албаны шилдэг ажилтнуудыг сонгон шалгаруулах замаар гадаад эх үүсвэрээс бэлтгэж байсан нь тухайн цаг үетэйгээ зохицсон тэргүүн туршлага хэмээн харагдаж байгаа юм.

Дотоод эх үүсвэр: Тухайн цагдаагийн байгууллагад ажиллаж буй ажиллагсад, алба хаагчид юм. Энэ нь байгууллагынхаа ажиллагсад алба хаагчдаас сул орон тоо гарсан ажлын байранд тохирох хүмүүсийг томилон ажиллуулах явдал байдаг. Ер нь аль ч байгууллагын ажиллагсад алба хаагчид дотроо шилжих, өөр албан тушаалд томилогдох нь элбэг тохиолддог бөгөөд ихэвчлэн тушаал дэвших маягаар нэг ажлын байрнаас нөгөөд шилждэг.

Иймээс ажиллаж байгаа хүмүүсээ нарийн сайн судлах, таних, тэдгээрийн ур чадварыг нээн илрүүлэх, урамшуулах, хөгжүүлэх, ажил амьдралын туршлага, мэргэшил, албандаа хандах хандлагыг тогтоож, ирээдүйн албан тушаалын боломжийг урьдчилан төлөвлөж байх нь чухал хэмээн үзэж байна.

Мөн өөрийн болон гадны хүчин зүйлийн хамаарлаас сахилгын арга хэмжээ авагдсан бол төрийн албаны тухай хууль бусад албаны хууль, тогтоомж, дүрэм журам зааврын дагуу тэдгээр алба хаагчдыг тодорхой хугацааны дараа цагаатгаж байх нь зүйтэй байдаг.

Зарим байгууллагын дарга, удирдлагууд энэ байдлыг олж хардаггүй, тухайн алба хаагч өөрийгөө өмгөөлж чадалгүй арга хэмжээ авагдсан бол насаар нь яллах хандлага гардаг ба цагдаагийн байгууллагад өөрийгөө өмгөөлөх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хязгаарлагдмал байдаг.

Энэ нь тухайн алба хаагчийн ажил хийх урам зоригийг бууруулахаар барахгүй хамт олонд эзлэх байр суурийг алдагдуулах ба албан тушаал ахих, шагнал урамшилд дэвшихэд садаа болдог төдийгүй, албан тушаал бууруулахад шалтаг болдог нь практик амьдрал дээр харагддаг.

Үүний цаана тухайн ажилтны ажилдаа хандах хандлага, албандаа үнэнч байдал, зорилго, ажиллах хугацааны нийгмийн сөрөг үр дагавартай тэмцэж ирсний ач холбогдол, үр дүн гэх мэтээр бүх үнэт зүйлс

нь алдагдаж байгааг тухайн байгууллагын менежер олж хардаггүй.

Гэтэл үүний эсрэгээр сайн алба хаагч хэмээн магтагдаж, шагнагдсан зарим алба хаагчийн албандаа итгэлтэй байх, ажил хийх урам зориг орж, ажилд бүтээлчээр хандах хандлага нь нэмэгддэг бол зарим улс төрийн болон ямар нэг даргын нөмөр нөөлгө, ивээлд орсон, дулдуйдсан, тал тохой зассаны хүчинд албан тушаалд хүрсэн, шагнагддаг хэсэг нь бүхнийг би, би, би бол..., өөрөөс нь өөр хүн байхгүй мэтээр сэтгэж биеэ тоох хандлага илэрдэг ба энэ нь хамт олон, бүлгийн уур амьсгалыг эвддэг болох нь практикаас ажиглагддаг.

Хууль зүйн ухааны доктор, цагдаагийн хурандаа К.Женисгүлийн “Үндэсний мэдээ сонин”-д өгсөн нэгэн ярилцлагад: ...Зарим хүн удирдах албан тушаалд очингуут их л буруугаар бодож, аашилж аяглах юм. Эдгээр хүмүүсийг хөндлөнгөөс харж байхад энэ албан тушаал нь мөнхийн суудал мэт арслан бар шиг аашилж, мөн ойр тойрондоо дээрэлхүү хандаж, олон ч сайн нөхдөө гомдоох юм.

Нэгд: хааны суудал халаатай, эзний суудал ээлжтэй. Нэг л нартай өдөр нөгөө дээрэлхээд байсан хүмүүстэйгээ зэрэгцээд сууж байна гэдгээ, энэ үед юу хэлэхээ, нүд рүү нь харж чадахаа бодох л хэрэгтэй, Хоёрд: албаны эрх ашиг, хувийн эрх ашиг ааш аягаа нягт салгаж ойлгоод ухамсартайгаар албандаа хандаж сурах нь чухал. Зарим нэг нь хувийн эрх ашгийн үүднээс албандаа хандаж, хувийн компанийнхаа ажилчдыг хөөж, тууж байгаа юм шиг л дөвчигнөж, эрхшээлдээ оруулж, төрийн албан хаагч энэ даргын гутлыг тосолж өгөх, өмд, цамцыг индүүдэж өгөх, бэлэг сэлт өгөх зэргээр үнэхээр сэтгэхүйн, ухамсрын, нэр төрийн хувьд доройтолд орж байсан тохиолдол харж л байлаа.

Ямар ч удирдах ажлын туршлага, мэдлэг, чадваргүй залуу хүн даргын суудалд хэн нэгний шахаас, нөлөөгөөр томилогдчихоод өрөөндөө компьютер тоглон, үзгээ эргүүлэн, хэн нэгний танилцуулсан, шийдвэрлэх ёстой ажлын утга, ач холбогдлыг ч ойлгохгүй, ёстой памперстай, манцуйтай хүү гэдэг шиг төрийн ажлаар тоглож байсан тохиолдол байсан юм шүү... хэмээн өгүүлсэн байдаг.

Дээрхи байдлаас байгууллагын удирдлага буюу хүний нөөцийн менежерүүд хүнээ, алба хаагчийнхаа ар гэр, ахуй амьдрал, санаа зорилгыг судлан тухайн



алба хаагчийн ур чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх дээрхи байдлыг харгалзан үзэж тодорхой албан тушаал дээр томилдог байх нь зүйтэй юм.

Өөрөөр хэлбэл байгууллагын хүний нөөцийн менежер нь аливаа нэг ажилтны хувийн болон албаны зан чанарууд, мэргэжлийн ямар ур чадвартай байх ёстойг сайн мэддэг байх хэрэгтэй. Мөн тухайн ажлын байранд тохирох хүний тодорхойлолтыг гарган өөрөө бие даан шийдвэр гаргаж, түүнийгээ байгууллагын даргын зөвлөлд оруулан, шийдвэр гаргуулах чадвартай байх нь зүйтэй хэмээн үзэж байгаа юм.

Дээрхи байдлаас хүний нөөцийн бүрдүүлэлтийн гадаад, дотоод эх үүсвэрүүдийг харьцуулан харуулбал:

Эх үүсвэр	Дотоод	Гадаад
Давуу тал	Зардал бага, байгууллагын онцлог, ажиллагсад алба хаагчдын зан чанар, чадвар, туршлагыг сайн мэддэг тул ажлын арга барилыг олж авахад хялбар, нөөцөд авагдсан байдаг	Олон тооны нэр дэвшигчдээс сонголт хийдэг. Шинэ санаа, шинэ арга барил бий болдог. Байгууллага дахь ажлын доголдол, дутагдлыг гадны хүний нүдээр олж харж илрүүлж засан залруулдаг.
Сул тал	Аливаа дутагдалтай эвлэрэх хандлагатай, өмнө нь ажиллаж байсан хамт олны зүгээс харилцах харилцаа холдож хөндийрдөг, хүлээн зөвшөөрөгддөггүй.	Ажил, хамт олон, тухайн ажлын байранд зохицох хугацаа урт, шинэ ажилтны ажлын арга барил тодорхойгүй байдаг.

Дээрхи гадаад ба дотоод эх үүсвэрээс Цагдаагийн байгууллагын ажилтныг сонгон тухайн албан тушаалд томилно гэдэг бол маш хариуцлагатай ажил байх ёстой. Менежментийн шинжлэх ухаанд томъёолсноор:

“Сонголт” гэдэг нь ажлыг гүйцэтгэхэд хувь хүнээс шаардагдах чадвар, боломж, туршлагыг үнэн зөв тодорхойлох үйл явц юм.

Цагдаагийн алба хаагчийн эзэмшсэн мэргэжил, мэргэжлийн мэдлэг, дадлага, туршлага, ажил гүйцэтгэх чадвартай хүнийг өөрт нь тохирсон албан тушаал дээр сонгон томилсны үндсэн дээр ажил, үйлчилгээ зохих төвшинд явагдана.

Цагдаагийн байгууллагад орж ажиллахаар өргөдөл гаргасан хүмүүсээс шаардлага хангасан алба хаагчийг сонгож авах нь маш хариуцлагатай бөгөөд олон шаттай ажил юм.

Сонголтын явцад тухайн ажлыг гүйцэтгэхэд хувь хүнээс шаардагдах чадвар, боломж, туршлагыг үнэн зөв тодорхойлох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сонголтын гол зорилго нь тухайн ажлын байрны шаардлагыг хангасан ажлын байран дээр тогтвор суурьшилтай, Цагдаагийн албанд дур сонирхолтой, үнэнч шударгаар ажиллах хүнийг таньж, зөв сонгон шалгаруулж томилох ажиллуулах явдал юм.

Гэтэл зарим удирдах албан тушаалд очсон хүмүүс тэнгэрээс од шүүрсэн мэт, бүхний дээр гарсан мэт байдаг нь илт. Харамсалтай нь тодорхой хугацааны дараа албан тушаалаа өгсний дараа зарим хэсэг нь маш их стресст өртдөг болох нь мөн л амьдрал дээр харагддаг.

Иймд хүмүүсийг элсүүлж, шилж сонгохоосоо өмнө ажлын байрны шинжилгээ хийж, ажлын байрыг зөв тодорхойлсон байх шаардлагатай.

Учир нь хүмүүст санал болгосон ажлын байрны тухай болон сонгож авах хүнд тавигдах шаардлагын талаар зарлал мэдээлэлд тусгагдсан байх ёстой.

Иймд ажлын байрны шинжилгээ, тодорхойлолтыг үндэслэн шинээр алба хаагчийг шилж сонгон ажилд томилох, цалин хөлс, цол, урамшууллыг зөв тогтоох үндэслэл болно.

Эндээс үүдээд ажлын байрны шинжилгээний тухай авч үзье.

“Ажлын байрны шинжилгээ гэдэг нь тухайн орон тоог эсвэл ажлын байрыг ойлгож мэдэхэд шаардагдах баримт мэдээллийг цуглуулах үйл явц юм”.

Ажлын байрны шинжилгээг ажиглалт, ярилцлага, асуулгын аргуудаар хийдэг. Ингэж ажлын байрны шинжилгээний үндсэн дээр ажлын байрны тодорхойлолтыг гаргаж ирдэг.

“Ажлын байрны тодорхойлолт” гэдэг нь тухайн ажлын байранд хийгдэх үндсэн ажил үүрэг, шаардагдах мэргэшил, туршлага, ур чадвар, эрх мэдэл, хариуцлага зэргийг тусгасан албан ёсны баримт бичиг юм.

Төрийн албаны тухай хуулийн 14-р зүйлийн 14.1-д зааснаар алба хаагч нь томилогдсон албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон ажлын байрны



тодохойлолтыг албан ёсоор гаргуулан авах, үүнийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхийг томилогдсон байгууллагын даргаас шаардах эрхтэй хэмээн заасан байдаг.

Тэгэхлээр цагдаагийн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт нь тухайн ажлын байранд тавигдах

- Мэргэжил, мэргэшлийн шаардлага, мэдлэг боловсролын чадвар-танин мэдэхүйн мэдлэгтэй байх,

- Бие сэтгэлзүйн чадвар-ажиллах чадвар,

- Ёс зүйн чадвар-тухайн ажилтны үнэт зүйл,

- Мотиваци, харилцааны чадвар-хамтран ажиллах,

- Харилцан нөлөөлөх чадвар, бүтээлч чадвар-бүтээл бий болгох шаардлага, туршлага, эрх үүрэг, хүлээх хариуцлага зэргийг ажил олгогчоос тогтоосон хэм хэмжээ юм. Энэ нь цагдаагийн алба хаагчийн үүргээ хэвийн гүйцэтгэх, шаардлагатай техник хэрэгслээр хангагдах гэх наад захын шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй юм.

Дээрх бүгдээс дүгнэж Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтөд дараах байдлуудыг анхаарах шаардлагатай хэмээн үзэж байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг судлаачийн зүгээс “Цагдаагийн албаны хуулиар хүлээсэн үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цагдаагийн зохистой хүний нөөц, чанарын хэмжээ, тэдний эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагыг тоймлон тогтоох үйл явц юм” хэмээн тодорхойлж байна.

Нийгэм, түүнийг бүрдүүлэгч элемент болох байгууллага, түүний амьд эс болох хүн байнга өөрчлөгдөж байдаг хөгжлийн жам ёсны хуультай.

Аливаа байгууллагын өөрчлөлт, хөгжлийг тодорхойлогч стратеги төлөвлөгөөг үндэслэн тухайн байгууллагад шаардлагатай хүн хүчний хэрэгцээ, түүнийг хангах боломж, эх сурвалжийг урьдчилан тодорхойлж төлөвлөх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулахын тулд тус

байгууллагын стратеги төлөвлөгөөг улам сайжруулах, түүнд хүний нөөцийн

хөгжлийн асуудлыг тусгаж өгөх, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Хүний нөөцийн төлөвлөлтийг оновчтой боловсруулахын тулд Цагдаагийн

байгууллагын хүний нөөцийн мэдээллийн системийг сайжруулж, гадаад, дотоод орчны шинжилгээг хийх нь зүйтэй байна.

3. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн менежер нь алба хаагчийн ажлын

байрны шинжилгээг хийх чадвартай, хамт олон, хувь хүний сэтгэл зүйн мэдлэгтэй байж багт найрсаг уур амьсгал бүрдүүлэх, шинэ алба хаагчийг төлөвшүүлэх, ажилтан болгоны мэргэжлийн ур чадвараа бүрэн нээхэд туслалцаа үзүүлэх чадвартай байх шаардлагатай.

Иймээс байгууллагын хүний нөөцийн менежерийн материал бүрдүүлэгч, танилцуулагчийн үүргээс татгалзаж, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, оновчтой шийдвэр гаргах ур чадварт суурилсан ажлын байрны чадавхийг сайжруулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

4. Одоогоор Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн мөн алба хаагчийн

хөгжлийн төлөвлөгөө тусгайлан боловсруулагдаагүй байх тул хүнийг чиглүүлэн хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөг гарган урамшуулал, сургалтын үйл ажиллагааны үр дүнг бодитойгоор тооцох аргачлалыг боловсруулах нь зүйтэй юм.

5. Мөн офицер алба хаагч, удирдах албан тушаалд ажилтнуудыг шинээр томилох тодорхой шалгуурыг тогтоож, ил тод байх зарчмыг хэрэгжүүлэх, улс төр, аль нэг намын нөлөөллөөс ангид, хараат бус томилгоо хийж байх шаардлагатай юм.

Иймээс цагдаагийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн менежер нь хүмүүсээ нарийн сайн судлах, таних, тэдгээрийн ур чадварыг нээн илрүүлэх, урамшуулах, хөгжүүлэх, ажил амьдралын туршлага, мэргэшил, албандаа хандах хандлагыг тогтоож, ирээдүйн албан тушаалын боломжийг урьдчилан төлөвлөж байх нь чухал хэмээн үзэж байна.